ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙГ МӨРДӨН ШАЛГАХ, ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ: ХУУЛЬ БУСААР АН АГНАХ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙГ МӨРДӨН ШАЛГАХ, ХЯНАН ШИЙДВЭРЛЭХЭД АНХААРАХ АСУУДЛУУД

СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГА

(Хууль сахиулах байгууллагуудын алба хаагч нарын албан хэрэгцээнд зориулав)

ДАА 340
ННА 67
Х-846

Хянаж, редакторласан:
Б.Чимэддорж
С.Пүрэвсүрэн
М.Гантулга (Ph.D)
Б.Жаргалсайхан (Ph.D)
Т.Баатар

Боловсруулсан:
М.Эрдэнэбаяр — Дотоод хэргийн их сургуулийн Гэмт хэрэг илрүүлэхүйн профессорын судалгааны багийн профессор, цагдаагийн хурандаа, доктор (Ph.D)
М.Гантулга — Улсын Ерөнхий прокурорын газрын Сургалтын төвийн дарга, хууль зүйн ухааны доктор (Ph.D)
Г.Оюунболд — Улсын Ерөнхий прокурорын газрын Сургалтын төвийн хяналтын прокурор, хууль цаазын итгэмжит зөвлөх

Зөвлөх:
С.Пүрэвсүрэн
Л.Нямгэрэл
М.Отгонжаргал

Зохиогчийн эрх:
© Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар

Зураач:
Х.Нямдорж

Гэрэл зураг:
Б.Гантулга © *(хуудас: 30, 59, 215, 240)*
н.Өнөртүвшин © *(хуудас: 47)*
Хомын талын тахь ТББ © *(хуудас: 120)*
Л.Жаргалсайхан © *(хуудас: 150)*
Ч.Нямдаваа © *(хуудас: 153)*
Л.Баярсайхан © *(хуудас: 174)*
Каненори Миюра © *(хуудас: 183)*
Б.Нямбаяр © *(хуудас: 217)*
Г.Буянбат © *(хуудас: 218)*
М.Ууганбаяр © *(хуудас: 252)*
Э.Сэргэлэн © *(хуудас: 253)*
Б.Мөнхцог © *(хуудас: 263)*

ISBN: 978-9919-9565-1-6

Зохион байгуулсан:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР

Захиалж, санхүүжүүлэн дэмжиж ажилласан:

ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САН

Гүйцэтгэсэн:

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР

Хамтран ажилласан:

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗАР

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ 10
УДИРТГАЛ 11

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, СУРГАН ЗААХ АРГА ЗҮЙ, СУРГАЛТЫН ХЭЛБЭР, ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС 13

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, ТАНИЛЦУУЛГА 14
Сургалтын үндсэн зорилго 14
Сургалтын хэрэгцээ шаардлага 14
Хичээлийн товч танилцуулга 15
Хичээлийн сэдэв, цагийн хуваарилалт 15
Сурган заах арга зүй ба сургалтын хэлбэр 17
Зайлшгүй уншиж судлах материал 20

БАГШИЙН ЗААХ АРГА ЗҮЙ БА СУРГАЛТ ЯВУУЛАХ АРГА, ХЭЛБЭРҮҮД . 20
Лекцийн арга (Lecture) 21
Эвлүүлгийн арга (Jacksaw) 21
Тохиолдол шинжлэх (Case method) 22
Маргаантай асуудлаар хэлэлцүүлэг явуулах арга 23
Сургалтыг идэвхжүүлэхэд чиглэсэн арга, дасгалууд 25
Солилцооны арга 26
Марафон бичлэгийн арга 26

БАГШИД ТАВИГДАХ ШААРДЛАГА 27

СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС 27

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХУУЛЬ БУСААР АН АГНАХ ГЭМТ ХЭРГИЙГ МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА, АРГА ЗҮЙ, ОНЦЛОГ 29

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.5 дугаар зүйл “Хууль бусаар ан агнах” гэмт хэргийн ойлголт 30
Хичээлийн товч танилцуулга, нэр томьёоны тайлбар 30
Сургалтын үйл ажиллагаа 32

Лекцийн товч агуулга 33
Хууль бусаар ан агнах гэмт хэргийн шинж 33
Гэмт хэргийн объект 34
Гэмт хэргийн халдлагын зүйл 35
Гэмт хэргийн объектив тал 36
Хууль бусаар ан агнах гэмт хэргийн криминалистик шинж 38
Хууль бусаар ан агнах гэмт хэргийн криминологи шинж 42

ХУУЛЬ БУСААР АН АГНАХ ГЭМТ ХЭРГИЙГ МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ 47
Хичээлийн товч танилцуулга, нэр томьёоны тайлбар 47
Сургалтын үйл ажиллагаа 48
Лекцийн товч агуулга 49
Мэдээллийн эх сурвалж 49
Нутгийн иргэд 50
Мэдээлэгчид 51
Цэргийн алба хаагчид 51
Хууль хэрэгжүүлэгч бусад байгууллагууд 52
Зар сурталчилгаа ба мэдээлэл 52
Мэдээлэл олж авах үйл ажиллагаа 53
Хойшлуулшгүй ажиллагаа 57

НОТЛОХ БАРИМТ БҮРДҮҮЛЭХ ТАКТИКИЙН АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ 59
Хичээлийн товч танилцуулга, нэр томьёоны тайлбар 59
Сургалтын үйл ажиллагаа 61
Лекцийн товч агуулга 61
Үзлэг 62
Хэргийн газрын үзлэг 62
Бэлтгэл үе шат 65
Хэргийн газрын үзлэг явуулах үе шат 67
Төгсгөлийн үе шат (Үзлэгийн дүнг бэхжүүлэн авах) 77
Хэргийн газрыг гэрэл зургийн аргаар бэхжүүлэх 78
Баримжаалах гэрэл зураг 78
Тойм зураг 79
Зангилаа гэрэл зураг 80
Нэг бүрчилсэн зураг 81
Нарийвчилсан гэрэл зураг 82
Хууль бусаар ан агнах гэмт хэргийг мөрдөх ажиллагаа 83

Эд мөрийн баримтад үзлэг хийх (тээврийн хэрэгсэл, галт зэвсэг, эд мөрийн баримтад хийх үзлэг) 89
Тээврийн хэрэгсэлд хийх үзлэг 89
Галт зэвсэгт хийх үзлэг 92
Нотлох баримтыг бэхжүүлэх 93
Биологийн гаралтай эд зүйлийг хураан авах ажиллагаа 98
Биологийн гаралтай эд эрхтнийг хадгалах 100
Шинжилгээ хийх 102
Амьтны үхлийн шалтгаан тогтоох (паталоги) 104
Амьтны биед үүссэн шархаар нь шалтгааныг тодорхойлох . . 105
Эд мөрийн баримтад хийх магадлан шинжилгээ 106
Шинжээчээс асуух асуулт 111
Ярилцлагын арга техник 113
Ярилцлага 114
Сэжигтэнтэй ярилцах арга техник 116
Сэжигтнийг ярьж буй байдал болон үйл хөдлөлөөр нь таних . 117
Хууль сахиулагчийн ёс зүй 118

ХУУЛЬ БУСААР АН АГНАХ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ 120

Хичээлийн товч танилцуулга, нэр томьёоны тайлбар 120
Сургалтын үйл ажиллагаа 121
Лекцийн товч агуулга 122
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоох үндэс болох нь 122
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зүй 124
Гэмт хэрэгтэй тэмцэхэд хамтын ажиллагааг зохион байгуулах . . . 127
Хамтын ажиллагаанд баримтлах зарчим 131
Гадаад хамтын ажиллагаа 131
Иргэдийн оролцоо хамтын ажиллагааны хэлбэр болох нь . . . 132
Хууль бусаар ан агнах гэмт хэргийн олон улсын чиг хандлага 134
Хууль бусаар ан агнах гэмт хэрэг бусад гэмт хэрэгтэй холбогдох нь 138
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаанд ашиглах объектын судалгаа 139
Амьтан агнах, барих зарим арга, зэвсэг хэрэгслийн талаарх танин мэдэхүйн ойлголт 141
Амьтан агнах уламжлалт аргууд 141
Амьтны тухай хуулиар хориглосон зарим арга хэрэгслийн тухай 143

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХУУЛЬ БУСААР АН АГНАХ ЗӨРЧЛИЙГ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА 149

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ 150
Хичээлийн товч танилцуулга, нэр томьёоны тайлбар 150
Зөрчлийн тухай ойлголт 151
Гэмт хэрэг ба зөрчлийн ялгаа 152

АМЬТАН ХАМГААЛАХ ЖУРМЫН ТАЛААР ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ТУСГАГДСАН ЗҮЙЛ, ТҮҮНИЙ ШИНЖ 153
Хичээлийн товч танилцуулга, нэр томьёоны тайлбар 153
Зөрчлийн тухай хуулийн 7.3 дугаар зүйл. Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль зөрчих. 155
Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйл. Амьтны тухай хууль зөрчих зөрчил 157
Зөрчлийн тухай хуулийн 16.1 дүгээр зүйл. Монгол Улсын хилийн тухай хууль зөрчих 172

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА 174
Хичээлийн товч танилцуулга, нэр томьёоны тайлбар 174
Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа 175
Үзлэг хийх 177
Мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах ажиллагаа 178
Эд зүйл, баримт бичиг хураан авах ажиллагаа 179
Эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаа 179
Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах ажиллагаа 180
Мэдүүлэг авах ажиллагаа 180
Шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах ажиллагаа 181
Шинжилгээ хийлгэх ажиллагаа. 182

ТОДОРХОЙ ЗӨРЧЛИЙГ ШАЛГАХ АРГАЧЛАЛ 183
Хичээлийн товч танилцуулга, нэр томьёоны тайлбар 183
Амьтны тухай хууль зөрчих зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа 185
Зөрчил илрүүлэх, шалгах хууль зүйн үндэслэл 185
Зөрчил илрүүлж, шалгах ажиллагаа. 186
Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх 192
Нотлох ажиллагаа 199

Эрх хязгаарлах арга хэмжээ 200
Зөрчлийн хэргийг танилцуулж, хэрэг бүртгэлтийг дуусгах . . . 200
Хууль зүйн хариуцлага 200
Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль зөрчих зөрчил шалгах анхаарах асуудал 201
CITES-ийн зөвшөөрөл 202
CITES-ийн зөвшөөрлийг шалгахад анхаарах зарим зүйл . . . 204
Монгол Улсын хилийн тухай хууль зөрчих зөрчил 205
Зөрчил шалган шийдвэрлэхэд анхаарах зүйл 206

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХУУЛЬ БУСААР АН АГНАХ, ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙГ ШАЛГАХ, ХЯНАН ШИЙДВЭРЛЭХЭД АНХААРАХ АСУУДЛУУД 211

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, ТАНИЛЦУУЛГА 212
Сургалтын хэрэгцээ шаардлага 212
Сургалтын зорилго 213
Сургалтын зорилт 213
Арга зүй 213
Сургалтын үнэлгээ, хэрэглэгдэхүүн, үйл явц 214

ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦ 215

АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛЬ ЗӨРЧИХ ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ. 218
Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зорилт, нэр томьёо болон эрх зүйн хүрээнд олгож буй боломж 219
Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал ба хөөн хэлэлцэх хугацаа 222
Эрх бүхий албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаанд гомдол гаргах ба зөрчил хянан шийдвэрлэх шүүх 224
Зөрчил шалгах ажиллагаа ба хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх, шийтгэл оногдуулсан шийдвэрт гомдол гаргах 229
Агнуурын амьтан агнах, барихыг хориглох хугацаа 233
Амьтан агнах, барихад хориглох арга, зэвсэг хэрэгсэл болон хориглосон үйл ажиллагаа, зохицуулалт 235

ШИНЖЭЭЧ ТОМИЛОХ, ШИНЖИЛГЭЭ ХИЙЛГЭХ 253

ХУУЛЬ БУСААР АН АГНАХ ГЭМТ ХЭРГИЙГ МӨРДӨН ШАЛГАХ АРГАЧЛАЛ, АНХААРАХ АСУУДАЛ 263

АШИГЛАСАН МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦ, НОМ, БҮТЭЭЛ 267

ХАВСРАЛТ 278

Хавсралт 1. Хууль бусаар ан агнах гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх аргачилсан зөвлөмж 278
Хавсралт 2. Хэргийн газрын үзлэг хийсэн тэмдэглэл 292
Хавсралт 3. Амьтны гаралтай эд зүйлд үзлэг хийсэн тэмдэглэл . . 297
Хавсралт 4. Мөрдөгчийн тогтоол ба шинжээчийн дүгнэлт 300
Хавсралт 5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зүйлчлэл хийх аргачлал 306

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Эрүүгийн хуульд Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийг тусгайлан бүлэг болгон хуульчилж, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаанд анхааран ажиллаж байгаа билээ.

Энэ төрлийн гэмт хэргүүд тухайлбал, хууль бусаар ан агнах, байгалийн ургамал, ой мод, газрын хэвлий болон ашигт малтмалыг хууль бусаар ашиглах, ой хээрийн түймэр тавих, газрын хөрсийг гэмтээх зэрэг байгаль орчинд ихээхэн хор уршиг учруулдаг гэмт хэргүүд голчлон гарч байгаа бөгөөд улам бүр өсөн нэмэгдэх хандлагатай байна.

Цаашид энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд зэрлэг амьтан, ургамал, ой, ус, агаар зэрэг хүрээлэн байгаа орчинд учруулсан хохирол, гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, гэмт хэргийн шинж, хохирол, хор уршгийг бүрэн бодиттой тогтоож, нотлох, хохирлыг нөхөн төлүүлэх, сэргээлгэх зэрэг үр дүнтэй мөрдөн шалгаж нотлох, яллах, зөрчлийн шийтгэл, эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд эрх бүхий албан тушаалтан, мөрдөгч, прокурор, шүүгчдийн мэдлэгийг шинэчлэх, ур чадварыг сайжруулах хэрэгцээ, шаардлага тулгарч байна.

Энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд эрх зүйн мэдлэгээс гадна, байгаль орчны чиглэлд хамрагдах салбаруудын харилцааг зохицуулж буй хууль эрх зүйн актууд, тэдгээрт гарсан өөрчлөлт, шинэчлэлийг байнга судалж, тусгай мэргэшлийн ур чадварыг эзэмших шаардлагатай бөгөөд иргэд, олон нийт, төрийн захиргааны болон хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын нэгдсэн ойлголт, олон талт хамтын ажиллагааны үр дүнд байгаль орчныг хамгаалах талаар Улсын Их Хурлаас баталсан хуулиуд, Засгийн газраас гаргасан дүрэм журам, стандарт нэг мөр хэрэгжих боломжтой юм.

Энэхүү гарын авлага нь хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэхэд Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, дотоодын хууль тогтоомжийг нэг мөр хэрэглэх, ан амьтан, байгаль орчны талаар хэрэглэгддэг нэр томьёо, ухагдахууныг зөв ойлгон үнэлэх, ашиглах, хууль тогтоомжоор эрх олгож заасан захиргааны хэм хэмжээний актаар хохирол, хор уршгийг тогтоох, шинжээч томилж шинжилгээ хийлгэх зэрэг мөрдөн шалгах ажиллагааг үр дүнтэй явуулах, прокурорын хяналтын ажлыг сайжруулахад тодорхой хувь нэмрээ оруулна гэдэгт итгэж байна.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗРЫН
СУРГАЛТЫН ТӨВИЙН ДАРГА,
ХУУЛЬ ЗҮЙН УХААНЫ ДОКТОР М.ГАНТУЛГА

УДИРТГАЛ

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF) нь Монгол улсад 1992 оноос эхлэн үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд түүнээс хойш тус бүр таван жилийн хугацаатай нийт дөрвөн байгаль хамгаалах стратеги төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлээд байна. 2017-2021 оны хооронд хэрэгжүүлэх таван жилийн стратеги төлөвлөгөөнд нэн ховор, ховор амьтан, ургамал болон цэнгэг усны экосистем, ойн нөөцийн хамгааллыг олон талын оролцоонд тулгуурлан өргөн хүрээтэй зохион байгуулан ажиллахаар тусгасан байдаг.

Мөн тус стратеги төлөвлөгөөнд Монгол орны амьтан, ургамлыг устах аюулд хүргэж буй гол 7 хүчин зүйлсэд хариуцлагагүй уул уурхай, оновчгүй дэд бүтцийн хөгжил, хууль бус агнуур, амьтан, ургамлын эд эрхтэн, бүтээгдэхүүнийг хууль бусаар худалдаалах, уур амьсгалын өөрчлөлт, бэлчээрийн доройтол, хариуцлагагүй газар тариалан орж байгааг тогтоосноос гадна, эдгээр хүчин зүйлс дээр ядуурал болон ажилгүйдлийн асуудал нэмэгдэж, улмаар байгалийн нөөцийг зохисгүй ашиглах явдал газар авсаар байгаа нь байгаль орчин доройтох нэмэлт нөхцөл болж байна хэмээн тодорхойлжээ.

Дээр дурдсанчлан зэрлэг амьтан, ургамал ховордох нэг үндсэн шалтгаан нь хууль бусаар амьтан агнаж, байгалийн ургамлыг түүж бэлтгэх, тэдгээрийн эд эрхтэн, түүгээр хийсэн хүнс, эм бэлдмэл, эд хэрэглэл, гоёл чимэглэлийн зүйлийг дотоодын зах зээл дээр болон хил дамжуулан хууль бусаар худалдаалах үйл ажиллагаа болж байна. Түүнчлэн олон улсын байгууллагууд (Interpol г.м) дэлхийн хэмжээнд хар тамхи, зэвсгийн наймаатай холбогдох гэмт хэргүүдийн дараа амьтан, ургамал, тэдгээрийн эд эрхтэн, бүтээгдэхүүн, түүгээр хийсэн хүнс, эм бэлдмэл, эд хэрэглэл, гоёл чимэглэлийн зүйлсийг олон улсын хэмжээнд хууль бусаар худалдаалах гэмт хэрэг орж байгаа талаар онцгойлон мэдээлсээр байна.

Ийм ч учраас, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар нь энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бууруулах ажлын хүрээнд (1) Олон улсын гэрээ конвенц (Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES), Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS), Биологийн олон янз байдлын тухай конвенц г.м)-ын хэрэгжилтийг сайжруулах, холбогдох төрийн байгууллагууд болон олон нийтэд хүргэх, сурталчлах, (2) Монгол Улсын хууль, эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийж, сайжруулах зөвлөмж боловсруулах, (3) улс, орон нутгийн түвшинд салбар хоорондын бодлого, үйл ажиллагааг уялдуулж, хамтын ажиллагааг сайжруулах, (4) хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдын мэдлэг, ур чадварыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, (5) энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгааны ажлуудыг олон талын оролцоотойгоор хамтран зохион байгуулах зэрэг чиглэлээр ажиллаж, тодорхой амжилтад хүрээд байна.

Дээрх чиглэлүүдээс хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдын мэдлэг, ур чадварыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд эхний ээлжид “Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх: Хууль бусаар ан агнах гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд анхаарах асуудлууд” сургалтын хөтөлбөр, гарын авлагыг олон талын оролцоотойгоор боловсруулан хүргэж байна. Энэхүү гарын авлага нь хууль сахиулах байгууллагын алба хаагчдын хууль бусаар ан агнах болон амьтны гаралтай эд эрхтэн, бүтээгдэхүүн, эд хэрэглэл, гоёл чимэглэлийн зүйлсийг хууль бусаар худалдаалах гэмт явдлаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, тэмцэх үйл ажиллагаанд бодитой хувь нэмэр болно хэмээн найдаж байна.

Энэхүү сургалтын хөтөлбөр, гарын авлагыг боловсруулах ажлын бүрэлдэхүүнийг томилж, дэмжин ажилласан Улсын Ерөнхий прокурор, төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх асан М.Энх-Амгалан, тус ажлын хэсгийг удирдан зохион байгуулж, гарын авлагын холбогдох сэдвүүдийг боловсруулах ажилд өөрсдийн мэдлэг оюун, цаг заваа харамгүй зориулж, хамтран ажилласан Улсын Ерөнхий прокурорын газрын Сургалтын төвийн дарга, хууль зүйн ухааны доктор (Ph.D) М.Гантулга, Улсын Ерөнхий прокурорын газрын Сургалтын төвийн хяналтын прокурор, хууль цаазын итгэмжит зөвлөх Г.Оюунболд болон Улсын Ерөнхий прокурорын газрын нийт хамт олонд талархсанаа илэрхийлье.

Сургалтын хөтөлбөр, гарын авлагыг боловсруулах ажилд өөрийн мэдлэг оюун, цаг зав, нөр их хөдөлмөр хүчээ харамгүй зориулж, хамтран ажилласан Дотоод хэргийн их сургуулийн Гэмт хэрэг илрүүлэхүйн профессорын судалгааны багийн профессор, доктор (Ph.D), цагдаагийн хурандаа М.Эрдэнэбаяр болон Дотоод хэргийн их сургуулийн судлаач, багш нарт тусгайлан талархсанаа илэрхийлж байна.

Энэхүү ажлыг дэмжиж, олон байгууллагуудын ажлын уялдаа, хамтын ажиллагааг хангаж, зохицуулан ажилласан Хууль зүй, дотоод хэргийн яам, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Л.Нямгэрэл болон тус ажлын албаны ахлах мэргэжилтэн бөгөөд Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга, цагдаагийн дэд хурандаа М.Отгонжаргал, мэргэжил, тактикийн үнэтэй зөвлөгөө өгч, холбогдох материалуудаар хангаж, дэмжиж ажилласан Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах алба болон Экологийн цагдаагийн албаны хамт олонд баярлалаа.

Ариун цагаан үйлс бүхэн дэлгэрэх болтугай!

ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САН (WWF)-ИЙН
МОНГОЛ ДАХЬ ХӨТӨЛБӨРИЙН ГАЗРЫН
БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН АСУУДАЛ
ХАРИУЦСАН ЗАХИРАЛ Б.ЧИМЭДДОРЖ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, СУРГАН ЗААХ АРГА ЗҮЙ, СУРГАЛТЫН ХЭЛБЭР, ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, ТАНИЛЦУУЛГА

СУРГАЛТЫН ҮНДСЭН ЗОРИЛГО

Хууль сахиулах байгууллагуудын алба хаагч нарыг хууль бусаар ан агнах гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаанд сургаж дадлагажуулах, ур чадварыг нэмэгдүүлэх болон энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар шинэ мэдлэг, мэдээлэл олгоход сургалтын үндсэн зорилго оршино.

Сургалтын хэрэгцээ шаардлага

Эрс тэрс уур амьсгалтай Монгол орны өөр хоорондоо ялгаатай олон янзын экосистемд дасан зохицсон хөхтөн амьтдын 16% нь бүс нутгийн хэмжээнд устах аюултай, 2% нь устаж байгаа, 11% нь устаж болзошгүй, 3% нь эмзэг буюу байгальд устах эрсдэл өндөр байна[1].

Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргүүд нь үндэсний аюулгүй байдалд бодит аюул учруулж байдаг, нийгэмд аюултай, өргөн тархсан хууль бус үйлдлүүдийн нийлбэр юм. Энэ гэмт явдлын бүрэлдэхүүнд хууль бусаар ан агнах гэмт хэрэг нь багтдаг бөгөөд сүүлийн 5 жилд хууль бусаар ан агнах гэмт хэрэг нь хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийн 0.2 хувийг эзэлж, 1.5 тэрбум төгрөгийн хохирол экологид учруулсан байна. Хууль бусаар ан агнах гэмт хэрэг эрүүгийн эрх зүйн ангилал, шалгууураар хүнд гэмт хэрэгт хамаарахгүй ч байгаль орчин, нийгэмд учруулдаг хор уршгийг хэрхэвч дутуу үнэлж болохгүй.

Иймд энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, мөрдөн шалгах, урьдчилан сэргийлэх болон хянан шийдвэрлэх ажиллагаанд оновчтой арга зүйг боловсруулж, хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдыг мэргэшүүлэх хэрэгцээ шаардлага зайлшгүй байна.

1 Монгол орны Байгаль орчны төлөв байдлын тайлан. (2011-2012) БОНХЯ. УБ., 2013.

Хичээлийн товч танилцуулга

Сургалтын хөтөлбөрийн нэр	Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх		
Хичээлийн нэр	Хууль бусаар ан агнах гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд анхаарах асуудлууд		
Хичээл заах багш	Тусгайлан бэлтгэгдсэн сургагч багш нар		
Багшийн хаяг И-мэйл			
Сургалтын цаг	Нийт 57	Танхимын цаг 38	Бие даан суралцах цаг 19
Хичээлийн зорилго	Хууль бусаар ан агнах гэмт хэрэг, зөрчлийн эрүүгийн эрх зүйн болон криминалистик, криминологи шинжийн талаарх ойлголт, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах ажиллагааны онцлог, нотлох баримтыг бүрдүүлэх, хэрэг мөрдөх, танин мэдэхүйн зарим асуудал болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудлуудын хүрээнд зохих мэдлэг олгож, ур чадвар эзэмшүүлэн хууль бус үйл ажиллагаатай тэмцэх, амьтныг хайрлан хамгаалах үзэл хандлага төлөвшүүлэх, түүнчлэн прокурорын эрүүгийн хэрэг, зөрчлийг шийдвэрлэхэд хууль бусаар ан агнах тухай мэдлэг, ойлголтыг баяжуулах, гүнзгийрүүлэх, мөн амьтан, тэдгээрийн эд эрхтэн, бүтээгдэхүүнийг хууль бусаар ашиглахтай холбоотой шинэ мэдлэг олгох, урьд олж авсан мэдлэгийг шинэчлэх, түүнчлэн хууль бусаар ан агнах гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд шаардлагатай ур чадварыг олгоход оршино.		

Хичээлийн сэдэв, цагийн хуваарилалт

№	Хичээлийн сэдэв	Сургалтын хэлбэр	Цаг
Нэгдүгээр бүлэг. Хууль бусаар ан агнах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа, арга зүй, онцлог			16 цаг
1.1	Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.5 дугаар зүйл “Хууль бусаар ан агнах” гэмт хэргийн ойлголт	Лекц, дасгал	4
1.2	Хууль бусаар ан агнах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны онцлог	Лекц, дасгал	4
1.3	Нотлох баримт бүрдүүлэх тактикийн анхаарах зарим асуудал	Лекц, дасгал	4

1.4	Хууль бусаар ан агнах гэмт хэргээс урьдчилан сэргийлэлт	Лекц, дасгал	4
Хоёрдугаар бүлэг. Хууль бусаар ан агнах зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаа			12 цаг
2.1	Зөрчлийн тухай ойлголт	Лекц, дасгал	1
2.2	Амьтан хамгаалах журмын талаар зөрчлийн тухай хуульд тусгагдсан зүйл, түүний шинж	Лекц, дасгал	4
2.3	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа	Лекц, дасгал	2
2.4	Тодорхой зөрчлийг шалгах аргачлал	Лекц, дасгал	5
Гуравдугаар бүлэг. Хууль бусаар ан агнах, худалдаалах гэмт хэрэг, зөрчлийг шалгах, хянан шийдвэрлэхэд анхаарах асуудлууд			10 цаг
3.1	Олон улсын гэрээ, конвенц	Лекц	1
3.2	Амьтны тухай хууль зөрчих зөрчил шалган шийдвэрлэхэд анхаарах асуудал	Лекц, багаар ажиллах, танилцуулга хийх, дүгнэх	3
3.3	Хууль бусаар ан агнах гэмт хэргийн шинж, зүйлчлэл	Лекц, багаар ажиллах, танилцуулга хийх, дүгнэх	3
3.4	Шинжээч томилох, шинжилгээ хийлгэх	Лекц, багаар ажиллах, танилцуулга хийх, дүгнэх	2
3.5	Хууль бусаар ан агнах гэмт хэргийг мөрдөн шалгах аргачлал, анхаарах асуудал	Лекц, дасгал	1
	Нийт		38 цаг

Сурган заах арга зүй ба сургалтын хэлбэр

№	Тухайн сэдвийн товч агуулга	Сурган заах арга зүй	Сургалт явуулах хэлбэр
Хичээлийн сэдэв: Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.5 дугаар зүйл “Хууль бусаар ан агнах” гэмт хэргийн ойлголт			
1.1	• Хууль бусаар ан агнах гэмт хэргийн ойлголт, эрүүгийн эрх зүйн шинж • Хууль бусаар ан агнах гэмт хэргийн криминалистик шинж • Хууль бусаар ан агнах гэмт хэргийн криминологи шинж	Тонгоруу анги Кейс ярилцлага Хэлэлцүүлэг	Лекц, Семинар
Хичээлийн сэдэв: Хууль бусаар ан агнах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны онцлог			
1.2	• Хууль бусаар ан агнах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны онцлог • Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн ойлголт, • Мэдээллийн эх сурвалж • Мэдээлэл олж авах үйл ажиллагаа • Хойшлуулшгүй ажиллагаа	Кейс ярилцлага Хэлэлцүүлэг Багаар ажиллах	Лекц Семинар Дасгал
Хичээлийн сэдэв: Нотлох баримт бүрдүүлэх тактикийн анхаарах зарим асуудал			
1.3	• Нотлох баримтыг бүрдүүлэхэд анхаарах зарим асуудал • Үзлэгийн тухай ойлголт • Хэргийн газрын үзлэг хийхэд анхаарах зүйл • Хууль бусаар ан агнах гэмт хэргийг мөрдөх ажиллагаа • Эд мөрийн баримтад үзлэг хийх • Биологийн гаралтай эд зүйлийг хураан авах ажиллагаа • Биологийн гаралтай эд эрхтнийг хадгалах • Шинжилгээ хийх • Амьтны үхлийн шалтгаан тогтоох (паталоги) • Амьтны эд эрхтэнд хийх магадлан шинжилгээ • Ярилцлагын арга техник • Сэжигтэнтэй ярилцах арга техникүүд • Хууль сахиулагчийн ёс зүй	Кейс ярилцлага Хэлэлцүүлэг Бичгийн дасгал	Лекц Семинар Дасгал

Хичээлийн сэдэв: Хууль бусаар ан агнах гэмт хэргээс урьдчилан сэргийлэлт			
1.4	• Хууль бусаар ан агнах гэмт хэргээс урьдчилан сэргийлэлт • Гэмт хэрэгтэй тэмцэхэд хамтын ажиллагааг зохион байгуулах нь • Хууль бусаар ан агнах гэмт хэргийн олон улсын чиг хандлага • Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаанд ашиглах объектын судалгаа • Амьтан агнах, барих зарим арга, зэвсэг хэрэгслийн талаарх танин мэдэхүйн ойлголт	Хэлэлцүүлэг	Лекц
Хичээлийн сэдэв: Зөрчлийн тухай ойлголт			
2.1	• Зөрчлийн ойлголт • Зөрчлийн шинж, бүрэлдэхүүн	Кейс ярилцлага Хэлэлцүүлэг Багаар ажиллах	Лекц Семинар Дасгал
Хичээлийн сэдэв: Амьтан хамгаалах журмын талаар зөрчлийн тухай хуульд тусгагдсан зүйл, түүний шинж			
2.2	• Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль зөрчих • Амьтны тухай хууль зөрчих • Монгол Улсын хилийн тухай хууль зөрчих	Кейс ярилцлага Хэлэлцүүлэг Багаар ажиллах	Лекц Семинар Дасгал
Хичээлийн сэдэв: Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа			
2.3	• Үзлэг хийх • Мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах ажиллагаа • Эд зүйл, баримт бичиг хураан авах ажиллагаа • Эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаа • Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах • Мэдүүлэг авах ажиллагаа • Шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах ажиллагаа • Шинжилгээ хийлгэх ажиллагаа	Кейс ярилцлага Хэлэлцүүлэг Багаар ажиллах	Лекц Семинар Дасгал

Хичээлийн сэдэв: Тодорхой зөрчлийг шалгах аргачлал			
2.4	• Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа • Зөрчил шалган шийдвэрлэх тодорхой ажиллагаа явуулах онцлог (бодит жишээ)	Кейс ярилцлага Хэлэлцүүлэг Багаар ажиллах	Лекц Семинар Дасгал
Хичээлийн сэдэв: Олон улсын гэрээ, конвенц			
3.1	• “Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц (RAMSAR, 1971)” • “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай (Бонны) конвенц (CMS, 1979)” • “Биологийн олон янз байдлын тухай конвенц (CBD, 1993)” • “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES, 1973)” • “Амьтны тухай хууль (2012)” • “Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах хөтөлбөр (2011)” • “Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр (2015)”	Хэлэлцүүлэг	Лекц Семинар
Хичээлийн сэдэв: Амьтны тухай хууль зөрчих зөрчил шалган шийдвэрлэхэд анхаарах асуудал			
3.2	• Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зорилт, нэр томьёо болон эрх зүйн хүрээнд олгож буй боломж • Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал ба хөөн хэлэлцэх хугацаа • Эрх бүхий албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаанд гомдол гаргах ба зөрчил хянан шийдвэрлэх • Зөрчил шалгах ажиллагаа ба хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх, шийтгэл оногдуулсан шийдвэрт гомдол гаргах • Агнуурын амьтан агнах, барихыг хориглох хугацаа • Амьтан агнах, барихад хориглох арга, зэвсэг хэрэгсэл болон хориглосон үйл ажиллагаа, зохицуулалт	Кейс ярилцлага Хэлэлцүүлэг Багаар ажиллах	Лекц Семинар Дасгал

Хичээлийн сэдэв: Хууль бусаар ан агнах гэмт хэргийн шинж, зүйлчлэл			
3.3	• Хууль бусаар ан агнах гэмт хэргийн шинж, зүйлчлэл • Хууль бусаар ан агнах гэмт хэргийн криминологи шинж • Хууль бусаар ан агнах гэмт хэргийн криминалистик шинж	Кейс ярилцлага Хэлэлцүүлэг Багаар ажиллах	Лекц Семинар Дасгал
Хичээлийн сэдэв: Шинжээч томилох, шинжилгээ хийлгэх			
3.4	• Шинжээч томилох, шинжилгээ хийлгэх • Шинжээчид тавих асуултын тухай • Биологийн гаралтай эд эрхтнийг хураан авах, хадгалах	Кейс ярилцлага Хэлэлцүүлэг Багаар ажиллах	Лекц Семинар Дасгал
Хичээлийн сэдэв: Хууль бусаар ан агнах гэмт хэргийг мөрдөн шалгах аргачлал, анхаарах асуудал			
3.5	• Хууль бусаар ан агнах гэмт хэргийг мөрдөн шалгах аргачлал • Хууль бусаар ан агнах гэмт хэргийг мөрдөн шалгахад анхаарах асуудал	Кейс ярилцлага Хэлэлцүүлэг Багаар ажиллах	Лекц Семинар

Зайлшгүй уншиж судлах материал

Энэ гарын авлагын Ашигласан Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенц, ном, бүтээл сэдэвт дурдсан Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенц, Улсын Их Хурал (УИХ), Засгийн газрын тогтоол, хөтөлбөр, нэг сэдэвт бүтээл, Монгол болон гадаад хэл дээр хэвлэгдсэн сурах бичиг, ном, гарын авлага, тайлан, эрдэм шинжилгээний өгүүлэл, сэтгүүлүүдийг дэлгэрүүлэн уншиж, судлах шаардлагатай.

БАГШИЙН ЗААХ АРГА ЗҮЙ БА СУРГАЛТ ЯВУУЛАХ АРГА, ХЭЛБЭРҮҮД

Сургалтын төлөвлөгөөнд заасан сэдэв бүрд тухайн хичээлийг удирдан явуулах сургалтын нийтлэг арга, багаар ажиллах, ярилцах, дасгалыг тусгасан. Сургалтыг үр дүнтэй, хүртээмжтэй явуулах зорилгоор сэдвийн онцлог, сургалтад оролцогчдын нас хүйс, мэргэжил, ажлын байрнаас шалтгаалан багш сургалтын дараах аргуудаас тохируулан сонгоно. Үүнд:

Лекцийн арга (Lecture)

Лекцийн товчлол болон танилцуулгыг хэвлэж урьдчилан тараана. Хичээлийн явцад суралцагч тодруулж тэмдэглэх зүйлээ бичиж болохуйц зайг тусгайлан гаргаж лекцийг хэвлэнэ.

Лекцийн хичээлийг багш сэдвийн агуулгаас хамааран түүний ойлголт, өргөн хүрээний мэдлэгийг суралцагчид өгөх, ойлгоход нарийн төвөгтэй зүйлийг тайлбарлан таниулах, зураг, бүдүүвч, дэлгэц, компьютер, проектор болон бусад үзүүлэн таниулах материал ашиглаж, хугацаа хэмнэх, суралцагчийн мэдээлэл хүлээн авах чадварыг нэмэгдүүлэхэд анхаарна.

Лекцийн аргаар сургалтыг явуулахдаа:

- Үргэлжилсэн урт хугацаагаар унших (суралцагч анхаарлаа төвлөрүүлэхэд бэрхшээл үүсгэдгийг харгалзан боломжтой нөхцөлд хэлэлцүүлэг, дүрд хувирах, биечлэн үзүүлэх зэрэг бусад аргыг лекциндээ багтаах нь зүйтэй)
- Багш ярихын зэрэгцээ үзүүлэн таниулах материал ашиглах (энэ тохиолдолд оюутнуудын тогтоох мэдээллийн хэмжээ 25% хүртэл нэмэгддэг бол заалгасан зүйлээ туршиж хэрэглэсэн нөхцөлд энэ үзүүлэлт 70% хүртэл өсдөг) зэргийг анхаарна.

Эвлүүлгийн арга (Jacksaw)

Энэ арга нь суралцагчид богино хугацаанд их хэмжээний мэдээлэл олж авах боломж олгодог ба лекцийг орлуулахад түүнийг ашиглана. Тухайлбал, хууль бусаар ан агнах гэмт хэргийн эрх зүйн шинжүүдийг нэгтгэн ойлгоход энэ арга үр нөлөөтэй байж болох юм.

Эвлүүлгийн арга нь суралцагчид бие биедээ заах, сургах боломж олгодог ба тухайн хичээлээр мэдээлэл олж авахад хүндрэлтэй тохиолдолд тайлбарлах, асуулт тавих, бусадтай харилцах, бусдыг сонсох чадварыг амьдралд хэрэглэхэд илүү үр дүнтэй байдаг.

Хичээлийн зарим сэдвийг судлахад суралцагчдад дэлгэрэнгүй мэдээлэл шаардагддаг ба энэ тохиолдолд тухайн мэдээлэл, лекцийн агуулга болон бусад нэмэлт хэрэглэгдэхүүнийг жижиг багийн тоогоор хуваах бэлтгэнэ. Бэлтгэсэн материалаа дугтуйд хийж багуудад тарааж өгнө. Тэдэнд «мэргэжилтэн» болоход хангалттай хугацаа өгөх хэрэгтэй учир баг бүр дээр багш очиж материалаа ойлгож байгаа эсэх, бусдад хэрхэн тайлбарлах талаар ярилцаж туслах шаардлагатай.

Тохиолдол шинжлэх (Case method)

Тохиолдол шинжлэх арга нь суралцагчдад эрх зүйн хэм хэмжээг амьдралын тодорхой жишээн дээр үндэслэн хэрэглэж сурахад нь туслах зорилготой асуултын аргад тулгуурласан хэлбэр юм.

Тодорхой жишээ гэдэг нь тухайн явдал, бодит хэрэг, шүүхийн шийдвэр зэрэг суралцагчдад нийгэм, хүрээлэн буй орчин, эрх зүй, хүний эрхийн асуудлаар шинэ сэргэг ойлголт, мэдлэг өгөх, асуудалд олон талаас нь шүүмжлэлтэй, нухацтай хандах сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэгдэж ашиглагдах хэрэглэгдэхүүн юм.

Сургалтын тохиолдлууд ихэвчлэн эх бичвэрийн хэлбэртэй байдаг боловч кино болон дүрс бичлэг, дуу хураагчийн бичлэг, дүр бүтээж тоглох болон бусад хэлбэрээр байж болно.

Тохиолдол шинжлэх аргыг хэрэглэхийн тулд амьдрал, практикт гарч байсан эрх зүйн онолын маргаантай холбоотой хэрэг маргааны талаарх янз бүрийн мэдээлэл, хууль тогтоомж, эрх зүйн актууд болон холбогдох гарын авлагуудыг бэлтгэсэн байх шаардлагатай.

Сургалтын энэ арга нь суралцагчийн ямар нэгэн бодит баримтын талаар асуулга тавих, тухай бүрийн тодорхой нөхцөлүүдэд чухал болохыг тодорхойлж, тэдгээрийг задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, тохиолдол бүрд эргэцүүлэн бодож байх боломж олгодог. Тохиолдлыг шинжлэх явцдаа суралцагчид нь цээжлэн тогтоох эхний хэлбэрээс эхлээд бодит баримтыг үнэлэх хүртэл сэтгэхүйн үйлдлүүдийг хийж дадлагажиж болно.

Түүнчлэн суралцагчид шүүхийн шийдвэр болон хэрэг маргаанд дүн шинжилгээ хийх, хууль хэрэглэх дадал, арга зүй олгох, тэдний идэвхийг өрнүүлэхэд энэ аргын зорилго оршино.

Энэ аргыг хэрэглэхдээ нэг багшид 20-оос илүүгүй суралцагч оногдохоор бодож тооцоолох хэрэгтэй бөгөөд оюутны тоо үүнээс илүү байх тохиолдолд хичээлийн зорилго, үр дүнд муугаар нөлөөлдөг. Багшийн хувьд хуулийн практикт ажилласан туршлагатай байх нь энэ хичээл амжилттай явагдах гол нөхцөл болно.

Маргаантай асуудлаар хэлэлцүүлэг явуулах арга

Энэ арга нь онолын эсрэг, тэсрэг үзэл бодлыг суралцагчид хамтран хэлэлцэж, өөрийн санал бодол, байр суурийг илэрхийлэх, хамгаалах, мэдээлэл солилцох, өрсөлдөгчийн үзэл бодлыг хүлээн зөвшөөрөх чадвартай болгох зорилготой. Маргаантай асуудлаар хэлэлцүүлэг явуулах аргаар хичээлийг зохион байгууллахад оюутнууд эсрэг, тэсрэг үзэл бодлыг хүлээн зөвшөөрч, ойлгож, няцаах, нотолгоог дэвшүүлэх чадвар, хандлага төлөвших боломжтой.

Суралцагчдаас уг асуудалд тэдний үзэж байгаагаар хамгийн чухал маргаантай асуудлууд нь чухам аль нь болохыг асууснаар багш энэ сэдэвт холбогдолтой хэлэлцүүлэг, ярилцлагыг эхэлж болох юм. Хичээлийн явц дүнгээс шалтгаалаад олон төрөл (хууль эрх зүй, ёс суртахууны эсхүл практикийн холбогдолтой)-ийн асуудлууд гарч болно.

Маргаантай асуудлаар хэлэлцүүлэг явуулахад суралцагч эхлээд тухайн тохиолдлын хамгийн маргаантай цөм хэсгийг ойлгох нь чухал бөгөөд үүнгүйгээр тэдэнд уг тохиолдлын бусад зүйлийг ойлгоход бэрх болно.

Багшийн зүгээс сургагчдын түвшин болон уг аргаар ажиллах дадлага туршлага зэргийг харгалзан өөрөө тухайн жишээний гол маргаантай хэсгийг нь тайлбарлан ярьж ч болох талтай. Ингэж багшийн эсхүл суралцагчийн өөрсдийн хүчээр тодорхой ойлгож авсан асуудлын гол хэсгийг дараа дараагийн үзэх зүйлүүдээс ялгаж салгах нь чухал юм.

Үүний дараа суралцагч онолын үндэслэл, баримт, нотолгоо олох, боловсруулах болон тэдний гаргасан баримт нотолгоо нь нэг үзэл санааг дэмжиж, нөгөөг эсэргүүцэх нь ойлгомжтой. Энэ явцад тэдэнтэй олон талыг хамарсан дараах асуудлыг хөндөн ярилцаж болно. Үүнд:

- Маргалдагч үзэл санаа бүрийг дэмжих буюу эсэргүүцэх ямар баримт, учир шалтгаан байж болох? Аль нь үнэмшил муутай болох? Яагаад?
- Энэ асуудлыг өөр арга замаар шийдвэрлэж болох эсэх?
- Хөндлөнгийн байр суурь болоод маргагч талуудын хувьд энэхүү асуудлыг яаж, хэрхэн шийдвэрлэснээр ямар үр дагавар учирч болох?
- Баримт нотолгоо, учир шалтгаан болон шийдвэр бүрийн давуу тал нь юу болох?

Суралцагчид хууль зүйн баримт, шалтгааныг ашиглах, нийгмийн үнэт зүйл болон улс төр, эдийн засгийн холбоо хамаарлыг судалж чадаж байгаа бол урам өгөх нь чухал. Янз бүрийн нотолгоо, баримт, учир шалтгааныг тодруулах

хэлэлцэх явцад бусдын буюу өөр нотолгоо, үндэслэлд хүлээцтэй, тэвчээртэй хандах, мөн хэлэлцүүлгийн ил тод байдлыг хангасан тийм уур амьсгал бүрдүүлэх нь зохистой байдаг.

Суралцагчаас шүүн хэлэлцэж буй ямар ч асуудал, санаа бодол, хүсэлт нь эв эетэй байдал, маргаан зөрүүтэй аль ч үед адил тэгш хэлэлцэгдэж, яригдах ёстойг ойлгосон байх ёстой. Өөрөөр хэлбэл, суралцагчид бусдыгаа сонсдог, үзэл санааг нь хүндэтгэдэг, бодитой хандаж, үнэлэлт өгөх чадвартай байна гэсэн үг.

Ингээд суралцагчдын бүх учир шалтгаан, нотолгоог сонссоны дараа шийдвэр гаргахад анхаарлын төвлөрүүлэх нь чухал. Тэдний гаргасан шийдвэрийн үндэслэлийг заавал асуух хэрэгтэй. Хэрэв шийдвэрийг багш гаргасан буюу уншиж сонсгосон бол дараа нь заавал сурагчдаар үнэлэлт өгүүлэх хэрэгтэй. Тухайлбал;

- Тэд багшийн уншсан сэдэвтэй санал нийлж байгаа эсэх? Ямар учраас?
- Энэ шийдвэр нь уг ажиллагаанд оролцогч талуудад хэрхэн тусч байна вэ?
- Нийгэмд ямар үр дагавар авчрах вэ? гэх мэтээр асуух нь тэдэнд үнэлэлт, дүгнэлтээ хэлэх боломжийг олгоно.

Хэрэв шийдвэрийг суралцагчид өөрсдөө гаргасан бол уг шийдвэрийг гаргах болсон шалтгаан, үндэслэлийг хэрхэн тайлбарлаж байгааг анхаарах нь зүйтэй. Энэ бүхний эцэст, хэрэв авсан тохиолдол нь шүүхээр шийдвэрлэгдсэн бодит хэрэг байсан бол багш шүүхийн шийдвэрийг хэлж өгөх нь зүйтэй. Үүнийг хийхдээ, сурагчид зөвхөн байгаа баримтад тулгуурлан өөр шийдвэр гаргаснаараа буруутай мэтээр өөрсдийгөө ойлгох байдал төрүүлэхгүйгээр хийх нь чухал. Үүний тулд багш дараах загвар асуултаас ашиглаж болно. Үүнд:

- Суралцагч болон хуулийн байгууллагын гаргасан шийдвэрийг харьцуулж, аль нь юуны учир илүү давуутай болохыг хэлэлцэнэ.
- Шүүх яагаад өөр шийдвэр биш, чухам тэрхүү шийдвэрийг гаргах болов? Энэхүү шийдвэрийг гаргахад юу нөлөөлөв?
- Та нар энэ шийдвэртэй санал хэрхэн нийлж байна вэ? Танд энэ шийдвэр хэрхэн нөлөөлж байна? Бусад хүмүүст бол яаж нөлөөлөх вэ? Энэ шийдвэрийн нөлөө, ач холбогдол ямар байх вэ? гэх мэт.

Хичээлээр хэлэлцэх маргаантай асуудлыг сонгох шалгуур:

- Асуудлыг олон талаас нь авч хэлэлцэх боломжтой, үнэхээр маргаантай асуудал мөн эсэхийг тогтооно.
- Энэ асуудал нь тухайн суралцагчид хэлэлцэхэд тохиромжтой болон эрх зүйн онол, арга зүйн хувьд ач холбогдолтой эсэх

Маргаантай асуудлыг хэлэлцэхэд хувь хүний үзэл бодлыг хөндөх ба сэтгэлийн хөдөлгөөн үүсгэдэг учраас заримдаа түүнийг зохион байгуулалттай дарааллаар хэрэглэхэд хүндрэлтэй байдаг. Иймээс хичээлийг зохион байгуулалт сайтай явуулах, үүссэн маргаантай байдлыг хяналтдаа байлгахад дараах дүрэм нь багшид тус болно. Тухайлбал;

- Дүрмийг зөвшилцөж гаргаад бүгд биелүүлнэ.
- Нотолгоо болон баттай мэдээлэл дээр анхаарлаа төвлөрүүлнэ.
- Цаг барьж, ганцаараа ярихаас зайлсхийнэ.
- Уриа хэрэглэхээс зайлсхийнэ.
- Маргааныг хийсвэр түвшинд хүргэхээсээ өмнө тодорхой асуудлуудаар ярилцана.
- Таны байр сууринд эргэлзэх бололцоог бусдадаа олгоно.
- Өөрийн байр суурийн эргэлзээтэй, хүнд хэцүү болон сул талуудыг хүлээн зөвшөөрнө.
- Бусдын санааг өөрчлөн хэлэх замаар ойлгож сурна. Ийм дадалтай болгохын тулд бусдаас сонссоноо өөрчлөн хэлж сурна. Үзэл бодол болгонд хүндэтгэлтэй хандана.

Хэрэгжүүлэх дараалал:

1. Хэлэлцэх асуудлын сэдвээс хамааран “Санал бүрэн нийлж байна”, “Санал нийлж байна”, “Шийдээгүй буюу эргэлзэж байна”, “Санал нийлэхгүй байна”, “Санал бүрэн нийлэхгүй байна” эсвэл “Маш зөв”, “Зөв”, “Буруу”, “Маш буруу” гэсэн бичиг бүхий цаасыг энэ дарааллаар байрлуулсан байна.
2. Энэ дасгал ажлыг хэрхэн хийх талаар дүрэм зохиогоод түүнийгээ хэлэлцэж батална.

Сургалтыг идэвхжүүлэхэд чиглэсэн арга, дасгалууд

Сургалтын арга зүйд мэдээлэл түгээх, оролцооны зэрэг дээр дурдсан аргуудаас гадна, тэдгээртэй хослуулан сургалтын явцад суралцагчдыг идэвхжүүлэх, өдөөх, анхаарал төвлөрүүлэх зорилгоор тусгай арга, дасгалуудыг хэрэглэх нь зүйтэй. Гэхдээ аль аргыг ямар сэдэв бүхий хичээл дээр, ямар аргуудтай хослуулан хэрэглэх талаар багш урьдчилан бэлтгэж, төлөвлөх хэрэгтэй. Энэ утгаар багш хичээлийн агуулга, сургалтын арга, аргачлал, дасгалуудыг уялдуулан төлөвлөх хүснэгтийг ашиглах боломжтой.

Сургалтыг идэвхжүүлэх арга, дасгалуудыг хичээлийн агуулгатай уялдуулан багш өөрийн арга барилаар баяжуулан хэрэглэнэ. Сургалтад өргөнөөр хэрэглэдэг зарим арга, дасгалуудаас дор дурдав.

Солилцооны арга

Зорилго: Тодорхой асуудлыг шинжлэхэд оролцогчдыг бүгдийг хамруулах, идэвхжүүлэх, бие даан асуудал дэвшүүлэн дүгнэх, шүүмжлэн хэлэлцэх чадварыг хөгжүүлэх

Анхаарах зүйл: Оролцогчид баг дотроо шийдвэрлэх асуудлаа зураг, график, хүснэгт гэх мэтээр илэрхийлэн хамтран ажиллана. Хэрэгжүүлэх дараалал:

- Багийн гишүүдийг дугаарлана.
- Багшийн хэлсэн тоо, эсвэл суралцагчид өөрсдөө хэн нэгнийгээ сонгон багтаа үлдээж, үлдсэн хэсэг нь бусад багийн ажилтай танилцахаар явна. Энэ үедээ бүх багийн ажилтай тойрон явж танилцахаас гадна, асуулт асууж, өөрсдийн саналыг хэлнэ.
- Багтаа үлдсэн хүн өөр багаас ирж байгаа хүмүүст өөрсдийн хийсэн ажлаа танилцуулна. Бүх оролцогчид өөрсдийн багтаа эргэн ирж, багтаа үлдсэн хүндээ бусдын санал бодлыг танилцуулж ярилцана. Багууд хийсэн ажлаа дахин хянаж, нэмэх, хасах зүйлийг тодорхойлон ажлаа нэгтгэнэ.

Марафон бичлэгийн арга

Энэ арга нь бага хугацаанд олон хүний саналыг гаргах, чөлөөт сэтгэлгээг хөгжүүлэх зорилготой оролцооны арга юм.

Анхаарах зүйл: Тодорхой сэдэв үзсэний дараагаар энэ аргыг хэрэглэн суралцагчдаар дүн шинжилгээ хийлгэнэ. Хэрэгжүүлэх дараалал:

- Сургалтын агуулгыг харгалзан оновчтой асуултыг урьдчилан бэлтгэнэ.
- Дээрх асуултад багийн гишүүн бүр нэг хуудас цаасан дээр өөрийн хариултаа бичээд баруун гар талын хүн рүүгээ дамжуулна. Ингээд анхны бичсэн хуудас эхний хүн дээр иртэл дамжуулна.
- Хариултууд нэлээд зөрүүтэй байвал баг дотроо ярилцах замаар цааш үргэлжлүүлж болно. Хэрвээ багийн гишүүд бүгд ижил хариулт бичсэн байвал эхний хүнийг урамшуулж болно.
- Марафон бичлэгийн аргыг аль болох хурдан хугацаанд тодорхой асуудлыг дүгнэн хэлэлцэх, оюутнуудыг идэвхжүүлэх, анхаарлыг төвлөрүүлэх болон хичээлийн төгсгөлд дүгнэх байдлаар хэрэглэхэд тохиромжтой.

Багшид тавигдах шаардлага

Тус гарын авлагад тусгагдсан сэдвийг заах багш нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Эрх зүйч мэргэжилтэй, боловсрол болон хууль зүйн магистр, түүнээс дээш зэрэгтэй гэмт хэрэг мөрдөх ажиллагааны туршлагатай, эрдэм шинжилгээ, сургалтын байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан тус хичээлийг заах онол, арга зүйн мэдлэг чадвар, дадлагатай байгалийн шинжлэлийн зохих мэдлэгтэй, логик сэтгэлгээтэй байх
- Сурган хүмүүжүүлэх сэтгэлгээ, ажилдаа хандах хандлагаа өөрчлөх чадвартай байх
- Бусдыг хүндэтгэх, хайрлах, эв еийг хичээх үзэлтэй, үнэнч шударга, нэр төрөө эрхэмлэн үүрэг хариуцлагаа ухамсарладаг, ёс зүйн болон харилцааны өндөр соёлтой байх
- Онолын асуудлуудын мөн чанар, учир холбогдлыг нээн харуулах, цэгцтэй тайлбарлах аргазүйг эзэмшсэн сурган заах арга зүйн өндөр мэдлэг лекц унших дадал, чадвартай байх
- Хууль зүйн сургалт явуулах арга зүйд гарч байгаа орчин үеийн хандлага өөрчлөлтийг мэдэрч өөрийн заах аргазүйг боловсронгуй болгох, шинэчлэх чин эрмэлзэлтэй байх
- Багаар ажиллах чадвартай, хамт олонч байх
- Мэдээлэл түгээх болон оролцооны идэвхтэй аргуудыг хэрэгжүүлэх зохих мэдлэг дадалтай байх
- Суралцагчийн судалж буй сэдвийн мөн чанар, шийдвэрлэхээр зорьж байгаа асуудалд зөвлөх мэдлэгтэй байх
- Багш судлаач байх, судалгааны аргуудыг эзэмшсэн, олон талын өргөн мэдлэг, чадвартай байх
- Орчин үеийн техник, хэрэгслийг сургалтын явцад ашиглах чадвартай байх (компьютер, проектор, кодоскопи, видео, аудио техник хэрэгсэл гэх мэт) зэрэг болно.

СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Үнэлгээ нь сургалтын хөтөлбөр, түүний гүйцэтгэл, үр дүнтэй хамааралтай бөгөөд багшийн ур чадвар, хөтөлбөрийн чанарыг үнэлэхэд үнэлгээний хуудасны зорилго оршино.

Таны эрхэлсэн ажилд сургалт нь хэр хамааралтай байсан (нэг тоог дугуйлна)

Хамааралгүй	Хамааралтай
1	2

Сургалтын агуулга таны сонсохыг хүсэж буй зүйлтэй нийцсэн эсэх

Огт нийцээгүй	Бага зэрэг		Ихэнх агуулга нь		Бүгд нийцсэн
1	2	3	4	5	6

Сургалт зорилгодоо нийцсэн эсэх

Огт нийцээгүй	Бага зэрэг		Ихэнх агуулга нь		Бүгд нийцсэн
1	2	3	4	5	6

Сургалтын агуулгад таны мэдэхгүй зүйл хэр их байсан

Шинэ зүйл алга	Зарим нэг шинэ мэдээлэлтэй		Ихэнх агуулга нь шинэ		Бүх мэдээлэл шинэ
1	2	3	4	5	6

Доорх хүчин зүйлсийг үнэлнэ үү?

Үзүүлэлт	Маш муу	Муу	Боломжийн	Сайн		Маш сайн
Сургалтын орчин	1	2	3	4	5	6
Техник хэрэгсэл, үзүүлэн компьютер	1	2	3	4	5	6
Зохион байгуулалт	1	2	3	4	5	6
Сургалтын явц	1	2	3	4	5	6
Тараах материал тоо, чанар	1	2	3	4	5	6

Сургалтын талаарх таны бодол (юуг сайжруулмаар байна, юунд анхаарах, цаашид ямар сэдвээр сургалт авах сонирхолтой байгаа талаар бичнэ).

.....

.....

.....

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХУУЛЬ БУСААР АН АГНАХ ГЭМТ ХЭРГИЙГ МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА, АРГА ЗҮЙ, ОНЦЛОГ

ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ТУСГАЙ АНГИЙН 24.5 ДУГААР ЗҮЙЛ “ХУУЛЬ БУСААР АН АГНАХ” ГЭМТ ХЭРГИЙН ОЙЛГОЛТ

Хичээлийн товч танилцуулга, нэр томьёоны тайлбар

Хамрах хүрээ	Цагдаагийн алба хаагчид	Сургалтын хэлбэр	Лекц
Сургалт явуулах газар	Сургалтын танхим (заал)	Хугацаа	4 цаг
Хичээлийн товч танилцуулга	Суралцагчид хууль бусаар ан агнах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн болон криминалистик, криминологи шинжийг тодорхойлох, жишээ, баримтыг тайлбарлан, ойлгуулах, мэдлэгийг суралцагчийн оролцооны аргаар хамтран бүтээх		
Сургалтын арга зүй	Суралцагчийн оролцооны аргууд: тонгоруу анги, өөрөөр нь яриулах, эерэг ба сөрөг байдлаар дүгнүүлэх болон тайлбарлан ойлгуулах, сонсгож таниулах		
Хичээлийн товч агуулга			
• Хууль бусаар ан агнах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж, ойлголт • Хууль бусаар ан агнах гэмт хэргийн криминалистик шинж • Хууль бусаар ан агнах гэмт хэргийн криминологи шинж			
Сургалтын хэрэглэгдэхүүн	- Цахим танилцуулга - Фондын лекц - Хичээлийн хөтөлбөр, нэгж хичээлийн удирдамж - Бусад		

Нэр томьёоны тайлбар			
Амьтан	**Нэн ховор амьтан**	**Ховор амьтан**	**Ангийн гаралтай түүхий эд**
Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга буюу түр нутагшсан, хөхтөн, шувуу, мөлхөгч, хоёр нутагтан, загас, хавч хэлбэртэн, зөөлөн биетэн, эгэл биетэн хамаарна.	Тархац нутагтаа бүхэлдээ, эсхүл ихэнх хэсэгт тоо толгой эрс цөөрсөн, ашиглах нөөцгүй, устах аюулд орсон амьтныг ойлгоно.	Тархац нутагтаа тоо толгой цөөрсөн, нөөц багатай, устаж болзошгүй амьтныг ойлгоно.	Амьтны арьс, шир, үс, өд, эвэр, толгой, цус, өөх, тос зэрэг эд эрхтнийг ойлгоно.
Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ	Улсын тусгай хамгаалалттай газар нутаг	Тусгай зөвшөөрөлгүй гэдгийг тайлбарлахад	
Тухайн зүйл амьтны амьдрах орчин болон экологийн, эдийн засгийн, эрх зүйн, нийгмийн ач холбогдлоор нь үнэлсэн тусгай аргачлалын дагуу тооцсон амьтны мөнгөн үнэлгээг ойлгоно.	- дархан цаазат газар; - байгалийн цогцолборт газар; - байгалийн нөөц газар; - дурсгалт газар гэж улсын тусгай хамгаалалттай газар нутгийг ангилна.	Нэн ховор амьтныг төрийн захиргааны төв байгууллагын тусгай зөвшөөрлөөр зөвхөн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх зориулалтаар агнаж, барьж болно. Энэ зориулалтаар агнаснаас бусад зориулалтаар нэн ховор амьтныг агнаж бэлтгэсэн арьс, яс, бусад түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглоно.	Төрийн захиргааны төв байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлөөр ховор амьтныг дараах тохиолдолд агнаж, барьж болно: - судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар; - Монгол Улсын болон гадаадын иргэн тусгай төлбөр төлсөн; - тодорхой нутаг дэвсгэрт амьтны сүргийн бүтцийг зохицуулах болон халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор.

Сэдвийн хүрээнд боловсруулсан хяналтын асуулт, гэрийн даалгавар, бие даалтын сэдэв, агуулга	**Хяналтын асуулт**
	• Хууль бусаар ан агнах гэмт хэргийн үндсэн болон хүндрүүлэх шинжийг нэрлэ. • Зөвшөөрөлгүйгээр ан агнах гэдэг ойлголтыг тайлбарлана уу? • Хууль бусаар ан агнах гэмт хэргийн санаа зорилгыг тайлбарлана уу? • Хууль бусаар ан агнах гэмт хэргийн криминалистик шинжийг ярилцана уу?
	Бие даалтын сэдэв, агуулга
	- Хууль бусаар ан агнах хэргийн халдлагын зүйлийн талаар судална уу? - Хууль бусаар ан агнах гэмт хэргийн криминологи шинжийг тодорхойлох

Сургалтын үйл ажиллагаа

№	Үе шат	Багшийн үйл ажиллагаа	Хугацаа мин	Суралцагчийн үйл ажиллагаа	Анхаарах зүйл
1.	Сэргээн санах буюу мэдлэгийг үнэлэх	Суралцагчидтай мэндчилж, өөрийгөө танилцуулна. Хичээлийн агуулгын талаар суралцагчдын үзэл хандлагыг асуулт тавих хэлбэрээр тодорхойлж, тэдний мэдлэгийн хүрээг тодорхойлно.	8	Багшийн тавьсан асуудлыг шийдвэрлэх, ойлголт, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх	Хэлэлцүүлгийг хичээлийн сэдэвтэй уялдуулан чиглүүлэх, сэдвийн хүрээнээс гаргахгүй байх
2.	Шинэ мэдлэг олгох үе шат	Урьдчилан бэлтгэсэн слайд дээр тулгуурлан лекцийг явуулахдаа суралцагчдын идэвхийг өрнүүлэх, мотиваци хэрэглэнэ.	40	Хичээлээр олж авсан өөрийн ойлголт, шинэ мэдлэгээ тэмдэглэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх	Лекцийн агуулгыг ойлгож буй эсэхэд анхаарах

3	Бататгах үе шат	Шинэ мэдлэгийг жишээ дээр тайлбарлах	10	Өөрийн зүгээс үзсэн сэдэвтэй холбоотой жишээ гаргах, түүнийг холбож тайлбарлах	Ярилцлагыг чиглүүлэх, дүгнэлтийг бичүүлж, бусдад нь сонсгох
4	Гэрийн даалгавар	Үзсэн хичээлийн сэдэвтэй холбоотой олж авсан мэдлэгээ бататгах үүднээс холбогдох материал уншиж судлах даалгавар өгнө.	2	Үзсэн сэдвийн хүрээнд уншсан ном, зохиол, сурах бичгээс товчлол бичих	
5	Дүгнэлт		Сургалтын үед гарсан амжилт, дутагдалыг тооцож, дараагийн сургалтад анхаарах, нэгж хичээлийн удирдамж, бэлдсэн лекц, заах арга зүйг баяжуулах		

Лекцийн товч агуулга

Энэ сэдэвт хууль бусаар ан агнах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн болон криминалистик, криминологи шинжийг авч үзнэ. Учир нь гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж нь тухайн гэмт хэргийг мөрдөх арга зүй, зөвлөмжийн үндэс суурь болдог бол криминологи шинж нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зүйг боловсруулахад тусална.

Хууль бусаар ан агнах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинжийг мөрдөгч мэдэхгүйгээр хэргийг үнэн зөв бодиттойгоор мөрдөх, үр дүнтэй урьдчилан сэргийлэх арга зүйг боловсруулах боломжгүй юм.

Хууль бусаар ан агнах гэмт хэргийн шинж

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан «Хууль бусаар ан агнах» гэмт хэрэг нь амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, түүний нөөцийг зохистой ашиглахтай холбоотой харилцаанд гэм буруугийн санаатай хэлбэрээр халдсан, Эрүүгийн хуулийн 24.5 дугаар зүйлд хуульчлан тодорхойлж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай үйлдэл[1] байдаг.

1 Б.Энхболд нар. Эрүүгийн эрх зүй. Тусгай анги. сурах бичиг. УБ., 2018. 443 дахь тал

Хууль бусаар ан агнах[1] гэмт хэргийг нийгмийн аюулын шинж, түүний хэр хэмжээг харгалзан үндсэн болон хүндрүүлэх шинжид хуваан ангилан үздэг. Хууль бусаар ан агнах гэмт хэрэгт “Байгаль орчны тухай[2]”, “Амьтны тухай”[3], “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай[4]” зэрэг эрх зүйн салбар хуулиудын холбогдол гүн гүнзгий байдаг.



Эрүүгийн эрх зүйн хамгаалалтад манай орны ховор, нэн ховор болон улсын тусгай хамгаалалттай газар нутгийн амьтад хамаарна

Гэмт хэргийн объект

Мал, гэрийн тэжээвэр амьтнаас бусад байгальд зэрлэгээр амьдардаг аливаа амьтныг хамгаалах, үржүүлэх, ашиглах болон олон улсын гэрээ, конвенцоор хамгаалсан хууль бусаар худалдаалахыг хориглосон харилцаа байна.

1 Эрүүгийн хуулийн 24.5 дугаар зүйл. Хууль бусаар ан агнах.
1.Улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүйгээр амьтан агнасан, барьсан, эсхүл ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр агнасан, барьсан, зориудаар тэжээж гаршуулсан, үржүүлсэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг хадгалсан, худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн, гадаад улсад гаргасан, ховор амьтны чихмэл, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
2.Нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүй агнасан, барьсан, зориудаар гаршуулан тэжээсэн, амьдрах орчныг алдагдуулсан тэдгээрийн түүхий эдийг бэлтгэсэн, тээвэрлэсэн, хадгалсан, худалдсан, худалдан авсан, гадаад улсад гаргасан, ховор амьтны чихмэл, түүхий эд, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
2 Байгаль орчныг хамгаалах тухай. 1995. //Төрийн мэдээлэл 1995. №5-6.
3 Амьтны тухай. 2012. //Төрийн мэдээлэл 2012 №22 (739).
4 Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай 1994. //Төрийн мэдээлэл 1994.№2.

Энэ хэргийн объектын өөр нэг онцгой шинжид тусгай хамгаалалтын газар нутгийн тухай ойлголт мөн хамаарна. Тусгай хамгаалалттай газар нутагт орших элбэг тархацтай болон ховор, нэн ховор амьтдыг зохих зөвшөөрөлгүйгээр агнах, барихыг хориглодог.

Гэмт хэргийн халдлагын зүйл

Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалж, Амьтны тухай хуульд заасан мал, гэрийн тэжээвэр амьтнаас бусад амьтан[1], тэдгээрийн гаралтай эд эрхтэн, чихмэл болон амьтны амьдрах орчин нь халдлагын зүйл байна.

Амьтны гаралтай «түүхий эд»-д амьтны арьс, шир, үс, өд, эвэр, толгой, цус, өөх, тос булчирхай, ноос ноолуур, яс, туурай, мах, дотор эрхтэн, хошуу зэрэг бүхий л эд эрхтэн хамаарах бөгөөд түүгээр хязгаарлагдахгүй юм.



Гэмт хэргийн халдлагын зүйл
1. Согооны сүүл
2. Хотон шувууны хошуу
3. Бөхөнгийн эвэр
4. Баавгайн донид

1 Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга буюу түр нутагшсан хөхтөн, шувуу, мөлхөгч, хоёр нутагтан, загас, хавч хэлбэртэн, шавж, зөөлөн биетэн, эгэл биетэн хамаарна. Байгаль орчныг хамгаалах тухай хууль. 1995 //Төрийн мэдээлэл.1995. №5-6

Гэмт хэргийн объектив тал

- Улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүйгээр амьтан агнасан, барьсан;
- Нэн ховор, ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр агнасан, барьсан;
  - зориудаар тэжээж гаршуулсан;
  - үржүүлсэн;
  - түүхий эдийн зүйлийг хадгалсан;
  - худалдсан;
  - худалдан авсан;
  - тээвэрлэсэн;
  - гадаад улсад гаргасан;
  - амьтны чихмэл, түүхий эдийн цуглуулга;
  - амьдрах орчныг алдагдуулсан;
  - түүхий эдийг бэлтгэсэн.

Хууль бусаар агнах гэмт хэрэг нь байгаль орчинд учруулсан хохирлын хэмжээнээс үл хамаарч хэлбэрийн шинжтэй үйлдэл хийснээр төгсдөг гэмт хэрэг болно. Хууль бусаар ан агнах гэмт хэргийн объектив үйлдлийг тайлбарлавал:

- Худалдсан, худалдан авсан гэдэгт амьтны түүхий эдийг хэн олзворлосноос үл хамаарч худалдах, худалдан авах үйлдэл хийсэн, бараа таваарын солилцоонд ашиглах, өр төлбөрт өгөх зэрэг аливаа арга хэлбэрээр төлбөрийн хэрэгсэл болгон шилжүүлэх, шилжүүлэн авахыг ойлгоно.
- Амьтны тухай хуульд зааснаар тодорхойлолт, гарал үүслийн гэрчилгээ аваагүй амьтны гаралтай түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглосон бөгөөд зөвшөөрөлгүй бол хууль бус гэж үзнэ.
- Тээвэрлэсэн гэдэгт зохих зөвшөөрөлгүйгээр бэлтгэсэн амьтны гаралтай түүхий эдийг тээврийн аливаа хэрэгслээр аль нэг цэгт, ямар нэгэн зорилгоор зөөвөрлөн авч явах үйлдлийг ойлгоно.
- Түүхий эдийн зүйлийг хадгалсан гэдэгт амьтны түүхий эдийг зохих зөвшөөрөлгүйгээр хадгалж байгаа үйлдлийг хэлнэ.
- Тэжээж гаршуулсан гэдэгт амьтны ашиг шимийг хүртэх, тоо толгойг хамгаалах болон бусад аливаа зорилгоор барьж дасгаж, өсгөн үржүүлж буй идэвхтэй үйлдлийг ойлгоно.

Амьтны эд эрхтнийг худалдах, худалдан авах, тээвэрлэх, хадгалах, бэлтгэх үйлдэл нь биеэ даасан бүрэлдэхүүнтэй боловч хууль бусаар ан агнах гэмт үйлдэлтэй шууд холбогддог. Учир нь хууль бусаар ан амьтан агнасан тохиолдолд л дээрх гэмт үйлдлүүд дагалдан гардаг бөгөөд бие биетэйгээ салшгүй шалтгаант холбоо хамааралтай байдаг.

Хууль бусаар ан агнах гэмт хэрэг гэдэг нь амьтныг зохих зөвшөөрөлгүйгээр агнах, барих болон амьтны эд эрхтнийг бэлтгэх, худалдаалах, үржүүлэх, тээвэрлэх, түүхий эдийг хадгалах, амьтны амьдрах орчныг алдагдуулах, чихмэл цуглуулга хийх үйлдлүүдийн нийлбэр юм

Амьтны эд эрхтэн хууль бусаар худалдаалах үйлдэл дэлхийн нийтийн хэмжээнд давамгайлах шинжтэй болж байгаа бөгөөд хууль бусаар ан агнах үйлдлийг дэмжигч голлох үйлдэл болоод байна.

Энэ гэмт хэргийг шууд санаатайгаар үйлддэг бөгөөд өртөг зардал багаар ашиг олз олох шунахай зорилготой, зарим тохиолдолд ан агнах барихаар хорхойсох, хийморио сэргээх, эсвэл адал явдал сонирхох гэсэн зорилготой, өөрийн хүсэл таашаалаа хангах сэдэлтэй байж болно.

Зэрлэг амьтан довтолж хүний амь насанд аюул учруулахад хүрсэн үед амьтан агнасан нь санаа зорилгоор өөр тул энэ гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй болно.

Гэмт хэргийн субъект нь эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр заасан 16 насанд хүрсэн хэрэг хариуцах чадвартай Монгол Улсын иргэн, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн зэрэг хэн ч байж болно.

Дээрх эрүүгийн эрх зүйн шинжийг мэдэж байх нь мөрдөх ажиллагааны хамгийн эхний алхам юм.

Гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж нь тодорхой төрлийн гэмт хэргийн үндсэн шинжүүдийг илэрхийлж, криминалистик, криминологи шинжийн суурь болж, улмаар гэмт хэргийг үр дүнтэй мөрдөх, түүнээс урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлох голлох хүчин зүйл болдог.

Хууль бусаар ан агнах гэмт хэргийн криминалистик шинж

Гэмт хэргийн криминалистик шинжийг тодорхойлохгүйгээр хэрэг мөрдөх арга зүйн зөвлөмж боловсруулах боломжгүй. Тийм учраас хууль бусаар ан агнах гэмт хэргийн криминалистик шинжийг тодорхойлох нь гэмт хэрэг мөрдөх үнэтэй зөвлөмж болдог.

Хууль бусаар ан агнах гэмт хэрэг бусад хэргээс өвөрмөц онцлогтой. Ан амьтныг агнахад ямар нэгэн зэвсэг хэрэгсэл, арга ашигладаг учраас гэмт хэргийн газарт ямар нэгэн ул мөр үлддэг.

Хууль бусаар ан агнах гэмт хэргийн объектив үйлдлийг зэвсэг хэрэгсэл ашигласан, амьтан агнаж, барих арга ашигласан гэж ангилан хуваж болно. Амьтан агнах зэвсэг хэрэгслийг хэрэглэх зориулалтаар нь:

1) амьтан өөрөө баригч, агнах хэрэгсэл, түүнийг дотор нь зөөврийн болон суурин гэж хуваана
2) амьдаар баригч багаж хэрэгсэл
3) галт зэвсэг
4) амьтнаар бариулах
5) туслах чанарын хэрэглэл гэсэн төрлөөр хуваан үзэж болно.

❶ *Амьтан өөрөө баригч, агнах хэрэгсэл.* (а) Амьтан өөрөө баригч байран хэрэглэлүүдэд олон төрлийн тэвхт болон оньст занга, сааль, хаж, баригч нүх гэх мэтийн амьтан агнах газар дээр хийж бэлтгэсэн багаж хэрэгслүүд орох бөгөөд түүнийг хэзээ ч өөр газарт нүүлгэдэггүй учраас “суурин” хэрэглэл гэнэ. (б) Амьтан өөрөө баригч зөөврийн багаж хэрэгслийг ан амьтан хаана байгаа газарт зөөвөрлөн аваачиж тавьдгаар суурин хэрэглэлээс ялгаатай бөгөөд үүнд, агнуурын уламжлалт хэрэгсэл болох хавх, урхи, тор зэрэг орно.

❷ *Амьдаар нь баригч багаж хэрэгсэл.* Үслэг жижиг мэрэгч амьтан, шувуу барих болон загасны элдэв тор, хаалт, хашлага байна. Эдгээр хэрэгсэл нь амьтныг амьдаар нь барьдгаараа онцлогтой. Сүүлийн үед амьтдыг гаршуулан тэжээх, ашигт байдлыг ашиглах, худалдан борлуулах зорилгоор амьдаар

баригч төрөл бүрийн сав хайрцаг, торон хэрэгсэл ашиглах болсон. Эдгээр хэрэглэл нь барих гэж буй амьтны төрлөөс шалтгаалан мод, төмөр, хуванцар, олс зэрэг төрөл бүрийн материалаар хийсэн янз бүрийн хэлбэр, хэмжээ, дүрстэй, амьтан тухайн хайрцаг сав, торонд ормогц оньс, дэгээ мултарч хаагдах, боогдохоор төхөөрөмжилсөн байдаг. Хайрцаг сав, торонд амьтны сонирхлыг татах өгөөш, мэн[1] тавьдаг.

❸ *Галт зэвсэг.* Энэ нь ан агнах гол зэвсэг юм. Төрөл бүрийн их, бага калибрын хол, ойрын тусгалтай бууг анд хэрэглэж байна. Тухайлбал, манай улсад ОХУ-ын Сайга, Тигр, Вперь, Тоз, Медведь, Лось, Винтов, Дровинк (дровинк буюу үрлээр шүршигч), Герман улсын ККҮ, Браунинг, Вальтер, Чех калибр, АНУ-ын Ремингтон зэрэг 60 гаруй загварын ангийн зориулалт бүхий 420000[2] гаруй галт зэвсэг хэрэглэж байна. Галт зэвсгийн сумны хувьд 17 мм-ээс эхлэн 5.6x10; 7.62x25; 7.64 зэрэг хэмжээтэй янз бүрийн сум хэрэглэж байна. Галт зэвсгийг үрлэн сумт (өнгөлсөн дотортой), цул сумт-винтэт буу карбинууд, цул-үрлэн сумт калибр хосолсон буунууд гэж ангилж, бууг сумлах, цэнэглэх байдлаар нь нэг, хоёр, гурав үсэрдэг, олон үсэрдэг, өөрөө сумладаг, автомат гэж хуваана. Үрлэн сумтай (өнгөлсөн дотортой) бууг 12; 16; 20; 24; 28; 32 зэрэг олон янзын калибраар үйлдвэрлэдэг. Үүнээс гадна, гар хийцийн буюу хэлбэр загварыг өөрчилсөн, бүртгэл судалгаанд хамрагдаагүй, байлдааны зориулалттай галт зэвсэг нуугдмал байдлаар иргэдийн гар дээр цөөнгүй байна.

Амьтныг агнасан байдлаар нь ямар төрлийн галт зэвсэг, сум хэрэглэсэн, мэргэжлийн анчин уу эсвэл туршлага багатай хүн агнасан эсэхийг тодорхойлж болно. Аливаа анг байлдааны зориулалттай галт зэвсэг, сумаар агнахыг хориглодог.

❹ *Амьтнаар бариулах.* Амьтныг тусгайлан сургасан нохой, шувуугаар агнадаг. Амьтны тухай хуульд тарвагыг нохойгоор бариулахыг хориглосон. Манай орны ойн бүсийн анчид нохой гахай, баавгай, буга зэрэг амьтдыг хоргоох, хаших, үргээх, ээрэх, барих зэрэгт сургасан байдаг бол тал хээрийн анчид тарвага, үнэг зэрэг амьтдыг нохойгоор бариулдаг. Өнөөг хүртэл манай улсын казак иргэдийн дунд бүргэдээр ан хийх уламжлал байсаар байна.

❺ *Туслах чанарын хэрэглэл.* Амьтан агнах туслах чанарын хэрэглэлд химийн болон тэсрэх дэлбэрэх, нойрсуулах, хордуулах үйлчилгээтэй хор бүхий бодис, гэрэлтүүлэх хэрэгсэл, цахилгаан гүйдэл үүсгэгч, бамбар зэргээс гадна, амьтан үргээх, дуудах шүгэл, дулаан мэдрэгч, шөнийн болон өдрийн дуран, амьтны үнэр шингээсэн үнэртүүлэгч, наалдуулагч зэрэг бодис, хэрэгслүүд орно.

1 Махчин амьтдад үнэрт мэн тавихаас гадна мэрэгч амьтдад шохоорхох мэнг тавьж болно. Жишээлбэл, хэрэмд ойн мөөг, хушны самар, булганд бор шувуу, адууны мах гэх мэт байна. Д.Эрэгдэндавга. БНМАУ-ын Ан агнуурын аж ахуй ба түүний зорилго. УБ., 63 дахь тал.

2 ЦЕГ-ын галт зэвсгийн тооллогын дүнгийн тайлан. УБ., 2013

Амьтны тухай хуулиар дараах аргуудаар амьтан агнахыг хориглосон байна. Тухайлбал, агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх, ус, хужир мараанд ирдэг буцдаг зам дээр нүх ухах, буу сойх, сааль тавих, ахуйн зориулалтаар загас барихад тор, хаалт хашлага, гувчуур, буу, бамбар хэрэглэх, гол мөрөнд завь ашиглах, химийн болон тэсэрч дэлбэрэх, тэсэлгээний бодис хэрэглэх, анд сургасан нохойгоор ан хийх, туурайтан амьтдыг цасанд умбуулах, мөсөнд халтируулах, хясаа, эрэг ганга уруу нисгэх, унагах[1] зэрэг олон аргуудыг дурдсан байдаг. Ан амьтан агнах, барих хэрэг нь зэвсэг хэрэгслийн тусламжтайгаар үйлдэгддэг.

Техник, тоног төхөөрөмж хөгжих тусам шинэ шинэ аргууд нэмэгдэж байна. Тухайлбал, хуучин аккумляторыг голд хаяж гүйдэл үүсгэх, загас барихад усан дотор цахилгаан гүйдлийг үүсгэн тогоор цохих, гол горхинд гэрэл тусган сүрэглэн буй загасыг соруулж авах, элдэв наалдамхай бодис тавьж жижиг шувуу, мэрэгчдийг агнах, үнэр ялгаруулдаг бодис ашиглан амьтдыг дуудаж агнах гэх мэт аргууд мэдэгдээд байна.

Амьтны эд, эрхтнийг хууль бусаар худалдаалагчид нь (а) бэлтгэн нийлүүлэгч анчин, (б) цуглуулагч, (в) тээвэрлэгч, (г) ченж нэртэй худалдан авагч, (д) ангийн эд, эрхтнийг хил дамнуулан зарагчид гэсэн сүлжээ бүхий зохион байгуулалтай байна.

Худалдан авагч, бэлтгэгч анчид нь ихэнх тохиолдолд бие биеэ танихгүй, утсаар хоорондоо харилцаж, шуудан илгээмж, явуулын хүнээр худалдаалах зүйлээ дамжуулж, төлбөрөө банк, АТМ-ээр хийх зэргээр нууц далд аргатай.

Амьтны эд, эрхтэн худалдан авагч ченж нь эд эрхтнийг хадгалах зориулалтын агуулах байр сав, хэрэгслийг урьдчилан бэлтгэсэн байдаг. Жишээлбэл, чив засаа, заар зэрэг амархан муудаж ялзрах эд, эрхтнийг хадгалах хөргүүр хөргөгч, шувуу байлгах тор, байр сав, нүдийг таглах өмсгөл, үслэг амьтны арьс, ус хадгалах агуулах зоорьтой байна. Ан амьтны эд эрхтэн худалдаалахад бага нэгжтэй нарийн жин хэмжүүр, туухай ашигладаг.

Хууль бусаар ан агнагчид амьтны эд эрхтний үлдэгдлийг булах, нуух устгах, машин техник, галт зэвсэг, бохирлогдсон эд зүйлээ цэвэрлэх зэргээр гэмт хэргээ нуун далдлах, ул мөрөө баллах идэвхтэй ажиллагаа явуулдаг. Амьтан агнах гэмт хэрэг нь эзгүй ой, хээр тал газар, ихэвчлэн шөнийн цагаар үйлдэгддэг тул тэр бүр бусдад мэдэгддэггүй, амьтны эд эрхтнийг хүний нүднээс далд хийдэг тул ихэнхдээ нуугдмал шинжийг агуулж байдаг.

1 Амьтны тухай. 2012.5 //Төрийн мэдээлэл 2012. №22 (739).

Мөн хууль бусаар ан агнагчид тусгай зөвшөөрлийг хуурамчаар үйлдэх, хяналт шалгалтаар ажиллаж буй алба хаагчтай тулгарах үед зугтаах, хулгайн гэх нэртэй замаар явах, малын махтай ангийн махыг холих, малын түүхий эд болох арьс шир, ноосон дунд нууж тээвэрлэх, баригдсан үедээ хууль сахиулах байгууллагын ажилтнуудад худал мэдүүлэг өгөх, гэрч нарыг дарамтлах, заналхийлэх зэргээр мөрдөх ажиллагаанд саад учруулдаг.

Судалгаанд хамрагдсан хэргийн материалаас үзэхэд, энэ төрлийн гэмт хэргийн 56.3%-ийг 06-19 цагийн хооронд буюу өдрийн цагт, 43.7%-ийг 19-06 цагийн хооронд буюу шөнийн цагт үйлдсэн байгаа нь агнуурын амьтдын зан төрх, идээшлэх цаг хугацаатай холбоотой байж болох юм. Өдрийн хувьд Даваа гарагт 28, Мягмар гарагт 25, Лхагва гарагт 26, Пүрэв гарагт 24, Баасан гарагт 25, Бямба гарагт 27, Ням гарагт 28 хэрэг тус тус үйлдэгдсэн байна[1]. Үүнээс үзвэл, ан агнахад тодорхой өдөр сонгодоггүй, түүнчлэн өдөр, шөнийн аль ч цагт энэ төрлийн гэмт хэргийг үйлддэг байна.

Криминалистик шинжийн өөр нэг элемент болох гэмт хэргийн бэлтгэл нь бусад гэмт хэрэгтэй харьцуулбал мөн л өвөрмөц.

Ямар ан хийх гэж буйгаас шалтгаалан гэмт этгээдүүд багаж хэрэгсэл, зэвсэг, хувцсаа бэлтгэдэг. Жишээлбэл, шөнийн цагт ан хийх бол шөнийн дуран харааны хэрэгсэл, гэрэлтүүлэгч зэргийг авч явна. Галт зэвсгээс өөр хэрэгслээр ан хийх гэж байгаа бол түүнийг урьдчилан заавал бэлтгэдэг. Мөн нохой, шувууг ан агнахад зориулан урьдаас уйгагүй сургадаг. Амьтан агнахаар явж байгаа этгээд анд явахад тохиромжтой “ангийн” гэж нэрлэгддэг ногоон эрээн өнгийн орчны өнгөтэй адил хувцас, гутал, майхан, дуран, завь мэтээр ан хийх төрлөөс шалтгаалан зохих бэлтгэл хангасан байдаг. Хөдөө орон нутгийн хүмүүс малдаа явахдаа зэрлэг амьтан бэлчээрийн малаас үргэдэггүй онцлогийг ашиглан байнга буу авч явж ан тааралдвал агнана гэсэн зорилготой байдаг.

Гэмт хэрэгтэн хувь хүн ба хохирогч. Энэ хэргийн хохирогч нь төр байдаг учраас хохирогчийн хувьд онцлог зүйл байхгүй. Гэвч ан амьтныг гэмт халдлагаас хамгаалах чиг үүрэгтэй төрийн алба хаагчдын хариуцлага сул, идэвх санаачилга муу байх нь хууль бусаар ан агнах гэмт хэрэг, зөрчлийн гаралтад нөлөөлдөг. Ямар ч иргэн өөрийн санаачилгаар хууль бусаар ан агнасан хэрэг, зөрчлийн талаар хууль хяналтын байгууллагад гомдол, нэхэмжлэл, мэдээлэл тэр бүр гаргадаггүй. Хууль бусаар ан агнах гэмт хэргийн араас хохирогч, нэхэмжлэгч нь тууштай хөөцөлддөггүйгээс зарим хэрэг мөрдөн байцаалт, шүүхийн шатанд замхардаг. Хохирогч, иргэний нэхэмжлэгчээр томилогдсон

1 Ан агнуурын хууль тогтоомж зөрчих гэмт хэргийн нөхцөл байдлын судалгаа (2002-2014). М.Эрдэнэбаяр.

төрийн алба хаагч хээл хахууль, авлигад өртөх магадлалтай зэрэг сул талыг гэмт хэрэг үйлдэгчид тун овжин ашигладаг.

Хууль бусаар ан агнах гэмт хэргийг эрэгтэйчүүд үйлддэг бол амьтны эд эрхтэн худалдаалах гэмт үйлдэлд эмэгтэйчүүд оролцдог байна.

Дэлхийн банкнаас амьтны эд эрхтэн худалдаалах, хууль бус агнуурын талаар 2006 онд хийсэн судалгаагаар, “Монгол Улсын хүн амын 10 хүн тутмын 1 нь буюу нийт эрчүүдийн 30% гаруй нь ямар нэгэн хэмжээгээр ан агнаж байна, анчдын ихэнх нь буюу 240000 иргэн ангийн зориулалттай галт зэвсэг эзэмшиж байгаа нь бусад орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр, ан хийгчид насны хувьд 18-28 насны залуучууд 44%, 29-42 насны 30%, 43-аас дээш насны хүмүүсийн 26% нь ан агнаж байна” хэмээн дүгнээд, энэ судалгаанд сонирхож ганц нэг ан хийдэг хүмүүсийг оруулаагүй болохыг мэдээлсэн[1] байна.

Ийм учраас уг гэмт хэргийг үйлдэж болзошгүй, сэжиглэл таамаглал дэвшүүлж болох хүмүүсийн хүрээ хязгаарлагдмал бус байна. Ийнхүү хууль бусаар ан агнах гэмт хэргийн криминалистик шинжийг гаргах нь тухайн гэмт хэргийг мөрдөх арга зүйн зөвлөмжийн үндсэн суурь болж байдагт түүний ач холбогдол оршино.

Хууль бусаар ан агнах гэмт хэргийн криминологи шинж

Хүмүүний байгальтай харьцаж эхэлсэн хамгийн анхны хэлбэр бол ан гөрөө юм. Шинжлэх ухаан, технологийн гайхамшигт ололтыг хүн төрөлхтөн эзэмшиж, асар их баялаг бүтээж чадсан ч ан ав эрхлэх уламжлалт соёл манай оронд төдийгүй, дэлхийн улс үндэстэн бүрд өнөө хүртэл хадгалагдсаар байна. Зуун зуунд Монголчууд нүүдлийн мал аж ахуй эрхлэн амьдрахдаа ан агнуурыг хавсарга аж ахуйн шинжтэй авч явсаар иржээ. Он удаан жил ан хийж ирсэн уламжлал, амьтан авлах хүсэл сонирхол монгол эр хүн бүрийн цусанд нь шингэсэн байж болох талтай.

Шийдвэрлэсэн хэргийн шүүгдэгч нарын мэдүүлгээс хэрэг үйлдэх болсон нөхцөл шалтгааныг[2] тодруулан үзэхэд, хийморь лундаагаа сэргээхээр ан хийх зорилготой явж, энэ явцдаа хуулиар агнахыг хориглосон амьтан таарахад амьтан алах гэсэн хүсэл эрмэлзэлдээ дийлдэж, баригдахгүй байх гэсэн өчүүхэн бодол сэдлээр ямар ч эргэлзээгүйгээр, зориуд хүсэж ан агнах[3], адуу малдаа явахдаа заавал галт зэвсэг авч явж ан тааралдахад агнаж[4] байгаа

1 Р. Жеймс Вингард. Зэлүүд тал; Монголын ан амьтны хууль бус худалдааны хямралтай асуудлууд. УБ., 2006.
2 Ан агнуурын хууль тогтоомж зөрчих гэмт хэргийн нөхцөл байдлын судалгаа (2002-2014). М.Эрдэнэбаяр
3 Эрүүгийн .....00243 дугаартай хэрэг. Шүүгдэгчийн мэдүүлэг
4 Эрүүгийн .....626 дугаартай хэрэг. Шүүгдэгчийн мэдүүлэг

нь амьтан агнаж авлах гэсэн бие хүний онцлог шинжтэй холбон тайлбарлаж болох юм. Монгол эр хүн бүрд байдаг ан агнах сонирхол нь хууль бус үйлдэл хийлгэхэд маш ойрхон болгодог хэдий ч тэр бодол санаа нь ухамсарт үйлээр хязгаарлагдах ёстой.

Хууль бусаар ан агнах гэмт хэргийг эрэгтэйчүүд үйлдэж байгаа бол амьтны эд эрхтнийг худалдаалах үйлдэлд эмэгтэйчүүдийн оролцоо 4.9%-тай байна. Энэ тоо цаашид ч өсөх хандлагатай байна.

Гэмт хэрэгт холбогдогчдыг насны ангиллаар авч үзвэл, 24.0% нь 30-34 насны, 18.1% нь 35-39 насны, 15.7% нь 40-44 насны хүмүүс голчлон үйлдэж байгаа нь тэдний амьдралд хандах үзэл бодол нь бүрэн төлөвшөөгүй, туршлага муутай, нийгэмд эзлэх байр суурь бага зэрэгтэй холбоотой. Харин нас ахих тусам гэмт хэрэгт холбогдох нь бага болж *(45-49 насныхны 10.1% нь, 50-54 насныхны 3.8% нь, 55-59 насныхны 1.0% нь, 60-64 насны хүн 0.7%)* байгаа нь бие хүний нийгэмтэй харьцах харьцаа сайжирч, үзэл бодол нь төлөвшиж, гэмт хэрэг үйлдэх идэвх нь буурч байгаатай холбоотой[1] гэж дүгнэж болохоор байна.

Хүн бүр өөрийн гэсэн давтагдашгүй онцлогтой бүтүүлэг ертөнц. Гэмт хэрэгтэн бие хүний зан төлөв, сэтгэл зүйн шинж нь бие хүний дотоод мөн чанарыг тодорхойлох хэмжүүр болдог ба ёс суртахуун, улс төрийн үзэл баримтлал, ертөнцийг үзэх үзэл, итгэл үнэмшил, амьдралын тухай үнэлэмжийн чиг баримжаа төсөөлөл, хүсэл эрмэлзэл, сонирхол, сэтгэхүйн үйл ажиллагаа, авир араншингийн онцлог зэргээр илэрнэ.

Гэмт хэрэгт холбогдогчдыг ажил эрхлэлт, боловсролын түвшингээр нь ангилан үзэж, нийгмийн ямар давхаргын хүмүүс энэ төрлийн гэмт хэргийг үйлдэж байгааг тодорхойлох нь чухал ач холбогдолтой. Тухайлбал, уг гэмт хэрэгт холбогдогч нарын 38.3% нь ажилчин, малчин, 37.3% нь эрхэлсэн тодорхой ажилгүй, 20.2% нь хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч, 2.1 хувь нь төрийн алба хаагч, 1.4% нь төрийн бус байгууллагын ажилтан, 0.7% нь оюутан байна.

Энэ төрлийн гэмт хэргийн 59.6%-ийг бүлэглэн гүйцэтгэж, 1.7%-ийг урьд ял шийтгэгдсэн хүмүүс, 1.0%-ийг согтуугаар үйлдсэн байгаа нь сонирхол татаж байна. Ихэнх гэмт хэргийн суурь шалтгаан болсон архидан согтуурах нь уг гэмт хэргийн гаралтад нөлөөтэй биш байгааг илтгэнэ. Харин ан агнуурыг бүлэглэн гүйцэтгэдэг нь энэ хэргийн онцлог бөгөөд гэмт хэргийг давтан үйлдэх, ял шийтгэгдсэн этгээдүүд бага байгаа нь ял шийтгэлийн үр нөлөөтэй шууд холбоотой гэж дүгнэж болно.

1 Ан агнуурын хууль тогтоомж зөрчих гэмт хэргийн нөхцөл байдлын судалгаа (2002-2014). М.Эрдэнэбаяр

Гэмт хэргийн нөхцөл байдлыг судлан үзэхэд[1], амьтад дараах зорилго, зориулалтаар ихэвчлэн хууль бус агналтад өртөж байна. Үүнд:

Гэмт үйлдлийн зорилгоор нь: (а) ашиг орлого олох, (б) ахуйн хэрэгцээндээ зориулах, (в) тодорхой чиглэсэн зорилгогүй зөвхөн зугаа, цэнгэл буюу амьтан алах сонирхлоор гэж ангилж болно.

Амьтны эд эрхтнийг хууль бусаар худалдаалж буй гэмт үйлдлийг: (1) үслэг ангийн худалдаа, (2) эмчилгээний, (3) ангийн махны худалдаа, (4) гоёл, чимэглэлийн зориулалтын гэж хуваана. Мөн хууль бус үйлдэлд өртөж байгаа амьтдыг төрлөөр нь ч ангилж үзэж болно. Үүнд:

- *Үслэг ангийн худалдаанд:* тарвага, үнэг, хярс, булга, суусар, баавгай, цоохор ирвэс, чоно зэрэг үслэг ан амьтад,
- *Эмчилгээний зориулалтад:* буга, хүдэр, бөхөн, чоно, хойлог зэрэг амьтад,
- *Ангийн махны худалдаанд:* буга, хандгай, зэрлэг гахай, бор гөрөөс, цагаан зээр, хар сүүлт, хулан, аргаль, янгир, тарвага, хур, сойр, олон зүйлийн загас өртөж байна.
- *Гоёл, чимэглэлийн зориулалтад:* амьтны чихмэл хийж, эвэр, соёо, туурай, яс, шагай, арьс, элдэв ясны цуглуулга, загасны арьсны хатаамал ашиглаж гоёл, чимэглэлийн зүйлс хийх зорилгоор аргаль, янгир, хандгай, буга, гахай, баавгай, чоно зэрэг хөхтөн, шонхор, тас, бүргэд зэрэг жигүүртэн, тул, хилэм, зэвэг зэрэг загасыг агнаж байна. Дээрх төрөлжүүлсэн ангилалд амьтан нь биологийн өвөрмөц онцлогоос шалтгаалан нэг зүйлийн амьтан бүх ангилалд орж болно.

Энэ гэмт хэргийн криминологи шинжийн чухал асуудлын нэг нь уг гэмт хэргийн гаралтын байдлыг үнэлэх явдал юм. Гэмт явдлын жил жилийн бодит гаралтыг нарийвчлан тогтоож чадахгүйгээр урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дүгнэх боломжгүй. Гэмт хэргийн гаралтыг тодорхойлох мэдээллийн үндсэн эх сурвалж нь эрүүгийн статистик[2] юм. Гэмт хэргийн гаралтыг доктор, профессор Н.Жанцан (а) бүртгэгдсэн гэмт хэрэг, (б) илэрсэн гэмт хэрэг (гэвч бүртгэгдээгүй), (в) нуугдмал гэмт хэргээс бүрдэнэ[3] хэмээн тэмдэглэсэн бөгөөд бодитоор үйлдэгдэж байгаа гэмт хэргийн гаралтын түвшнийг зөвхөн хууль сахиулах байгууллагад бүртгэгдсэн хэргээр авч үзэж болохгүй нь ойлгомжтой юм.

Бодитоор үйлдэгдсэн гэмт явдал, гэмт хэргийн гаралтыг үнэлэхдээ нуугдмал

1 Ан агнуурын хууль тогтоомж зөрчих гэмт хэргийн нөхцөл байдлын судалгаа (2002-2014). М.Эрдэнэбаяр
2 Н.Жанцан. Гэмт явдлын гаралтын байдлыг үнэлэх асуудалд. //Гэмт хэрэгтэй тэмцэх асуудал. 1985. №8. 32 дахь тал.
3 Н.Жанцан. Гэмт явдлын гаралтын байдлыг үнэлэх асуудалд. //Гэмт хэрэгтэй тэмцэх асуудал. 1985. №8. 33 дахь тал.

гэмт явдлын түвшнийг зайлшгүй харгалзах шаардлагатай болдог. Хууль бусаар ан агнах, барих үйлдэл нь хөдөө хээр, хүнгүй газарт зэвсэг хэрэгсэл ашиглан үйлдэгддэг, харин амьтны эд эрхтэн худалдаалах үйлдэл нь зөвхөн худалдагч, худалдан авагч нарын дунд хүний нүднээс далд хийгддэг зэргээрээ нуугдмал шинжтэй, нийгмийн хор аюулаар үлэмж их гэмт хэрэг учраас энэ гэмт хэргийн гаралтыг үнэлэхдээ нуугдмал түвшнийг тогтоох нь чухал. Уг гэмт хэргийн нуугдмал шинжийн нэгээхэн хэсгийг цагдаагийн байгууллагын статистик бүртгэлээс хялбархан харж болно.

Амьтны эд, эрхтнийг хууль бусаар хил нэвтрүүлж байгаа гэмт хэргээс үзэхэд[1], хураагдсан амьтны эд, эрхтэн нь хууль бусаар агнагдсан амьтдыг илэрхийлэх бөгөөд энэ нь хууль бусаар ан агнах гэмт хэргийн гаралтын нуугдмал байдлын түвшинг зохих хэмжээгээр илэрхийлнэ. Хууль бусаар агнасан эдгээр үйлдлийг цагдаагийн байгууллага огт шалгахгүй байгаа нь судалгаанаас харагддаг бөгөөд энэ нь тухайн байгууллагын ажлын хариуцлага, мэдлэг чадвар сул гэж үзэхээс өөр аргагүй юм.

Гэмт хэргийн нуугдмал байдлын түвшинг тогтоох нь хялбар ажил биш. Түүнийг тодорхойлохын тулд судалгааны янз бүрийн арга хэрэглэх ёстой. Оросын эрдэмтэн В.В. Панкратов[2] нуугдмал гэмт явдлын асуудлыг шийдвэрлэхэд хамгийн тохиромжтой арга бол тойруу судалгааны арга юм. Асуулга явуулах, нийгэм-эдийн засгийн байдлыг задлан шинжлэх, хууль хяналтын байгууллагын бусад мэдээ баримтад дүн шинжилгээ хийх нь тойруу судалгааны аргын бүрэлдэхүүн элемент болохыг тодорхойлжээ. Өнөө үед математик статистикийн аргын тусламжтайгаар нуугдмал гэмт хэрэгт судалгаа хийж байна.

АНУ-ын болон барууны орны хуульч эрдэмтэд нэг илэрсэн гэмт хэргийн ард 3-10 нуугдмал хэрэг байдаг[3] гэж үздэг. Доктор Ц.Цэлмэг[4] Байгаль орчны эсрэг зөрчил 1 жилд 15000 орчим бүртгэгдэж байгаагийн 20% орчим нь гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй байхад эрүүгийн хэрэг үүсгэхгүйгээр захиргааны хариуцлага тооцсон, гааль дээр хураагдсан их хэмжээний амьтны эд, эрхтний тоо зэргээс хүрээлэн буй орчны эсрэг нэг хэргийн цаана 50 орчим гэмт хэрэг нуугдмал байна гэж тодорхойлжээ. Хэдийгээр манай улсад нуугдмал гэмт хэргийн гаралтыг хэмжих бодитой, шалгарсан аргачлал одоо хэр байхгүй байгаа ч нуугдмал гэмт хэргийн гаралтын түвшинг судалгааны хэд хэдэн арга ашиглаж тогтоох нь онол-практикийн чухал ач холбогдолтой юм. Тодорхой төрлийн

1 Ан агнуурын хууль тогтоомж зөрчих гэмт хэргийн нөхцөл байдлын судалгаа (2002-2014). М.Эрдэнэбаяр
2 В.В.Панкратов. Косвенные методы изучения преступности В сб: Вопросы борьбы с преступностью. М.,1967, 9 дэх тал.
3 Ц. Цэлмэг. Байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдаж буй асуудал. Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын хэрэгжилт, чиг хандлага. //Олон улсын эрдэм шинжилгээний хурал. Эмхэтгэл. УБ., 2013. 35 дахь тал.
4 Мөн тэнд.

гэмт хэргийг задлан шинжилж, судлахад түүний тухай бүх мэдээллийг заавал авах шаардлагагүй, хамгийн гол нь тэдний мөн чанарыг танин мэдэх, үр нөлөө бүхий арга замыг олох нь чухал. Хууль бусаар ан агнах, амьтны эд эрхтэн худалдаалах гэмт хэргийн гаралтын түвшнийг тогтооход дараах тулгуур баримтуудад түшиглэн дүгнэлт гаргах нь зүйтэй. Үүнд:

- Тухайн нутаг дэвсгэрийн нэгжид гарч байгаа гэмт хэргийн гаралтын бүртгэгдсэн статистик мэдээ, гэмт хэргийн бүтэц, шинж, нийгмийн аюулын хэмжээ;
- Гэмт хэргийн шалтгаан нөхцөл, нийгэмд учруулж буй хор хохирол;
- Хууль хяналтын байгууллагуудын мэдээ баримт, дүн шинжилгээ;
- Нутаг дэвсгэрийн иргэдийн санал, асуулга;
- Нутаг дэвсгэрийн байгаль, газар зүйн онцлог, амьтдын судалгаа, шинжилгээ;
- Нутаг дэвсгэрийн засаг захиргааны нэгжийн зохион байгуулалт, хүн амын нягтрал суурьшил, харилцаа холбооны байдал, иргэдийн амьжиргаа, ажил хөдөлмөр эрхлэлт, зах зээл, худалдаа арилжааны сүлжээ;
- Гадаад болон дотоод дахь зах зээлийн эрэлт хэрэгцээ;
- Төр засгийн явуулж байгаа бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт, гэмт явдалтай тэмцэх иргэдийн нийгмийн идэвх;
- Гэмт явдлын өөрчлөлтөд хийсэн урьдчилсан дүгнэлт;
- Ардын уламжлал, зан үйл, хэв шинж зэрэг олон талын судалгаанд тулгуурлан гэмт хэргийн гаралтыг тогтоох нь илүү бодитой байх болно.

ХУУЛЬ БУСААР АН АГНАХ ГЭМТ ХЭРГИЙГ МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ

Хичээлийн товч танилцуулга, нэр томьёоны тайлбар

Хамрах хүрээ	Цагдаагийн алба хаагчид	Сургалтын хэлбэр	Лекц
Сургалт явуулах газар	Сургалтын танхим (заал)	Хугацаа	4 цаг
Хичээлийн товч танилцуулга	Суралцагчдад хууль бусаар ан агнах гэмт хэргийг мөрдөн шалгах зарим ажиллагааны онцлог болох мэдээллийн эх сурвалж, мэдээлэл олж авах ажиллагаа, хойшлуулшгүй ажиллагааг тайлбарлан, ойлгуулах, мэдлэгийг суралцагчийн оролцооны аргаар хамтран бүтээх		
Сургалтын арга зүй	Суралцагчийн оролцооны аргууд: тонгоруу анги, өөрөөр нь яриулах, эерэг ба сөрөг байдлаар дүгнүүлэх болон тайлбарлан ойлгуулах, сонсгож таниулах		
Хичээлийн товч агуулга			
• Хууль бусаар ан агнах гэмт хэргийг илрүүлэх мэдээллийн сурвалж • Гэмт хэргийн мэдээлэл олж авах ажиллагаа • Гэмт хэргийн хойшлуулшгүй ажиллагаа			
Сургалтын хэрэглэгдэхүүн	- Цахим танилцуулга - Фондын лекц - Хичээлийн хөтөлбөр, нэгж хичээлийн удирдамж - Бусад		

Нэр томьёоны тайлбар		
Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авах	**Хойшлуулшгүй тохиолдол**	**Үндэслэл бүхий сэжиг**
Мөрдөгч, прокурор дараах тохиолдолд гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч шалгана: - хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас гэмт хэргийн талаар гомдол гаргасан, эсхүл мэдээлсэн; - гэмт хэргийн шинжийг өөрөө шууд илрүүлсэн; - гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийгөө илчилж ирсэн. Мөрдөгч, прокурор гэмт хэрэг үйлдсэн, үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай гомдол, мэдээллийг хүлээн авах үүрэгтэй.	Хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах, сэжигтэн, яллагдагч оргон зайлах, хэргийн ул мөр, эд мөрийн баримт устах, зөөвөрлөх, нуун далдлах, үрэгдэх бодит аюул байгаа тохиолдолд хойшлуулшгүй ажиллагаа явуулна.	Цагдаагийн алба хаагч өөрт ил болсон тодорхой үйл явдал, мэдээ баримт, тухайн нутаг дэвсгэрийн онцлог, гэмт хэрэг, зөрчлийн гаралтын түвшин, сэжигтэй хүн, хуулийн этгээдийн байдал, үйл ажиллагаа зэргийг үнэлэн энэ хуульд заасан ажиллагааг гүйцэтгэх шаардлагатай гэх дүгнэлтэд хүрэх нөхцөл байдлыг ойлгоно.

Сэдвийн хүрээнд боловсруулсан хяналтын асуулт, гэрийн даалгавар, бие даалтын сэдэв, агуулга	Хяналтын асуулт
	• Мэдээллийн эх сурвалжийг нэрлэнэ үү? • Мэдээлэл олж авах идэвхтэй үйлдэл гэж юуг ойлгох вэ?
	Бие даалтын сэдэв, агуулга
	Мэдээлэл олж авахад дэвшилтэд техник, технологи ашиглах асуудал

Сургалтын үйл ажиллагаа

№	Үе шат	Багшийн үйл ажиллагаа	Хугацаа мин	Суралцагчийн үйл ажиллагаа	Анхаарах зүйл
1	Сэргээн санах буюу мэдлэгийг үнэлэх	Суралцагчидтай мэндчилж, өөрийгөө танилцуулна. Хичээлийн агуулгын талаар суралцагчдын үзэл хандлагыг асуулт асуух хэлбэрээр тодорхойлж, тэдний мэдлэгийн хүрээг тодорхойлно.	8	Багшийн дэвшүүлсэн асуудлыг шийдвэрлэх, ойлголт, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх	Хэлэлцүүлгийг хичээлийн сэдэвтэй уялдуулан чиглүүлэх, сэдвийн хүрээнээс гаргахгүй байх

2	Шинэ мэдлэг олгох үе шат	Урьдчилан бэлтгэсэн слайд дээр тулгуурлан лекцийг явуулахдаа суралцагчдын идэвхийг өрнүүлэх, сэдэл хэрэглэнэ.	40	Хичээлээр олж авсан өөрийн ойлголт, шинэ мэдлэгээ тэмдэглэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх	Лекцийн агуулгыг ойлгож буй эсэхэд анхаарах
3	Бататгах үе шат	Шинэ мэдлэгийг жишээ дээр тайлбарлах	10	Өөрийн зүгээс үзсэн сэдэвтэй холбоотой жишээ гаргах, түүнийг холбож тайлбарлах	Ярилцлагыг чиглүүлэх, дүгнэлт бичүүлж, бусдад нь сонсгох
4	Гэрийн даалгавар	Үзсэн хичээлийн сэдэвтэй холбоотой олж авсан мэдлэгээ бататгах үүднээс холбогдох материал уншиж судлах даалгавар өгнө.	2	Үзсэн сэдвийн хүрээнд уншсан ном, зохиол, сурах бичгээс товчлол бичих	
5	Дүгнэлт		Сургалтын үед гарсан амжилт, дутагдлыг тооцож, дараагийн сургалтад анхаарах, нэгж хичээлийн удирдамж, бэлдсэн лекц, заах арга зүйг баяжуулах		

Лекцийн товч агуулга

Энэ сэдэвт хууль бусаар ан агнах гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, мэдээллийн эх сурвалжийг тодорхойлох талаар ойлголт өгнө.

Аливаа гэмт хэрэг мөрдөхөд мөрдөгч нарт эн тэргүүнд чиглэл, баримжаа авах, үр ашигтай, жишиг зөвлөмж буюу мөрдөн шалгах аргачлал чухал шаардлагатай. Зөвлөмж нь практикаас урган гарсан, түүгээр дамжин туршсан шинжлэх ухааны үндэслэлтэй байдгаараа чухал ач холбогдолтой байдаг.

Мэдээллийн эх сурвалж

Ерөнхий зүйл. Хууль бусаар ан агнах гэмт хэргийг илрүүлэхэд мэдээллийг хаанаас олж авах, түүний эх сурвалжийн талаар мэдлэг олж авна.

Хууль бусаар ан агнах гэмт хэрэг ихэвчлэн ой тайга, хээр тал зэрэг хүний нүднээс далд газар оронд үйлдэгдэг учир тэр бүр илрэх боломжоор бага байдаг. Тийм учраас энэ гэмт хэргийн мэдээллийг олж авахаар идэвхтэй үйл ажиллагаа явуулах нь зүйтэй.

Аливаа гэмт хэргийн талаарх мэдээллийг урсгалаараа аяндаа ирнэ гэж гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагын ажилтан алгуурлан, хүлээн сууж хэрхэвч болохгүй. Мэдээллийг янз бүрийн эх сурвалжаас авч болох бөгөөд доорх мэдээллийн эх сурвалж нь хууль бусаар ан агнах гэмт хэргийг илрүүлэх боломжийн нэгээхэн хэсэг юм.

Мэдээллийн эх сурвалжид дүн шинжилгээ хийж, ашиглах нь энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхэд чухал ач холбогдолтой. Мэдээллийн эх сурвалжуудаас дурдвал:

- Тухайн орон нутгийн иргэд
- Мэдээлэгчид
- Цэргийн алба хаагчид
- Хууль хэрэгжүүлэгч бусад байгууллага, тэдгээрийн ажилтнууд (мэргэжлийн хяналт, гаалийн байцаагч, байгаль хамгаалагч нар)
- Зар сурталчилгаа ба мэдээлэл
- Мэдээлэл олж авахын тулд хууль сахиулах байгууллагын ажилтны явуулж байгаа идэвхтэй үйлдэл, үйл ажиллагаа (ажиглалт, эргүүл хяналт шалгалт) зэрэг болно.

Нутгийн иргэд

Байгалийн баялаг, ан амьтныг хамгаалах хүсэл эрмэлзэл ихэнх иргэдэд байдаг. Тэд оршин суугаа газрынхаа байгалийг хамгаалах, тэнд гарч буй хууль бус үзэгдлийн талаар өөр хоорондоо ярилцаж, зарим нь хууль хяналтын байгууллагад хүртэл гомдол, мэдээлэл гаргаж байдаг.

Ам дамжсан “хууль бус үйлдэл”-ийн тухай яриа нь нарийн тодорхой мэдээлэл болохгүй ч тэдгээр нь мөрдөх ажлын эхлэл болох төдийгүй, тухайн гэмт хэргийн гаралтыг тодорхойлох чиг баримжаа болдог.

Нутгийн иргэдийн өгсөн мэдээлэл бүрийн учиг сэжүүрийг сайтар нягт шалгах шаардлагатай.

Мэдээлэгчид[1]

Мэдээлэгчид гэдэг нь «нууц ажилтан»-ууд биш, зөвхөн хууль тогтоомжид заасны дагуу байгаль орчны хэрэг зөрчлийг илрүүлэхэд мэдээлэл өгч, хууль хяналтын байгууллагад туслалцаа үзүүлж байгаа иргэд юм.

Ийм мэдээлэгч нарт ан амьтныг хууль бусаар агнах, эд эрхтнийг худалдаалдаг гэмт этгээдүүдийн тухай олон чухал мэдээлэл байдаг. Гэвч тэдний өгч байгаа мэдээлэлд бүрэн төгс итгэж болохгүй. Учир нь буруу ташаа, хэтрүүлэгтэй, худал байж болзошгүйг анхаарахын зэрэгцээ мэдээллийн нууцлалыг хамгаалах шаардлагатай.

Цэргийн алба хаагчид

Цэргийн анги, салбарууд үүрэгт ажлынхаа онцлогоос шалтгаалан янз бүрийн газар нутагт шилжин байршиж ажилладаг. Харуул манаа болон бусад ажил үүрэг гүйцэтгэх явцдаа хууль бусаар ан агнах, амьтны эд, эрхтнийг худалдаалах, тээвэрлэх үйлдлүүдийг харж үзэж болно.

1 “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 34.4-т “Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн, түүнчлэн зөрчлийг илрүүлсэн, илрүүлэхэд бодиттой туслалцаа үзүүлсэн иргэнд зөрчил гаргагчид ноогдуулсан торгууль, нөхөн төлбөрийн орлогын дүнгийн 15 хувьтай тэнцэх мөнгөн урамшууллыг сум, дүүргийн засаг дарга олгоно.” //Төрийн мэдээлэл. 1995. № 5-6.



Ялангуяа, хил хамгаалах байгууллага улсын хилийн бүсийг хамгаалах явцдаа ан амьтныг хамгаалах үүргийг давхар хариуцдаг бөгөөд хууль бусаар ан агнах үйлдлийг илрүүлэх боломжтой байдаг.

Хууль хэрэгжүүлэгч бусад байгууллагууд

(Мэргэжлийн хяналт, байгаль орчин, гааль, гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн байгууллага г.м) Хууль хэрэгжүүлэгч бусад байгууллагууд болон яам, агентлаг, нутгийн удирдлагын байгууллагууд төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ янз бүрийн мэдээлэлтэй болсон байдаг.

Ялангуяа, мэргэжлийн хяналт, гааль, байгаль хамгаалагч нар амьтны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавихдаа гэмт хэрэг, зөрчилтэй таарах, энэ чиглэлийн мэдээлэл олох магадлал тун өндөртэй.

Мэдээлэл олох болон энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр байгууллага хоорондын хамтын ажиллагааны хүрээнд анхаарах асуудлын талаар «Хамтын ажиллагаа» гэсэн бүлэгт тодорхой дурдсан болно.

Зар сурталчилгаа ба мэдээлэл

Мэдээллийн эх сурвалжийн нэг нь зар сурталчилгаа юм. Зар сурталчилгааны тухай хуулиар нэн ховор, ховор амьтны эд эрхтнийг худалдаалах талаар зар

явуулахыг хориглосон хэдий ч энэ төрлийн зар[1] сонин хэвлэл, телевиз, радио, интернэт болон мэдээллийн бусад хэрэгслээр цацагдсан хэвээр л байна.

Өнөө үед мэдээллийн хэрэгслээр явагдаж байгаа зар сурталчилгаа нь хүмүүсийн харилцааны чухал нэгэн хэрэглүүр болжээ. Зар сурталчилгааны мэдээлэл нь хууль бусаар амьтны эд, эрхтэн худалдаалдаг цэг, байршил, гэмт этгээдүүдийг илрүүлэхэд нэмэр өгөх тохиолдол бий.

Мэдээлэл олж авах үйл ажиллагаа

Гэмт хэргийн шинжтэй мэдээлэл олж авахын тулд хууль сахиулах байгууллагын алба хаагчдын өөрсдийн идэвхтэй үйлдэл, үйл ажиллагаа чухал ач холбогдолтой. Уг үйл ажиллагааг цагдаагийн байгууллагын алба хаагч нь өөрөө биечлэн болон гэмт хэрэгтэй тэмцэх үүрэг бүхий бусад алба хаагчид, нутаг дэвсгэр хариуцсан албадтай хамтран тодорхой зорилго, зорилт бүхий ажил, арга хэмжээ зохион явуулж болно. Тухайлбал, эргүүл, хяналт, шалгалт г.м.

Цагдаагийн байгууллага бусад байгууллага, ард иргэдийн оролцоотойгоор эсвэл дангаараа нэгдсэн, бүсчилсэн, хэсэгчилсэн эргүүл, хяналт шалгалтын ажиллагааг идэвхтэй зохион явуулдаг ба түүнд хяналт[2] тогтоох нь гэмт хэргийг илрүүлэх, мэдээллийг олж авах эх сурвалжийн нэг болдог.

1 Зар сурталчилгааны тухай хуулийн 14.1-д “Нэн ховор, ховор ургамал, амьтны жагсаалтад орсон болон тэдгээрийн үндэс, иш, мөчир, навч, бугын цусан эвэр, чив, засаа, согоогны сүүл, сав, хүдрийн заар, баавгайн донъд зэрэг зарыг бэлтгэх, худалдах, худалдан авах тухай зар сурталчилгааг хориглоно”.

2 Цагдаагийн албаны тухай хуулийн 11.1.2-д 11.1.2.гудамж, талбай болон нийтийн эзэмшлийн бусад газарт эргүүл хийх, байгууллагаатай хянаж-нэвтрүүлэх цэг ажиллуулах дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, бусад арга, техник хэрэгсэл ашиглан хяналт тавих;

Хяналт шалгалт, эргүүл хийхэд хамгийн энгийн арга нь ажиглалт юм. Ажиглалт бол гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй газар орон, нөхцөл байдал, хөдөлгөөн, сэжигтэй хүнийг харах, сонсох, харьцуулах үйл ажиллагаа юм. Энэ Сэдэвт дурдаж буй ажиглалт нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу явагдаж буй мөрдөн шалгах ажиллагааны энгийн болон нууц ажиглалт биш болохыг анхаарна уу!

Ажиглалт нь хүн, эд зүйл, түүний байрлал, объектод орох, гарах хөдөлгөөнийг илрүүлэх, ажлын зураг авах, сэжигтэн, зөрчил гаргагчийг гэмт үйлдэлд нь барих зэрэгт тусалдаг, цаг хугацаа нэлээд зарцуулдаг үйл ажиллагаа боловч маш олон мэдээллийг танд өгнө.

Ажиглалтын аргыг явуулж байгаа хэлбэрээс нь шалтгаалан “хяналтын цэгээс”, “явган явах”, “агаарын, автомашинт, завь, бусад техник хэрэгслийн”, “мэдээллийн” гэх мэт төрлүүдэд ангилж болох боловч энэ нь цаашид нэмэгдэж ч болно.

а *Хяналтын цэгээс ажиглах.* Ажиглалтын энэ аргыг нийтийг хамарсан газарт эсвэл өндөрлөг газраас тухайн нутаг дэвсгэрийг алба хаагч биечлэн болон техник хэрэгсэл ашиглан ажиглаж болно. Цагдаагийн пост, цэг нь ажиглалтын энэ аргын нэг хэлбэр бөгөөд дүрс бичлэг, гэрэл зургийн хэрэгсэл ашиглаж болно. Жишээлбэл, орон нутгаас нийслэлд орох төв зам, худалдааны зах зэрэг газруудад хяналтын камер байрлуулах эсвэл бусад байгууллагын техник хэрэгсэл ашиглаж болно.

б *Явган явж ажиглах.* Энэ арга нь байрандаа ажиглахтай адил олон хүн цуглардаг болон зах худалдааны газруудад ашиглахад тун тохиромжтой. Тэнд болж буй үйл ажиллагааг (энгийн хувцастайгаар) илээр ажиглахаас гадна, тухайн зах дээр хууль бус худалдаа наймаа хийдэг эсэх талаар өөр төрлийн наймаа хийдэг танил худалдаачин, бусад хүмүүсээс тодруулах, үйлчлүүлэгч болж үзэх зэрэг аргуудыг ашиглаж болно. Энэ нь хэрэг мөрдөхөд туслах олон чухал мэдээллийг өгнө. Гэхдээ албаны дүрэмт хувцастай хийх нь тийм ч үр дүнтэй бус.

в *Завиар явж ажиглах.* Завиар явж ажиглах аргыг гол мөрөнд ашиглана. Амьтан агнах хориотой улирлын үед голд завиар эргүүл, хяналт хийх нь эргийн ойролцоо болж буй аливаа үйл явцыг харах, загасчилж байгаа хүмүүс рүү чимээ багатайгаар ойртоход дөхөмтэй. Эргүүл, хяналт шалгалтаар яваа алба хаагчдын тээврийн хэрэгсэл (машин, мотоцикл)-ийн дуу чимээгээр голын эрэг орчимд хууль бус үйлдэл хийж байгаа этгээдүүд зугтах, эд мөрийн баримтыг нуух бололцоог олгодог учраас түүнээс сэргийлнэ.

Агаарын ажиглалт ба завь, явган ажиглалт

г *Агаарын ажиглалт.* Хүний хүч хөдөлмөр хөнгөвчилсөн, өртөг зардал бага, цаг хугацаа хэмнэсэн үр дүнтэй, ажиглалтын нэг төрөл юм. Эргүүл, хяналт шалгалт явуулах бололцоо боломж муутай газарт хууль бусаар мод бэлтгэх, агнуурын отог, түүний байршил, зам харгуй зэргийг тогтоох, гэмт этгээдүүдийн үйлдлийг баримтжуулах, таслан зогсоох, отолт хийх газрыг сонгох, богино хугацаанд хяналтыг үр дүнтэй зохион байгуулах, газар орны нөхцөл байдлыг судлах зэрэг олон талын ач холбогдолтой. Агаарын ажиглалт явуулахад бага оврын нисэх онгоц (1-2 хүний), нисгэгчгүй нисдэг төхөөрөмж (дрон) зэрэг хэрэгслийг цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэхэд ашиглах өргөн боломж бий.

д *Авто машинт ажиглалт.* Эргүүл, хяналт шалгалт явуулахад ашиглаж буй гол тээврийн хэрэгсэл одоогоор автомашин болж байна. Цагдаагийн байгууллагад “хөдөлгөөнт эргүүл” нэртэй автомашинт эргүүлээр иргэдийн хөдөлгөөнд ажиглалт, урьдчилан сэргийлэх ажлыг явуулж байгаа нь ажиглалтын нэг төрөл юм.

ж *Мэдээллийн ажиглалт.* Мэдээлэл хүний амьдралын салшгүй нэг хэсэг болжээ. Ялангуяа, фейсбүүк, твиттер, мэйл, мессенжер гэх мэт цахим мэдээлэл маш чухал. Цахим мэдээлэлд хяналт тавих нь чухал болж буй өнөө үед технологийн дэвшилтэт үр дүнтэй техник хэрэгслүүдийг ашиглах нь зүйтэй.

Аливаа эргүүл, хяналт шалгалт явуулахдаа мөрдөгч нь суурь судалгаа, төлөвлөлтийг урьдчилан гаргаж байх нь цаг хэмнэх, эрсдэлийг багасгахад тусална. Төлөвлөгөө уян хатан байх ёстой төдийгүй зохион байгуулах ажлыг үр дүнтэй, эрсдэлгүй болгох эхний алхам юм.

Төлөвлөлтөд объектын судалгааг ашиглах, хяналт шалгалт явуулах газар нутгийн масштаб зургийг гаргах, зам харгуй, орчны байдал, айл өрхийн суурьшил болон тухайн цаг үеийн нөхцөл байдал, цаг агаар, улирлын байдлыг тодорхойлох, түүнд тохируулан хамтран ажиллах байгууллага, хүн хүч, техник хэрэгслийн тооцоо зэргийг урьдчилан гаргах нь зүйтэй.

Эргүүл, хяналт шалгалтыг хөдөө орон нутагт явуулахаас гадна, төв суурин газар, худалдаа наймааны зах, цэгүүдэд шалгалт явуулах, хяналт тогтоох нь гэмт хэргийн талаарх мэдээлэл олж авах эх сурвалжийн нэг болно.

Зах худалдааны газруудад хууль бусаар агнасан амьтны эд эрхтний худалдаа ихэвчлэн нууц далд явагддаг тул худалдаа, наймаа эрхлэгч нартай уулзаж

хэлхээ холбоо тогтоох, мэдээлэл олж авахдаа албаны хүн гэдгээ мэдэгдэх эсвэл мэдэгдэхгүйгээр харилцах нь тухайн үеийн нөхцөл байдлаа зөв үнэлж гаргах таны шийдвэр юм. Амьтны эд эрхтнийг худалдан авах, зарах, хадгалах нь өөрөө гэмт хэрэг тул наймаачидтай тун болгоомжтой хандах нь чухал.

Хойшлуулшгүй ажиллагаа

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд **“хойшлуулшгүй тохиолдол”** гэж хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах, сэжигтэн, яллагдагч оргон зайлах, хэргийн ул мөр, эд мөрийн баримт устах, зөөвөрлөх, нуун далдлах, үрэгдэх бодит аюул байгааг гэж тайлбарласан байдаг.

Түүнчлэн мөрдөгч гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хянан үзээд гэмт хэргийн шинж байгаа эсэхийг тогтоох шаардлагатай бол гомдол, мэдээллийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор мөрдөн шалгах ажиллагаа явуулж болно гэж заажээ.

Тийм учраас гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийг мөрдөгч шалгахдаа үзлэг хийх, шинжилгээнд зориулж дээж, хурууны хээ, ул мөрийн хэв авах, гэрчээс мэдүүлэг авах, хэрэгт ач холбогдол бүхий тээврийн хэрэгсэл, мөнгө, эд зүйлийг хураж авах, эд хөрөнгийг битүүмжлэх ажиллагааг хойшлуулшгүйгээр гүйцэтгэнэ.

Хойшлуулшгүй ажиллагааны хүрээнд чухалчлан авч үзэх хэд хэдэн ажиллагаа, зарим анхаарах асуудлуудын талаар дурдахад:

а Амьтны эд эрхтэн худалдан борлуулж байгаа эсвэл сэжигтэй тээврийн хэрэгсэл, ачаа тээш, хүний биед үзлэг хийхэд анхаарах.

б Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийг шалгахдаа хэрэг, учрал болсон гэх тэрхүү газрын ойр орчмын айлын хүмүүсээс тухайн нутаг газарт ан агнахаар хүмүүс явж байсан эсэх, буун дуу гарсан эсэх зэрэг талаар асуун сураглаж, тэдгээр иргэдээс тайлбар гаргуулах. Ялангуяа, тухайн газрын байгаль хамгаалагч, тусгай хамгаалалтын газар нутгийн байцаагч зэрэг хүмүүсээс ажиглалт судалгаа хийсэн байдал, сэжигтэй зүйл илэрсэн эсэх талаар нарийн тодруулж асууна. Байгаль хамгаалагч нар өдөр бүр хариуцсан нутаг дэвсгэртээ ан амьтдын байршил, нутагшил, хужир мараанд ирдэг цаг хугацаа, үр төл, мөр, баас зэрэгт ажиглалт судалгаа явуулах үүрэгтэй бөгөөд энэ талаараа тэмдэглэл бичдэг, энэ тэмдэглэл нь нотлох баримт ч болж болзошгүйг анхаарах хэрэгтэй.

в Хойшлуулшгүй ажиллагааны хүрээнд ан амьтан агнасан хугацааг тодорхойлж чадвал тухайн газраас тээврийн хэрэгсэлтэй хүмүүс хэдий хугацаанд хэр их зайтай газарт холдож болох зэргийг судлан үзэж замын постууд болон зах худалдааны газрууд, тодорхой нутаг дэвсгэр, орон байранд нэвтрэн орох гарахад хяналт тогтоож болно.

г Хэргийн газарт үзлэг явуулж, түүгээр илэрсэн эд зүйлд криминалистикийн болон бусад шинжилгээнд зориулж дээж, ул мөрийн хэв авч болно. Хэргийн газарт үлдсэн амьтны сэг зэм, эвэр туурай зэргээс тухайн амьтан ямар зүйлийн амьтан болох, нас, хүйсийг тодорхойлох зорилгоор дээж авч, шинжилгээнд хүргүүлэхдээ зохих технологи журмыг сайтар баримтлах нь зүйтэй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.7 дугаар зүйлд зааснаар гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хянан үзээд гэмт хэргийн шинж байгаа эсэхийг тогтоох зорилгоор үзлэг хийж болохыг хуульчилсан бөгөөд энэ үзлэг нь гэмт хэргийн халуун мөрөөр орох боломжтой, аль эсхүл ул мөр баларч болзошгүй тодорхой мэдээ, мэдээллийн мөрөөр уг ажиллагааг шуурхай явуулах шаардлага юм.

Үзлэгийг хэрэг гарсан газар болон эд зүйлд хийх бөгөөд энэ талаар «Үзлэг» гэсэн хэсэгт дэлгэрэнгүй авч үзсэн болно.

НОТЛОХ БАРИМТ БҮРДҮҮЛЭХ ТАКТИКИЙН АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Хичээлийн товч танилцуулга, нэр томьёоны тайлбар

Хамрах хүрээ	Цагдаагийн алба хаагчид	Сургалтын хэлбэр	Лекц
Сургалт явуулах газар	Сургалтын танхим (заал)	Хугацаа	4 цаг
Хичээлийн товч танилцуулга	Суралцагчдад хууль бусаар ан агнах гэмт хэргийг нотлох зарим ажиллагааны онцлогийг тайлбарлаж, ойлгуулах, мэдлэгийг суралцагчийн оролцооны аргаар хамтран бүтээх		
Сургалтын арга зүй	Суралцагчийн оролцооны аргууд: тонгоруу анги, өөрөөр нь яриулах, эерэг ба сөрөг байдлаар дүгнүүлэх болон тайлбарлан ойлгуулах, сонсгож таниулах		
Хичээлийн товч агуулга			
• Хууль бусаар ан агнах гэмт хэргийн нотлох ажиллагаа • Нотлох ажиллагааны төрөл болох үзлэг • Хэргийн газрын болон эд мөрийн баримт, тээврийн хэрэгсэл, галт зэвсэгт хийх үзлэг • Үзлэгийг бэхжүүлэх • Хууль бусаар ан агнах гэмт хэргийг мөрдөх ажиллагаа • Эд мөрийн баримт хураан авах, хадгалах онцлог, биологийн гаралтай эд эрхтнийг хураан авах • Шинжилгээ явуулах, амьтны үхлийн шалтгаан, эд эрхтэнд хийх шинжилгээ, амьтны үс шинжлэх, шинжилгээгээр тогтоох асуулт • Хэргийн гэрч, сэжигтэн, яллагдагч нартай харилцах, ярилцлагын арга техник, хууль сахиулагчийн ёс зүй			

Сургалтын хэрэглэгдэхүүн	- Цахим танилцуулга - Фондын лекц - Хичээлийн хөтөлбөр, нэгж хичээлийн удирдамж - Бусад	

Нэр томьёоны тайлбар		
Үзлэг	**Хэргийн газрын үзлэг**	**Эд мөрийн баримт**
Мөрдөгч гэмт хэрэг гарсан байдал, хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлыг тогтоох, тодруулах зорилгоор хүний бие, эд зүйл, баримт бичиг, тээврийн хэрэгсэл, ачаа тээш, мал, амьтан, хэрэг гарсан газарт үзлэг хийнэ.	Мөрдөгч гэмт хэрэг үйлдэгдсэн, үйлдэгдсэн байж болзошгүй гэх бодит үндэслэл байгаа бол хэргийн нотлох баримтыг олж тогтоох, хэрэгт ач холбогдол бүхий байдлыг тодруулах зорилгоор орон байр, бусад газар, нийтийн эзэмшил газрын тодорхой хэсгийг хэргийн газраар тогтоон үзлэг хийнэ.	Эд мөрийн баримтад гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн тээврийн хэрэгсэл, уналга, зэвсэг, хэрэгсэл, гэмт үйлдлийн замаар олсон мөнгө, үнэ бүхий зүйл, бусад эд зүйлс, гэмт хэргийн ул мөр үлдсэн, агуулсан түүнчлэн гэмт хэрэг, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг илрүүлэх, хэргийн бодит байдлыг тогтоох, эсхүл сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм бурууг үгүйсгэх, эсхүл хөнгөрүүлэхэд ач холбогдол бүхий бичмэл болон цахим баримт, бусад эд зүйлийг тооцно.
Сэдвийн хүрээнд боловсруулсан хяналтын асуулт, гэрийн даалгавар, бие даалтын сэдэв, агуулга	Хяналтын асуулт	
	Хэргийн газрын үзлэг хийхэд анхаарах ямар асуудлууд байдаг бэ? Биологийн гаралтай эд мөрийн баримт хураан авах онцлог юу бэ? Сэжигтэнтэй ярилцах аргуудыг нэрлэ.	
	Бие даалтын сэдэв, агуулга	
	Хэргийн газрын үзлэгийг явуулахад анхаарах асуудал Амьтны эд эрхтэнд шинжилгээ хийх, шинжээчээс асуух асуулт, агуулга, хэлбэр Ярилцлага явуулах арга техник	

Сургалтын үйл ажиллагаа

№	Үе шат	Багшийн үйл ажиллагаа	Хугацаа мин	Суралцагчийн үйл ажиллагаа	Анхаарах зүйл
1	Сэргээн санах буюу мэдлэгийг үнэлэх	Суралцагчидтай мэндчилж, өөрийгөө танилцуулна. Хичээлийн агуулгын талаар суралцагчдын үзэл хандлагыг асуулт асуух хэлбэрээр тодорхойлж, тэдний мэдлэгийн хүрээг тодорхойлно.	8	Багшийн дэвшүүлсэн асуудлыг шийдвэрлэх, ойлголт, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх	Хэлэлцүүлгийг хичээлийн сэдэвтэй уялдуулан чиглүүлэх, сэдвийн хүрээнээс гаргахгүй байх
2	Шинэ мэдлэг олгох үе шат	Урьдчилан бэлтгэсэн слайд дээр тулгуурлан лекцийг явуулахдаа суралцагчдын идэвхийг өрнүүлэх, сэдэл хэрэглэнэ.	40	Хичээлээр олж авсан өөрийн ойлголт, шинэ мэдлэгээ тэмдэглэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх	Лекцийн агуулгыг ойлгож буй эсэхэд анхаарах
3	Бататгах үе шат	Шинэ мэдлэгийг жишээ дээр тайлбарлах	10	Өөрийн зүгээс үзсэн сэдэвтэй холбоотой жишээ гаргах, түүнийг холбож тайлбарлах	Ярилцлагыг чиглүүлэх, дүгнэлт бичүүлж, бусдад нь сонсгох
4	Гэрийн даалгавар	Үзсэн хичээлийн сэдэвтэй холбоотой олж авсан мэдлэгээ бататгах үүднээс холбогдох материал уншиж судлах даалгавар өгнө.	2	Үзсэн сэдвийн хүрээнд уншсан ном, зохиол, сурах бичгээс товчлол бичих	
5	Дүгнэлт		Сургалтын үед гарсан амжилт, дутагдлыг тооцож, дараагийн сургалтад анхаарах, нэгж хичээлийн удирдамж, бэлдсэн лекц, заах арга зүйг баяжуулах		

Лекцийн товч агуулга

“Нотлох ажиллагаа” нь хуулийн зорилгыг хангах, зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд хуульд тогтоосон үндэслэл, тодорхойлсон журмын дагуу, үүрэгжсэн

байгууллагын үүрэг бүхий албан тушаалтнаас хуулийн дагуу хэрэгжүүлж байгаа өөр хоорондоо нарийн холбоотой иж бүрэн, цогц үйл явц байдаг гэж тодорхойлж болно. Үүний зорилго нь болж өнгөрсөн нөхцөл байдлын гагцхүү бодит үнэнийг тогтооход чиглэгдэнэ.

Үзлэг

Үзлэг нь нотлох баримт цуглуулах үндсэн арга болдог. Түүний зорилго нь хэрэг, зөрчлийн ул мөр, эд мөрийн бусад баримтыг илрүүлэх, бэхжүүлэх, хэрэг зөрчилтэй холбоотой бусад байдлыг шалгах, үнэлэх, тодруулах зорилгоор судлан үзэж буй бие даасан тодорхой ажиллагаа юм.

Өөрөөр хэлбэл, болж өнгөрсөн үйл явдлыг ойлгож мэдэх, түүнтэй холбоотой материаллаг зүйлийг илрүүлж, бэхжүүлэх зорилгоор хийгдэж буй танин мэдэхүйн шинж чанартай хэрэг, зөрчил шалгах ажиллагааны нэг хэлбэр юм.

Хэргийн газрын үзлэг

Мөрдөгч танд хэргийн газрын үзлэгээр юуг тодорхойлох, ямар үе шаттайгаар явагдах, үзлэгээр нотлох баримт яаж цуглуулах талаар дээд сургуульд үзэж байсан мэдлэгийг сэргээх зорилгоор товч ойлголтыг өгье гэж бодож байна.

Мөрдлөгийн анхан шатанд нотлох баримтыг илрүүлэхийн тулд хуульд заасан аливаа ажиллагааг явуулж болох боловч чухам аль ажиллагааг эхлэн хэрэгжүүлэх нь чухал болохыг мөрдөгч нөхцөл байдлаа үнэлэн өөрөө шийдвэрлэнэ. Хууль бусаар ан агнах гэмт хэргийг мөрдөх ажиллагаа бусад хэргийн нэг адил үйлдлийн арга, хэлбэр, цаг үе, үйлдсэн газар орчны байдлаас шалтгаалан өвөрмөц онцлогтой байдаг.

1 Хууль бусаар ан агнах ихэнх хэрэгт нэлээд хугацаа өнгөрсний дараа эрүүгийн хэрэг үүсгэгддэг. Учир нь энэ гэмт хэрэг хөдөө алс зэлүүд газарт үйлдэгддэг, үйлдэгдсэн даруйдаа тэр бүр цагдаагийн байгууллагад мэдээлэл ирдэггүй, ирсэн ч хугацаа алдаж ирдэг. Хэргийн тухай мэдээ хожуу хүлээн авч байгаагаас гэмт этгээдийг “халуун мөр”-өөр нь мөрдөх боломж багасдаг. Тийм учраас мөрдөн байцаалтыг цагдаагийн бусад албадтай хамтран өргөн хүрээтэй явуулах хэрэгтэй болдог.

2 Хууль бусаар ан агнах гэмт хэрэгт “хэргийн газар”-ын үзлэг явуулснаар гэмт хэрэгт хэчнээн хүн оролцсон, ямар чиглэлд явсан зэрэг хэрэгт ач холбогдолтой зүйлүүдийг тодорхойлж, нотлох баримтыг цуглуулна.

3 Үзлэгийн явцад эд мөрийн баримт илрүүлэн хураан авч хэргийг цаашид нотлоход ашиглах боломжтой. Иймд, мөрдөх ажиллагааны “анхан шатны ажиллагаа”[1]-ны үндсэн элементийн нэг болох нотлох баримтыг хойшлуулшгүйгээр цуглуулах, бэхжүүлэх ажиллагааны чухал хэлбэр болох хэргийн газрын үзлэг, түүний үүрэг, ач холбогдол, сэжигтэн этгээдийг эрэн сурвалжлах асуудлуудыг авч үзнэ.

Аливаа гэмт хэрэгт “хэргийн газрын үзлэг”-ийг зайлшгүй хийх шаардлагатай. Гэвч үзлэг явуулах боломжтой хэргүүд гэж байдаг бол хэргийн газрын үзлэг тэр бүр явуулаад байдаггүй хэрэг гэж байдаг. Тухайлбал, хүний амь насыг хохироох, бусдын эд хөрөнгийг хулгайлах хэрэгт “хэргийн газрын үзлэг”-ийг зайлшгүй явуулдаг бол албан тушаалын, татварын гэх хэрэгт тэр бүрийд хэргийн газрын үзлэгийг явуулах боломжоор хязгаарлагдмал, шаардлагагүй байдаг тул бусад байцаан шийтгэх тодорхой ажиллагаагаар нотлох баримтыг цуглуулах боломжтой. Харин хууль бусаар ан агнах гэмт хэрэг бол хэргийн газрын үзлэгийг явуулах боломжтой хэргийн нэг юм.

Хууль бусаар ан агнах гэмт хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн нийт гэмт хэргийн 29.7% нь хэргийн газрын үзлэг явуулж, нотолгооны ач холбогдолтой амьтны сэг зэмийн үлдэгдэл яс, үс, толгой, шийр, арьс, эвэр туурай зэрэг амьтны эд эрхтэн, түүнээс гадна сэжигтэн этгээдийн үлдээсэн сумны хонгио, хутга, тамхины иш зэрэг эд зүйлийг илрүүлж, эд мөрийн баримтаар хураан авчсан[2] байдаг. Гэвч хууль бусаар ан агнах гэмт хэргийн 70.3%-д үзлэг огт хийгээгүй байгаа нь түүний ач холбогдлыг дутуу үнэлж, мөрдөгч, прокурорууд мэдүүлэг, байцаалтад голчлон анхаарал хандуулж байна уу гэж үзэхэд хүргэдэг байна.

Хууль бусаар ан агнах гэмт хэргийг шууд үзсэн харсан гэрч гэж бараг байдаггүй. Гэмт хэргийн тухай мэдээлэл цагдаагийн байгууллагад хожуу ирдэг байдлаас шалтгаалан хэргийн газрын үзлэгийг халуун сэргэг дээр нь хийх боломж нөхцөлөөр тааруу байдаг ч “хэргийн газрын үзлэг”-ийн чанараас хэргийн хувь заяа ихээхэн хамааралтай байдаг.

Хууль бусаар ан агнах гэмт хэргийн “хэргийн газрын үзлэг” нь тухайн хэргийг мөрдөх үед нэн түрүүнд хийвэл зохих, үр нөлөө бүхий ажиллагааны нэг мөн бөгөөд хэрэг бүртгэлтийн анхан шатны ажиллагааны нэгээхэн хэсэг юм. Хууль бусаар ан агнах гэмт хэргийн “хэргийн газрын үзлэг” нь:

1 Анхан шатанд мөрдөн байцаагч дараах үндсэн зорилгыг шийдвэрлэнэ.
   1. Эрүүгийн хэрэг үүсгэх шийдвэр гаргах үед байсан баримтыг үндэслэн гэмт хэргийн үйл явдлын тухай ерөнхий нийтлэг таамаглал шалгах,
   2. Шинжлэх шаардлагатай үйл явдлыг тодруулах,
   3. Нотлох баримтыг хойшлуулшгүйгээр цуглуулах, бэхжүүлэх сэжигтэн этгээдийг эрэн сурвалжлах асуудлууд хамаарна. С.Будрагчаа, В.И.Комиссаров. Урьдчилсан мөрдөн байцаалтын шинжлэх ухааны үндэс. УБ., 1987. 27 дахь тал.

2 Ан агнуурын хууль тогтоомж зөрчих гэмт хэргийн нөхцөл байдлын судалгаа (2002-2014). М.Эрдэнэбаяр

- Хэргийн газарт үзлэгийг зохион байгуулах
- Нотлох баримт бүхий мэдээллийн эд мөрийн эх сурвалжийг эрж хайх
- Хэргийн газрын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, гэмт этгээдийн үйлдлийн арга, хэрэгтний дүр төрхийн зураглал хийх
- Үзлэгийн явцад цуглуулсан мэдээллийн үндсэн дээр эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулах[1]
- Хэргийн газрын үзлэг хийхэд техник хэрэгслийг ашиглах нөхцөл, хязгаар[2] зэрэг гол элементүүдээс бүрдэнэ.

Хууль бусаар ан агнах, амьтны эд эрхтнийг худалдаалах гэмт хэргийн мөрдөн байцаалтын үзлэг (хэргийн газрын)-ийг гэмт хэрэг гарсан нь баттай тогтоогдсон үед нотлох баримтыг олж илрүүлэх, цуглуулж бэхжүүлэх зорилгоор хийнэ. Учир нь зохих зөвшөөрөлтэйгөөр ч ан амьтныг агнаж, барьдаг тул аливаа амьтны сэг зэмийг хууль ёсны дагуу агнасан эсхүл хууль бусаар агнасан гэдгийг шалгах ажиллагааг урьдчилан хийхгүйгээр шууд үнэлэлт, дүгнэлт өгөх боломжгүй юм.

1 К.Бегалиев, В.И. Попов. Теоретические вопросы осмотра места происшествия. В кн: Вопросы борьбы с преступностью. Вып. 39. М., 1983. 60 дахь тал

2 “Мөрдөн байцаалтын хэргийн газрын үзлэг хийх онолын асуудалд дараах зүйлийг оруулж болох юм гэж үзсэн. Үүнд мөрдөн байцаалтын үзлэг хийх ойлголт, зорилт, түүний төрөл, хэргийн газрын үзлэгт оролцогчид болон тэдгээрийн роль, үзлэг хийх явцад мөрдөн байцаалт, шуурхай эрэн сурвалжлах болон бусад арга хэмжээнүүдийн харилцан холбоо, үзлэгийн явцад мөрдөн байцаалтын сэжиг таамаг дэвшүүлж шалгах ажлын шинж чанарыг тодорхойлж буй бодит нөхцөл байдлууд (үүний дотор сөрөг), хэргийн газрын үзлэг хийхэд техник хэрэгслийг ашиглах нөхцөл хязгаар болон бусад асуудлууд орно”. Хэргийн газрын үзлэг хийхэд анхаарах зарим асуудлууд. Н.Жанцан.//Социалист хууль ёс. сэтгүүл. 1987.№2. 27 дахь тал.

Гэхдээ ан агнахыг хориглосон газар эсхүл нэн ховор амьтан агнагдсан, түүний сэг зэм байвал түүнийг хэрэг гарсан газар гэж үзэж шууд үзлэг явуулах нь хойшлуулшгүй ажиллагаа болно[1]. Үзлэгийг хаанаас эхлэх, ямар зүйлүүдэд гол анхаарлаа хандуулж шалгах нь гэмт хэрэг гарсан газрын онцлогоос хамаарч харилцан адилгүй байна.

Гэмт хэргийн газрын үзлэгийг зөвхөн амьтан, хүн болон малын мөрийг судлах ажиллагаагаар хязгаарлах бус бусад нотлох зүйлийг олж тогтоох, эрэн хайх, гэмт хэрэгтний үйлдлийн шинж чанар, арга хэлбэрийг тодорхойлох нь үзлэгийн гол гогцоо асуудлын нэг мөн.

Хэргийн газрын үзлэгийг (а) бэлтгэл, (б) хэргийн газрын үзлэг явуулах, (в) төгсгөлийн гэсэн үе шаттайгаар явуулна.

Бэлтгэл үе шат

Гэмт хэргийн тухай мэдээллийг хүлээн авснаар дараах хэдэн асуудлыг тодруулах болон холбогдох зарим арга хэмжээг авна. Үүнд: хэзээ, хаана, ямар асуудал болсон, хэргийн газар ямар замаар очих зэрэг асуудлыг мэдээлэл өгөгчөөс болон жижүүрийн албанаас авна.

Гэмт хэргийн ул мөр арилж балрахаас урьдчилан сэргийлж, хэргийн газрын орчимд байгаа хүмүүст дураар явахгүй байхыг анхааруулах, хэрэв гэрч нар байгаа бол албаны хүмүүс очтол байлгах, нэр хаягийг нь авах, хэрэг гарсан газрыг хамгаалах зэрэг зөвлөмжийг мэдээлэгчид өгч ажиллана. Мөрдөгч нь хэргийн газрын үзлэг явуулахад шаардлагатай “Мөрдөгчийн цүнх”-нд байх иж бүрдлийг бүрэн хангаж, дүрс бичлэг, дуу хураагч, гэрэл зургийн хэрэгсэл, тэдгээрийн бүрэн ажиллагаа, зай, цэнэгийг шалгаж ажилд бэлтгэнэ.

Хууль бусаар ан агнах гэмт хэрэгт эд мөрийн баримтаар гол төлөв биологийн гаралтай эд зүйлс хураагддаг тул тэдгээрийг муутгахгүй, чанар байдлыг алдагдуулахгүй хадгалах зориулалтын цаасан уут, сав баглаа боодлыг урьдчилан бэлтгэнэ.

Энэ төрлийн гэмт хэрэг ихэвчлэн хээр тал, хөвч тайгад үйлдэгддэг учраас бартаа саад туулах чадвартай машин техникийг урьдчилан бэлтгүүлнэ.

1 Амьтны тухай Монгол Улсын хуулийн 7.2-д: “Нэн ховор амьтныг төрийн захиргааны төв байгууллагын тусгай зөвшөөрлөөр зөвхөн эрдэм шинжилгээний зориулалтаар агнаж барьж болно” гэсэн заалттай. //Төрийн мэдээлэл. 2012. №22 (739).

Хэргийн газрын үзлэг явуулах үе шат

Үзлэг нь нарийн төвөгтэй боловч хамгийн их үр дүн өгдөг мөрдөх ажиллагааны чухал төрөл төдийгүй мөрдөн байцаалтын анхны, хойшлуулшгүй ажиллагаа бөгөөд үзлэгийн энэ үе шатанд үйл явдал болсон шинж тэмдгийн бодит мөр, бусад мэдээллийг шууд эрж хайх, шинжлэх, хураан авах асуудлууд багтана.

Хууль бусаар ан агнах гэмт хэрэгт хийх үзлэгийг бусад гэмт хэрэгт хийх хэргийн газрын үзлэгтэй адил зарчмаар явуулж болох боловч бас өөрийн өвөрмөц онцлогтой. Тэдгээр зарим онцлогоос дурдвал;

Мэдээлэл өгсөн хүмүүсээс хэргийн нөхцөл байдлын талаар товч мэдээлэл авч хэргийн газрыг баримжаална.

Үзлэг явуулах орчны хил, үзлэг эхлэх цэгийг байршил заагчаар хөдөлбөргүй тогтоож, үзлэг явуулах дарааллыг тогтооно. Байршлыг нарийн тогтоох нь хэрэг болсон газар тусгай хамгаалалттай, эсвэл аль аймаг, сумын нутаг дэвсгэр болохыг тодорхойлох ач холбогдолтой бөгөөд энэ нь иргэний нэхэмжлэгчийг тогтоох, хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх зэрэг хэргийн зүйчлэлд шууд нөлөөлнө.

Амьтны мөр: ямар амьтны мөр, тухайн амьтан хэд байсан, өөр мөр холилдож орж ирсэн, тээврийн хэрэгслийн болон хэдэн хүн байсан, мөн орчны байр байдал, явсан чиглэл зэрэг олон мэдээллүүд авч болно.



Үзлэгийг объектив[1] хийж байгаа тохиолдолд их төлөв төвөөс эхлэн зах руу (эксцентрик) явуулах арга илүү үр дүнтэй. Учир нь мөрдөн байцаалтад ач холбогдол бүхий мөр, эд зүйлсийг ихээр илрүүлэн тогтоодог бөгөөд тухайн хэрэгтэй холбоотой эсэхийг нягтлах боломж илүү байдаг.

Захаас төв рүү (концентрик) арга нь хэрэг яг хаана болсныг тогтоох боломжгүй байгаа, зах орчмоос илрүүлж болох мөрийг баллах устгах магадлалтай байгаа бол захаас зах хязгаар хүртэлх (фронт) арга нь төв рүү хүрэхийн тулд зах орчмын мөрийг туучиж талхлахаар бол энэ аргыг хэрэглэнэ.



Захаас төв рүү (концентрик) арга



Төвөөс эхлэн зах руу (эксцентрик) арга

Хууль бусаар ан агнасан газарт дээрх аргуудын аль нэгийг заавал ашиглана гэсэн зүйлгүй юм.

Энэ төрлийн гэмт хэрэг ихэвчлэн задгай газарт буюу хээр талд, эсвэл аглаг бөглүү ой тайгад үйлдэгдэг тул хэргийн газрыг “GPS“ байршил тогтоогч хэрэгслийг ашиглан координатыг авч баталгаажуулна. Хэргийн газрыг тогтоож, баримжаалсны дараа үзлэг явуулах орчны хил хязгаарыг тогтооно.

Хууль бусаар ан агнасан гэмт хэргийн “Хэргийн газрын үзлэг”-ийг дахин давтагдашгүй гэж үздэг бөгөөд анхны үзлэгээр хэргийн газрыг чанартай явуулахыг шаарддаг. Учир нь үзлэгийг хангалтгүй явуулбал тодорхой хугацааны дараа давтан үзэхэд, амьтны сэг зэмийг нохой шувуу идэх, цас

1 Хэргийн газрын үзлэгийг тодорхой хоёр аргаар явуулах талаар өнөө үеийн криминалистууд үздэг. Хэргийн газрын үзлэгийг субъектив ба объектив аргаар явуулна. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн мөр, эд мөрийн баримтад сонгон үзлэг явуулах, эсвэл нийтэд нь үзлэгийг явуулах арга юм.

Субъектив буюу эд мөрийн баримтыг сонгон авч үзлэгийг явуулах арга нь мөрдөгч зөвхөн гэмт хэрэгтний явах замд учрах объектуудыг шинжлэх, хамгийн их мөр үлдсэн байж болох, эсхүл байгаа талбайг шинжилнэ. Тодруулбал мөр байгаа гэсэн тэр хэсэг газарт үзлэг хийж бусад газарт үзлэг хийхгүй юм. Энэ аргын дутагдалтай тал нь хэрэгт ач холбогдол бүхий мөр өөр газарт байгааг анзаарахгүй орхиж болох талтай.

Объектив буюу үзлэгийг нийтэд нь хийх арга нь хэргийн газрын үзлэг хийвэл зохих газрыг нийтэд нь хамарч байдгаараа субъектив аргаас ялгаатай бөгөөд үзлэгийг их хэмжээний хүч хэрэгсэл, талбай хамарч, цаг хугацаа үр ашиггүйгээр зарцуулагдах явдал олонтоо гарна. Ер нь хэргийн газрыг бүхэлд нь дэс дараалалтай судлах нь ямагт илүү оновчтой байдаг нь практикаас харагдаж байдаг.

бороо орж ул мөрийг арилгаж, шинж байдлыг алдагдуулах, “GPS”[1]-ээр байршил тогтоогоогүй бол эргэж газраа олоход бэрхшээл учрах, олохгүй байх, алс хол газарт дахин очих зэрэг хөрөнгө, хүч үргүй зарах асуудал гардаг.

Гэмт хэрэг гарсан газрыг маш анхааралтай нягтлан шалгах ёстой. Хэргийн ул мөр, баримт нь анзаарагдамгүй жижиг, эсвэл нуугдмал далд байж болзошгүй.

Хэргийн газрын үзлэгээр гэмт этгээд тухайн газарт ирсэн буцсан чиглэл, замыг тогтоох, илрүүлсэн эд зүйлээс гэмт этгээд хэдүүлээ байсан, ямар ан агнасан, ямар эд эрхтнийг нь авсан, үйлдлийн аргад галт зэвсэг эсвэл хавх, занга, сааль зэрэг ямар ангийн хэрэгсэл хэрэглэсэн, хэргийг үйлдэхдээ морь, мотоцикл, автомашин гэх мэт ямар тээврийн хэрэгсэл ашигласан зэрэг олон асуултад хариулт олж авах боломжтой.

Хэргийн газарт мөр мөшгөхөд онцлон анхаарах зүйлийн нэг нь чөлөөтэй мөрөнд орсон огцом хөдөлгөөн өөрчлөлт, түүнд шинээр нэмэгдсэн мөр байгаа эсэхийг тогтоох тухайлбал, агнагдсан амьтны мөр байлаа гэхэд түүний хөдөлгөөний чиглэлд адууны мөр нэмэгдсэн байвал морьтой хүн ан хийсэн байна гэсэн сэжиг дүгнэлт гаргаж болно.



1. Халиуны мөр
   а) нойтон элсэн дээрх мөр
   б) хөвсгөр цасан дээрх мөр
2. Бугын мөр
   в) бугын мөр алхам хоорондын зай 70 см
   г) согооны мөр алхам хоорондын зай 50 см

1 GPS (Global Positioning System). АНУ-ын БХЯ-аас 1970 аад оноос эхлэн хөөргөсөн хиймэл дагуулуудыг ашиглан бүтээсэн байрлал тодорхойлох систем. Байрлал тодорхойлох багажийг ч мөн GPS гэдэг. Хээрийн судалгааны дүнг газрын зураг дээр тэмдэглэхдээ хэрэглэдэг. Таками Юүичи. Байгаль орчны үндсэн ухагдахуун (тайлбар толь). УБ., 2003. 15 дахь тал.

Хэргийн газарт үлддэг ул мөр, эд зүйлс
1.) Агнасан амьтны үлдэгдэл, 2.) Эврийн огтлон авсан байдал, 3.) Аяга, 4.) Гутлын мөр, 5.) Ундааны сав, 6.) Тамхины иш, 7.) Уяа дээсний үлдэгдэл

Хэргийн газраас сэжигтний гутлын мөрийг илрүүлж бэхжүүлж авах нь мөрдөн байцаалтын хамгийн эгзэгтэй асуудлыг шийдвэрлэх чухал баримт болно. Мөрөөр нь хүний хөдөлгөөний чиглэл, нас, хүйс, хүний биеийн байдал болох доголон, суга таягтай зэрэг олон мэдээлэл авч болно.

Хэргийн газрын үзлэгийг нягт явуулснаар амьтныг үргээх, хөөх, отох зэрэг ямар аргаар агнасан болон тухайн нөхцөл байдлыг тодорхойлж болно. Тухайлбал, үргээх арга хэрэглэсэн тохиолдолд үргээгч, хашигч, тосон буудагч зэрэг хүмүүс оролцдог тул оролцогчийн тоог харьцуулан гаргаж болно. Үргээгчид ихэвчлэн тухайн газар нутгийн хүмүүс байдаг тул эрэн сурвалжлах ажиллагааны хүрээг ч тодорхойлох боломжтой.

Үзлэгээр илэрсэн эд мөрийн баримтад гаднын нөлөөний өөрчлөлт болох нохой, шувуу идэж мэрэх, нар салхины нөлөөгөөр хатсан, хөөсөн амьтны биед сумны шарх, хавх, урхины ор мөр байгаа эсэх, уг амьтан ямар шалтгаанаар (байгалийн жамаар) үхсэн эсэх зэргийг тодорхой бичнэ.

Галт зэвсгээр амьтан агнасан хэрэгт буудлагын мөр илрүүлэх ажиллагааг хийх нь зүйтэй. Энэ төрлийн хэргийг гол төлөв галт зэвсгээр үйлддэг учраас буудагчийн байрлалыг (агнасан амьтны сэг зэм, орчны зүйлээс баримжаалж) тогтоох хэрэгтэй. Анчин амьтныг ихэвчлэн гүйх, харайх, зогсож байх үед буудахад уг амьтан газарт унахдаа янз бүрийн байрлалтай болох тохиолдол байдаг тул буудагчийн байрлалыг шууд тогтооход төвөгтэй байдаг. Иймд агнасан амьтны дэргэдээс илрүүлсэн гутлын мөрийн чиглэлээс агнагч аль зүгээс ирснийг тогтоож, түүний буудлага хийсэн газрыг хайх хэрэгтэй. Агнасан амьтны биед орсон, гарсан сумны нүхний байдлаар буудагчийн байрлал чиглэлийг тогтоохыг оролдох хэрэгтэй. Сумны оролтын мөр бага хэмжээтэй, гаралтын мөр тодорхой хэлбэр дүрсгүй хэмжээгээр том байдаг. Хэрвээ сумны гарсан мөр байхгүй тохиолдолд сумны хошуу амьтны биед байна гэж үзэж сумны хошууг хайх хэрэгтэй. Үүний тулд амьтны бие, эд эрхтнийг өвчиж нарийвчлан үзэх шаардлагатай. Сумны хошуу, хонгиог хэргийн газрын үзлэгээр илрүүлж олох нь чухал бөгөөд хэрэгтнийг шуурхай эрэн сурвалжлах, нотлох баримтыг бүрдүүлэхэд ихээхэн ач холбогдолтой. Хэргийн газрын үзлэгээр юуны өмнө хэдэн удаагийн буудлага болсныг тогтоож, бүх хошууг олох нь чухал. Сумны хошуу очиж үйлчилсэн объект, хэрэв нэвт гарсан бол түүний цаана байгаа зүйлс, хөрс шороо, цас ус зэрэг орчинд эрэх нь зүйтэй[1].

Анчид ихэвчлэн 200-300 метрээс хэтрэхгүй газраас анг отон, сахиж буудаг. Автомат ажиллагаатай буу хонгиогоо баруун тийш 60 орчим градус өнцгөөр 1-5 метр зайд хаядаг.



Аливаа анг ихэвчлэн 200-300 м орчим зайд агнадаг учраас хэргийн газрын үзлэгийн радиусыг энэ зайд тогтоох нь зүйтэй.

1 Т.Очирбат, Ч.Соригзонболд. Хэргийн газрын үзлэг. УБ., 2012. 140 дэх тал.

Хонгио унахдаа юманд цохигдон өөр тийш үсрэх, өнхөрсөн байж болзошгүйг давхар тооцох нь зүйтэй[1]. Ангийн зориулалтын автомат биш зарим буу нэг удаагийн буудлага үйлдсэн тохиолдолд хонгио хэргийн газарт хаягдахгүй, өөрөөр хэлбэл бууны хүхээгт хонгио үлддэг. Үүнийг бас тооцох хэрэгтэй.

Хэргийн газраас илрүүлсэн сумны хошуу, хонгионы тусламжтайгаар ямар төрөл марк, калибрын буу хэрэглэсэн, тухайн бууны шинж тэмдэг зэрэг олон асуудлыг шийдвэрлэнэ. Анчин мод, бут, хад зэрэг бартааны өвөрт биеэ далдалж ан агнах тул түүний ойр орчимд сумны хонгио, бусад эд зүйлс орхигдох, хүн хэвтэж сууж байсан ором, мөр зэргийг анхаарах хэрэгтэй.

Хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн хонгиог гэрэл зургийн аргаар бэхжүүлэн хонгио дээр үүссэн мөрийг (цохигч, хаягч, үсэргэгч) үзэж, түүний хэлбэр, хэмжээ, өнгө зэргийг бичихээс гадна, хонгио бүрд байдаг үйлдвэрийн тэмдэг, өнгийг тодорхойлон бичиж, хонгионы урт, диаметр зэргийг хэмжинэ. Хонгиог эрж хайхдаа металл хайгч болон шигшүүр зэргийг ашиглаж болно.

Үрэл, хорголжин сумаар буудлага үйлдсэн тохиолдолд үрлийг буудагдсан биетээс түүж авна. Амьтны биед сум орсон, гарсан нүх нь биеийн аль хэсэг болохыг (цээж, хулхи, тархи) үзлэгийн тэмдэглэлд тодорхойлж бичнэ.

Хэргийн газрын үзлэгт **“сөрөг нөхцөл байдал”**-ын тухай ойлголт гарч ирдэг[2]. “Сөрөг зүйл гэж хэргийн газрын үзлэгийн явцад тогтоогдож буй зүйл нь агуулга, хэлбэрээрээ тухайн орчин, нөхцөлд нийцэхгүй байгааг”, өөрөөр хэлбэл хэргийн газарт байх ёстой мөр, эд мөрийн баримт байхгүй байх явдал юм. Тухайлбал, амьтан буудаж агнасан газарт цус байхгүй байх нь тухайн амьтныг өөр газраас зөөж авчирсныг даруй илтгэнэ. Тусгай хамгаалалттай газарт агнасан амьтныг тусгай хамгаалалтгүй газарт агнасан мэт харагдуулахаар зориудаар зохиомол нөхцөлийг бий болгож, гэмт үйлдлээ нуун далдалсан байж болзошгүй.

Сөрөг нөхцөл нь хэргийг “халуун мөр”-өөр нь хөөж, хэрэгтнийг илрүүлэхэд тусалдгаараа чухал ач холбогдолтой. Хэргийн газрын үзлэг явуулж байгаа газарт сөрөг зүйл тогтоогдвол зөвхөн илэрч буй зүйлээр хязгаарлалгүйгээр, сөрөг зүйлийг тайлбарлах мөр, шинжийг тогтоохыг эрмэлзэх, сөрөг байдлыг тайлбарлаж чадах тусгай мэдлэг, түүнийг эзэмшсэн мэргэжилтнийг үзлэгт оролцуулах, үүссэн нөхцөл байдлыг тайлбарлуулах, зөвлөгөө авах зэрэг ажиллагааг хийж болно.

1 Б.Жаргалсайхан. Криминалистикийн техник (сурах бичиг). УБ.,1998. 95 дахь тал.
2 Б.Жаргалсайхан. Учралын газрын үзлэг. УБ.,2008. 22 дахь тал.

Мөрдөгчид хэргийн газрын үзлэг явуулж байгаа нь



Тээврийн хэрэгслийн мөр үүсэх механизм

Хэргийн газрын үзлэг явуулж байх үед шуурхай-эрэн сурвалжлах ажиллагааг нэгэн зэрэг явуулах нь анхан шатны ажиллагааны бас нэгэн чухал хэсэг юм. Хэргийн газрын үзлэгээр илэрсэн нөхцөл байдал, эд мөрийн баримтын тухай эрэн сурвалжлах ажиллагаанд шаардлагатай мэдээллийг тухай бүр мөрдөн байцаагч мэдэгдэж байх ёстой.

Хэргийн газрын нэг бүрчилсэн үзлэгээр илэрч байгаа зүйлийг дараах байдлаар хуваан үзнэ. Үүнд:

а/ Амьтны холбогдол бүхий эд мөрийн баримт (амьтны сэг зэм болох арьс мах, үс ноос, толгой шийр, эвэр, цус зэрэг биологийн гаралтай эд зүйл, амьтны биед үүссэн гэмтэл)

б/ Гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан багаж хэрэгсэлтэй холбогдол бүхий эд мөрийн баримт (амьтныг агнах, төхөөрөхөд хэрэглэсэн багаж зэвсэг, хутга мэс, олс дээсний тасархай, сумны хошуу, хонгио зэрэг орхигдож, гээгдсэн эд зүйлс. Гэмт үйлдлээ нуун далдлах болон ашигласан тээврийн хэрэгсэл, морь мал, гутлын мөр)

в/ Бусад эд зүйлс (Сэжигтний хэргийн газарт үлдээсэн тамхины иш болон гутлын мөр, хувийн эд зүйлс. Ашигласан авто машины шатах тослох материалын дуссан асгарсан мөр, гал түүдэг асаасан ором) гэж хуваан үздэг.

Амьтны мөр. Монголчууд мал, амьтны мөрийг таних, ялгах, мөрөөр нь мөшгөх эртний уламжлалтай. Эртний хүмүүс амьтны мөрийг ялган таньж, түүнийгээ ан гөрөө хийхэд ашигладаг байв. Тэдний ан агнах арга олон янз байснаас гадна, амьтан агнах аргад мөр мөшгөх аргыг нэлээд ашигладаг байжээ. Үүний нэг хэлбэр нь мөрдөж агнах арга юм. Энэ аргыг өвлийн улиралд ихэвчлэн хэрэглэх бөгөөд цасан дээр гарсан амьтдын мөрийг ашиглана. Мөрдөж авлах

аргаар агнуурын ямар ч амьтдыг агнаж болно. Мөрдөх аргыг нохойтой агнах, хөөж хавх, зангад оруулах аргатай хослуулан хэрэглэж болдог байна.

Бодит жишээ 1. Судлаач Ч.Сонгино *"... Хоёр малчин малаа алдчихаад хайж явсаар нэгэн бууц дээр иржээ. Гэтэл нэг нь айлын хотны бууриар хэсэг явснаа өнгөрсөн шөнө энэ бууц дээр 70 хонь, 26 ямаа, нэг шар нохой хэвтжээ. Хонин дотор нэг хар, хоёр харлаг хонь байжээ гэв. Цааш нь мөрөөр мөшгөн явахдаа энэ малыг буруу талын нүд сохор тэмээ унасан эмэгтэй хүн тууж явжээ гээд нүүдэлчдийг гүйцэн ирэхэд дээрх бүгд цөм таарч байв. Яаж мэдсэн талаар асуухад нөгөө малчин хонь ямааны төрлийг хотонд хэвтсэн мөр, түүний байршлаар, малын тоог цасан дээр хэвтэж хонхойлсон тоогоор, хар, харлаг хонь, нохойг цасан дээр хэвтэхдээ унагаасан үсээр, сохор тэмээг замын хажуу талын өвс шүүрдэж идсэн байдлаар, эмэгтэй хүнийг цасан дээр шээсэн шээснийх нь байдлаар мэдсэн" гэж* тэмдэглэсэн нь буй.

Дэлхийн улс орнуудын эрдэмтэн судлаачид мөрийн талаар ихээхэн судалж анхаарсан байдаг. Тухайлбал, А.Л.Ященко Австралиар аялах явцдаа, нэг удаа ноён Мадлей түүнд нэг цахилгаан үзүүлжээ. Түүнд янз бүрийн газар шороо ой тал, уулаар 40 милл-ийн туршид бидний нүдэнд үл үзэгдэх адууны мөрөөр мөрдөж гэмт хэрэгтнийг барьсан тухай бичсэн байв. А.Л.Ященко "Хэрэв нотлох баримт байхгүй бол энэ ухааршгүй, байж болшгүй зүйл" гэж гайхжээ[1]. Манай орны эрдэмтэн, судлаачид ч гэсэн амьтны мөр судлалд анхаарал хандуулж, доктор Б.Бат-Эрдэнэ[2], Ц.Гантулга[3], магистр Ш.Довдон нар ан амьтны хөлийн мөр гэмт хэргийн нотлох баримтын эх сурвалж болох талаар судалгаа явуулж, криминалистикийн мөр судлалд амьтны хөлийн мөрийг судлах шаардлага байгааг тодорхой дурдсан байдаг.

Америкийн байгаль судлаач, зохиолч, зураач Э.Сетон Томпсон *"Цасан дээрх мөрөнд ид шидтэй ямар их хүч нуугдаж байна вэ? Энэхүү ярьдаг хээг тайлбал хэчнээн олон гайхамшигт өгүүллийг уншиж болох вэ? Хөдөлгөөн болгоны бичлэг нь алмайран зогсохоос аргагүйгээр тийм өө сэвгүй юм"* гэж бахдан өгүүлсэн байдаг[4].

1 Ш.Довдон. Криминалистик. \мал судлал\.УБ.,2010. 144 дэх тал.

2 "Криминалистикийн мал, амьтан судлал нь гэмт хэргийг илрүүлэх, мөрдөх зорилгоор амьтны гаралтай төрөл бүрийн мөр, юмс үүсэх зүй тогтолыг судалж, тэдгээрийг илрүүлэх, бэхжүүлэх, шинжлэх болон мал, амьтныг бүртгэх арга хэрэгслийг боловсруулдаг криминалистикийн техник зүйн дэд салбар мөн бөгөөд [криминалистикийн фаунологи] хэмээн нэрлэх болсоор тун удаагүй байна" гэж доктор Б.Бат-Эрдэнэ тодорхойлжээ. Ш.Довдон. Криминалистик /мал судлал/ УБ., 2010. 5 дахь тал.

3 Ц.Гантулга. Доказательственное значение следов в раскрытии преступлений :на примере следов животных. Автореферат диссертации на соискание кандитата юридических наук. М.,2009.

4 В.Дёжкин. Экологийн тухай яриа. УХГ. УБ.1988. 26 дахь тал

Амьтан бүр өөр өөрийн гэсэн морфологи шинжтэй учраас тэдгээрийн мөр ч гэсэн өөрийн гэсэн онцлогтой байдаг. Мөр өөрөө байгаль, цаг уураас шалтгаалан салхи бороонд бүдгэрэх, чийгтэй, зөөлөн шороотой газар тод, хатуу газарт бүдэг, цасны шинэ хуучнаас шалтгаалан өөр өөр гардаг. Ялангуяа, өөр амьтан, малын мөртэй холилдсоныг ялган таних нэн хэцүү. Мөр үүсэх механизмыг сайн судалж мөрийг оношлохоос гадна, аливаа амьтны мөрийг таньж мэднэ гэдэг нь амьдралын туршлага, ажигч гярхай байдал ихээхэн нөлөөлнө.

Гэвч хашир анчид, мөрчид аливаа амьтны гишгэсэн мөрийг хэд хонож байгаа гэдгийг ялгаж мэдэхээр барахгүй, хэзээ бороо орж, аль өдөр шороо хийсэж, хэдийд цас орсон зэрэг мөртэй холбогдох байгалийн хувиралтыг андахгүй мэдэж, энэ хугацаанд амьтны мөр хэрхэн хувирсан гэдгийг ч дотроо анзаарч мэдсэн байдгаас эхлээд амьтны ялгадасны өнгө, шээсний булагдсан байдлыг холбон шинжиж тэрхүү мөр нь хэд хоногийн өмнөх болохыг тодорхойлж чаддаг.

Тухайн амьтны хөдөлгөөний чигийг мөрөөр нь мэдэж болно. Мөн амьтны мөрний шинэ хуучин, амьтны тоо, хэдий үед явсан байна гэдгийг мэдэхэд хүнд биш. Шинэ мөр гэдэг нь яваад 15-20 минутаас дээд тал нь цаг болоогүй мөрийг хэлнэ. Урьд өдөр нь эсвэл орой, өдөр нь цас хүчтэй шуурсан бол мөр хуучирсан байна. Салхи хүчтэй шуураагүй, зөвхөн мөрийг өнгөлсөн төдий байвал шинэ хуучин мөрийг ялгаж болно. Хуучин мөрний зах ирмэг нь нягтарч хатуурсан байна. Иймээс аль ч амьтны мөрийг хараад өглөө, өдөр, орой, өчигдрийнх эсвэл 2-3 хоносон мөр байна гэдгийг ялгаж сурах боломжтой. Амьтны мөрний дүрс байдлаар ямар амьтан болохыг сайн мэддэг байх хэрэгтэй.

Аль нэг амьтан цасанд хэдий чинээ гүн шигдэх нь юуны өмнө түүний жингээс шалтгаална. Амьтдын үнэмлэхүй жингийн нөлөөг харьцуулах ямар нэг үндэс хэрэгтэй, харин түүнийг эрдэмтэд олжээ. Энэ нь мөрийн гадаргуугийн нэг см-т ногдох жинг граммаар илэрхийлсэн ачаалал юм. Тэр нь чандаганд дунджаар 19, туулайд 23-тай тэнцүү байна. Энэ нь гүн цастай нөхцөлд амьдрахад зохицсон биеийн бүтэцтэй холбоо бүхий морфологийн хэрэгсэл юм. Харин бусад хөхтөн амьтад болох хандгайд 500, гөрөөсөнд 320, чононд 190, шилүүсэнд 42, үнэгэнд 28, ойн суусар болон булганд 12, үенд 8-10 байна.

Махчин амьтад царцанги цасаар гулсаж байгаа мэт хөнгөн гүйдэг атал, хандгай алхам тутамдаа цасанд шигдэж явна. Туурайтан амьтдын мөрийн ачаалал үслэг амьтдынхаас үлэмж их байдаг. Сайн ажиглавал, наад зах нь 7-8 хандгайн мөрийг ялгаж болно. Тэд зун намрын цагт ганцаараа эсвэл цөөн

бүлгээрээ хэсүүчилдэг. Өвлийн цагт бол сүрэгт нэгддэг. Их цастай газарт амьтад мөр мөрөө дагаж явна. Энэ нь эрчим хүчээ хэмнэж хүчээ барахгүй байх амьтдын зан төрхийн онцлог юм.

Амьтдын насыг тогтоохын тулд жинг ашиглах нь нэлээд түгээмэл боловч яв цав тодорхойлох боломжгүй юм. Байгаль дээр амьтны мөрөөр насыг тогтоох нь тун ярвигтай бөгөөд олзворлосны дараа л тодорхойлж болно. Мөр хоорондын зай, газрын хөрсийг онгилж хаясан нүхний гүн, гишгэлтийн зөрүү (урд болон хойд хөлийн тусалт)-ээр амьтан нь тайван идээшилж байсан, үргэсэн, давхиж байсан, хэдэн амьтан байсан, тэдгээрийн нас, хүйс зэргийг тодорхойлж болно.

Мөр бэхжүүлэх, хураан авах. Мөр ямар байдалтай байгаагаас, тухайлбал гүн буюу өнгөц, үзэгдэх буюу үл үзэгдэхээс түүнийг илрүүлэх, бэхжүүлэх хураан авах арга барил шалтгаална. Мөрийг (а) мөрдөх ажиллагааны тэмдэглэлд тодорхойлон бичих, (б) гэрэл зураг болон механик аргаар хуулбарлах гэсэн үндсэн хоёр аргаар бэхжүүлнэ.

Амьтны хөлийн мөрийг судалснаар гэмт явдлын зарим байдал, тэр ч байтугай түүнийг бүхэлд нь сэргээн босгох бололцоо өгнө. Амьтан бүр өөрийн явалттай бөгөөд үүний үр дүнд түүний онцлогийг харуулсан мөр зам бий болно. Амьтны мөрөөр алхааны урт, өргөн, хөлийн тавилт, явалтын онцлог, мөр аль хөлийнх болох, мөрөөр туурай, тавхайн хэлбэр, хэмжээ, янз бүрийн согог өөрчлөлтийг тодорхойлно.

Дараах байдлаар мөр бий болсон хугацааг тодорхойлно. Гүн мөрийн элементийн гадар төлөвийн ялгааны зэрэглэл, хуучин мөрд хурц ирмэг нь нар салхины нөлөөгөөр мөлгөр болно. Тухайн орчны чийглэг байдалтай харьцуулсан мөрийн хөрсний чийглэгийн зэрэглэл, мөр бий болсон цагийг бороо цас орсон, зогссон цагтай жишсэн үр дүн, амьтны хөлийн дардас мөрөөс гадна, ялгадас, үс, өвс ногоо зэрэг олон зүйл үлдэнэ. Дээрх баримт нь яллагдагчийг байцаах тактик боловсруулахад үр дүнтэй. Хэргийн газрын үзлэгийг чанартай сайн хийх талаар сургамж, анхааруулга, санамж болгох зорилгоор бодит хэргээс жишээ дурдахад;

Бодит жишээ 2. Хөвсгөл аймгийн Их уул сумын Зүүн зоог гэдэг газарт гурван буга агнасан газарт үзлэг хийхэд “буга бүрийн эвэр, засаа чив, сүүлийн авсан..., 2 дахь буга агнасан газраас ертөнцийн зүгээр зүүн хойд талд отолт хийсэн байж болохоор ул мөр илэрсэн, тус газрын 10 м тойрог орчимд суурь хэсэгтээ 711/90, 60/75 гэсэн дугаартай 2 ш сумны хонгио илрүүлсэн гэж үзлэгийн тэмдэглэлд тусгасан байна. Хэрэгт сэжиглэж буй хүмүүсийн авч явсан галт зэвсгээр харьцуулан шинжлэх буудлага үйлдэж шинжилгээг явуулж, хэргийн газраас илрүүлсэн хонгиотой ул мөр нь тохирч, гэмт хэрэгтнийг илчилж, үзлэгийг сайн явуулсан хэдий ч хэргийн холбогдогч нараас эд мөрийн баримтаар бугын толгой, чив, засаа сүүл зэргийг хураан авч шинжилгээнд хүргүүлэхдээ гялгар уутанд хийж, дулаан газарт удаан хугацаагаар хадгалж өмхийрүүлж, ялзруулан муутгасан ажээ[41].

Үүнээс үзэхэд, энэ хэргийн холбогдогч нараас эд мөрийн баримтаар хураан авсан бугын толгой, чив, засаа сүүл зэргийг шинжилгээнд хүргүүлэхдээ гялгар уутанд хийж, дулаан газарт удаан хугацаагаар хадгалж өмхийрүүлж, ялзруулан муутгасан нь эд мөрийн баримтыг хадгалах, хамгаалах горимыг алдагдуулж, шинжилгээ хийхэд хүндрэлтэй болгосон, мөн хэргийн материалд бугын эврийг зөвхөн эвэр гэж бичсэнээр тухайн эвэр цусан эвэр эсвэл ясан эвэр аль нь байсныг тодорхой дурдаагүй зэрэг дутагдлууд байна.

Бодит жишээ 3. Төв аймгийн Мөнгөнморьт суманд орших Хан Хэнтийн Тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалагч 2007 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр Хэрлэнгийн хөдөө арал, Хадан хошууны чиглэлд өдөр тутмын ажиглалтаа хийж, үүргээ гүйцэтгэх үедээ хужир мараанд байнга ирдэг тугалтай хандгай байхгүй байгааг ажиглан мэдэж, ойр орчмын газраар хайж байтал Хар төгөл гэдэг газарт амьтны гэдэс дотрыг авч хаясан сэвстэй таарч, уг амьтныг чирч явсан мөрөөр нь мөшгөн Петровис компанийн амралтын газар тулж очжээ. Энэ бүх байдлаа байгаль хамгаалагч тэмдэглэн авч, “GPS” багажийн тусламжтайгаар солбицол (N 4848499; E 10883050)-ыг тогтоож, аймгийн цагдаагийн газрын шуурхай бүрэлдэхүүнийг дуудсан байна.

1 Эрүүгийн ....9525 дугаартай эрүүгийн хэрэг. Хэргийн утга нь: Чонын үргэлгэнд 2011 оны 12 дугаар сард яваад 17 буга гарч 14 буудаад 3 буга агнасан бүлэг этгээдүүдийн хэрэг.

Цагдаагийн ажилтнууд хэргийн газарт үзлэг явуулж, амьтан чирсэн мөрөөр амралтын газарт үзлэгийг үргэлжлүүлэн явуулахад, амралтын газрын авто машины гаржаас эм хандгай 1 (арьстайгаа, эвдээгүй), хярс 2, туулай 2, хөтүү 3 зэрэг агнасан амьтад илэрсэн. Хандгайн арьс маханд үзлэгийг нарийвчлан явуулснаар 3 удаа буудаж агнасан болох нь сумны нүхээр батлагдаж байгааг, мөн тусгай хамгаалалттай газар нутагт уг хэрэг гарсан байгааг байршил тогтоогчоор бэхжүүлэн авч, мөрдөн байцаалтын хойшлуулшгүй ажиллагаа явуулж, тухайн газарт амарч байсан нэгэн компанийн жолооч уг амьтныг агнасан болохыг илрүүлж, уг хэргийг шийдвэрлэжээ. Уг хэргийг шийдвэрлэгдсэний дараа гүйцэтгэх ажлын шугамаар тухайн хэрэгт амьтан агнах үед жолооч, компанийн захирал хоёулаа байсан, захирал нь хандгайг буудсан, харин жолооч ганцаараа амьтан агнасан, захирал байгаагүй гэж хэрэг хүлээсэн талаар мэдээлэл авсан боловч энэ хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нэгэнт өнгөрсөн, захирлыг буруутгах шууд нотлох баримт бүрдүүлж чадаагүй ажээ[42].

Энэ хэргээс үзэхэд, тухайн үед цагдаагийн ажилтнууд хэргийн газрын үзлэгийг явуулахдаа бусад ул мөр болох гутлын мөр, өөр бусад баримтыг илрүүлээгүй, ан агнасан буунд тухайн үед үзлэг хийгээгүй, буунаас шинжилгээнд зориулж дээж болох дарь тортгийн үлдэгдлийг авааагүй зэрэг энэ гэмт хэргийг илрүүлэх ажиллагааг бүрэн хийгээгүйн улмаас бусдад ял завшуулж, хэргийг үнэн мөнөөр нь шийдвэрлүүлж чадаагүй байна.

Төгсгөлийн үе шат (Үзлэгийн дүнг бэхжүүлэн авах)

Энэ үе шатанд үзлэгийн явцад олж авсан үр дүнг баримтжуулах, бэхжүүлэх асуудлууд хамаарна. Хэргийн газрын үзлэгийн явц үр дүнг бэхжүүлж, цугларсан эд мөрийн баримтуудыг хураан авахдаа бусад хэргийн газрын үзлэг явуулах нийтлэг журмыг баримтална. Хураан авахад анхаарах асуудлын талаар хураан авах ажиллагаа хэсгээс үзнэ үү.

Илрүүлсэн эд мөрийн баримтыг мөрдөх ажиллагаанд нотлох ач холбогдлыг алдагдуулахгүйн тулд түүний нотолгооны болон адилтгалын онцлог шинжийг хэвээр хадгалан үлдээхээр хамгаалах, бататгах арга технологийн дагуу бэхжүүлнэ.

Бэхжүүлэхийн тулд тодорхойлон бичих, схем, план масштаблан үйлдэх, гэрэл зураг, гар зураг үйлдэх, дуу, дүрс бичлэг хийх, хэв цутган авах зэрэг аргыг

1 М.Эрдэнэбаяр. Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийг илрүүлэх шалгахад анхаарах зарим асуудал. УБ.,2010. 42-43 дахь тал.

хэрэглэж болно. Бие биеэс салангид орших эд мөрийн баримтыг тус тусад нь бэхжүүлнэ.

Хэргийн газрыг гэрэл зургийн аргаар бэхжүүлэх

Хэргийн газрын гэрэл зураг нь хэрэг үйлдэгдсэн орчин, илэрсэн ул мөр, эд зүйлс, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан зэвсэг хэрэгсэл, агнагдсан амьтны эд эрхтэн, түүний үлдэгдэл, үс яс болон бусад баримтуудын ерөнхий байршил, объект нэг бүрийн онцлогийг харуулсан гэрэл зургууд юм.

Хэргийн газрыг гэрэл зургийн аргаар бэхжүүлэхдээ баримжаалах, тоймлох, зангилаа, нэг бүрчилсэн, нарийвчилсан хэлбэрээр гэрэл зургуудыг авна.

Баримжаалах гэрэл зураг

Баримжаалах гэрэл зурагт хэрэг үйлдэгдсэн газар орон, байгалийн тогтоц зэрэг онцлох зүйлсийг дүрсэлнэ. Баримжаалах зураг нь хэрэг үйлдэгдсэн орчин, нөхцөлийн талаар мэдээлэл олж авах, хожим ямар нэгэн шалтгаанаар хэргийн газрыг эрж олох шаардлага гарвал чиг баримжаа болгоно. Иймд, хэргийн газрын орчны зургийг хэд хэдэн цэгээс авах шаардлагатай.

Баримжаалах гэрэл зураг

Тойм зураг

Тойм зураг

Хэрэг үйлдсэн газрыг тоймлон харуулж буй ерөнхий зураг юм. Тоймлох гэрэл зурагт объектууд харьцангуй ойрын зайнаас дүрслэгдэх тул ач холбогдолтой өндөр цэгүүдэд үсэг болон тоон бичиглэл бүхий таних тэмдэг тавьж авч болно[1].

1 Т.Очирбат. Ч.Соронзонболд. Хэргийн газрын үзлэг /биет нотлох баримт цуглуулах арга хэрэгсэл/. УБ., 2012

Зангилаа гэрэл зураг

Зангилаа гэрэл зургаар хэргийн газрын хэсэг, объектуудын харилцан байрлалыг харуулна. Хэргийн газрын хамгийн ач холбогдолтой мэдээлэл агуулсан хэсгийн зураг байна.

Зангилгаа зураг

Нэг бүрчилсэн зураг

Ул мөр, эд мөрийн баримтын хэлбэр хэмжээ, шинж тэмдгийг харуулахын тулд хэмжих хэрэгсэл ашиглан авч буй зураг.

Нарийвчилсан гэрэл зураг

Эд мөрийн баримт, ул мөр, тэдгээрийн онцлог хэсгийн шинж байдлыг харуулах зорилгоор томруулан татаж авсан зураг байна.

Зангилгаа зураг



Хэргийн газрын үзлэгээс гадна, гэмт хэрэг үйлдсэн газрын орон зайг зөв тогтоох, өөрөөр хэлбэл “Орон зайн шинж байдлын судалгаа”-г криминалистикийн техник хэрэгслийг ашиглан хийх нь чухал ач холбогдолтой.

Гэмт хэрэг гарсан орон зайн шинж байдлыг тодорхойлох нь хэргийн газарт хийх үзлэгтэй нягт холбоотой боловч адилтган үзэж болохгүй. Орон зайн шинж нь тухайн нутгийн байгалийн төлөв, уул хад, гуу жалга, намаг, гол мөрөн, ой шугуй, цас зэрэг физик газар зүйн шинж байдлыг агуулсан ойлголт юм[1]. Хэрэг гарсан газрын орон зайн шинжийг тодорхойлох нь үзлэг явуулах, мөр сурвалжлахад тус дөхөм үзүүлэх төдийгүй эрэн сурвалжлах ажлыг төлөвлөх, чиг баримжааг тогтоох, таамаг сэжиг дэвшүүлэх, эд мөрийн баримтыг олж илрүүлэх, хэргийн нөхцөл байдлыг тогтооход чухал ач холбогдолтой криминалистик арга зүйн нэг хэлбэр юм.

Ихэнх мөрдөгч нар орон зайн шинжийг хэргийн газрын үзлэгтэй хольж хутгах, нэг зүйл мэт үздэг явдал олонтоо төдийгүй мөрдөх ажиллагаанд огт ашиглахгүй байгаа нь харамсалтай. Орон зайн шинжийг тодорхойлох нь практик ач холбогдлоор өндөр ч хялбар ажиллагаатай судалгаа юм.

1 Тодорхой төрлийн зарим гэмт хэргийг мөрдөх аргачлал. Ред Т.Дэндэв. УБ., 1977. 47 дахь тал.

Мөрдөгч өөрийн ажиглалтаар орчны байдлыг тодорхойлон тэмдэглэлд тусгаж, зохих объектууд болон хэрэг гарсан газрын алслагдсан байдал зэргийг схемээр харуулж, гэрэл зургийг материалд хавсаргана.

Зарим мөрдөгч нотлох баримт цуглуулан судлах, эрэн сурвалжлах ажлаас төвөгшөөн бэрхшээх, эсвэл хэргийг зөв таньж мэдэхгүйгээс “Орон зайн шинж байдлын судалгаа”-г хийхгүй орхигдуулж байгаа нь түүний ач холбогдлыг үнэлж чадахгүй, илүүц зүйл гэж боддогтой шууд холбоотой юм.



Хууль бусаар ан агнах гэмт хэргийг мөрдөх ажиллагаа

Мөрдөн шинжлэхүй нь хууль ёсыг хатуу сахиж, гэмт хэрэг бүрийг цаг тухайд нь бүрэн илрүүлж, нягтлан шалгахад хүний хүч, мэдлэг, авхаалж самбаа, уйгагүй нямбай ажиллагааг шаарддаг оюуны хүнд хөдөлмөр учраас нарийн зохион байгуулсан байх шаардлагатай. Тийм учраас мөрдөх ажлыг зохион байгуулахдаа юуны өмнө төлөвлөхөөс эхлэх ёстой.

Мөрдөх ажлын нэг гол зохион байгуулалт, зарчим, зангилаа асуудал нь мөрдөгчөөс мөрдлөгийг зөв төлөвлөх асуудал мөн[1]. Төлөвлөлт нь мөрдөлтийн чиглэл, зорилго, тэдгээрийг хуулийн хүрээнд шийдвэрлэх арга, хэрэгслийг тодорхойлоход оршдог сэтгэхүйн төвөгтэй процесс[2] төдийгүй мөрдөх ажиллагааны зохион байгуулалтын үндэс юм. Мөрдөх ажиллагааны зохион байгуулалтын үндэс нь төлөвлөлт юм бол энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлэх үетэй, өөрөөр хэлбэл гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл цагдаагийн байгууллагад ирсэн үеэс эхлэх ёстой болж байна.

Шинжлэх ухааны доктор, профессор Ж.Болдбаатар “Мөрдөн байцаалтын эхэн, ялангуяа хэрэг учралын газарт мөрдөн байцаалтын хойшлуулшгүй ажиллагаа явагдаж байх үед төлөвлөгөөг бичгээр үйлдэх боломжгүй байдгаас мөрдөн

1 Ряцев, В. П. Мөрдөн байцаагчийн хөдөлмөрийг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах нь //тодорхой төрлийн зарим гэмт хэргийг мөрдөх аргачлал. эмхэтгэл. УБ.,1977. 9 дэх тал.

2 Хурцгэрэл, Ж. Криминалистик II. УБ., 2004. 53 дахь тал.

байцаагч төлөвлөгөөг цээжээр буюу хийсвэр маягаар хийнэ. Чухам энэ үеэс эхлэн ямар нэг тодорхой төлөвлөгөөг удирдлага болгохгүй бол үйл ажиллагаа эмх цэгцгүй болж үр дүнд хүрэхгүй нь ойлгомжтой. Хойшлуулшгүй ажиллагааг бүрэн хийж гүйцэтгэсний эцэст мөрдөн байцаагч төлөвлөгөөг бичгээр үйлдэх ажилдаа орно[1]" гэсэн нь улам ч тодорхой харуулж байна.

Мөрдөх ажиллагааны төлөвлөлт хоорондоо холбоотой элементүүдээс бүрдэнэ. Төлөвлөх ажиллагаа нь суурь болсон хэд хэдэн зарчим дээр үндэслэгдэнэ. Үүнд: (а) төлөвлөлт тодорхой байх, (б) хэрэг нэг бүрийн онцлогт тохирсон байх, (в) хөдөлгөөнтэй байх, (г) бодитой байх зэрэг болно.

Төлөвлөлтийн агуулга нь өргөн утгатай ойлголт бөгөөд мөрдөх ажлын эхнээс нь аваад дуустал үргэлжлүүлэх бүтээлч, зохион байгуулалттай үйл ажиллагааны нийлбэр цогц юм.

Төлөвлөлтийн агуулга нь:

- Анхны мэдээлэл задлан шинжлэх;
- Таамаглал дэвшүүлэх, мөрдлөгийн зорилгыг тодорхойлох, төлөвлөсөн зорилгоо шийдвэрлэх арга, замыг тодорхойлох;
- Засвар нэмэлт оруулах зэргээс бүрдэнэ.

Мөрдлөгийн төлөвлөгөө нь:

- Анхан шатны төлөвлөлт;
- Дараагийн шатны төлөвлөлт;
- Төгсгөлийн шатны төлөвлөлт зэрэг мөрдөх ажиллагааны үе шатнаас хамаарч хийнэ.

Мөрдөх ажиллагааны төлөвлөлтөд:

1. Хэргийг мөрдөх ажил бүхэлдээ
2. Хэргийн тодорхой шатанд мөрдөх ажиллагаа явуулах
3. Мөрдөх ажиллагааны зорилтыг шийдвэрлэх
4. Гэмт хэргийн зарим хэсэг нөхцөл байдлыг тогтоох
5. Яллагдагч бүрийн гэм бурууг тус тусад нь нарийвчлан тогтоох
6. Мөрдөх үйл ажиллагааны зохион байгуулах тусгай арга хэмжээ явуулах
7. Мөрдөгч, олон нийт, хянан шалгагч, бусад байгууллага хүмүүстэй харилцаа холбоо тогтоож, хамтран ажиллах
8. Мөрдөгч, эрүүгийн мөрдөгч нарын хамтарсан групп байгуулж ажиллах ажиллагаа зэрэг хамрагдана.

1 Болдбаатар, Ж. Криминалистикийн тактик. УБ., 2001. 19 дэх тал.

Мөрдөх ажиллагаа доорх дараалалтай байвал зүйтэй гэдэг нь практикаар нотлогдсон байна. Үүнд: (а) тогтоовол зохих нөхцөл байдлууд, (б) цуглуулсан материалд дүгнэлт хийсний үндсэн дээр хийсэн таамаглал, (в) таамгийг тодруулахаар авах мөрдөх ажиллагааны зохион байгуулалт болон эрэн сурвалжлах ажиллагаа, (г) дээрх ажиллагааны хугацаа, гүйцэтгэгч нарыг заах зэрэг байна.

Сайн боловсруулсан төлөвлөгөө мөрдөгчийг хариуцлага сахилга бат, эмх цэгцтэй болгож, ажлыг зөв зохистой зохион байгуулах, үр ашигтай байх, хүний хүч хөдөлмөр, цагийг хэмнэх нөхцөл боломж олгохоос гадна, мөрдөх ажиллагааг урсгалаар явуулахгүй, хуулийн заалтыг хэрэгжүүлэх, хохирогч холбогдогчийн эрх ашгийг хамгаалах, чирэгдэл төвөг учруулахгүй байх зэрэг олон талын ач холбогдолтой.

Хууль бусаар ан агнах гэмт хэргийг мөрдөх ажлын төлөвлөлтийг зохиохдоо цугларсан мэдээ, мэдээллийг шинжлэн судалж, мөрдөх ажиллагааны анхан шатны ба дараагийн шатны ажиллагааны үед хийх төлөвлөгөө гэж ангилна.

Анхан шатны ажиллагааны үеийн төлөвлөлтөд:

- Хойшлуулшгүй хүрээнд хийх ажил;
- Шуурхай эрэн сурвалжлах ажлын хүрээнд хийх ажлууд;
- Таамаглал шалгах ажлууд;
- Гүйцэтгэх ажлын арга хэмжээтэй хослуулан явуулах, мэдээлэл солилцох, хамтран ажиллах чиглэл, мөрдөх тодорхой ажиллагаанууд;
- Гэмт этгээдийг баривчлах, нотлох баримтыг цуглуулах бэхжүүлэх, хураан авах хадгалах, шинжилгээ явуулах зэрэг асуудлууд хамаарах бол дараагийн шатны ажиллагааны төлөвлөлтөд:
- Гэмт хэргийн сэдэлт, гэм буруугийн хэлбэр;
- Яллагдагчийн хувийн байдал, түүнд хүлээлгэх хариуцлагын хэмжээ;
- Хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, шинж чанар;
- Гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг тогтоох зэрэг ажлууд тусгагдана.

Түүнээс гадна, тодорхой мөрдөх ажиллагааг хэн гүйцэтгэх, ямар хугацаанд, ажиллагааны дэс дараалал, ашиглах багаж хэрэгсэл, хүн хүч, гарах зардал, төрийн бусад байгууллагатай хамтран ажиллах уялдаа, тэдгээрээс авч болох мэдээлэл зэргийг бодитой тооцож, мөрдөж буй хэргийнхээ онцлогт тохируулан уян хатан, хөдөлгөөнтэй байхаар боловсруулах ёстой.

Хууль бусаар ан агнах гэмт хэрэгт хийх төлөвлөгөө бусад гэмт хэргийг мөрдөх нийтлэг төлөвлөгөөний дагуу боловсруулахаас гадна, дараах онцлогтой.

Энэ төрлийн гэмт хэргийг тодорхой орон зай газарт гэмт этгээдийн зохих үйл ажиллагааны үр дүнд үйлдэх тул тухайн орчинд гэмт этгээдийн үйлдлийн ул мөр, баримт үлдэх нь зайлшгүй. Тиймээс тухайн газарт хийх үзлэг хэргийн бодит байдлыг тогтоох, гэмт хэрэг гарсан эсэх, гэмт үйлдэлд өртсөн амьтан, холбогдогчийн талаарх мэдээлэл зэргийг тогтоох олон талын ач холбогдолтой. Иймд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үзлэг зөвхөн эд мөрийн баримтыг цуглуулах хэрэгсэл төдийгүй мөрдлөгийн цаашдын ажлыг төлөвлөх үндэс болдог тул бүрэн зүй зохистой, чанартай явуулахаар төлөвлөх нь зүйтэй.

Энэ гэмт хэрэгт үзлэгээр хэргийн нотлох гол баримт болох амьтны гаралтай эд эрхтэн хураах, эд мөрийн баримтад амьд амьтан байх тохиолдлууд гарах тул тэдгээрийг агуулах зориулалтын сав хайрцаг, хаана хадгалах, хэрвээ зориулалтын хадгалах газар байхгүй бол өөр ямар газарт хадгалж болох, хадгалахтай холбоотой бичиг баримт бүрдүүлэх зэргийг төлөвлөгөөнд урьдчилан тусгасан байх ёстой.

Хураасан амьтны гаралтай эд эрхтэнд шинжилгээ хийлгэж ямар амьтны эд, эрхтэн болохыг тодорхойлохын тулд хаана, ямар албан байгууллагад шинжилгээ хийлгэх, эд эрхтний шинжилгээ мөрдөх ажиллагааны хугацааг удаашруулж болзошгүй тул хугацаа шаардагдах эсэхийг харгалзан төлөвлөгөөнд тусгана.

Хууль бусаар ан агнах гэмт хэрэг хөдөө орон нутагт үйлдэгдэх тул төлөвлөгөөнд хэргийн газрын үзлэгийг хэдийд явуулах, ямар тээврийн хэрэгслээр очих, түүний зардал, амьтан судлаач, агнуур зүйч зэрэг мэргэжилтнүүдийг оролцуулах ажлыг нарийн төлөвлөнө. Хууль бус үйлдлийн талаарх мэдээллийг түүний бусад эх сурвалжтай хамтад нь шалгах хэрэгтэй. Энэ үед мэдээлэл хангалттай бус, тодорхой биш байж болзошгүй тул хийсвэр таамаглал дэвшүүлж, түүнийг шалгаж, мухарлана. Жишээлбэл, зах дээр тарваганы арьс зарж борлуулж байгаа мэдээлэл авбал нэн даруй гэнэтийн шалгалт, үзлэгийн төлөвлөгөө гаргаж болно. Гэхдээ амьтны эд эрхтэн зарж борлуулдаг эх үүсвэр, түүний томоохон сүлжээг илрүүлнэ гэж тооцвол өөр баримт мэдээлэл цуглуулах, ажиглалт явуулах зэргээр илүү их цаг, хүн хүч хэрэгтэй болох тул төлөвлөгөөг урт хугацааны, хамрах хүрээг өргөжүүлсэн байдлаар зохионо.

Ер нь мэдээлэл цуглуулах, хэрэг илрүүлэх, мөрдөх ажиллагааны анхан шатны ажиллагааны үеийн төлөвлөгөөнд бодит баримтад үндэслэсэн мэдээллүүдийн хоорондын шалтгаант холбоотой таамаглалыг шалгах заалт заавал орно.

Мөрдөн байцаалтын шатанд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зорилтыг хангах, хэргийн талаар нотолбол зохих асуудлууд багтдаг. Үүнд: гэмт

хэрэг гарсан байдал, гэмт хэргийг үйлдсэн этгээд хэн болохыг тогтоох, гэмт хэргийн сэдэл, гэм буруугийн хэлбэр, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хэмжээ, холбогдогчийн хувийн байдал, түүнд хүлээлгэх хариуцлагын хэр хэмжээ, шинж чанарт нөлөөлөх нөхцөлүүдийг тогтоох ёстой.

Гэмт хэрэг бүрд нотолбол зохих нийтлэг асуудлуудыг нэг бүрчлэн шалгаж тогтоох боловч хууль бусаар ан агнах гэмт хэргийн нотолбол зохих асуудлуудад анхаарах цөөн хэдэн онцлогууд байдаг. Үүнд:

1 *Гэмт хэрэг гарсан байдал.* Гэмт хэрэг гарсан байдлыг тогтоох элементэд хэрэг гарсан газрыг тогтоох асуудал багтана. Хэрвээ тухайн гэмт хэрэгт хэргийн газрын үзлэг явуулаагүй бол мөрдөн байцаалтын ажиллагаагаар гэмт хэрэг гарсан газрыг нарийвчлан тогтоох шаардлагатай.

Хууль бусаар ан агнах гэмт хэргийн зүйлд ан агнахыг хориглосон газар буюу тусгай хамгаалалттай газар нутагт амьтан агнасан бол хариуцлага оногдуулах заалттай учраас ан агнасан газар тусгай хамгаалалттай газар нутаг мөн эсэхийг тогтоох хэрэгцээ бий болдог. Ан хийсэн газрыг тогтоохын тулд сэжигтэн, гэрч, хохирогч нараас асууж тодруулсны дараа мэдүүлгийг шалгах тодорхой ажиллагаа явуулна. Мэдүүлгийг шалгахдаа байршил тогтоогч, нарийвчилсан газарзүйн зураг ашиглана. Мэдүүлгийг газар дээр нь шалгахдаа урьд өгсөн мэдүүлгийг харьцуулан үзэж, өмнөх мэдүүлгийг нотлохын зэрэгцээ шинэ баримт мэдээлэл олж тогтоох нь тус ажиллагааны онцлог юм.

2 *Цаг хугацаа.* Гэмт хэргийн байдлын өөр нэг тогтоох зайлшгүй шаардлагатай зүйл бол цаг хугацаа юм. Тухайн гэмт хэрэгт цаг хугацааг нарийн тогтоох нь хэргийн шийдвэрлэлтэд чухал нөлөө үзүүлдэг. Амьтан агнасан эсэхийг хэрэгт цуглуулсан мэдүүлэг нотлох баримтаас гадна, баримжаа хугацааг тухайн амьтны арьс, үсний морфологи шинж (амьтны үс улирлаас шалтгаалан жилд 2 удаа гуужих тул үс хөрсний байдал, эврийн ургалт г.м) зэргээр тодорхойлох боломж бий. Сэжигтэн этгээд агнасан хугацааг худлаа мэдүүлж болно.

3 *Гэмт хэрэг үйлдсэн арга.* Гэмт хэрэг үйлдсэн аргыг тогтоох нь нотолбол зохих асуудлуудын нэг юм. Гэмт хэргийг сэжигтэн этгээд үйлдэхдээ ашигласан арга, зэвсэг хэрэгслээр үйлдсэн эсэхийг тогтоох ёстой. Амьтныг агнах, барихыг хориглосон арга, хэрэгслийг Амьтны тухай хуульд тун тодорхой заасан байдаг. Ихэнх мөрдөгч, прокурор, шүүгч нар гэмт хэргийн объектив үйлдлийг зөвхөн амьтан агнасан байдлаар нь хязгаарлаж, чухам ямар арга, зэвсэг хэрэглэж агнасан байдлыг нотлох баримтаар тогтооход анхаардаггүй[1] нь судалгаанаас харагддаг.

1 Ан агнуурын хууль тогтоомж зөрчих гэмт хэргийн нөхцөл байдлын судалгаа (2002-2014). М.Эрдэнэбаяр

Химийн болон тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах, агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга сааль тавих, туурайтан амьтныг агнахад цасанд умбуулах, мөсөнд халтиргах, хясаа, эрэг ганга руу нисгэх, хавх тавих, агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх, загас барихад буу, бамбар, цахилгаан гүйдэл, хаалт, хашлага, гувчуур, тор хэрэглэх, бүх төрлийн гол мөрөнд завиар загасчлах, зориулалтын бус сумаар амьтан агнах зэрэг хуулиар хориглосон арга, зэвсэг хэрэгслээр амьтан агнасан, барьсан үйлдлийг баримтаар нотлон тогтоох нь мөрдөх ажиллагааны нэгээхэн хэсэг юм. Мөрдөн байцаалтаар тухайн гэмт хэргийг үйлдэхдээ амьтны эд эрхтнийг хадгалсан, тээвэрлэсэн, худалдан авсан, худалдсан үйлдлүүдийг нэг бүрчлэн нарийвчлан тогтоох шаардлагатай.

❹ *Хохирлын хэмжээ, шинж чанар.* Мөрдөх ажиллагааны шатанд хийх асуудлын нэг нь гэмт хэргийн улмаас учирсан хохирол, түүний хэмжээг тогтоох явдал. Хохирлын хэмжээг зөв тогтоох нь гэмт этгээдийн хариуцлагын хэмжээ, шинж чанарт шууд нөлөөлөх нөхцөлийн нэг юм.

Амьтны аймагт учирсан хохирол нь Амьтны тухай хуульд заасан экологи-эдийн засгийн үнэлгээгээр тогтоогдох бөгөөд тэр нь амьтны нас, хүйсээс шалтгаалан[1] өөр өөр байна. Тиймээс мөрдөх шатанд ямар зүйлийн амьтан болох, нас, хүйсийг тогтоох, шинжлэн магадлах, шинжилгээ явуулахад онцгой анхаарах ёстой.

Хууль бусаар ан агнах гэмт хэрэгт холбогдох этгээдийг олж тогтоож чадахгүй байгаа нь зарим ажиллагааг гүйцэд хийгээгүйгээс ихэвчлэн шалтгаалдаг. Үүнд мөрдөх ажиллагааг цаг алдаж эхэлсэн, тодорхой нөхцөлд зайлшгүй хийвэл зохих хойшлуулшгүй ажиллагааг орхигдуулсан, хэргийн газрын үзлэгийг чанаргүй хийсэн, хохирогч, гэрч нарыг хугацаа алдаж хагас дутуу байцаасан, шуурхай эрэн сурвалжлах ажиллагааг иж бүрэн явуулаагүй, хангалтгүй хэрэгжүүлсэн, мөрдөх ажиллагааны төлөвлөгөөг эмх цэгцгүй хийсэн, зохих мэргэжилтний туслалцааг аваагүй, анхан шатны ажиллагааны үед хэргийн газраас урган гарч байгаа таамаглалыг танин олж үйлдээгүй, ганц таамаглал дэвшүүлж түүнд хөтлөгдөн бусад таамгийг шалгаагүй орхигдуулсан, мөрдөгч нарын хамтын ажиллагаа, зөв зохион байгуулалт, дэс дараатай ажиллагаа байхгүй байгаад оршиж байдаг.

Гэвч түүнийг дан ганц хууль сахиулах байгууллагын ажилтны алдаагаар тайлбарлах нь учир дутагдалтай. Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэмт

1 Тухайлбал; Монгол бөхөн эр 2000.00, эм 2200.00, Хулан адуу эр 9700.00, эм 11000.00 мянган төгрөг байдаг. Монгол улсын Засгийн газрын тогтоол. 2011 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр. Дугаар 23. Үнэлгээ, төлбөр, хураамжийн хэмжээг шинэчлэн батлах тухай.

хэрэгтний бэлтгэл, дадлагаас бас хамаарна. Эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хэргийг илрүүлэх тактикт юуны өмнө хэргийн материалд цуглуулсан баримтад дүн шинжилгээ хийж, нотлох баримтыг судлах, үнэлэлт өгөх хэрэгтэй байдаг. Түүнчлэн гүйцэтгэх ажлын болон эрэн сурвалжлах ажиллагааны хүрээнд цуглуулсан материалыг судлах, дэвшүүлсэн таамаг бүрийг шалгасан эсэх, хойшлуулшгүй ажиллагааг явуулсан байдал, гэмт хэрэг үйлдсэн аргыг хэрхэн зөв тодорхойлсон, төстэй гэмт хэрэгтэй харьцуулан судалж үзэх, хэргийг илрүүлэх чиглэлээр мөрдөлтийн алдаа дутагдлыг олох, боломжтой бол тэдгээрийг арилгах, цаашид хийх ажлын чиглэл гаргах, алдсан эд зүйлийг хайх, олон нийтийн хүчийг зөв зохион байгуулах, мэргэжлийн шинжээч нартай тогтмол уулзаж, зөвлөгөө авах, эрүүгийн мөрдөгч нарын хамтын ажиллагааг идэвхжүүлэх, тэдэнд шаардлага тавих, тагнуул, хорих болон байгаль орчин, мэргэжлийн хяналт, гадаадын харьяатын асуудал эрхэлсэн байгууллага зэрэгтэй мэдээлэл солилцох, хамтран ажиллах зэрэг ажиллагааг хийвэл зохимжтой.

Эд мөрийн баримтад үзлэг хийх (тээврийн хэрэгсэл, галт зэвсэг, эд мөрийн баримтад хийх үзлэг)

Тээврийн хэрэгсэлд хийх үзлэг

Хууль бусаар ан агнах гэмт хэргийг гэмт этгээдүүд үйлдэхдээ ихэвчлэн тээврийн хэрэгсэл ашигладаг тул эргүүл, шалгалтыг хулгайн гэх тодотголтой замуудад явуулж, авто машины хөдөлгөөнд хяналт тогтоох, сэжигтэй тээврийн хэрэгслийг шалгах шаардлагатай.

Хяналт шалгалтыг явуулж байгаа алба хаагчид тактикийн шинжтэй зарим зүйлийг анхаарах хэрэгтэй. Тухайлбал, хөдөлгөөнд оролцож байгаа бүх автомашиныг шалгахаасаа илүү хот суурин газрын зүгт чиглэсэн, гадна байдлаараа тоос шороо, шавар шавхай болсон, бартаа саад туулах чадвартай, бидний хэлдгээр “жип” ангиллын машинууд илүү сэжиг өндөртэй байна.

Тээврийн хэрэгсэлд үзлэг хийхдээ жолооч болон зорчигчдоос аль зүгт, ямар зорилгоор явж байгааг тодруулах, зорчигч, жолооч нарыг өөр хооронд нь цохилдуулан асуух зэргээр ярилцах хэрэгтэй.

Тээврийн хэрэгсэлд үзлэг хийхэд цусны толбо, амьтны үс, үнэр зэрэг бичил ул мөрийг нягт нямбай сайтар үзэх, машины гадна талын байдлыг нягтлан харах, хэрвээ галт зэвсэг авч яваа бол түүний гэрчилгээ бичиг баримтыг үзэх шаардлагатай

Авто машины тээшний хэсэг, зорчигчдын авч яваа эд юмсыг үзэж шалгахдаа зорчигчдын бие, хувцас, авч яваа эд зүйл, автомашины гадна болон дотор хэсэгт амьтны цусны толбо, үс, хялгас наалдсан эсэхийг сайтар ажиглана.

Хэрвээ ан амьтан агнасан бол гарал үүслийн тодорхойлолтыг үзэх шаардлагатай.



Хууль бусаар ан агнах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд эд мөрийн баримт нь онцгой чухал үүрэгтэй байдаг. Энэ гэмт хэргийн эд мөрийн баримтад гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, хэрэгсэл, амьтны эд, эрхтэн, бусад зүйлс, түүнчлэн гэмт үйлдлийн замаар олсон мөнгө, үнэ бүхий зүйл, баримт бичиг болон гэмт хэргийг илрүүлэх, хэргийн бодит байдлыг тогтоох, гэмт этгээдийг олох, эсхүл сэжигтэн, яллагдагч,

шүүгдэгчийн гэм бурууг үгүйсгэх буюу хөнгөрүүлэхэд ач холбогдол бүхий бусад эд зүйлийг тооцдог.

Амьтны эд эрхтнийг янзалж, төхөөрсөн болон бэлтгэсэн газарт үзлэг хийхэд ангийн арьс үсийг цэвэрлэх вандан, өлгүүр мод, мохоо хутга, арьс цэвэрлэсэн газарт өөх тос, махны тасархай, шар мах, үс ноосны хэсэг байж болно. Вандан дээр арьсыг цовдлон хатаасан бол хадаасны нүх гардгийг анхаарах хэрэгтэй.

Амьтны үсийг хэргийн газраас хайж олох нь ихээхэн бэрхшээлтэй бөгөөд цайвар гадаргуу дээр цагаан үс мэдэгдэхгүй үлдэж болно. Сэжигтний бие, хувцас, харьцсан объект, бусад газарт үс байж болно. Үс хайхдаа гэрэлтүүлэгч гар чийдэн, өсгөгч шил, бичил тоос сорогч ашиглаж хэргийн газрын орчин, бүх эд зүйл, түүний гадаргуу зай завсарт анхаарлаа хандуулах хэрэгтэй.

Хувцас даавуун дээр үс хайхдаа цагаан цаасан дээр зөөлөн сэгсрэх буюу гялгар уутанд хийж гөвөхөд үс үлдэж болно. Мөн сүүлийн үеийн скоч буюу наалтууз болон хувцасны хог авдаг наалдамхай туузаар наалдуулан авч болно.



Олсон үсэндээ механик гэмтэл учруулахгүйн тулд тухайн гадаргуугаас үзүүртээ резин зөөлөвчтэй хямсаа буюу гараар эсвэл өнгөгүй наалдамхай туузад наалдуулан авч дугтуйд хийж, хэн хэзээ, хаанаас авснаа тодорхой бичих хэрэгтэй. Үзлэгээр өөр өөр газраас авсан үс бүрийг тус тусад нь дугтуйд хийнэ.

Галт зэвсэгт хийх үзлэг

Бууг шалгахдаа аюулгүй байдлыг хангаж, бууны **цоожлогчийг** цоожилсон эсэхийг эхэлж үзнэ. Хэрвээ цоожлогч (гал хамгаалагч) цоожлогдоогүй байвал бууны цоожлогчийг буулгаад буу магазинтай бол буунаас магазиныг салгана. Дараа нь бууны хүхээгт сум байгаа эсэхийг шалгахын тулд цоожлогчийг нээж, замгийг татаж үзнэ. Ингэж татаж үзэх үедээ бууны гол төмрийн амыг ямагт дээш нь хүн амьтан байхгүй чигт чиглүүлж барина. Бууны чавх, цохигч сойгдсон байвал санамсаргүй байдлаар буулгахгүй байх, бууг унагах, юманд цохиж доргиохгүй байхад анхаарна.

Бууг аюулгүй болгосны дараа үзлэгийг явуулна. Төрөл бүрийн галт зэвсгийн буудлага үйлдэх зарчим, сум магазин, цоожлогчийн талаар зохих мэдлэгтэй байх шаардлагатай. Хэрвээ огт үзэж хараагүй буу байвал бууны эзэмшигчээр бууг аюулгүй болгох арга хэмжээг авах хэрэгтэй.

Галт зэвсэгт үзлэг хийхдээ бууны калибр марк, төрлийг тогтооно. Улмаар бууны гол төмөр, замаг, замгийн рам дээр байгаа дугаар тэмдэглэгээ, үйлдвэрийн газрын тэмдэг, бусад нэмж бичсэн зүйлийг нарийн үзэж тэмдэглэлд тусгана. Бууны хэлбэр дүрсийг хэсэгчилсэн буюу нарийвчилсан гэрэл зургаар бэхжүүлж, эд ангийг хэмжинэ. Галт зэвсгийн зөвшөөрөл гэрчилгээг юуны урьд шалгах нь зүйтэй.



Буунд гадна үзлэг хийсний дараа нарийвчилсан лабораторийн шинжилгээнд хүргүүлэхээр зөөвөрлөхдөө бууны гол төмрийн амнаас дарийн угаар үнэртэж байвал цэвэр даавуу, цаасаар бөглөх таглах, гарын мөр илэрч болзошгүй хэсгийг хамгаалж тусгай хайрцагт хийх, хайрцаг байхгүй тохиолдолд зөөлөн даавуугаар ороож битүүмжлэн зөөвөрлөнө. Уут, хайрцаг саван дээр хэзээ, хаана, ямар хэргийн холбогдолтой зэрэг мэдээллийг бичнэ.

Нотлох баримтыг бэхжүүлэх

Гэмт хэргийг нотлох ажиллагааны чухал үе шатны нэг нь эд мөрийн баримт (амьтны эд эрхтэн, арьс зэрэг биологийн гаралтай зүйлс)-ыг бэхжүүлэх ажиллагаа юм. Бэхжүүлэх ажиллагаанд эд мөрийн баримтын онцлог шинжийг тэмдэглэлд зөв, тодорхой, бүрэн тусгана.



Эд мөрийн баримтын шинж, онцлогийг тэмдэглэлд бүрэн тусгах шаардлагатай

Тиймээс мөрдөгчид үзлэгийн тэмдэглэлд аливаа баримтыг зөв, тодорхой дүрслэхийн тулд амьтны морфологи шинжийн талаар мэдлэгтэй байх ёстой. Жишээлбэл, амьтны арьсанд үзлэг хийх бол амьтны арьсны үсэн бүрхүүлийн тархац, хөрсний зузаан, нимгэн зэрэг шинж чанар байдлын онцлогоос хамааруулж хэд хэдэн топограф хэсэгт хуваадаг.



Баримжаалах гэрэл зураг

Ан амьтны арьсыг нуруу, хэвлий хэсэг гэсэн 2 үндсэн хэсэгт хуваана. Түүнчлэн хоншоор, дух, хүзүү, сэрвээ, хоолой, хажуу дал, өгзөг, хонго, цавь зэрэг нэлээд хэдэн хэсэгт ангилна. Хоншоор гэж хамрын үзүүрээс хоёр нүдний хоорондын зайг, дух гэж толгойн дээд хэсгийн хоёр нүдний хоорондын зайнаас чих хүртэлх арьсыг, хацар гэж толгойн хоёр талын арьсыг, сэрвээ гэж дал хүртэлх хүзүүний үргэлжлэл хэсгийг, зоо гэж нурууны дагуух буюу арьсны төв хэсгийн арьсыг тус тус нэрлэх бөгөөд ихэнх амьтны арьсны зоо нурууны хэсэг нь нэлээд урт үсэн бүрхүүлтэй, бараандуу байна.

Амьтан болгон өөр өөр зүстэй байдаг. Тухайлбал, шар үнэгийг тодорхойлон бичих бол цайвар шаргал зүстэй, сор үстэй, хажуу тал бүдэг шаргал, толгой цайвар улаан шаргалдуу. Биеийн урт 60-90 см, сүүл 40-60 см.

Илбэнх биеийн урт 65-80 см, биеийн ерөнхий өнгө цайвар хүрэндүү байх боловч нуруун талдаа хар хүрэн өнгийн сор үстэй. Нурууныхаа голоор тод нарийн хар судалтай бөгөөд энэ нь хойшлох тусмаа бүдгэрч толборхог болох ба далны орчимд үл мэдэг тоононолжин хэлбэрийг үүсгэдэг. Хэвлий ерөнхийдөө цайвар шаргал өнгөтэй, хамар, дух, шанаа хацар тачирхан цайвар бор үстэй, сүүл нь нэлээд сахлаг урт үсээр бүрхэгдсэн.



1. Хар сүүлт, 2. Цагаан зээр, 3. Монгол бөхөн, 4. Янгир, 5. Аргаль хонь

Баавгайн арьс урт нь 240 см, сүүл 21 см, сүүл нь үснээс бараг цухуйхгүй шахам богинохон. Хөлийн хуруу тус бүр бараан өнгийн тахир хумстай. Зүс тод хар, хүрнээс цайвардуу хүрэн, саарал хүрэн гэх мэт олон янз.

Ирвэсийн арьс урт нь 120-150 см, сүүл 90 см, ерөнхий зүс эрээн цоохор, их биеийн үүлэн саарал дэвсгэр өнгөн дээр 4-6 см голч бүхий гархин буюу матигар бараавтар ба хүрэн толбо, нүүр толгойн мөн тийм дэвсгэр өнгөнд жижигхэн бараан толботой, үс нь зөөлөн сор бүхий, өтгөн ноолууртай гэх мэтээр шинж тэмдгийг бүрэн тодорхойлон бичнэ.

Булга биеийн урт 38-51 см, сүүл 11,5-19 см, бараан хардуу урт сортой, цайвардуу шаргал, өтгөн ноолууртай. Монголд тархсан булганы зүс харилцан адилгүй хамгийн үнэтэйд Хэнтийн булга орно. Тэр нь ихэвчлэн хар, хар хүрэн, халтар хүрэн зүстэй, бараан хардуу сортой байна. Сор үс хар ноолуур ихэвчлэн хөхөвтөр саарал, заримдаа шаргалдуу байх явдал бий. Өвлийн цагт сахлаг гялалзсан урт өтгөн үстэй. Нурууны үс хажуу ба хэвлий талаасаа нэлээд бараан толгой их биеэсээ ихээхэн цайруу өнгөтэй байна. Хөөмий цагаан, улаавтар шаргал ба шар өнгө бүхий толботой. Энэ толбоны хэлбэр хоорондоо өөр өөр байх боловч зарим булга хөөмийндөө толбогүй ч байх явдал тохиолддог. Зуны улиралд үс бараан, сор нэлээд ширүүн тачир ноолуур бага.

Хэрмийн биеийн урт 16-28 см, сүүл 14-23 см, зундаа хар хүрэн, өвөл цайвар бор хүрэн, хэвлий цагаан өнгөтэй. Зүсний өнгө ерөнхийдөө бараан цайвар саарал буюу шаргал туяатай үнсэн саарал өнгөтэй гэх мэтээр шинж тэмдгийг тусган тодорхойлон бичнэ.



Амьтны эд эрхтэн байвал түүний гадна морфологи шинж болох эвэр, туурай, амьтны хөл, гуяа, яс, мах зэргийн шинж байдлыг харж тодорхойлж бичнэ. Ингэхдээ амьтны эд эрхтнийг таних гарын авлага ашиглаж болно.

Хууль бусаар ан агнах гэмт хэрэгт эд мөрийн баримтаар хураасан болон хураан авах амьтны эд эрхтний зүйлээ ерөнхий шинжээр нь буюу нүдэн баримжаагаар таньж мэддэг байх хэрэгтэй.

Махыг харж таних. Аливаа амьтны махыг нямбай үзэж, өнгө, үнэр, ясны анатомийн онцлогт анхаарал хандуулж, махны өнгө, булчингийн ширхэг, үнэр зэргээр ямар зүйлийн амьтных болохыг энгийн ажиглалтын аргаар мэдэж болно. Тухайлбал, хандгайн мах хөхөвтөр туяатай, улаан хүрэн өнгөтэй, хатуу холбогч эдийн судлууд сайн хөгжсөн, булчингийн эдүүдийн хооронд өөх бараг байхгүй байдаг бол үхрийн мах цайвар улаанаас хүрэн улаан өнгөтэй, адууны мах улаан хүрэн өнгөтэй, агаарт улам барайж, хөхөвтөр туяатай хар хүрэн өнгөтэй болох ба буцалгахад хөөс буй болно. Бугын мах хар бараан өнгөтэй бүдүүн ширхэгтэй, харин цаа бугын мах түүний наснаас хамаарч цайвар ягаанаас хүрэн улаан хүртэл өнгөтэй, нарийн ширхэгтэй байдаг. Туулайн мах цайвар ягаан өнгөтэй, зөөлөн нарийн ширхэгтэй. Нохойн мах хар хүрэн өнгөтэй, нохойн ноосны өвөрмөц үнэртэй.

Амьтны ясны анатомийн бүтцээр махыг таних. Бүтэн гулууз болон тал буюу өрөөл махаар мал, амьтны зүйлийг тодорхойлж болно. Хонь, ямааны гулуузыг чоно, нохойноос ялгахад хялбар бөгөөд нохойны эхний хос хавирга зууван маягтай холбогдож, хавирга нь ерөнхийдөө нарийхан дугараг, харцага нь 7 нугаламтай, хажуугийн сэртэнгүүд нь нарийнхан доош чиглэлтэй. Өвчүүний яс нь нарийн, шаант нь хоёр хэсэг яснаас тогтоно. Харин хонины хавирга хурц өнцгөөр холбогдох ба хавирга нь нэлээд хавтгай, харцаганы нугалам нь 6 бөгөөд хажуугийн сэртэнгүүд нохойноос өргөн. Хажуу тийш чиглэлтэй. Өвчүүний яс нь өргөн. Шаант ганц яснаас тогтоно.

Хандгай 13 хос хавиргатай. Хавирга нь бөөрөнхий хавчиг, бие биедээ ойрхон байрлаж, хавирганы толгой урт, бараг 3 тал хэлбэртэй. Өвчүүний үзүүр нь бараг 2 дахин өргөн. Чөмөг яснуудын хөндийд ялтас ба утаслагаас тогтсон ясны тор үгүй.

Эрхтнүүдийн анатомийн бүтцээр махыг тодорхойлох. Хандгайн хэл урт, нарийхан, үзүүр нь дугараг, дээд талдаа гүвгэр хэсгүүдтэй. Гахайн хэл урт, нарийхан гүвгэр байхгүй. Нохой, чонын хэл өргөн, хавтгай, хурц улаан өнгөтэй, гадаргуу нь хилэн шиг зөөлөн нөсөөгүй байдаг. Хандгайн бөөр хэлтэнцэргүй, шош маягийн зууван хэлбэртэй, дэлүү нь хавтгай зузаан.

Мал, амьтны махыг өөхөөр нь ялгах. Янз бүрийн мал, амьтны өөх нь хайлах температур, өнгө, үнэрээрээ өөр өөр байдаг. Өөхний хайлах температур химийн бүтцээс хамаарна. Өөхөнд хүчил хэдий чинээ их байвал хайлах температур төдий чинээ их байна. Бага температурт хайлдаг өөхөнд олейны хүчил, стеорины хүчил бага байна. Амьтны өөхний өнгө нь тэжээлийн найрлага, өөхөн доторх липохром гэдэг нөсөөнөөс ихээхэн хамаарна. Адууны өөх ихэвчлэн шаравтар өнгөтэй, 15-16^{0}С-д зөөлөрч, 18-39^{0}С-д хайлна. Хонины өөх хатуу, цагаан өнгөтэй, 42-52^{0}С-д хайлна. Нохойн өөх тасалгааны температурт зөөлөрч, адууны өөхтэй ойролцоо хайлна. Гахайн өөх цагаан өнгөтэй, 28-48^{0}С-д хайлна. Цаа бугын өөх цагаан, хатуу нягт, 51-52^{0}С-д хайлна.

Биологийн гаралтай эд зүйлийг хураан авах ажиллагаа

Эд мөрийн баримт (биологийн гаралтай)-ыг хураан авах тэмдэглэл үйлдэхдээ тухайн эд зүйлд хийсэн үзлэгийн тэмдэглэлийг үндэслэн эд мөрийн баримтын шинж байдлыг мөн нарийн тодорхойлон бичнэ.

Хураан авах ажиллагааны дараа нотлох баримтыг зохих журмаар хадгалах асуудал маш чухлаар тавигддаг. Мөрдөгч нотлох баримтыг үрэгдэх, гэмтэх, солигдох, устгагдах нөхцөл үүсгэхгүй байх шаардлагыг хангах ёстой.

Энэ гэмт хэрэгт амьд амьтан хэргийн баримт болох тохиолдол цөөнгүй байдаг. Амьд амьтан тухайн хэргийг нотлох хөдөлшгүй баримт мөн. Хууль бусаар ан агнах, барих гэмт хэрэгт зохих зөвшөөрөлгүйгээр нэн ховор, ховор амьтан, тэдгээрийн үр төлийг амьдаар нь барьж тэжээх, гаршуулах, худалдан борлуулж буй хэргүүд олон бий. Тэдгээр амьтныг эд мөрийн баримтаар хураан авах, хадгалах, буцаан тавих ажиллагаа нь бусад гэмт хэргийн эд мөрийн баримт, түүнийг хураан авах, хадгалах арга зүйгээс ялгагдах онцлогуудтай. Амьд амьтан хураан авсан хэргийн баримтуудаас дурдвал;

Бодит жишээ 4. 2007 онд Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Амирита” нэртэй бар цэнгээний газарт зохих зөвшөөрөлгүйгээр хүрэн баавгайн бамбарууш тэжээсэн, Нарантуул худалдааны захад мөн хүрэн баавгайн бамбарууш худалдсан, Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутагт айлын хашаанд шонхор шувууг олноор нь барьж, гадаадын иргэдэд худалдахаар агуулж, түүнд өгөөш болгох зорилгоор их хэмжээгээр тагтаа барьж тэжээж байсан, тусгай хамгаалалттай газар нутгаас тарвага барьж өөр газарт нутагшуулах нэрээр зохих зөвшөөрөлгүй барьж, торон саванд хадгалсан зэрэг хэргүүд шалгагдсан байна.

Хураасан амьтныг зориулалтын торонд оруулсан байгаа нь

Хууль бусаар барьсан амьтан нь амьд байгаа тохиолдолд тухайн амьтныг хэрхэх талаарх шийдвэрийг яаралтай гаргана. Тухайн хэргийг илрүүлсэн даруйд амьтныг байгальд нь буцаан тавих боломжтой, орчин нөхцөл нь тохирсон бол шууд тавих шаардлагатай. Энэ үед эд мөрийн баримт болох амьтныг гэрэл зураг, дүрс бичлэг, тэмдэглэлээр бэхжүүлнэ. Амьтныг байгальд нь буцаан тавихдаа тухайн газар нь тэр зүйл амьтан амьдрах боломжтой орчин нөхцөл эсэхийг тооцоолж, хот суурин газраас хол, хүн малын хөлөөс зайдуу газрыг сонгож тавьдаг[1]. Зэрлэг амьтныг байгальд нь эргүүлэн тавьж байгаа тохиолдолд алба хаагчид өөрсдийн аюулгүй байдлыг хангахад анхаарах шаардлагатай.

Амьтан өөрийн өвөрмөц зан төрхөөсөө шалтгаалан дайрах, хазах, мөргөх, түлхэх, өшиглөх зэрэг үйлдлүүд гаргаж болзошгүйг санаж байх шаардлагатай. Аливаа амьтныг байгальд буцаан тавих ажиллагаанд боломжтой бол мэргэжилтнийг оролцуулж, тэдний зөвлөгөөг авч хаана, хэрхэн яаж тавих, оролцох хүн тээврийн хэрэгсэл, бусад багаж хэрэгсэл зэргийг урьдчилан сайтар төлөвлөж, уг ажиллагааг мэргэжлийн хүмүүсээр гүйцэтгүүлж, харин мөрдөгч тэдгээрийн үйл ажиллагааг баримтжуулбал зохимжтой.

1 Амьтныг байгальд эргүүлэн тавихдаа: амьтанд тохирох идэш тэжээлгүй, хоргодох хэвтэх бартаа саадгүй газарт болон бие даах чадваргүй нялх төлийг байгальд шууд тавьснаар үхэх аюултай, олон тооны амьтныг нэг дор зэрэг тавихад өөр хоорондоо сөргөлдөөн үүсэх зэрэг байдлыг харгалзах хэрэгтэй. Жишээ дурдвал, “Амирита” бааранд хууль бусаар баавгай тэжээж байсныг хураан авч циркэд түр хугацаагаар хадгалуулсан. Энэ үед Нарантуул захад 2 сар ч хүрээгүй баавгайн бамбарууш худалдаж байсан хууль бус үйлдлийг илрүүлж, мөн хураан авсан. Тэдгээр хураасан амьтдыг байгальд нь эргүүлэн тавих комиссын шийдвэрийн дагуу ойд буцаан тавихдаа баавгайг бамбаруушаас нь тусад нь өөр газарт тавьсан. Учир нь том нь багаа барьж идэх аюултайг харгалзан үзсэн болно.

Хэрвээ буцаан тавих боломжгүй бол тухайн амьтныг хадгалах тохиромжтой байр сав, зөөж тээвэрлэх тээврийн хэрэгслийг бэлтгэнэ. Энэ үед амьтныг хангалттай хооллох хэрэгтэй. Амьтныг зөөж тээвэрлэхдээ түүний айдсыг намжаахын тулд аль болох юмаар бүтээх, нарнаас хол байлгаж ус өгч, дуу чимээнээс хол байлгана. Дуу чимээ болон хүмүүс түүнийг стресст оруулж, шархдах үхэх нөхцөлийг нэмэгдүүлнэ. Амьтад наршсанаас үхэх аюултай. Амьтанд ус хоолноос ч илүү чухал байдаг.

Амьтныг зөөж тээвэрлэх үедээ хаана байрлуулах талаар ямар нэгэн шийдвэр гаргасан байх ёстой. Учир нь хууль хяналтын байгууллагад амьд амьтан хадгалах зориулалтын байр байхгүй тул амьтны хүрээлэн, цирк, хувираа амьтан тэжээдэг хүмүүс зэргийг сонгон авч урьдчилан тохирох, зохих зөвшөөрлийг авсан байх шаардлагатай. Амьтдыг зөөж тээвэрлэх үеийн үйл ажиллагааг гэрэл зураг, видео бичлэгээр баримтжуулна.

Биологийн гаралтай эд эрхтнийг хадгалах

Хууль бусаар ан агнах гэмт хэрэгт биологийн гаралтай эд мөрийн баримтыг хураан авах, хадгалах тусгай горим, арга ажиллагааг шаарддаг.

Баримтыг хураан авч бэхжүүлэх, чанар байдлыг алдагдуулахгүй хадгалах нь нотлох ажиллагааны нэг элемент төдийгүй нотлох ажиллагааны зорилтыг хангах чухал хэрэглүүр юм. Хэргийн газраас болон мөрдөн байцаалтын үзлэгээр илрүүлсэн эд мөрийн баримт болох амьтны эд эрхтнийг хураан авахдаа эд эрхтэн тус бүрийг уут саванд хийж, битүүмжлэн дугаарлаж хаягжуулна.

Биологийн гаралтай эд мөрийн баримтыг зориулалтын уутанд хийж байгаа нь

Биологийн гаралтай эд эрхтнийг зөвхөн цаасан уутанд хийж, аль болох нар тусахгүй, халаах хэрэгсэл, хорхой шавжаас хол тавьж, сэрүүн газарт хадгална. Эд мөрийн баримтыг гялгар уутанд хийж хэрхэвч болохгүй, муудах

аюултай. Амархан муудах цус, бусад эд эрхтнийг хөргөгч, хөлдөөгчид яаралтай хийж, хадгална. Ийм учраас хууль хяналтын байгууллагууд нь эд мөрийн баримт хадгалдаг газартаа хөргөгч, хөлдөөгч заавал байлгах шаардлагатай.

Аливаа үслэг эдийг хадгалахад агуулах хэрэгтэй. Эд мөрийн баримтаар хурааж авсан ангийн үс, арьсыг хүлээн авахдаа тэдгээрийг төрөлжүүлэн ялгах, баглах, хүлээн авсан үеийн анхны чанар байдлыг алдагдуулахгүйн тулд норж гэмтэх, хортон шавжаас хамгаалах, ариутгал цэвэрлэгээ хийх, чанарын хамгаалалт, хаягжуулалт хийнэ.

Агуулах байрны температур, агаарын харьцангуй чийг ялгаатай байх шаардлагатай. Тухайлбал, хатааж чанар байдлыг хамгаалсан арьсанд агаарын чийг 50-60%, давсалж хатаасан арьсанд 60-65%, нойтон давсалсан арьсанд 75-80% тус тус байх нь зохимжтой. Агаарын температур хатаасан арьсанд +15-20^{0}C, нойтон давсалсан арьсанд 8-12^{0}C тус тус байна. Арьс хадгалах агуулахыг тавиур, вандан, өлгүүр, тасалгаатай шүүгээ, хэц зэргээр тоноглосон байна.

Үнэг, хярс, мануул, шилүүс зэрэг амьтдын арьсыг нүд хамрын нүхээр нь холбон агуулахын хана туурганаас хөндий хэц, тусгай өлгүүрт өлгөнө. Усны булга, булга, суусар, солонгын арьсыг хайрцаг тавиурт, хэрмийн арьсыг нүдний нүхээр нь холбон баглаж, багцлан хадгална. Жирх, зурмын арьсыг 50-100 ширхгээр нь багцалж тавиур дээр хураах буюу хайрцагт хадгална.

Эд мөрийн баримтаар хураасан амьтны арьсыг өлгөж байгаа нь

Гэмт хэргийн статистик баримтаас үзэхэд, улсын хилээр хууль бусаар гаргах гэж байгаад баригдсан 8000 ширхэг хэрмийн арьс, 2500 ширхэг үнэгний арьс зэрэг эд мөрийн баримтыг хадгалах, хамгаалах шаардлага зүй ёсоор гарч байжээ.

Шинжилгээ хийх

Хууль бусаар ан агнах, мал хулгайлах гэмт хэрэг сүүлийн үед ихсэж, малын махыг амьтны махаар солих, нохой, буга, зээр, хулан зэрэг амьтдын махаар хоол унд хийж худалдах, хууль бусаар баавгайн доньд, хүдрийн заарыг худалдан борлуулж байгаад баригдах үедээ үхрийн цөс, малын засаа гэж мэлзэх асуудал цөөнгүй гарч, түүнийг илрүүлэхэд амьтан судлалын мэдлэгийг ашиглаж эхлээд удаагүй байна. Иймээс, хууль хяналтын байгууллагын ажилтнуудад тухайн мах ямар зүйлийн амьтны мах болохыг найдвартай ялган таних мэдрэг арга зайлшгүй хэрэгтэй болж байна.

Манай орны эрдэмтэд амьтдын махыг ясны анатомийн онцлогоор тодорхойлох, амьтны морфологи шинжээр ямар зүйлийн амьтан болохыг таних зэрэг шинжлэх ухааны аргуудаас гадна, ийлдэс, дархлаа судлалын олон аргыг боловсруулж, үйлдвэрлэлд нэвтрүүлжээ. Тэдгээрээс тоймлон дурдвал, доктор А.Батсүрэн, Г.Уртнасан, Э.Төмөртогтох нар үхэр, хонь, ямаа, буга, цагаан зээр, хар сүүлтийн махыг ялган таних арга[1], доктор Т.Даваа адуу, хулангийн махыг нэвчин тунадасжих урвалын өвөрмөц ийлдсээр махны төрлийг ялгах[2] зэрэг үнэ өртөг багатай, мал эмнэлэг, ариун цэврийн аль ч лабораторид ашиглаж болох арга зүйг боловсруулж, стандарт (MNS-5817 2007)-ыг батлуулсан байна.

Хүн ба амьтны үс[3] ашиглаж гэмт хэрэг илрүүлэх боломжийн талаар доктор А.Доржготов судалгаа явуулж, үс бол гэмт хэрэг илрүүлэх нэг чухал эх үүсвэр бөгөөд тухайн гэмт хэргийн талаар өөртөө үнэтэй мэдээлэл агуулж байгааг адилтгал, харьцуулалт, хими, биологийн арга зүйн мэдлэгийг ашиглан тогтоосон байна.

Ан амьтны мөр нь гэмт хэргийн нотлох баримтын эх сурвалж болох талаар доктор Ц.Гантулга судалгаа явуулж, криминалистикийн мөр судлалд амьтны хөлийн мөрийг судлах шаардлага байгааг тогтоосон бол судлаач С.Лхагвасүрэн, Ц.Амарсайхан нар орчин үеийн судалгааны арга зүй ашиглаж боловсруулалт хийсэн махан бүтээгдэхүүн, олон жил хадгалсан амьтны үс, ноос, ялгадас, цусны толбо, арьсны гуужсан хэсгээс ч махны төрөл, амьтны

1 С.Лхавгасүрэн. Махны төрөл, малын хүйс тодорхойлох ДНХ оношилгоо.//Эрдэм шинжилгээ бүтээлийн эмхэтгэл. УБ.,2014. 243 дахь тал.

2 Т.Даваа. Адуу, хулангийн махны шинэлэг байдал, ялган таних арга. Мал эмнэлгийн ухаанаар боловсролын докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2008.

3 А.Доржготов. Хүн ба амьтны үс ашиглаж гэмт хэрэг илрүүлэх боломж. Хууль зүйн ухааны дэд докторын зэрэг горилсон бүтээл. УБ.,1995.

хүйсийг илрүүлэх ДНХ[1]-ийн оношилгооны арга зүйг боловсруулсан нь практикт нэвтрээд удаагүй байна.

Хууль бусаар ан агнах гэмт хэргийн эд мөрийн баримт болох амьтны эд, эрхтэнд шинжлэн магадлахуйн-амьтан судлалын шинжилгээ явуулахад дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй. Энэ гэмт хэрэгт амьтны эд эрхтэнд хийх шинжилгээ болон бусад шинжилгээ гэж хоёр хувааж үзэж болно.

а) Амьтны эд эрхтэнд хийх шинжилгээнд

- Амьтны үхлийн шалтгаан тодорхойлох – Паталоги
- Амьтны эд эрхтнийг тодорхойлох – Биологи
- Эд эрхтнийг таних, төрөл зүйлийг тодорхойлох – Генетик
- Морфологи[2], ДНХ[3]-ийн шинжилгээг хийлгэж болно.

Дээрх магадлах шинжилгээг хийлгэснээр ямар зүйлийн амьтан болох, нас, хүйсийг тогтооно. Амьтны нас, хүйс, үр төлийг тодорхойлсноор хохирлын хэмжээг тогтоох зэрэг хэргийн зүйчлэлд чухал нөлөө үзүүлнэ. Амьтад нас, хүйсээс хамаарч экологи-эдийн засгийн өөр өөр үнэлгээтэй байх тул хохирол бодитоор тогтоогдоно.

б) Энэ төрлийн гэмт хэрэгт томилох бусад шинжилгээнд

- Мөр судлал (тээврийн хэрэгсэл, гутал, мал, амьтны мөр г.м);
- Галт зэвсэг
- Хүйтэн зэвсэг
- Биологи
- Үнэр судлал
- Амьтан агнах барих бусад зэвсэг хэрэгсэл (амьтан агнах, барихад хуулиар хориглосон зэвсэг болох сааль, занга, урхи, хаж, загас барих тор, цахилгаан гүйдэл, хаалт, хашлага, гувчуур зэрэг хэрэгсэл)
- Хөрс, ургамал, шавж зэрэг шинжилгээ хамаарна.

---

1 PCR-RFLP-ийн шинжилгээний арга зүйгээр тухайн төрөл зүйлийн хүрээнд генетикийн варицыг митохондрийн цитохром В генийг ашиглан шулсан, ангилсан, савласан халууны боловсруулалт хийсэн махны төрөл, гарал үүслийг тодорхойлсон. Мөн амьтдын хүйсийг тодорхойлоход PSR-ийн аргыг хэрэглэх нь найдвартайг туршилтаар тогтоосон байна. Чоно, ирвэс, зээрийн махны төрлийг тогтоохдоо дэлхийн гений банк (GenBank)-ны судалгааны дүнг ашиглажээ. С.Лхагвасүрэн нар. Махны төрөл, малын хүйс тодорхойлох ДНХ оношилгоо. //Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл. УБ., 2014. 243 дах тал.

2 Морфология - хэлбэр бүтцийн зүй. Ц. Дамдинсүрэн, А. Лувсандэндэв. Русско-Монгольский словарь. Около 55000 слов. УБ., 1982. 279 дэх тал.

3 Англиар dezxyribonucleic acid гэхийг DNA гэж, оросоор дизоксирибонуклеиновая кислота гэхийг ДНК гэж товчилдог бөгөөд манайд аль алийг нь ашигладаг ба Монголоор дизоксирибонукленны хүчил буюу ДНХ гэнэ. Б.Жаргалсайхан. Монгол Улсад криминалистикийн үнэр судлалын хөгжлийн онол, арга зүйн асуудал. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. УБ.,2015. 14 дэх тал.

Бие махбодод нийлэгждэг уургийн молекул байгууламжийн тухай мэдээлэл нуклейны хүчлийн молекулд хадгалагдаж байдаг. Түүнээс гадна, дезоксирибонуклеины хүчил өөрөө өөрийгөө нийлэгжүүлэх “увидастай” цорын ганц молекул юм. Д.Жамъянсүрэн. Биофизик. МЭДН. Улсын хэвлэлийн газар. УБ., 1986. 6 дахь тал.

Амьтны үхлийн шалтгаан тогтоох (паталоги)

Амьтны үхсэн шалтгааныг тогтооход шинжээч амьтны хүүр байсан газрыг үзэх, түүнчлэн эргэн тойрны байдлыг харах нь дүгнэлт гаргахад маш их тус болдог. Хууль бусаар агнасан амьтны хүүр бүрэн бүтэн байх нь тун ховор. Ихэвчлэн эд эрхтнийг нь авсан, эвдэж янзалсан байдалтай олддог. Хүүрийг үзэхдээ гэмтлийн шинж байдал, цус, хөөс гэх мэт болон гаднын юмс байгаа эсэхэд анхаарлаа хандуулна. Илэрсэн бүх зүйлийг нарийн үзэж, үр дүнг тэмдэглэлд тусгаж оруулна. Амьтан үхсэний дараа хүүрэнд хөрөлт, хаталт, хөшилт болон хүүрийн задралт зэрэг олон янзын өөрчлөлтүүд бий болдог. Амьтан үхмэгц ялгах булчирхайн үйл ажиллагаа зогсож чийгээ алдаж хатна.

Хэргийн газрын үзлэгийг ихэнх тохиолдолд нэлээд цаг хугацаа өнгөрч, амьтны хүүр хатсан үед хийж таардаг. Хаталт нь ил харагдах салст бүрхүүл, нүдний эвэрлэг бүрхүүлээс эхэлж, булингартаж, дараа нь үрчийж, сүүлдээ бүр хуурай болно. Хаталтын хугацаа янз бүр байх бөгөөд хуурай цаг ууртай дулаан улиралд хаталтын хугацаа богиносож, харин агаарын чийг их, сэрүүн үед уртасна.

Хүүрийн хөшилт үхэх үед ямар байсан тэр байдлаа хадгална. Хэрэв хөшсөн байдлыг хүчээр өөрчилбөл буцаж анхны байдалдаа орохгүй. Хүүрийн задрал амьтны эд эсэд орших олон янзын бактери, нянгуудын нөлөөгөөр явагдана. Хүүрийн задрал тухайн амьтан үхсэнээсээ хойш хэр удсаныг тогтооход тусална. Задрал явагдахад агаарын чийг, температур (20-25^{0}C) болон орчны бусад хүчин зүйлс нөлөөлнө. Задрал нь дунд зэргийн температурт хожуу, удаан явагдах ба хасах температурт явагдахгүй.

Үхлийн хугацааг тодорхойлоход хүүрийн төрөлхийн сүвнүүд дэх (энэ нь жилийн тодорхой улирлаас хамаарна) ялааны авгалдайн хөгжлийн янз бүрийн үе шатыг ашиглах бололцоотой. Хэрэв хүүрэнд ялааны зөвхөн өндөгнүүд оршиж байвал (цайвар өнгөтэй, бөөгнөрсөн, зууван хэлбэртэй) тухайн амьтан үхсэнээс хойш нэг хоног хэртэй хугацаа өнгөрсөн байх магадлалтай, харин өндөгтэй авгалдай байвал нэг хоногоос илүү, авгалдай олон байвал 3-5 хоног буюу илүү удсан ч байж болох талтай. Хэрэв хүүхэлдэй болон өт дайралдвал лавтай 7 хоносон байна. Дээрх хугацаа 15-20^{0}C дулаан үед хамаарна.

Агаарын температур үүнээс дулаахан бол ялааны хөгжил улам богиносно. Гэхдээ ялааны хөгжил дунджаар 3 долоо хонгийн дотор гүйцэх бөгөөд хэрэв хүүхэлдэйг цуглуулж хуруу шилэнд байлгаж ажиглавал 22 өдрийн дотор бие гүйцнэ. Үүгээр хүүр тухайн амьтан үхсэнээс хойш шинжлэх хүртэл хэдий хугацаа өнгөрснийг тогтоож болно.

Амьтны биед үүссэн шархаар нь шалтгааныг тодорхойлох

Амьтны бие махбодын гадна талын бүрэн бүтэн байдал эвдэхийг шарх гэнэ. Шархыг өнгөц буюу арьсыг нэвтлээгүй, гүн, дотор эд эрхтнийг гэмтээсэн, нэвтэрсэн, хоёр талаасаа онгорхой гэж хуваана.

Амьд байх үеийн шарх. Үхсэний дараахаас ялгагдах нэг онцлог нь дотно ба гадна цус гоожилтын ором байх төдийгүй шархны эргэн тойронд улайж хавдсан зэрэг үрэвслийн шинж илэрсэн, эд ба үс ноосонд цус наалдсан байна. Амьтан шарх авснаас хойш үхэх хүртэл урт хугацаа өнгөрсөн байх тусам шархны ялгагдах шинж тэмдэг төдий чинээ тод байна. Амьд үеийн шархны амсар нь амьд эдийн агшилтаас болж заавал ангайна. Хэрвээ шархны амсар цайвар ба цусгүй, ангайлт нь сул байвал үхсэний дараа шархалсныг гэрчилнэ.

Хатгаагдсан шарх. Эдэд хурц үзүүртэй сэрээ, шөвөг, хурц үзүүртэй саваа төмөр утас зэрэг нэвтрэн орсноос үүднэ. Шархлуулсан зүйл хатгаастай хэвээр бол шарх хэлбэрээ өөрчлөөгүй байдаг. Хатгасан зүйлийг авсны дараа ихэвчлэн ээрүүл хэлбэртэй болно.

Огтлогдсон шарх. Хурц иртэй зүйлээр эд гэмтэхийг хэлнэ. Огтолсон шархнаас ихэвчлэн цус гоожих ба нэлээд ангайна. Хэрвээ шархлуулсан зүйлийн ир хурц бол шархны зах тэгш, мохоо бол шархны зах шүдэлсэн заримдаа урагдсан байдаг.

Цавчигдсан шарх. Огтлогдсон шархны нэг хэлбэр бөгөөд ямар нэгэн иртэй зүйлд цохигдоход үүснэ. Цохилтын хүч нь цохисон зүйлийн жин, далайцын их багаас хамаарна. Ихэвчлэн сүх цүүц зэргээр цавчина.

Няцарсан шарх. Ихэвчлэн амьтан унаснаас үүсэх ба шархны зах няцарч, эдүүд урагдаж тасарсан байна. Арьсан дор яс ойрхон газарт гэмтэл их байна.

Урагдсан шарх. Энэ нь механик гэмтлээс үүсэх ба гэмтсэн эдийг урж тастан унжуулна. Энэ үед булчин шөрмөс нэлээд гэмтэнэ. Нохойд хазуулсан шарх, амьтны хумсаар уруулахад үүссэн шарх хамаарна.

Хазагдсан шарх. Биеийн аль ч хэсэгт байж болно. Хазсан амьтны зүйлээс хамаарч олон янз байна. Нохой буюу чоно ноцох үед олон тооны хазсан шарх илэрнэ.

Буудагдсан шарх. Сумны орсон нүх, шархны суваг байхаас гадна, сум нэвт гарсан үед нүх гарсан байна. Сум нэвт гаралгүй тухайн биед үлдсэн байж

болдог. Буудагдсан шарх нь бууны хийц, хэлбэр, их бага, буудалтын зай зэргээс шалтгаалан хэмжээ, гүнээрээ харилцан адилгүй байна. Том сумны шархнаас гадна, үрлэн сумны шарх дайралдана. Маш ойрхноос буудсан бол үрлэн сумнууд нэг газарт тусаж, ганц том сумных мэт шарх үүсгэнэ. Холоос буудсан тохиолдолд бие биеэсээ янз бүрийн зайтай орших олон тооны шарх үүсгэнэ. Бүр ойроос буудсан үед сумны орсон нүхний эргэн тойронд тортог суусан байдаг. Амьтны бие махбодоос олдсон сумны шовгор тал нисэлтийн чигийг заана.

Эд мөрийн баримтад хийх магадлан шинжилгээ

Эд мөрийн баримтаар хураасан амьтны эд эрхтэнд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах нь мөрдөх ажиллагааны чухал хэсэг бөгөөд шинжилгээгээр юуг тогтоож болох, шинжээчээс ямар асуулт асууж шийдвэрлүүлэх нь нотолгооны онцгой ач холбогдолтой байдаг.

Амьтан судлалын магадлах шинжилгээнд шинжлэх гэж буй эд эрхтэн нь жижиглэн тастагдсан, бүтээгдэхүүн болсон, халуун аргын боловсруулалтад орсон зэрэг гаднах хэлбэр дүрс, хэмжээ нь өөрчлөгдөж, ясны жишил анатоми, морфологийн шинжилгээгээр тодорхойлогдох боломжгүй болсон байдаг.

Энэ үед хими, биологи, бактери, генетик судлалын магадлан шинжилгээг тусгай лабораторид хийлгэх шаардлагатай.

Амьтны эд эрхтнийг тодорхойлох ДНХ-ийн шинжилгээ. Судлаачид мал, амьтны махны төрлийг ясны анатомийн онцлогоор тодорхойлох, булчинд агуулагдах гликогений хэмжээгээр ялгах, ДНХ эрлийзжүүлэгийн аргаар тодорхойлох, шингэний хроматограф, изоэлектрик фокусинг аргаар махны төрлийг ялгах аргыг судалж, ийлдэс, дархлаа судлалын шинжилгээний олон аргуудыг үйлдвэрлэлд нэвтрүүлжээ.

Тэдгээрээс гадна, махыг жижиглэсэн, яснаас салгасан, хэлбэр дүрсийг өөрчилсөн, боловсруулж өнгө үнэрийг танигдахгүй болгосон үед түүний төрлийг ялган таних найдвартай мэдрэг аргыг гений түвшинд, өөрөөр хэлбэл ДНХ-ийн аргаар махны төрөл, амьтны хүйсийг тогтоох найдвартай аргыг боловсруулж, түүгээр шинжилгээ хийж эхлээд байна. Амьтны мах, цус, бусад эдээс ДНХ ялган авч гений санд буй амьтны ДНХ-ийн тодорхойлолттой харьцуулж, махны төрөл, зүйлийг тогтооно. Түүнчлэн эмэгчин амьтны дээжид хос Х хромсомоос үүдэлтэй 1 толбо, эрэгчин амьтны дээжид Х ба У интроноос үүдэлтэй 2 толбо илрэх зарчимд тулгуурлан амьтны хүйсийг тодорхойлж байна.

Амьтныг химийн аливаа хороор хордуулсан эсэхийг тодорхойлоход хор судлалын шинжилгээ чухал ач холбогдолтой. Хор гэдэг нь амьтны бие махбодод бага хэмжээгээр ороход эрүүл байдлыг өөрчилж, үхэлд хүргэдэг бодисыг хэлнэ. Одоогоор амьтныг хордуулж агнасан хэрэг бүртгэгдээгүй боловч чоно, үнэг зэрэг амьтанд хортой өгөөш тавьж агнах арга байдаг.

Амьтны эд эрхтнийг тодорхойлох биологийн шинжилгээ (Амьтны үс шинжлэх). Үсийг шинжлэхдээ физик, хими, биологи зэрэг суурь шинжлэх ухааны зэрэгцээ биофизик, биохими, удамшил зүй зэрэг салбар шинжлэх ухааны ололт, арга зүйг өргөн ашиглаж, амьтны үсний шинж чанарыг иж бүрэн судалж, үсний гадна шинж, өнгө, урт, өргөн бүтцээр нь тухайн амьтны зүйлийг тогтоож байна.

Үсний морфологи бүтэц. Амьтны үсэн бүрхүүл нь биеийн дулаан хүйтнийг зохицуулах, эд эсийн чийглэгийг хадгалах, бие организмыг хамгаалах зэрэг биологийн олон чухал үүрэг гүйцэтгэдэг олон тооны үсний нийлбэр цогц юм. Амьтны үсэн бүрхүүлийн олон тооны үсний ширхгүүд нь морфологи болон гистологи бүтэц, хэмжээ хэлбэр, хөндлөн огтлол, атираа, өнгө зүс, байрлал зэргээрээ ялгаатай. Үсийг гадаад хэлбэрээр нь конус, цилиндр, тууз, ээрүүл, сэлэм хэлбэрийн гэж ангилна.

Ээрүүл хэлбэрийн үсний уг нь нарийн, үсний уртын 1/3-ээс дээших хэсэгт бүдүүрсэн байна. Цилиндр хэлбэрийн үс уртынхаа дагуу бараг бүхэлдээ ижил диаметртэй байх боловч төгсгөл болон үндсэн хэсэгт үл мэдэг нарийссан байна. Конус хэлбэрийн үс үзүүрээсээ уг руугаа жигд өргөссөн байна. Сэлэм хэлбэрийн үс нь дээд үзүүр хэсгээрээ сэлэм мэт хавтгайрч доод сууриараа цилиндр хэлбэртэй байна. Туузан хэлбэрийн үс нь бүх хэсгээрээ жигд хавтгайрсан байна. Эдгээрээс ээрүүл хэлбэрийн үсийг уртынх нь дагуу үзүүр, ирмэг, хүзүү, иш гэсэн 4 хэсэгт хуваана.



Үсний морфологи бүтэц
Үзүүр, гранн, хүзүү, суурь
1. Мэдрэгч үс
2. Чиглүүлэгч үс
3. Сор үс
4. Завсрын үс
5. Ноолуур

Үсний атирааны хэлбэр
Үсний хөндлөн огтлолын хэлбэр

Үслэг амьтдын үсний хөндлөн огтлолын хэлбэр харилцан адилгүй олон янз байдаг. Ноолуур үсний хөндлөн огтлол үсний уртын дагууд ижил дугуй байхад чиглүүлэгч болон сор үсний угийн хэсгийн хөндлөн огтлол үсний өргөн хэсэг болох ирмэг хэсэгтээ өргөн байна. Тухайлбал, сохор номин, үхэр огдойн үсний хөндлөн огтлол дугуй хэлбэртэй, булга суусар, цагаан үнэгнийх зууван хэлбэртэй, халиу, минжнийх хавтгай хэлбэртэй, тарваганых буурцаг хэлбэртэй, туулайных лийр хэлбэртэй байна.

Үсийг атираатаж долгиотсон байдлаар нь шулуун, тахир, хугарсан, долгиотсон, атираатсан, гархилсан гэж ангилна.

Үсний төрөл. Үсэн бүрхүүл дэх үсний ширхгүүдийг мэдрэмж үс буюу сахал, чиглүүлэгч үс, сор, ноолуур, завсрын үс гэж хэд хэдэн бүлэгт хувааж үздэг.

Мэдрэгч үс буюу сахал нь урт бүдүүн бага зэрэг тахирдуу байх бөгөөд амьтны толгой, уруул, нүдний ойролцоо заримдаа хүзүү, цээж, хөлийн тавхайд байдаг мэдрэгч үс ихэвчлэн 3-11-ээр бүлэглэж уруулын дээд, доод талд нүд, хүзүү, цээж өвчүү, хөлийн тавхайн хэсэгт байрлана. Амьтдын үсэн бүрхүүл дэх бусдаас урт, өндөр, бүдүүн үсийг чиглүүлэгч үс гэнэ. Чиглүүлэгч үсний уг арьсанд хамгийн гүн суусан байдаг. Чиглүүлэгч үсний тоо цөөн, арьсны 1 см^2 талбайд дунджаар 5-20 ширхэг байна.

Сор үс чиглүүлэгч үснээс богино, нарийн долгиотсон, тод илрэх ирмэгтэй, ирмэг хэсгээрээ бага зэрэг тахийсан байна. 1 см^2 дунджаар 50-200 ширхэг байна. Завсрын үс ихэнх шинж тэмдэг, чанараараа сор үс ноолуурын дундаж байрыг эзлэх бөгөөд сор үснээс богино нарийн ноолууранс бүдүүн урт байна. Ноолуур бол хамгийн богино, нарийн, зөөлөн атираатсан байхаас гадна, уртын дагуу жигд нарийхан байна.

Үсний байрлал. Амьтны үс нь арьс хөрсөндөө тодорхой зохион байгуулалт, дэс дараатай байна. Үсэн бүрхүүлийн байрлалыг дангаар болон бүлгээр байрласан гэж ялгана. Сор үс ноолууртай хамт нэг багц болон нэг нүхээр ил гарахыг багцаар байрлах, дангаараа нэг нүхээр ил гарахыг дан гэнэ. Ихэнх амьтдын үс сүүл рүүгээ, биеийн хажуу талын үс үл мэдэг доош буюу хойш, хөлийн үс доош чиглэн ургасан байна.

Үсний гистологи бүтэц. Төрөл бүрийн үсний ширхгүүд нь тэдгээрийн гистологи бүтцийн бүрэлдэхүүн болох хайрслаг, цайвар, хөндий гол давхаргуудыг бүрдүүлж буй янз бүрийн бүтэц, хэлбэр бүхий тусгай эсүүдээс тогтоно. Амьтан бүрийн үсний гистологи харилцан адилгүй байдаг. Энэ онцлог шинжээр нь ямар амьтны үс болох талаар лабораторийн шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулж болно.

Хайрслаг давхарга нь бүх төрлийн үсний ширхэгт байх бөгөөд үсийг загасны хайрс мэт бүрхэж тогтсон байдаг. Хайрслаг давхарга нь эвэршсэн, тунгалаг, нимгэн хавтгай эсээс тогтох үсний гадна бүрхүүл юм. Хайрслаг давхаргыг цагариг, цагариг бус хэлбэртэй гэж ангилна. 1 мм үсний уртад 45-80 ширхэг хайрс байрладаг.

Цайвар давхарга гэж үсний хайрслаг үеийн дотор орших үеийг хэлнэ. Цайварлаг давхарга нь бүх төрлийн үсний ширхэгт байна.

Хөндий гол давхарга нь үсний ширхэг бүрд байдаггүй. Сор, чиглүүлэгч үсэнд цайвар үеэс гадна, цайвар давхаргын дотор эвэршсэн сийрэг эсээс тогтох агааараар дүүрсэн үргэлжилсэн ба тасархайтсан байдалтай гуурсан үе байх ба түүнийг “хөндий гол” үе гэнэ. Хөндий гол нь үсний ширхгийн хөндлөн огтлолд эзлэх хэмжээ нь чандаганы үсэнд 9.0, хэрмийн үсэнд 21.0, халиуны үсэнд 70.0 хувийг тус тус эзэлж байх жишээтэй.

Амьтны арьс нь эвэрлэг бүрхэвч, шар махан давхарга гэсэн 3 үе давхаргаас тогтоно. Эвэрлэг бүрхэвч нь арьсны гадна талын нимгэн үе бөгөөд арьсны зузааны 0.5-4.0%-ийг эзэлнэ. Эвэрлэг бүрхэвчийн дор орших давхаргыг дермо буюу жинхэнэ хөрс гэнэ. Энэ нь арьсны зузааны 95%-ийг эзэлнэ. Энэ давхаргад хөлс, тосны булчирхайнууд, мэдрэлийн судасны төгсгөлүүд, үсний уг байрлана.

Амьтдын арьсны хөрсний зузаан амьтны зүйл, нас, хүйс, тухайн орчны онцлог, агнасан хугацаа зэрэг олон хүчин зүйлүүдээс хамаарч харилцан адилгүй байна. Ихэнх амьтдын арьс гэдэс, хэвлийн хэсэгтээ нимгэн, нуруундаа зузаан, хажуу хэсгээрээ зузаавтар байна.

Амьтны үсний гадна талын бохирдол, гэмтэл (механик, дулаан, цахилгаан, галт зэвсгийн)-ээр нь тухайн нөхцөл байдлыг тодорхойлж болно. Тухайлбал, амьтныг нүхэнд нь утаж алснаас үс харлах, түлэгдэж хярваслагдах, цус хурах шинж тэмдэг байдаг бол хавхаар агнасан амьтны арьс тасрах буюу үс нь халцарч, хөлдөж наалдсан анг ховх татаж авснаас үс ноос нь зулгарсан байдалтай байна. Мөн жижиг амьтдыг төмөр урхиар барихад тэдний хүзүүний үс ноос урхины ороор холгогдож унасан байдаг.

Амьтны эд эрхтнээр хийсэн бүтээгдэхүүн. Аливаа амьтныг тодорхой зорилгоор агнадаг. Тухайлбал, арьс үсийг ашиглах, мах, дотор эд эрхтэн, эвэр, туурай зэргээр ямар нэгэн бүтээгдэхүүн хийж, ашиг олох зорилготой байж болно. Тиймээс, тухайн бүтээгдэхүүнийг судалж, агнахыг хориглосон амьтны эд эрхтнээр хийсэн эд зүйл үү, эсвэл эмчилгээ, сувилгаанд зориулж мах болон

бусад эд эрхтнийг хэрэглэхээр бэлтгэсэн эсэхийг таньж мэдэх шаардлага бий болдог. Манай улсад амьтны арьс үс, яс, эвэр, туурай зэргээр аливаа бүтээгдэхүүн хийх, мах дотор эрхтнийг ахуйн болон эмчилгээ сувилгаанд ашиглахаар боловсруулж бэлтгэх, амьтны чихмэл, чимэглэл хийх зэргээр бэлтгэдэг.

Амьтны арьс үсийг бусад амьтны арьстай адилхан болгож дуурайлган буддаг. Тухайлбал, зурмын арьсыг усны булга, муурын арьсыг модны булга, тарваганы арьсыг булганы арьс болгож дуурайлган буддаг ажээ. Бага үнэтэй арьсыг нэгэн жигд хяргаж янзлах, сорыг зулгаах зэргээр өндөр үнэтэй амьтдын арьсыг дуурайлган буддаг байна. Тухайлбал, үсийг нь жигд хяргасан хонины арьсыг халиуны арьс болгож дуурайлгадаг байна.

Монголчууд тарвага, зурам, туулай, нохой зээх зэрэг үслэг ангийн арьсаар төрөл бүрийн дээл, хувцас урлана. Булга, суусар зэрэг үнэт арьсаар малгай, хантааз, ороолт, нударга хийнэ.

Үслэг түүхий эдийг амьтдын арьсны үсэн бүрхүүл, хөрсний таваарлаг шинж тэмдгүүдийн нийлбэр цогцоор нь 1, 2, 3 дугаар зэргийн арьс гэх мэтээр[1] ангилал зэрэглэл тогтоодог. Үслэг амьтны үсийг будсан, тусгай засал хийсэн тохиолдолд 1 см^2 талбайд орших үсний тоогоор нь ямар амьтан болохыг тодорхойлж болно. Тухайлбал, онцгой өтгөн үстэй буюу 1 см^2 талбайд 20000-аас дээш үс бүхий арьсанд халиу, голын минж, цагаан үнэг, чандаганы арьс, дунд зэргийн өтгөн үстэй буюу 1 см^2 талбайд 12000-20000 үс бүхий арьсанд

1 Тарваганы арьсыг газарзүйн байрлалаар нь Алтайн, Өрнөдийн, Дорнодын гэж ангилж бэлтгэхээр стандарт тогтоожээ. Газар зүйн ялгаатай нутагт оршдог тарваганы арьсны үсэн бүрхүүлийн өтгөн, урт богино, нарийн бүдүүн нь харилцан адилгүй талаар судалгаа хийсэн байна.

Алтайн тарвага хар хүрэн сортой өтгөн, сахлаг, торгомсог ноолууртай. Үсний өтгөн сийргийн 1 см^2 талбайд байх үсний тоогоор тодорхойлсон байна. Өрнөдийн тарвага хөх саарал ноолууртай зоо нуруугаараа бараандуу туяатай, хүрэн сор бүхий үстэй, ерөнхийдөө бараан саарал үстэй. Дорнодын тарвага саарал ноолууртай зоо нуруугаараа бор, бор саарал шаргал өнгийн сор бүхий цайвар, шаргал зүстэй. Үс богино, шингэвтэр ноолууртай.

Тарваганы үсний өтгөн, сийрэг

Тарваганы төрөл	1 см^2 талбайд ноогдох үсний тоо			
	Хажуу, бөөр хэсгээр		Гуяны орчмоор	
	Сор үс	Чиглүүлэгч үс	Сор үс	Чиглүүлэгч үс
Өрнөдийн	1258	193	1514	209
Дорнодын	2257	271	2108	254
Алтайн	1596	134	1424	115

Тарваганы үсний урт, нарийныг хэмжсэн дүн

Тарваганы төрөл				
	Үсний урт, мм		Үсний нарийн, мкм	
	Хажуу, бөөр орчмоор	Гуяны орчмоор	Хажуу, бөөр орчмоор	Гуяны орчмоор
Өрнөдийн	19,7	17,5	29,79	31,25
Дорнодын	15,0	15,0	27,52	27,97
Алтайн	21,2	22,5	31,91	32,76

ойн булга, молтогчин, заарт хархны арьс, сийрэг үстэй буюу 1 см^2 талбайд 2000-6000 үс бүхий арьсанд тарвага, дорго, нохой зээхийн арьс, хэт сийрэг үстэй буюу 1 см^2 талбайд 2000 хүртэл үс бүхий арьсанд зурам, баавгайн арьс тус тус ордог байна.

Профессор Б.Ф.Церевитинов үслэг арьсны үсэн бүрхүүлийн уртаар нь ангилсан байдаг бөгөөд онцгой урт үстэй буюу 90 мм-ээс дээш урттай сор бүхий арьсанд чоно, нохой зээх, дорго, баавгайн арьс, урт үстэй буюу 50-90 мм урт сор бүхий арьсанд халиу, минж, үнэгний арьс, дунд зэргийн урт үстэй буюу 25-50 мм урт сор бүхий арьсанд ойн булга, суусар, молтогчин туулайн арьс, богино үстэй буюу 15-25 мм урт сор бүхий арьсанд хэрмийн арьс, хэт богино үстэй буюу 8-15 мм урт үстэй арьсанд жижиг мэрэгчдийн арьсыг тус тус оруулсан байна.

Шинжээчээс асуух асуулт

Амьтны үхлийн шалтгааныг тогтоолгохоор шинжилгээнд хүргүүлж буй амьтан бүхлээрээ байгаа тохиолдолд үхлийн шалтгааныг тогтоох боломжтой бөгөөд шинжээч бололцооны хирээр дараах асуултуудад хариулах хэрэгтэй.

Эд мөрийн бариmтаар амьд амьтан хураагдаж ирсэн бол:

- Шинжилгээнд хүргүүлж буй амьтан (амьд бол) ямар зүйлийн амьтан болох, түүний олон улсын нэршил?
- Тухайн амьтан Монгол орны аль хэсэгт тархсан болох?

Хэрвээ эд мөрийн бариmтаар хураасан амьтан амьд байгаа бөгөөд гадна үзлэгээр бэртсэн, гэмтсэн, цус гарсан, шархтай байгаа бол:

- Тухайн амьтны биеийн аль хэсэгт ямар шарх үүссэн байна вэ?
- Уг шарх хатуу мохоо, эсвэл хурц үзүүртэй зүйлээр (хутга, шөвөг г.м) хатгагдсан, огтлогдсон, зүсэгдсэн, эсвэл буудагдсан аль нь болох?

Хэрвээ агнасан амьтны үхлийн шалтгааныг тогтоож болохоор бүхлээрээ байгаа, эсхүл хангалттай эд хэсгүүд байгаа тохиолдолд;

- Тухайн амьтны үхлийн шалтгаан юу болох?
- Уг амьтны биеийн гадна арьсанд ил харагдах ямар ямар гэмтэл үүссэн байна вэ?
- Задлан шинжилгээгээр амьтны дотор эд эрхтэнд ямар ямар гэмтэл (буудсанаас, хавх, урхины г.м) үүссэн байна вэ?
- Үхэлд хүргэх гаднын ямар нөхцөлүүд нөлөөлсөн байна вэ?

- Амьтан үхсэнээс хойш хэдий хугацаа өнгөрсөн, хугацааг ойролцоогоор тогтоож болох эсэх, дурдсан хугацаанд (... төдийд) үхсэн байж болох уу?

Амьтны эд эрхтэнд хийсэн шинжилгээгээр;

- Шинжилгээнд хүргүүлсэн зүйл (арьс, булчин, мах, яс, дотор эрхтний хэсэг г.м) амьтны эд эрхтэн мөн үү? Хэрвээ мөн бол хүн, мал, амьтны аль нь болох?
- Шинжилгээнд хүргүүлсэн эд эрхтэн амьтных мөн бол ямар зүйлийн амьтных (арьс, мах, эвэр, туурай, дотор эрхтэн) вэ? Олон улсын нэршил.
- Тухайн амьтан манай орны аль хэсэгт тархсан вэ?
- Уг эд, эрхтнээр тухайн амьтны нас, хүйсийг тогтоох боломжтой эсэх?
- Амьтны эд эрхтэн нь холилдсон олон тоотой байвал, ямар ямар амьтны аль хэсгийн, хэдэн тоо бүхий эд эрхтэн байгааг тодорхойлох боломжтой эсэх?
- Шинжилгээнд хүргүүлсэн амьтны эд эрхтэн болох эвэр, арьс, үсээр тухайн амьтан хэдийд агнагдсан хугацааг тогтоох боломжтой эсэх?
- Шинжилгээнд хүргүүлсэн эд зүйл (нэрийг нь бичих) дээр цус байгаа эсэх?
- Хэрэв цус мөн бол хүнийх үү амьтных уу? Амьтных бол ямар зүйлийн амьтных вэ?
- Тухайн объект үс мөн эсэх?
- Хэрэв мөн бол хүн ба амьтны үсний аль нь болох?
- Хэрэв амьтны үс бол ямар амьтны үс вэ?
- ..... тухайн амьтны үс мөн эсэх?
- Үс нь ямар зүйлээр бохирлогдсон болох?
- Ямар шалтгаанаар үс гэмтэлд орсон болох?
- Үс зулгаагдсан, тасалсан, хайчилсан алин болох?
- Амьтны аль хэсгийн үс болох?
- Хэрэг учрал болсон газарт илэрсэн хөлийн мөр ямар амьтных болох? (энэ нь тухай амьтны мөрний талаарх харьцуулах хэв загвартай үед хийх боломжтой)
- Тухайн мөрний хувийн онцлог шинж тэмдэг юу вэ?
- Тухайн амьтан аль чиглэлд явж байсан бэ?
- Амьтны мөрөөр нас, хүйсийг тогтоох боломжтой эсэх?
- Хэрэг учрал болсон газарт хэчнээн тооны амьтан байсныг тогтоох боломжтой эсэх?
- Тухайн амьтны явдлын мөрөнд өөр амьтан (ялангуяа морь, тэмээ, үхэр г.м)-ны мөр холилдон орсон эсэх зэрэг асуудлаар хариулт авах боломжтой.

Үүнээс гадна, тухайн шинжээч нь шинжилгээний явцад олж мэдсэн бусад асуудлын талаар асуулт асуугаагүй ч гэсэн томилогдсон мэргэжилтний хувьд тодорхойлж бичнэ.

Ярилцлагын арга техник

Энэ бүлэгт мөрдөгчийн бусадтай ярилцах арга техник, анхаарах асуудлын талаар авч үзнэ. Мөрдөгчид аливаа хэргийг шалгахад хэн нэгэнтэй заавал харилцан ярилцаж байдаг. Тэдгээр ярилцлагаас шинэ мэдээлэл олж авах, өөр бусад мэдээллийг бататгах, хэрэг зөрчил хэр үйлдэгдэж байгаа зэрэгт дүн шинжилгээ хийж, олон асуудлыг тодорхой болгож байдаг.

Та хэн нэгэнтэй (энгийн иргэн, хэргийн гэрч хохирогч болон сэжигтэнтэй г.м) ярилцахдаа ямар асуулт асуух, яаж асуухаа мэддэг байх, өөртөө итгэлтэй байх зэрэг ур чадваруудыг хөгжүүлж, тодорхой арга техникүүдийг судалж, тогтмол суралцаж байх шаардлагатай. Мөн хүн бүр янз бүрийн ааш зан, дадал хэвшилтэй байдаг гэдгийг та ямагт анхаарч байх хэрэгтэй. Дараах зөвлөгөө хүн бүрд таарч тохирох зүйл биш бөгөөд нийтлэг гаргадаг шинжийг нэгтгэн танилцуулж байна.

Сэжигтэн чөлөөтэй цэх суусан байгаа нь

Ярилцлага

Та гэмт хэргийн тухай, гэр бүлийн болон түүний хамсаатны талаар мэдээлэл хүлээн авч болно (Мэдээллийн эх сурвалж хэсгийг дахин үзээрэй). Тэднээс асуухыг хүссэн асуултуудаа урьдчилан гаргаж бэлтгэх хэрэгтэй. Ярилцлага нь ерөнхий асуултаар эхэлж, дараа нь өвөрмөц онцгой асуулт руу шилжих байдлаар явагдах ёстой.

Ярилцлагын эхэнд. Ярилцагчийн эгц өөдөөс нь харж суугаад биеэ суллан чөлөөтэй байлгах хэрэгтэй. Та хөлөө ачих юм уу гараа элгэндээ тэвэрч болохгүй. Биеэ чөлөөтэй байлгах нь түүний хэлж ярихыг сонсох хүсэлтэй байгааг илтгэнэ.

Таны ярилцлага ярилцагчтай мэндэлж, өөрийгөө танилцуулснаар эхэлнэ. Ярилцлагын үед ярилцагч руугаа харах хэрэгтэй боловч түүн рүү ширтэж болохгүй. Та нөхөрсөг, эелдэг байж, хэрвээ дүрэмт хувцасгүй байгаа бол албаны үнэмлэхээ үзүүлнэ.

Ярилцагчаа тайвшруулах. Албаны хэргээр бусадтай ярилцахад зарим хүмүүс айх сандрах байдалд ордог. Ийм үед та ярилцагчдаа амархан бөгөөд энгийн асуултууд (тавгүйтүүлэх асуулт асуухгүй байх) тавьж, түүнийг тайвширсны дараа гол асуултуудаа асууж эхлэх нь зохистой.

Хэрвээ ярилцагч мөрдөн шалгах ажилд туслахааргүй байвал ярилцагч хүндээ мөрдөн шалгах ажлын тухай мэдээлэл битгий өг. Шаардлагатай биш бол та мэдээж мөрдлөгийнхөө нарийн ширийн зүйлсийг бусдад зарлах хэрэггүй.

Ярилцлагын үед. Та тухайн хүнтэй ярилцах цорын ганц боломжтой хүн байж болох юм. Та ярилцаж буй хүнээсээ аль болох бололцоотой мэдээллүүдээ авахыг хичээгээрэй. Та тун няхуур байж, хариултуудад маш хурдан дүн шинжилгээ хийж, бататгах асуулт асуух хэрэгтэй. Жишээлбэл, та андуураагүй биз, түүнтэй адилхан хүн явж байсан юм биш биз, таны хараа сайн уу гэх мэт асуултуудыг өөр талаас нь сөргүүлэн тавьж хариултыг бататгахыг хичээх хэрэгтэй. Энэ үед ярилцагч эгдүүцэж байвал түүнээс эвтэйхэн зайлсхийж гарах хэрэгтэй. Харин тухайн хүнтэй муудалцах, өөрийнхөөрөө зүтгэх, тулгах байдал гаргаж болохгүй. Мөн хууран мэхлэх, төөрөгдөлд оруулах зэрэг зүйл хийхийг хориглоно.

Ярилцлагын асуултын эхлэх хэлбэр нь тун энгийн байх хэрэгтэй. Гэхдээ мэндэлсний дараа таны асуух асуулт нь хэт энгийн буюу тийм, үгүй гэж

хариулагдахаар байх ёсгүй. Жишээ нь, “саяхан энэ хавьд нэн ховор амьтан болох бөхөн агнагдсан тухай мэдээлэл гараад байна л даа, та энэ талаар мэдэж байгаа зүйлсээ надад яриач?” гэж асууж болох юм. Тийм, үгүй гэж хариулахаар асуулт нь ярилцагчтай цаашид хийх ярилцлагын эхлэл болж чадахгүй хязгаарлагдах боломжтой. Тиймээс, аль болох нээлттэй, дэлгэрэнгүй, чөлөөтэй ярилцах боломжтой сэдвээр асуултыг эхэлж, ярилцлагыг үргэлжлүүлэх нь илүү их мэдээлэл олж авах боломжийг олгоно. Өөрөөр хэлбэл, тухайн асуултууд нь ам халж цаашид ярих сэдлийг өдөөхөөр байх хэрэгтэй.

Ярилцагчаа тухайн сэдвээр чөлөөтэй яриулахын тулд түүний хариултыг битгий таслаарай. Та зарим чөлөөтэй асуулт асуусныхаа дараа өвөрмөц асуултыг тавих хэрэгтэй. Жишээ нь, “хэн бөхөн агнасан бэ?” эсвэл “энэ үед та хаана байсан бэ?” гэх мэт.

Та түүнээс бүх хариултаа авах хүртлээ энгийн болон онцгой асуултуудыг хослуулан тавьж, ярилцлагыг үргэлжлүүлэх хэрэгтэй. Хэрвээ худлаа ярьж байгаа бол та түүнийг худлаа ярьж байна гэж шууд хэлэх хэрэггүй. Худлаа ярьж байгааг нь сайн тэмдэглэж авсны дараагаар ижил асуулт асууж, ижил хариулж байгаа эсэхээр нь түүнийг шалгаж болно. Дараа нь харин ярилцагчдаа худлаа ярьж байгааг нь хэлж, яагаад худлаа ярих болсон талаар нь асууж тодруулж болох юм. Та түүнээс зөвхөн үнэнийг л хүсэж байгаагаа хэлэх хэрэгтэй.

Хүлээн авсан мэдээллээ бариматжуул. Хэрвээ боломжтой бол ярилцагчийнхаа яриаг энгийн дуу хураагчид бичиж авах хэрэгтэй. Гэхдээ зарим хүмүүс дуу хураагч тавьсан үед чөлөөтэй ярьж чаддаггүй.

Ярилцлагын дундуур гарч болохгүй, энэ нь тухайн ярилцагчид үл хүндэтгэсэн сэтгэгдэл төрүүлэхээс гадна, ярилцагчид бодож төлөвлөн хариулах хугацаа олгох, түүний анхаарлыг сарниулах, ярилцагчийн яг хэлье гэж бодож байсан зүйлсийг мартуулах юм уу аман дээр тулж ирсэн үгээ «буцаан залгих» гэх мэт олон сөрөг талуудыг дагуулна.

Ярилцахдаа хөтөлж асуухгүй байх. Харин чиглүүлэх зорилгоор зарим зүйлийг санууулан хэлж өгч болно. Ярилцахдаа «хэн, хэзээ, юуг, хаана, яагаад, яаж» гэсэн асуултуудад хариулт авахаар асуултаа төлөвлөж, хариултаа авах хэрэгтэй.

Ярилцаж буй хүнийхээ худал хэлж буй эсэхийг мэдэхийн тулд дахин яриулах хэрэгтэй. Худлаа юм уу эсвэл хэтрүүлэн ярьж буй хүмүүс ярьсан зүйлээ дахин яг тэр чигээр нь ярьж чаддаггүй.

Худлаа ярьж байгаа хүмүүс нарийн ширийн зүйлийг хэзээ ч хэлж чаддаггүй. Та ярилцлагын үед нарийн ширийн зүйлсийг мэдэхийг хичээх хэрэгтэй. Ярилцагчийнхаа санаа бодлыг сорих юм уу эсхүл эсэргүүцэж болохгүй.

Асуултууд хоорондын хугацааг урт байлгаж болохгүй. Хэрвээ асуултуудыг хэт их зайтайгаар асуувал ярилцагч цаг хожиж өөрийнхөө хариултаа төлөвлөж эхэлдэг.

Товч тодорхой, сүрдүүлээгүй асуулт асуух. Та үг, үйлдлээрээ ярилцагчийнхаа нөхцөл байдал, санаа бодол, сонирхлыг ойлгож байгаагаа түүнд итгүүлэх хэрэгтэй.

Биеэ барьж, уурлахгүй байх. Нөхцөл байдал ямар ч байсан хамаагүй та биеэ барьж аль болох тайван байх хэрэгтэй бөгөөд хэзээ ч уурлаж болохгүй. Иймэрхүү байдал нь ярилцагчид таныг аргандаа оруулах боломжтой юм байна гэсэн ойлголтыг өгнө.

Ярилцлагаа дуусгахгүйгээр ямар нэгэн зүйл бүү амла. Ямар нэгэн шийтгэл оногдуулахыг зөвхөн шүүх л шийднэ гэдгийг та санаж байх ёстой.

Ярилцлагын төгсгөл. Ярилцагчаар гарын үсэг зуруулж, үнэн зөв бичсэн эсэхийг өөрөөр нь бичүүлж авах хэрэгтэй. Учир нь сэжигтнүүд мэдүүлгээ өөрчилдөг.

Сэжигтэнтэй ярилцах арга техник

Та сэжигтэнд өөрт тань олон мэдээлэл байгаа, түүнээс үнэнийг хэлэхийг хүлээж байгаагаа хэлж болно. Та бас түүнд бидний хамтын ажиллагаа нь ялыг хөнгөрүүлэх боломжтойг хэлж болно. Гэсэн хэдий ч ямар нэгэн зүйл бүү амла.

Сэжигтний үйлдэл, түүний хамсаатнууд дээр анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэй. Та хэн, юуг, хэзээ, яаж, яагаад гэсэн асуултуудад хариулт авахыг хичээх хэрэгтэй. Ялангуяа сэжигтэн худлаа ярьж байна гэж бодсон бол та түүнийг яриулаад байх хэрэгтэй, дараа нь та түүнд худлаа ярьсан гэдгийг нь ойлгомжтойгоор тайлбарлаж өгөөрэй. Сэжигтэн дараа нь таныг бүхнийг мэдэж байгаа гэдэгт итгэснээр танд бүх үнэнийг хэлэхээр шийдэж болох юм.

Сэжигтэнд зөвшөөрөхүйц санал тавих. Хэрвээ тэр зөвшөөрч байгаа, хууль зөрчсөн өөрийнхөн үйлдэл буруу гэдгийг хүлээж авахуйцаар тайлбарлаж өгсөн тохиолдолд сэжигтэн гэм буруугаа хүлээхэд бэлэн байдаг. Жишээ нь, сэжигтэн Тусгай хамгаалалттай газар нутагт амьтан агнасан бол та энэ үйлдлийг тухайн

сэжигтэнд өөрийнхөө гэр бүлийг тэжээхийн тулд хийсэн байх гэж хэлж болно. Хэдийгээр энэ нь худлаа байсан ч гэсэн сэжигтэн энэ шалтгааныг дэмжиж, үнэнээ хэлж магадгүй юм.

Буруугаа хүлээх. Хэрвээ сэжигтэн буруугаа хүлээвэл түүнтэй санал нийлж, хэн нэгэн нь түүнийг хууль зөрчихийг хүчилсэн, тулгасан эсэхийг асуух хэрэгтэй.

Гэрэл зургийг үзүүлэх. Та тухайн гэмт хэрэгтэй холбоотой зургуудыг сэжигтэнд үзүүлснээр тэр гэмт хэргийн дүр төрх, нөхцөл байдлыг эргэн санаж, улмаар тухайн гэмт хэрэг, зөрчилд гүйцэтгэсэн үүргийнхээ талаар үнэнээ хэлж магадгүй.

Хоёр үзүүртэй асуултыг ашиглах. Эдгээр асуулт нь хоёр боломжийн хариултуудыг агуулсан байдаг төдийгүй сэжигтнүүдийн хамсаатнууд руу хүрэх замыг заадаг. Жишээлбэл, “та буга агнахдаа буудаж алсан уу, эсвэл занга тавьсан уу?”, “та буга агнасныхаа дараа мах, эд эрхтэн (эвэр, сүүл, сав чив г.м)-ийг нь зарсан уу?” гэх мэт асуултууд байж болно.

Сэжигтний байр байдлыг шалгах. Ярилцлагын явцад та сэжигтнээс асуугдаж байхдаа юу мэдэрч байгааг асуух нь зүйтэй. Ингэснээр, гэм буруугүй хүн уурлах юм уу сандарч байснаа тантай хамтран ажиллаж эхэлдэг бол харин гэм буруутай хүн өөрийнхөн цагийг үрж байгаа, түүнийг доромжилж, эрхийг нь зөрчиж байна гэх мэт зүйл ярьсаар байдаг.

Та зарим мэддэггүй зүйлээ мэддэг юм шиг царайл. Та сэжигтэнд тухайн хэргийг мэдэхгүй байгаа бодит байдлыг мэдэж байна гэж хэлж болно, үнэнд аль болох ойрхон байх хэрэгтэй.

Сэжигтнийг ярьж буй байдал болон үйл хөдлөлөөр нь таних

Ихэнх хүмүүс хууль сахиулах байгууллагын ажилтантай ярилцаж байхдаа гэм буруугүй байсан ч эхэндээ сандрах юм уу уурлах, уцаарлах байдал гаргадаг. Гэсэн хэдий ч гэм буруугүй хүмүүс аажимдаа тайвширдаг бол гэмтнүүд улам л сандарна. Та хэн нэгнийг худлаа ярьж байна гэж буруутгалгүй хамтран ажиллах хэрэгтэй байгаагаа хэлээрэй.

Сэжигтний дараах байдлууд үнэнийг хэлж байгааг илтгэнэ. Үүнд:

- Ойлгогдохоор үндэслэлтэй хариулт өгч байх
- Цухалдаагүй, бардам ихэрхүү биш байж дөлгөөн намуухан байх
- Гэмт хэрэгт их санаа зовсон байх

- Чин сэтгэлээсээ хандаж байх
- Мэдээллээр хангахыг хүсэж байх.

Сэжигтний дараах үйл хөдлөлүүд үнэнийг илтгэнэ. Үүнд:

- Цэх суусан
- Чөлөөтэй байдлаар суугаад амарч байх
- Санаандгүй бөхийсөн
- Ярилцагчийнхаа өөдөөс эгц харж суусан
- Байрлалаа чөлөөтэй өөрчилж байх.

Сэжигтний дараах байдлууд худлаа хэлж буйг харуулна. Үүнд:

- Ээрэх юм уу дуу хоолойн чичрэх
- Асуудлыг өөрчлөхийг оролдох
- Гэм бурууг хэн нэгэн рүү түлхэх
- Халуун байна, ам цангаж байна, эсвэл өвчтэй, бие муу байна гэж гомдоллох
- Эелдэг бус байх
- Хэт их инээх буюу инээмсэглэх
- Уурлах, өөрийгөө гүтгүүлсэн гэж хэлэх
- Сэтгэлийн дарамтад орж, гутарсан байх
- Бүгдийг ярихгүй байх
- Асуултад хуурмаг байдлаар хариулах
- Асуултад хариулж чадахгүй байх
- Асуултад хариулахаас зайлсхийж, асуудлыг өөрчлөх гэж оролдох
- Ярилцагч хүнийхээ асуултыг дуусгалгүй асуултад хариулах
- Асуултыг дахин лавлах замаар хариултаа удаашруулах
- Юуг ч санахгүй байна гэж мэдүүлэх эсхүл хэт нарийн ширийн зүйлийг санах юм уу үзүүлдэг (тэр гэмт хэрэг гарсан долоо хоногийн туршид юу хийж байснаа сайн санаж байдаг)
- “Миний санаж байгаагаар» эсвэл «би ер нь яачихсан юм вэ» гэх мэтээр хариулах.

Дараах үйл хөдлөлүүд нь сэжигтнийг худлаа ярьж байгааг илтгэнэ. Үүнд:

- Таны урдаас эгц харж чадахгүй байх
- Хөлрөх
- Гараа ихээр савчих
- Юм тонших эсвэл гар хуруу, хөлөө байнга савчих
- Нүдээ дэндүү ихээр цавчих эсвэл эвшээх
- Уруулаа долоох юм уу хазлах
- Үзэг харандаа мэтийн зүйлээр тоглох
- Дэндүү ихээр тамхи татах

- Хөлөө ачих юм уу гараа элгэндээ эвхэх
- Бөгтийх
- Хажуу тийшээ буюу жишүү харж суух
- Юу ч сонирхохгүй байгаа царай гаргах
- Байн байн байрлалаа солих
- Ярилцагчаасаа холдох
- Холхих.

Сэжигтэн дараах байдал үзүүлбэл буруугаа хүлээх гэж байж магадгүй. Үүнд:

- Таныг хир их зүйл мэдэж байгааг асуух
- Зөрчил гаргасан хүмүүст юу тохиолдсоныг асуух
- Хэрвээ тэр мэдүүлэг өгвөл түүнд юу тохиолдохыг асуух
- Түүний үйлдэл ямар нэгэн зөрчил биш гэж хэлэх
- Толгойгоо гудайлгаж, лаг хийтэл суух.

Хууль сахиулагчийн ёс зүй

Ярилцлагын явцад таны гол зорилго бол үр ашигтай мэдээлэл бүрдүүлэх явдал. Биеийн болон оюун санааны хүчирхийллийг ямар ч тохиолдолд гаргахгүй байх хэрэгтэй. Тухайн сэжигтнийг айлган сүрдүүлэх, заналхийлсэн нөхцөл байдалд тэр таны асуусан асуултуудад бодож төлөвлөж хариулах бөгөөд яг үнэнийг хэлэхгүй.

ХУУЛЬ БУСААР АН АГНАХ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ

Хичээлийн товч танилцуулга, нэр томьёоны тайлбар

Хамрах хүрээ	Цагдаагийн алба хаагчид	Сургалтын хэлбэр	Лекц
Сургалт явуулах газар	Сургалтын танхим (заал)	Хугацаа	4 цаг
Хичээлийн товч танилцуулга	Суралцагчдад хууль бусаар ан агнах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зүйг тайлбарлан ойлгуулах, мэдлэгийг суралцагчийн оролцооны аргаар хамтран бүтээх		
Сургалтын арга зүй	Суралцагчийн оролцооны аргууд: тонгоруу анги, өөрөөр нь яриулах, эерэг ба сөрөг байдлаар дүгнүүлэх болон тайлбарлан ойлгуулах, сонсгож таниулах		
Хичээлийн товч агуулга			
Гэмт хэргээс урьдчилан сэргийлэлт, гэмт хэрэгтэй тэмцэхэд хамтын ажиллагааг зохион байгуулах, хууль бусаар ан агнах гэмт хэргийн олон улсын чиг хандлага болон урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд ашиглах судалгаа, танин мэдэхүйн талаар танилцуулна.			
Сургалтын хэрэглэгдэхүүн	-Цахим танилцуулга -фондын лекц -Хичээлийн хөтөлбөр, нэгж хичээлийн удирдамж -бусад		

Нэр томьёоны тайлбар	
Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил	**Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэл**
Гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсийг тогтоож, түүнийг арилгахад чиглэсэн эдийн засаг, нийгэм, эрх зүйн болон зохион байгуулалтын бусад арга хэмжээний нийлбэр цогцыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил гэнэ.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэл ерөнхий, тусгай, нэг бүрчилсэн, соён гэгээрүүлэх, гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх чиглэлээс бүрдэнэ.

Сэдвийн хүрээнд боловсруулсан хяналтын асуулт, гэрийн даалгавар, бие даалтын сэдэв, агуулга	Хяналтын асуулт
	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаа гэж юуг ойлгох бэ? Гэмт хэрэгтэй тэмцэхэд хамтын ажиллагааны ач холбогдол
	Бие даалтын сэдэв, агуулга
	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зүйг боловсруулах, судалгаа явуулах Гэмт хэрэгтэй тэмцэхэд хамтын ажиллагааны онцлог, ач холбогдол

Сургалтын үйл ажиллагаа

№	Үе шат	Багшийн үйл ажиллагаа	Хугацаа мин	Суралцагчийн үйл ажиллагаа	Анхаарах зүйл
1	Сэргээн санах буюу мэдлэгийг үнэлэх	Суралцагчидтай мэндчилж, өөрийгөө танилцуулна. Хичээлийн агуулгын талаар суралцагчдын үзэл хандлагыг асуулт асуух хэлбэрээр тодорхойлж, тэдний мэдлэгийн хүрээг тодорхойлно.	8	Багшийн дэвшүүлсэн асуудлыг шийдвэрлэх, ойлголт, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх	Хэлэлцүүлгийг хичээлийн сэдэвтэй уялдуулан чиглүүлэх, сэдвийн хүрээнээс гаргахгүй байх
2	Шинэ мэдлэг олгох үе шат	Урьдчилан бэлтгэсэн слайд дээр тулгуурлан лекцийг явуулахдаа суралцагчдын идэвхийг өрнүүлэх, сэдэл хэрэглэнэ.	40	Хичээлээр олж авсан өөрийн ойлголт, шинэ мэдлэгээ тэмдэглэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх	Лекцийн агуулгыг ойлгож буй эсэхэд анхаарах

3	Батагтах үе шат	Шинэ мэдлэгийг жишээ дээр тайлбарлах	10	Өөрийн зүгээс үзсэн сэдэвтэй холбоотой жишээ гаргах, түүнийг холбож тайлбарлах	Ярилцлагыг чиглүүлэх, дүгнэлт бичүүлж, бусдад нь сонсгох
4	Гэрийн даалгавар	Үзсэн хичээлийн сэдэвтэй холбоотой олж авсан мэдлэгээ батагтах үүднээс холбогдох материал уншиж судлах даалгавар өгнө.	2	Үзсэн сэдвийн хүрээнд уншсан ном, зохиол, сурах бичгээс товчлол бичих	
5	Дүгнэлт		Сургалтын үед гарсан амжилт, дутагдлыг тооцож, дараагийн сургалтад анхаарах, нэгж хичээлийн удирдамж, бэлдсэн лекц, заах арга зүйг баяжуулах.		

Лекцийн товч агуулга

Хууль бусаар ан агнах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зүйг тодорхойлох, тухайн чиглэлийн мэдлэг олгоно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоох үндэс болох нь

Гэмт хэрэг үйлдэгдэх болсон шалтгааныг тогтоох анхдагч үндэс, урьдчилан сэргийлэх ажлын уг сурвалж нь мөрдөн байцаалт, шүүх хуралдаан юм. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны явцад гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг нотолсон байхыг хуульчилж өгчээ. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат бүрд явуулж байдаг бөгөөд гэмт хэргийн тухай гомдол мэдээлэл, өргөдлийг хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэхээс уг ажил нь эхэлнэ.

Түүнчлэн хэргийн газрын үзлэг, нэгжлэг, шинээч томилж дүгнэлт гаргуулах, гэрч, хохирогчийг байцаах зэрэг мөрдөн шалгах ажиллагаа нь гэмт хэргийг бүрэн дүүрэн нотлох зорилгод чиглэгдэж, улмаар тухайн гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, дөхөм болсон нөхцөл байдлуудыг илрүүлэн тогтоох нь урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад ач холбогдолтой байдаг. Жишээлбэл, хууль бусаар ан агнах гэмт хэрэгт явуулж байгаа үзлэг, нэгжлэг нь үйлдэхээр

бэлтгэж байгаа өөр төрлийн гэмт хэргийг таслан зогсоох, хамтран үйлдэгчийг олж илрүүлэх, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан багаж, зэвсэг хэрэгсэл, эд зүйл зэрэг хэрэгт ач холбогдол бүхий зүйлийг илрүүлж, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлдэг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.6 дугаар зүйлд *"Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг тогтоомогц мөрдөгч, прокурор нь зохих хуулийн этгээдэд тэрхүү шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авхуулахаар мэдэгдэл бичнэ. Хуулийн этгээд нь мэдэгдлийн дагуу шаардлагатай арга хэмжээ авч, сарын дотор тэр тухай мөрдөгч, прокурор нарт хариу мэдэгдэх үүрэгтэй"* гэж заасан байдаг.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тогтоохдоо гэмт этгээдийн хувийн байдал, хэрэг үйлдэх үеийн орчны нөлөө, цаг хугацаа, үйлдлийн арга зэргийг нарийн судлан тогтооно. Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тогтоосон мөрдөгчийн мэдэгдлийн үнэ цэнтэй мэдээлэл нь урьдчилан сэргийлэлтийн нэг болж, иргэд, байгууллага төдийгүй хууль тогтоох, гүйцэтгэх засаглал, хууль хяналтын бусад байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндэс болж төрийн бодлогод зохих хэмжээгээр тусгагдаж байх тийм хүчин чадалтай юм.

Шүүн таслах ажиллагаа нь хууль бусаар ан агнах гэмт хэргийн шалтгаан, хор уршгийг олон нийтэд тодорхой харуулж байдгаараа бусдад сургамж, сэрэмжлүүлэг болдог. Энэ нь урьдчилан сэргийлэх ажлын нэг бөгөөд түүний үр нөлөөг өндөржүүлэх нь чухал юм. Шүүхээс гаргаж буй шударга шийдвэр нь гэмт хэргийг таслан зогсоох, дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх, хуулийг иргэдэд таниулан ойлгуулах зэрэг олон талын үүрэгтэй. Шүүхийн шийдвэр ил тод байдаг тул хүмүүжил, сургамжийн нөлөө үзүүлдэг. Шүүхийн ил тод байдлын хүрээнд таслан шийдвэрлэсэн (хаалттайгаас бусад) шүүхийн процесс, шийтгэх тогтоол цахим хэлбэрээр иргэдэд хүрч байгаа нь бусдад сургамж болгох, сэрэмжлүүлэх зорилгоор ашиглах боломж нээлттэй болсон.

Иймд, мөрдөх ажиллагааны үе шат бүхэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шинжийг агуулж байдаг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтаар эхэлж, гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тогтоосон судалгаа шинжилгээ нь орон нутаг, байгууллага, бүс нутаг, улсын хэмжээнд гэмт явдлаас сэргийлэхэд хэрэгжүүлэх ажлын голлох чиглэл, төрийн бодлого болон хувирч байдаг тийм өргөн цар хүрээтэй ажиллагаа юм. Ийм учраас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нягт нямбай, цогцоор нь хийвэл зохих нарийн чимхлүүр ажил байх ёстой.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зүй

Олон гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тогтоож, түүнд судалгаа шинжилгээ хийснээр улсын хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чиглэл, зорилго, зохион байгуулалт, тогтолцоо тодорхой болно.

Хууль бусаар ан агнах гэмт хэрэг ихэвчлэн орон нутагт үйлдэгддэг учраас тухайн газрын иргэдэд яриа, мэдээлэл хийх нь дахин гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой юм. Нөгөө талаар мөрдсөн хэргийг нэгтгэн судалж, дүгнэлт гарган төрийн захиргааны болон байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон нийтийн байгууллагуудад танилцуулга, илтгэл, сонсгол, хурал, санал асуулга, хэлэлцүүлэг зэрэг ажил зохион байгуулж байх нь зүйтэй юм.

Мөрдөгч нар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүргийнхээ дагуу иргэдэд хуулийн бодлогыг сурталчлах, хэрэг зөрчилд холбогдож болзошгүй хүмүүстэй нэг бүрчлэн ажиллах, хэвлэл радио, телевизээр хууль журмыг тайлбарлан таниулах яриа, лекц хийх ажилд идэвхтэй оролцохын зэрэгцээ өөрийн нөр их ажлын хажуугаар ямагт урьдчилан сэргийлэх ажлыг бололцооны түвшинд хийж байх ёстой. Түүнээс гадна, урьдчилан сэргийлэх талаар авсан арга хэмжээгээ газар дээр нь хэрэгжүүлэх, олон нийтийн байгууллага, нөхөрлөлд туслах ажил зохион явуулж байх нь зүйтэй.

Гэмт хэрэг, эрх зүйн зөрчил гарч болох нөхцөл байдлуудыг арилгахад чиглэсэн арга хэмжээг иж бүрэн, цогцоор нь зохион байгуулж байх нь хамгийн чухал, нэн тодорхой ажил юм. Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээг цагдаагийн байгууллага зохион байгуулахдаа:

Нэгд, гэмт хэргийн гаралтын байдал, хөдөлгөөн, бүтэц, шалтгаан, нөхцөлийн талаарх гэмт хэргийн тоо бүртгэлийн статистик материалд тулгуурлах;

Хоёрт, нийгмийн хүрээнд бий болсон бодит зөрчлүүдийг задлан шинжлэх;

Гуравт, гэмт хэргийн субъектын хувийн байдлыг харуулах үзүүлэлтүүдийг бүрэн судлах замаар тодорхойлох шаардлагатай байдаг.

Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэстэй явуулах үндсэн нөхцөл, арга зүй бол судалгаа юм. Аливаа гэмт хэргийг урьдчилан судлахдаа тэдгээрийг задлан шинжилж урьдчилан сэргийлэх чиглэлүүдээ гаргана. Гэмт хэргийн задлан шинжилгээгээр дор дурдсан үзүүлэлтийг тогтоож болно. Үүнд:

1. Гэмт хэргийн гаралтын байдал, түүний хөдөлгөөн, бүтэц, өөрчлөлт, шалтгаан, ялангуяа аюултай буюу түгээмэл дэлгэрсэн гэмт хэргийн байдал, хөдөлгөөн;
2. Гэмт хэрэг, эрх зүйн бусад зөрчлийн тархалтыг нутаг дэвсгэр, хүн амын суурьшил, үйлдвэржилт зэрэг нягтралаар харьцуулсан харьцаа;
3. Гэмт хэргийн хор аюулын шинж;
4. Гэмт үйл ажиллагааны зорилго, сэдлийг тодорхойлох статистик үнэлэлт;
5. Дахин давтан ба бүлэг гэмт хэрэг;
6. Гэмт хэрэг (нуугдмал гэмт хэрэг)-ийн илрүүлэлтийн түвшин зэрэг үзүүлэлтийг бүрэн хэмжээгээр тогтоосноор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад тус болохуйц үнэ цэнтэй дүгнэлт гаргаж болно.

Жишээ дурдвал, хууль бусаар ан агнах гэмт хэргийн өсөлт, бууралт, тэдгээрт ямар хөдөлгөөн гарч байгаа, тархалтыг тогтоосноор хаана, ямар объектод илүү хүчтэй ажил зохион байгуулж болохыг тодорхойлно. Гэхдээ гэмт явдлын задлан шинжилгээг нэг загвараар хийхийг шаардаж байгаа бус, тухайн нутаг дэвсгэрийн онцлогийг харгалзан олон янзаар хийхийг үгүйсгэхгүй.

Судалгааг илүү нарийвчилбал гэмт хэрэг гарч буй улирлын хэлбэлзлийг ч тогтоож болно. Өөрөөр хэлбэл, жилийн аль улиралд гэмт хэрэг илүү гарч байгааг тогтоосноор тухайн сард ямар ажил, ажиллагаа зохион байгуулж болохыг төлөвлөж болно. Тухайлбал, хаврын улиралд халиун буга, бор гөрөөс агнах, загас барих хэргүүд нэмэгдэх бол зуны улиралд тарвага агнах, намар, өвлийн улиралд үнэг, чоно, гахай зэрэг амьтдыг хууль бусаар агнах хэрэг ихэснэ.

Гэмт хэргийн хор аюулын шинж чанарт хийсэн судалгаагаар ямар зүйлийн амьтад илүү ихээр агнагдаж байгааг тогтооно. Аливаа үзэгдэлд задлан шинжилгээ хийхдээ түүний тухай бүх мэдээллийг заавал авах хэрэггүй, хамгийн чухал нь тэдний мөн чанарыг танин мэдэх илүү үр нөлөө бүхий арга замыг олох нь чухал[1] гэж үздэг.

Гэмт явдлын задлан шинжилгээг зөвхөн төрийн байгууллагуудад цугларсан тоон мэдээ төдийгөөр хязгаарлах бус олон нийтийн санаа бодлыг сонсох, фокус ярилцлага, социологийн судалгаа, хэвлэл мэдээлэлд дүн шинжилгээ хийх зэргээр судалгааг өргөн хүрээтэй явуулах нь үр дүнтэй. Задлан шинжилгээ нь зарим талаараа бэрхшээлтэй боловч практикийн хувьд зайлшгүй хэрэгцээтэй зүйл. Тухайн нутаг дэвсгэр, бүсийн хэмжээнд гэмт явдлын болон тодорхой

1 А.Г.Аванесов. Криминология и социальная профилактика М., 1980. 166 дахь тал.

төрлийн гэмт хэргийн задлан шинжилгээг арга зүйн дагуу чанарын өндөр түвшинд бололцоотой бүх үзүүлэлтээр хийсэн байх шаардлагагүй. Үүнд судалгааны ажлын мэдлэг, туршлага, цаг хугацаа ч дутах нь мэдээж. Гэхдээ энэ нь орон нутгийн түвшин дэх гэмт хэргийн судалгаа шинжилгээний ажлын чанар, шаардлагыг сулруулах учиргүй, харин хийсэн судалгаандаа гүнзгий дүгнэлт хийх нь практикийн тулгамдсан хэрэгцээ юм.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх криминологи прогноз буюу урьдчилан харалтыг тодорхойлох нь арга зүйн хувьд боломжтой боловч одоогоор урьдчилан харалтыг огт тодорхойлохгүй байна.

Хууль бусаар ан агнах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх криминологи прогноз буюу урьдчилан харалтын зорилт нь хэтдээ гарч болох гэмт явдлын бүх үзүүлэлтийн дэлгэрэнгүй мэдээлэлд тулгуурлан, төлөвлөгөө боловсруулахад оршино.

Криминологи прогнозыг бүрэн дүүрэн бодитой, шинжлэх ухаанчаар тодорхойлох нь гэмт явдлын цаашдын хандлага, түүнд нөлөөлж болох бусад байдлуудыг тогтоож, гэмт явдалтай тэмцэхэд иргэд, байгууллагуудын үйл ажиллагааг эртнээс бэлтгэх, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах, бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох, нөгөө талаас криминологийн шинжлэх ухаан болон урьдчилан харалтыг улам боловсронгуй болгох практик ач холбогдолтой юм. Криминологи прогнозыг ойрын, дунд, урт хугацааны гэж төрөлжүүлнэ.

Ойрын хугацааны прогноз нь 1 жил хүртэлх хугацааг хамаарч болно. Үүнд; эдийн засгийн байдал, үнэ ханшийн огцом өөрчлөлт, улс төрийн тогтворгүй байдал, хууль хяналтын байгууллагын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт зэрэг хүчин зүйлүүдийг тодорхойлж, түүний үндсэн дээр богино хугацааны төлөвлөгөө зохиож шуурхай арга хэмжээ авах боломжтой. Тухайлбал, 2013 оны сүүлчээс эхлэн манай улсад эдийн засгийн хүндрэл эхэлж, улс төр тогтворгүй болж, засгийн газар огцорч, төрийн байгууллагуудад орон тооны цомхотгол явагдаж, бараа таваарын үнэ өссөн зэргээс шалтгаалан зүүн аймгуудад цагаан зээрийг хууль бусаар их хэмжээгээр агнаж хүнсэндээ хэрэглэх, зарж борлуулах зэрэг сөрөг үзэгдэл гарч эхэлсэн баримт хууль хяналтын байгууллагад ихээхэн ирсэн байдаг. Ийм үед цагаан зээрийг хамгаалах богино хугацааны төлөвлөгөө зохиож болно.

Дунд хугацааны прогнозыг 4 жил хүртэлх хугацаагаар төлөвлөвөл зохимжтой. Учир нь криминологи прогнозыг тухайн УИХ-ын бүрэн эрхийн хугацаанд

хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн мөрийн хөтөлбөр, авах арга хэмжээний зорилттой уялдуулбал үр дүнд хүрнэ. Ховордож байгаа амьтан эсвэл аймаг, сум, бүс нутгийн хэмжээнд хууль бус агнуурtай тэмцэх зорилтыг мөрийн хөтөлбөрт оруулах зэргээр ашиглаж болно.

Урт хугацааны прогноз нь гэмт явдлын өрнөл, шалтгаан нөхцөл, үзэгдэл, түгээмэл зүй тогтол, урьдчилан сэргийлэхээр зохиосон ажлуудыг задлан дүгнэсэн судалгаанд үндэслэж байдгаараа богино, дунд хугацааны прогнозоос ялгаатай.

Прогнозыг хэрэгжүүлэгч нь төлөвлөлт бөгөөд энэ нь гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргийн хор уршгийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажиллагааны зорилго, зорилтыг хэрэгжүүлэх гол баталгаа юм. *Криминологи төлөвлөлт гэдэг нь өргөн утгаараа гэмт явдалтай тэмцэх мөрийн хөтөлбөр байдаг бол явцуу утгаараа гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх практик арга зам* гэж үзэж болно.

Гэмт хэрэгтэй тэмцэхэд хамтын ажиллагааг зохион байгуулах

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа ганц нэг байгууллагын хуулиар хүлээсэн үүрэг биш. Дангаар тэмцээд үр ашиг багатай болохыг дэлхий нийтийн туршлага нэгэнт батлаад байна.

Хууль сахиулах байгууллагууд шаардлагатай хүч хэрэгслээр бүрэн хангагдаагүй байдаг учир хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгтэй байгаль хамгаалах болон мэргэжлийн хяналт, шалгалтын бусад байгууллагуудтай тогтмол хамтран ажиллах шаардлага үүсэж байдаг.

Төрийн байгууллагуудад хуулиар хүлээлгэсэн маш олон чиг үүрэг байдаг бөгөөд ялангуяа гэмт явдалтай тэмцэх нийтлэг үүргийг хууль, хяналт, шалгалтын бусад байгууллагууд, иргэдийн оролцоотой хамтран ажиллахыг эрх зүйгээр зохицуулсан байдаг. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд хууль сахиулах, хэрэгжүүлэх, хамгаалах байгууллагын хамтын ажиллагаа гэмт хэрэг гарахад нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөлийг арилгахад чиглэгдсэн урт хугацааны системтэй, нөр их ажил бөгөөд бүх нийтийн идэвхийг өрнүүлсний үндсэн дээр зохион байгуулагдах цогц арга хэмжээ юм. Өөрөөр хэлбэл, хамтын ажиллагаа нь гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, дэг журмыг сахиулж, хуулийн хэрэгжилтийг хангах зорилгод нэгтгэгдэн, байгууллагууд хоорондоо харилцан зөвшилцсөний үндсэн дээр эрх тэгш, өөрсдийн хэм хэмжээний хүрээнд салбарынхаа онцлогт тохируулж, үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах ажиллагаа гэж ойлгож болно.

Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр нөлөөг дээшлүүлэх зайлшгүй нэг хүчин зүйл нь хамтын ажиллагаа бөгөөд байгууллагууд хоорондын үйл ажиллагааг зохицуулах явдал хамгаас чухал юм.

“Зохицуулалт нь аливаа ажил үйлдлийн хооронд зүй зохист харьцаа, хамаарал тогтоох, уялдуулах, нийцүүлэх гэсэн гол утгыг илэрхийлдэг[1]” байна. Тодруулж хэлбэл, олон төрлийн чиг үүрэгтэй байгууллага, ажилтны үйл ажиллагааг уялдуулан холбож, харилцан бие биеийн ажиллагаанд зохистой харьцаа тогтооход зохицуулалтын зорилго оршино.

Олон төрлийн байгууллага өөрсдийн өмнөх нийтлэг зорилтыг хүч хамсан шийдвэрлэхийн тулд тус тусын гүйцэтгэх үүрэг, гаргах хүч хөрөнгө, уг ажлыг эхлэх дуусгах хугацаа, хэрэгжүүлэх, дүгнэх арга, хэлбэр зэрэг олон талын асуудлыг урьдчилан тохиролцох буюу товлон тогтоож, түүний дагуу практик үйлдлүүдийг хооронд нь хэлхэж, холбож өгөх, ингэснээрээ тухайн ажил үүргийг хийдүүлэх, давхардуулж зэрэгцүүлэх явдлаас сэргийлж, объект (Жишээ нь, доод шатны байгууллагууд)-ыг хүндрүүлэхгүй байх, улмаар цаг, хүч, хөрөнгийн хэмнэлт гаргахад зохицуулалтын ач холбогдол илэрдэг[2] байна.

Хамтын ажиллагааг аль нэгэн байгууллагын санаачилгаас гадна, эрх зүйн зохицуулалтаар хэрэгжүүлнэ. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (шинэчилсэн найруулга)-д зааснаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар төрийн байгууллагын үүрэгт **«хуульд заасан эрх хэмжээний хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар бусад байгууллагад дэмжлэг үзүүлэх, харилцан мэдээлэл солилцох, хамтран ажиллах»**-аар заасан нь хамтын ажиллагааны голлох эрх зүйн зохицуулалт юм.

Сүүлийн үед хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирч, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар зохиож байгаа ажлын чанар дээшилж, тэдний хамтын хүчин чармайлтаар хүрээлэн буй орчны эсрэг зарим төрлийн гэмт хэргийн гаралт буурч, иргэдийн эрх зүйн боловсрол, хүмүүжлийн болон урьдчилан сэргийлэх ажлын систем тогтож, нэгдмэл үйл ажиллагаа явуулах туршлага зохих хэмжээгээр хуримтлагджээ.

Хамтран ажиллахдаа төрийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн биелэлтийг шалгах, гэмт явдлын байдал, бүтэц, хөдөлгөөн,

1 Ю. М. Козлов. Координация в управлении в народном хозяйстве в СССР. Изд Московского университета. 1976. 5 дахь тал.

2 Б.Чимэд. Хууль хамгаалах байгууллагуудын хамтын ажиллагааны зохицуулалт, түүний үндсэн хэлбэр // Социалист хууль ёс. 1979. №3. 28 дахь тал.

хандлагыг улсын хэмжээгээр болон засаг захиргааны нэгж, улс ардын аж ахуйн салбар, үйлдвэр, аж ахуйн газар, байгууллага, иргэдийн дунд судлах, тэдний хууль эрхийн мэдлэгийг дээшлүүлэх болон төр засгаас дэвшүүлсэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нийтлэг арга хэмжээний зорилттой уялдуулан зохиовол зохино. Хамтын уялдаа холбоог сайжруулж, үр нөлөөг дээшлүүлэхэд дараах үндсэн нөхцөлийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

- Юуны өмнө хамтран ажиллах төлөвлөлтийг зохиох, түүнийг хэрэгжүүлэх арга, шаардагдах хөрөнгө, зардал, цаг хугацааны талаар тохиролцсон байх ёстой.
- Хэрэгжүүлэх арга хэмжээ нь тухайн байгууллагын эрхлэх чиг үүрэг эрх хэмжээний дотор байхын зэрэгцээ нэг байгууллагын онцлог, эрх хэмжээ үүрэгт холбогдох асуудлыг нөгөө байгууллага шийдвэрлэхгүй байх ёстой.
- Байгууллагууд урьдчилан сэргийлэх хамтын ажиллагаагаа олон нийтийн хүчинд тулгуурлаж, тэдний туслалцааг авч хэрэгжүүлдэг байх нь зүйтэй.
- Хууль хяналт, шалгалтын байгууллагуудаас зохиох гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийн чухал хэсэг бол гэмт хэрэг, зөрчлийн байдал, түүнийг үйлдсэн этгээдийн тухай болон шалтгаан нөхцөлийн талаар бие биедээ харилцан мэдээлж байх явдал юм.

Хамтын ажиллагааны үүрэг нь нэгдсэн төлөвлөгөө боловсруулахаас эхэлнэ. Төлөвлөгөө хэтийн, дунд хугацааны буюу цаг үеийн, ойрын гэж байх нь гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлыг системтэй явуулахад ач холбогдолтой. Төлөвлөгөө нь зохион байгуулалтын асуудал, хамтран хийх хяналт шалгалтын ажил, судлах боловсруулах асуудал, ухуулга сурталчилгааны ажил, төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх гэсэн хэсгүүдээс бүрдэж болох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.

Хамтын ажиллагааны зохион байгуулалтын асуудалд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хурал зөвлөгөөн, хэлэлцүүлэг зохион байгуулах, тодорхой асуудлаар санал боловсруулах зэрэг асуудлууд багтана. Харин хамтран хийх хяналт шалгалтаар тодорхой газар орон, бүс нутаг, үйлдвэр, аж ахуйн нэгжид шалгалт явуулж, түүний үр дүнг хэлэлцэж, хамтран хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулна. Хамтын ажиллагаагаар ажлын хэсэг байгуулан гэмт явдлын бүтэц, хөдөлгөөн, гаралт, хандлага, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх ажлыг зохион явуулж байгаа ажлын практикийг судалж болно.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж байгаа ажлыг дотоод, гадаад хамтын ажиллагаа гэж ангилна.

Дотоод хамтын ажиллагаанд:

- Хууль сахиулах байгууллагуудын;
- Төрийн болон төрийн бус байгууллагуудын;
- Төр ба иргэдийн;
- Шинжлэх ухааны ба хуулийн байгууллага;
- Байгууллагын дотоод бүтцийн нэгжийн гэж хуваан үзэж болно.

Гадаад хамтын ажиллагаанд:

- Хөрш зэргэлдээ улсуудын;
- Бусад орны;
- Гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын байгууллагуудын (интерпол г.м) гэж хувааж үзнэ.

Хууль сахиулах байгууллагууд дараах ажлыг хамтран зохион байгуулах боломжтой. Үүнд:

- Гааль, мэргэжлийн хяналтын зэрэг байгууллагууд хууль бусаар ан агнах гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллээр хангах;
- Шаардлагатай үед мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах, тэдгээрт мэргэжлийн үүднээс дэмжлэг туслалцаа үзүүлэх;
- Зөрчлийг шийдвэрлэх;
- Гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөлийг арилгах талаар хуулийн байгууллагаас ирүүлсэн мэдэгдлийн мөрөөр урьдчилан сэргийлэх ажлуудыг зохион байгуулж, хариу мэдэгдэх;
- Байгаль хамгаалах чиглэлээр гадаад орны туршлага судлах;
- Хамтран сургалт зохиох;
- Нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ явуулах;
- Цагдаагийн байгууллагын зүгээс гааль, мэргэжлийн хяналтын байгууллагуудыг хяналтын үүргээ хэрэгжүүлэхэд бүхий л талын туслалцаа үзүүлж, хамтран ажиллах;
- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд төрийн эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдүүлэхээр тогтоосон дүрэм журам, стандартыг зөрчсөн тухай мэдээллийг илрүүлсэн тохиолдолд шилжүүлэх;
- Байгууллага, иргэдийн гомдол, мэдээллийн дагуу шалгасан асуудал нь гэмт хэргийн шинжгүй бол захиргааны болон бусад хариуцлага тооцуулахаар гааль, мэргэжлийн хяналтын байгууллагад шилжүүлэх;
- Зарим төрлийн лабораторийн шинжилгээг хийлгүүлэх;
- Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

- Мэдээллээ саадгүй солилцож байх зэрэг олон ажил зохион байгуулж болно.

Хамтын ажиллагаанд баримтлах зарчим

Хамтын ажиллагааны хүрээнд дараах зарчим баримтална. Үүнд:

- Тус тусын байгууллага, албан тушаалтан, ажилтанд хүндэтгэлтэй хандах,
- Хууль ёс дээдлэх,
- Шударга, шуурхай байх зэрэг болно.

Төрийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллахаас гадна, цагдаагийн байгууллага дотроо албадын хамтын ажиллагааг зохион байгуулах нь нэгдмэл байдлыг хангах, хүч бололцоогоо зөв хуваарилах, мэдээллийг шуурхай дамжуулах, гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох зэрэг олон талын ач холбогдолтой. Иймд, зохион байгуулалтын нэгжүүдэд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хамтын ажиллагааны хэлбэрүүд дараах зохион байгуулалттай байж болно. Үүнд:

а) Зохион байгуулалтын нэгжүүдийн хоорондох;
б) Зохион байгуулалттай нэгж–нутаг дэвсгэрийн байгууллага хоорондын;
в) Нутаг дэвсгэрийн байгууллага хоорондын гэж байгууллага, салбар нэгжээр авч үзэж болох юм.

Гадаад хамтын ажиллагаа

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн илтгэлд *“Хууль бус агнуур, ашиглалт нь ...хил дамнасан худалдааны зохион байгуулалттай гэмт хэргийн сүлжээ бий болсон байна”* хэмээн онцлон тэмдэглэсэн нь энэ гэмт хэргийн бүтэц, тархалт өөрчлөгдөж олон улсын шинжтэй болсны нотолгоо юм.

Хууль бусаар амьтны эд эрхтэн худалдаалах хэрэг, зөрчилтэй тэмцэх, хил дамжин үйлдэгдэж байгаа үйлдлийг таслан зогсоох, илрүүлэх, урьдчилан сэргийлэхэд хөрш орнуудын хууль сахиулах байгууллагууд хоорондын хамтын ажиллагаа онцгой чухал ач холбогдолтой бөгөөд хөрш орнуудтай гэрээ, хэлэлцээр байгуулан ажиллаж байна. Хамтын ажиллагаа хөрш орнуудын төрийн эрх барих дээд байгууллагын хооронд байгуулсан эрх зүйн баримт бичгээр баталгаажиж, үйл ажиллагааны чиглэл нь тодорхойлогдоно.

Хууль бусаар ан агнах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсооход хөрш зэргэлдээ улс (ОХУ, БНХАУ)-ын хууль сахиулах байгууллага болон Олон улсын цагдаагийн байгууллага Интерпол ихээхэн нөлөө, үүрэгтэй.

Манай улсын цагдаагийн байгууллага олон улсын болон хөрш оронтой байгуулсан гэрээний дагуу ижил эрх хэмжээтэй хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах санамж бичиг, гэрээг байгуулж ажиллахын зэрэгцээ, хилийн дагуу байрлах орон нутгийн цагдаагийн байгууллагууд тухайн улсын орон нутгийн цагдаагийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллаж байна. Орон нутгийн цагдаагийн байгууллагуудын хооронд байгуулах гэрээ, санамж бичиг байгуулах эрх зүйн үндэс нь хоёр улсын хооронд байгуулсан гэрээнээс гадна, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмаар зохицуулагдаж байна.

Тус журамд цагдаагийн байгууллага, албаа хаагч нь цагдаагийн төв байгууллагын даргад хөрш орны ижил эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллах хүсэлт тавин зөвшөөрөл авч, гэрээ байгуулахаар заасан. Одоогоор улсын хил дагуу байрлах 14 аймгийн дийлэнх нь хөрш орныхоо цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ хэлэлцээр байгуулан ажиллаж байна.

Иргэдийн оролцоо хамтын ажиллагааны хэлбэр болох нь

Амьтны эд эрхтний хууль бус худалдаанаас урьдчилан сэргийлэхэд төрийн байгууллагууд хоорондын хамтын ажиллагаанаас гадна, иргэдийн оролцоог хангах, түүнийг нэмэгдүүлэх нь өнөө үеийн чухал шаардлагын нэг болоод байна.

Байгаль хамгааллын менежментийн стратегийг боловсруулах явцад гаргасан нэг том алдаа нь нутгийн иргэдийн оролцоо, дэмжлэгийг дутуу үнэлэх, хүлээн зөвшөөрөхгүй байх явдал байсан. Төрийн байгууллага л дангаараа байгаль хамгааллын асуудлыг зохион байгуулж байсан менежментийн бодлого өнгөрсөн үед явагдаж байсан бол дэлхийн нийтийн хандлага нь иргэдийн оролцоог хангах, тэдгээрийг татан оролцуулах, нутгийн иргэдэд түшиглэх болсон. Иргэдийг байгаль хамгаалах ажилд татан оролцуулах нь хамтын ажиллагааны хамгийн идэвхтэй хэлбэр юм.

Нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль орчны менежментийг нэвтрүүлэх, иргэд, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, байгаль орчны стратегийн үнэлгээ болон аудитын тогтолцоог шинээр нэвтрүүлэх, ногоон эдийн засгийн

хөгжлийн үндсийг тавьснаар байгаль хамгааллын цоо шинэ эрх зүйн орчин бүрдсэн.

Байгаль хамгаалалд иргэний оролцооны анхдагч элемент нь тэднийг мэдээллээр хангах явдал юм. Иргэд аливаа асуудлаар мэдээлэлтэй болсон тохиолдолд оролцох боломж нээгдэж, оролцооны үндэс суурь тавигдана. Өнөөдрийн эрх зүйн зохицуулалтаар ч тэр иргэдийн хамтын ажиллагааны оролцооны хэлбэр нь мэдээллээр хангах, мэдээлэл авах гэсэн хэлбэр илүү түлхүү байна.

Мэдээллийг олон нийтэд ил байлгах үүргийг хуулиар даалгасан боловч хэн, ямар мэдээллийг хэзээ, ямар арга замаар нийтэд хүргэх талаар тодорхой механизмыг заалгүй “нийтэд мэдээлнэ”, “нийтэд ил байлгана”, “мэдээллээр хангана” гэх мэт тунхгийн шинжтэй, хариуцах эзэнгүй орхигдуулснаас гадна, нийтэд мэдээлэх үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд ямар хариуцлага хүлээлгэхийг тусгалгүй орхижээ.

Байгаль орчны зөрчлийн талаар үнэн зөв мэдээллийг холбогдох байгууллагад мэдээлсэн, иргэд, байгууллагыг урамшуулах тухай шинэлэг заалтууд Байгаль орчныг хамгаалах тухай, Амьтны тухай, Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуулиудад тусгагдсан[1] байдаг.

Гэхдээ иргэдээс байгаль орчны зөрчлийн мэдээллийг авах тогтсон арга, хэрэгсэл байхгүй, утсаар ярих, биечлэн уулзах зэргээр л мэдээлэл авч байна. Мэдээлэгчийг нууцалж чаддаггүй учраас хүмүүс бичгээр гарын үсэг зурж

1 Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 54 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах эдийн засгийн хөшүүрэг
4. Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн, түүнчлэн зөрчлийг илрүүлсэн, илрүүлэхэд бодитой туслалцаа үзүүлсэн иргэнд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн орлогын дүнгийн 15 хувьтай тэнцэх мөнгөн урамшууллыг сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгоно.
6. Энэ зүйлийн 4, 5, 8, 9 дэх хэсэгт заасан урамшуулал олгох журмыг Сангийн болон Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд батална.
7. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан мэдээлэгчийг холбогдох хууль тогтоомжийн дагуу нууцлана.
8. Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн иргэн, нөхөрлөл, төрийн бус байгууллагад 150000 төгрөгийн мөнгөн урамшууллыг сум, дүүргийн Засаг дарга ажлын 10 өдөрт багтаан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгоно.
/Энэ хэсгийг 2015 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар нэмсэн/
“Амьтны тухай хуулийн 8 дугаар зүйл. Зөрчил илрүүлсэн, мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулах
38.1. Амьтны тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийг илрүүлсэн, илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн буюу түүний тухай мэдээлэл өгсөн иргэнд уг мэдээлэл нь батлагдсан тохиолдолд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн хэмжээний 15 хувиар тооцож мөнгөн шагналыг сум, дүүргийн Засаг дарга олгоно.
“Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуулийн 14 дүгээр зүйл. Зөрчил илрүүлсэн, мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулах
14.1. Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийг илрүүлсэн буюу түүний тухай мэдээлэл өгсөн иргэнд уг мэдээлэл нь батлагдсан тохиолдолд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн хэмжээний 20 хүртэл хувиар тооцож мөнгөн шагналыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

мэдээлэл өгдөггүй. Нэгэнт гарын үсэг бүхий мэдээлэл байхгүй учраас мэдээлэл өгсөн хүнийг урамшуулах боломжгүй болдог. Мэдээлэл өгсөн иргэдийг урамшуулах хуулийн заалт хэрэгждэггүй, мэдээлэгч буюу мэдээллийн эх сурвалжийг нууцлах боломжгүй учраас нэг удаа мэдээлэл өгсөн хүн дахин мэдээлэл өгөх сонирхолгүй байдаг. Учир нь сум, орон нутгийн хүн бүр бие биеэ таньдаг, цуу яриа амархан тардаг учраас хэн мэдээлэл өгснийг бусад хүмүүс маш хурдан мэддэг, тэдэнд нэр хоч өгдөг, заналхийлэх явдал гардаг байна[1].

Иргэдийн оролцоотойгоор байгаль хамгааллын утга санааг бусад иргэдэд хүргэх нь урьдчилан сэргийлэх ажлын хамгийн үр дүнтэй, оновчтой хэлбэр мөн гэдгийг онцгой анхаарах хэрэгтэй.

Хууль бусаар ан агнах гэмт хэргийн олон улсын чиг хандлага

Өнөө үед дэлхий дахинд сэтгэл эмзэглүүлсэн, давын өмнө шийдвэрлэвэл зохих олон асуудал байна. Тухайлбал, гэмт хэргийн ертөнцөд алан хядах ажиллагаа, терроризм, галт зэвсэг, хар тамхи - мансууруулах бодис, мөнгө угаах, хүний наймаа, байгаль орчин, кибер, хууль бус цагаачлал, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн өсөлт хурдсаж, дэлхий нийтийн улс орнуудыг бараг бүхэлд нь хамрах боллоо. Үүний зэрэгцээ бидний хүрээлэн буй орчин, цаг хугацааны хувьсал өөрчлөлт, дэлхийн дулаарал, нийгмийн хөгжил, хүмүүний хэрэглээ, зохисгүй үйл ажиллагааны улмаас оршихуйн тэнцвэрт харьцаанд гүнзгий өөрчлөлт орж, байгалийн нөөц хомсдох, нөхөн сэргэхгүй, доройтох аюул бодитой болжээ.

Тулгамдсан олон асуудлуудаас амьтдын талаар яагаад чухалчлан үзэж байгаа нь хэд хэдэн үндэстэй юм. Энэ ертөнцийн тогтолцоо нэгдмэл цул, ялангуяа зэрлэг амьтан, ургамал нь олон төрөл, зүйл бөгөөд үзэсгэлэнтэй сайхан болоод янз бүрийн хэлбэр төрхөөрөө орлуулшгүй байгалийн бүрэлдэхүүн хэсэг юм. Түүнийг эдийн засгийн нүдээр харах юм бол маш их мөнгө, маш их боломж, хоол тэжээлийн хямдхан эх үүсвэр, орлуулшгүй бүтээгдэхүүн гэдгээр харж, хайр найргүй устгах, цөлмөх, худалдан ашиг олохоор улайрсан нь тэднийг бүрмөсөн устахад хүргэх юм уу, байгалийн жамаар нөхөн сэргэх боломжгүй хэмжээнд хүргэж байна.

Дэлхийн хэмжээнд хууль бус ан агнуур болон амьтны эд эрхтэн, бүтээгдэхүүнийг хууль бусаар худалдаалах гэмт хэрэг нь аль нэг орон, үндэстний хэмжээний бус даяарших шинжтэй болсоор байна. Хууль бус худалдаанд хамгийн ихээр

1 БОНБҮ дэх иргэдийн оролцоо мониторингийн тайлан. 2010. Хүний эрх хөгжил төв.
Байгаль орчны асуудлаар шийдвэр гаргахад олон нийтийн оролцоо судалгааны тайлан. 2011. Хүний эрх хөгжил төв.

өртөж байгаа амьтдыг ангилж үзвэл, хөхтөн, зөөлөн биетэн, загас, мөлхөгчид, шувуу, хавч хэлбэртэн, хоёр нутагтан, шүрэн биетэн, шавж, аалз хэлбэртэн, цагирган хорхой зэрэг амьтад байна. Тэдгээр амьтдыг хүмүүсийн хэрэглэж байгаа хэрэгцээ, шаардлагаар нь төрөлжүүлэн үзвэл:

а) Хүнсний хэрэгцээнд,
б) Эд хэрэглэл, амьтдын арьс үсээр хийсэн хувцас, гутал, ангийн чихмэл,
в) Эмийн бүтээгдэхүүн зэрэг болж байна.

Хууль бусаар агнаж байгаа амьтны эд эрхтнийг зөөж тээвэрлэн буй байдлаар нь ангилж үзвэл, агаарын, далайн, төмөр зам, автомашинаар болон тээвэр, шуудан, хувь хүний ачаа, тээшээр ихэвчлэн хил давуулан худалдаалж байна. **Энэ гэмт хэргийн бүтэц үндэстэн дамнасан, зохион байгуулалттай, олон сүлжээ бүхий бүлэглэлийн зүгээс үйлдэгдэж байгаагаараа онцлог бөгөөд хор уршигтай юм** *(Нэг зохион байгуулалттай бүлэглэлийг илрүүлэхэд бусад сүлжээ илрэх, үлдэх магадлал маш их, иймд олон улсын сүлжээг задлах шаардлагатай).*

Гэмт хэргийн урсгал чиглэл нь нийгэм, эдийн засгийн хөгжил сул, дорой эсвэл хөгжиж буй орнуудаас өндөр хөгжилтэй, хүн ам ихээр нягтран суусан орон руу чиглэсэн хөдөлгөөнтэй байна. Тухайлбал, АНУ, Канад зэрэг баруун бүсийн өндөр хөгжилтэй орнууд руу Латин Америк, Африк, Зүүн өмнөд Ази, Европ, ОХУ гэсэн чиглэлтэй, Европ, Хятад, ОХУ руу Зүүн өмнөд Ази, дундад Ази, Африк гэсэн чиглэлтэй байгаа тухай Олон улсын цагдаагийн байгууллага болох Интерполоос мэдээлжээ.

Амьтны хууль бус наймаа нь ашиг орлогын хувьд хар тамхи, зэвсгийн наймааны дараа орж, хамрах хүрээний хувьд улс орон бүрд тархсан байна. Гэмт хэрэгтнүүд олон улсын хэмжээнд хамтын зөвшилцөлд хүрээгүй, мөн улс бүр өөр өөрийн гэсэн эрх зүйн орчны ялгаатай байдлыг ашиглан гэмт хэрэг үйлддэг. Жишээлбэл, тэд нэг улсад ховор амьтныг агнаж, дараагийн улсад бараа бүтээгдэхүүнийг бэлдэж, өөр бас нэг улсаар экспортыг дамжуулдаг. Нэг улсад гэмт хэрэг гэж тооцогдох үйлдэл нөгөө улсад гэмт хэрэг гэж тооцогддоггүй. Ингэснээр, гэмт хэрэгтнүүд хуулийн хариуцлага хүлээх, шүүхийн өмнө татагдахдаа “өөрт нь аль ашигтай улсын шүүхээр шийтгүүлж” байна.

Эрдэмтэн, судлаачид хамгийн түрүүнд байгаль орчин болон ан амьтантай холбоотой гэмт хэргийг “ноцтой хэрэг” гэж үзэх хэрэгтэй хэмээн тодорхойлдог. Ингэхдээ хэргийн байдлаас шалтгаалан ял шийтгэлийг хүнд, хөнгөнөөр авч үзэх нь зүйтэй. Жишээлбэл, ангийн улирлын үед агнаж болохгүй амьтныг

андуурч агнасан анчин болон дэлхийд ховордсон хирсийг санаатайгаар агнаж буй хууль бус анчин хоёр хоорондоо эрс ялгаатай. Тиймээс ял шийтгэлийн асуудал бол маш нарийн төвөгтэй ажил юм. Байгаль орчны гэмт хэрэгтэй холбоотой дийлэнх хууль тогтоомж тухайн ойлголтыг зөвхөн ховордсон амьтан болон ургамлын хэмжээнд хязгаарладаг.

Интерполын зүгээс санхүүгийн гэмт хэрэг, авлига хээл хахууль, хууль бус худалдаа болон хүний наймаа гэх зэрэг хууль бус үйл ажиллагаа явуулдаг гэмт хэргийн сүлжээнүүд байгаль орчны гэмт хэрэгт ямар нэгэн байдлаар оролцож, аль эсхүл түүнд дэмжлэг үзүүлж байдаг болохыг хүлээн зөвшөөрсөн. Интерполын Ерөнхий Ассамблей 2014 онд байгаль орчны аюулгүй байдалд халтай аюулын талаар тогтоол гаргаж (AG-2014-RES-03), үүнд байгаль орчны гэмт хэрэг гэдэг ойлголтыг тодорхойлохын оронд Интерпол “байгаль орчны аюулгүй байдал” гэдэг зүйлд анхаарал хандуулан байгаль орчны гэмт хэрэг хэрхэн улс үндэстний үйлдвэрийн тогтвортой байдал, байгаль орчны чанар, байгалийн нөөц, биологийн төрөл зүйл, эдийн засаг болон хүний амьдралд нөлөөлдөг болохыг чухалчилсан. Энэ ойлголт, аргачлалыг Интерпол болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэлт, Эрүүгийн эрх зүйн асуудал хариуцсан Комисс (Commission on Crime Prevention and Criminal Justice - CCPCJ) ашиглаж эхэлсэн байна.

“Авлига, хээл хахууль бол хууль бусаар байгалийн гаралтай эд бараа болон түлээ, мод худалдаалж буй хэргийг үүсгэж буй үндсэн хүчин зүйл юм” гэж НҮБ-ын Гэмт хэрэг болон Мансуурах бодистой тэмцэх албанаас мэдээлж, байгаль орчны гэмт хэргийг цогц утгаар нь ойлгож, түүнийг зохицуулах хууль тогтоомжид дараах зүйлсийг тусгах шаардлагатай байгааг мэдэгдэж байна *(үүгээр зөвхөн хязгаарлагдахгүй)*. Үүнд: санхүүгийн ноцтой гэмт хэрэг, бизнес корпорацын гэмт хэрэг, хуурамчаар үйлдэх гэмт хэрэг, залилан мэхлэх гэмт хэрэг, зохион байгуулалттай гэмт хэрэг, алан хядах үйл ажиллагаа болон түүний санхүүжилт багтана *(алан хядах үйл ажиллагаа байгаль орчинд хор хөнөөл учруулах аль эсхүл байгалийн нөөц ашиглах, түүнийг улам дордуулах арга замаар хэрэгжиж байгаа тохиолдолд).*

2014 онд Лондон хотод болсон чуулга уулзалтад улс орны Засгийн газрын тэргүүн нар хууль бус агналт, түүхий эдийн худалдаанд хүчтэй арга хэмжээ авахыг уриалсан бол ОХУ, Япон зэрэг улсууд хууль бус ан агнуурын гэмт хэрэгт оногдуулдаг хариуцлагыг өндөржүүлж, тав хүртэл жилээр хорих ял оногдуулдаг болохоор хуульдаа тусгахаар хэлэлцэж байна. ОХУ-ын ерөнхийлөгч Путин хууль бус ан агнуур, худалдаа наймааг эдийн засгийн эсрэг үйл ажиллагаатай дүйцүүлэн үзэж, төрийн думд энэ талаар нухацтай авч үзэх

талаар мэдэгдэж байгаа бол Зүүн, Өмнөд Азийн TRAFFIC-ийн бүсийн захирал өнгөрсөн сард Бээжин хотноо “Зэрлэг амьтдын хууль бус бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ байсаар байна. Хууль бус эрэлтийг бууруулахад хэрэглэгчийн зан үйлийг өөрчлөх, олон нийтийн боловсрол мөн чухал байна” хэмээн онцлон тэмдэглэсэн байна.

Олон улсын хэмжээнд хэдий хэмжээний амьтан хууль бусаар худалдаалагдаж байгаа тоо баримтыг багцаалан тогтооход ихээхэн төвөгтэй байгаа бөгөөд үүнийг өдрөөс өдөрт тоо толгой нь хорогдож байгаа, устаж үгүй болж байгаа амьтны тооноос үнэн бодитой тоог харж болохыг Интерполоос мэдэгдсэн байдаг. Энэ гэмт хэрэгтэй тэмцэхэд хамтын хүчин чармайлт, хууль сахиулах байгууллагуудын хүчтэй ажиллагаа, олон нийтийн эерэг зөв үзэл бодол маш чухал юм.

Хууль бус энэхүү ажиллагаатай тэмцэхэд үндэстэн бүрийн хууль сахиулах байгууллагуудаас гадна, Олон улсын цагдаагийн байгууллага болох Интерпол ихээхэн нөлөө, үүрэгтэй. Интерпол нь 1992 оноос эхлэн “Байгаль орчны гэмт хэрэгтэй тэмцэх хороо[1]”-г байгуулж, олон улсын хэмжээнд байгаль орчны гэмт хэргийн чиг хандлагыг тодорхойлох, үндэстний хууль сахиулах байгууллагуудын уялдаа холбоо, хамтын ажиллагааг үндэсний товчоогоороо дамжуулан хэрэгжүүлж, гүйцэтгэн ирсэн байна. Интерполын Байгаль орчны гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөрт[2]:

- Тагнуулын бодлогод тулгуурлан байгаль орчны гэмт хэргийн цаана байгаа гэмт хэргийн сүлжээг задлахад дэлхий нийтийн болон бүс нутгийн үйл ажиллагааг чиглүүлэх;
- Хууль сахиулах байгууллагуудын шилдэг туршлагын гарын авлага, төлөвлөгөө, удирдамж болон бусад эх үүсвэрийг боловсруулж, бусдад түгээх;
- Интерполын Үндэсний төв товчоод, тэдний уялдаа холбоог сайжруулах замаар байгаль орчны хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг нэгтгэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Манай улсын цагдаагийн байгууллага Интерполын үндэсний товчоогоор дамжуулан үндэстэн дамнасан хар тамхи, хүн худалдаалах, зэвсгийн наймаа, хууль бусаар амьтны эд эрхтэн хил давуулан худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр Интерполын шугамаар ирэх илгээлт, хүсэлт, лавлагаа, хариуг хүлээн авах, хариу явуулах, хурал зөвлөгөөн, сургалт болон

1 Environmental crime http://www.interpol.int/Crime-areas/Environmental crime/Environmental-crime 2014.4.18
2 Global cooperation vital against soaring wildlife crime, Interpol president tells London conference http://www.sabrizain.org/traffic/londonconference/INTERPOL_speech.pdf.2014.4.18

интерполын материал, мэдээ, мэдээлэл солилцох зэргээр хамтран ажиллаж байна. Интерполын мэдээ, материалыг[1] хүлээн авах, дамжуулах ажиллагаа цагдаагийн төв байгууллагаас батлан гаргасан журмаар зохицуулж байна.

Хууль бусаар ан агнах гэмт хэрэг бусад гэмт хэрэгтэй холбогдох нь

Хууль бусаар ан агнах, амьтны эд эрхтэн, бүтээгдэхүүнийг хууль бусаар хил дамжуулан худалдаалах төрлийн гэмт хэрэг нь олон улсын хэмжээнд дангаараа үйлдэгддэггүй бөгөөд энэ төрлийн гэмт хэрэг бусад олон гэмт хэргийн дамжуулга, эхлэл болж байгаа тухай зарим бодит жишээ, баримтуудаас дор оруулаа.

Бодит жишээ 5. Био-терроризм болон үндэсний аюулгүй байдал – Жон Ф.Кеннедигийн нэрэмжит нисэх онгоцны буудал дээр мөрдөгчид Баруун Африкаас ирж буй зорчигчийн ачаа тээшийг үзэхэд, цүнхэндээ 8 сармагчны хүүр авч явсан гэмт үйлдлийг илрүүлжээ. Энэ нь ДОХ болон бусад халдварт өвчин дэгдээх аюултай байж болзошгүй.

Бодит жишээ 6. Зохион байгуулалттай гэмт хэрэг – Холбооны мөрдөн байцаагчид хэдэн тэрбум долларын ашигтай тэнцэх загасны түрс худалдаалж буй хар захыг хаав. Тухайн хар захыг олон улсад гэмт хэрэг үйлддэг зохион байгуулалттай гэмт хэргийн бүлгэм удирдаж байжээ.

Бодит жишээ 7. Амьтны хүчирхийлэл, тамлал, харгислал – Нохойн ДНХ-ийн мэдээллийн санг ашиглан амьтан судлалын шүүхийн шинжээчид Америк даяар хууль бус нохойн зодоон зохион байгуулж байсан хэрэгтнүүдийг баривчилсан ажээ.

Бодит жишээ 8. Олон улсын терроризм – Хууль бусаар заан болон хирс агнаж, соёог нь худалдаалснаар Африк дахь террорист бүлгүүд галт зэвсгийн наймаа, алан хядах үйл ажиллагааныхаа санхүүгийн эх үүсвэрийг олж байжээ.

1 Интерполын материалд – гарын дардас, гэрэл зураг, цахим мэдээлэл, ДНХ-ийн мэдээлэл зэрэг багтана. ЦЕГ-ын даргын 2010.06.30-ны өдрийн 351 дугаар тушаалаар батлагдсан “Интерполын мэдээ, материалыг хүлээн авах, дамжуулах” журам код №131. Монгол Улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. (Хоёрдугаар хэвлэл) УБ., 2012. 103 дахь тал.

Бодит жишээ 9. Хүнсний аюулгүй байдал – АНУ-ын Мэргэжлийн хяналтын алба, шинжлэн магадлахуйн амьтан судлалын лабораторитой хамтран Америк руу хуурамч шошготой орж ирж байсан далайн гаралтай хүнсний бүтээгдэхүүнийг илрүүлжээ. Энэ нь олон нийтийн эрүүл мэндийг хохирохоос гадна, тухайн бизнесийн салбар дахь нэр хүндийг унагаах эрсдэлтэй байжээ.

Бодит жишээ 10. Ноцтой гэмт хэрэг – Тэжээвэр амьтны шүлс, үс болон ялгадсанд шинжилгээ хийж, хүн амины хэрэг, бэлгийн хүчирхийлэл, орон байрны хулгай болон алан хядах гэмт хэрэг үйлдсэн хэрэгтнүүдийг баривчлах тохиолдол бий. Учир нь АНУ-д л гэхэд 78 сая нохой, 94 сая муур байдаг бөгөөд гэмт хэрэг үйлдэгдсэн газрын 62%-д нь мөн тэжээвэр амьтдын биологийн ул мөр байдаг байна. Чухам ийм төрлийн ул мөрийг тухайн үед ямар ч нотлох баримт олдоогүй хэргийг мөрдөхөд ашиглаж байна. Үүнээс гадна, амьтан тамладаг хүмүүс сэтгэцийн ямар нэгэн гаж нөлөөтэй байгааг судалгаагаар баталсан байна. Тухайлбал, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 80% нь тэдний нөхөр тэжээвэр амьтдыг урд өмнө ямар нэгэн байдлаар тамлаж, харгисалдаг байсан тухай мэдүүлэг өгдөг байна[66].

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаанд ашиглах объектын судалгаа

Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг сахиулах, хамгаалах үйл ажиллагаандаа Цагдаагийн албаны тухай хуульд зааснаар мэдээллийн сан үүсгэж ашигладаг. Мэдээллийн санд буй гэмт хэрэгт сэжиглэгдсэн болон мөрдөгдөж байгаа хүн, галт зэвсэг эзэмшигч, бусад мэдээллийг хууль бусаар ан агнах гэмт хэрэгтэй тэмцэхэд ашиглаж болно. Түүнээс гадна, цагдаагийн байгууллагын нутаг дэвсгэр хариуцсан ажилтнууд (хэсгийн байцаагч, төлөөлөгч, хэв журмын ажилтан, мөрдөгч) хууль бусаар ан агнах гэмт хэрэгтэй тэмцэхдээ, бидний хэлж дадсан “объект”-ын судалгааг дараах мэдээллээр баяжуулан ашиглах нь зүйтэй.

1 ASPCA. (2015) Protecting All the Victims of Domestic Violence. Дараах хаягаас харна уу: https://www.aspca.org/blog/protecting-all-victims-domestic-violence [Хандсан өдөр: 2017 оны 5 дугаар сарын 26]

Судалгааг хийхдээ Цагдаагийн албаны тухай хууль[1], Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль[2], Байгууллагын нууцын тухай хууль[3], Хувь хүний нууцын тухай хууль[4] болон бусад холбогдох эрхийн актуудыг мөрдлөг болгоно. Судалгаанд дараах мэдээлэл байх нь зүйтэй. Үүнд:

- Хариуцсан нутаг дэвсгэрийн байгаль орчин, цаг уурын онцлог, нэн ховор, ховор амьтдын тархац, агнуурын бүс нутгийн байршил бүхий газрын зураг;
- Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас жил бүр үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг аймаг, нийслэл тус бүрээр, аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сум, дүүрэг тус бүрээр тогтоосон дээд хязгаар болон Засгийн газраас тогтоосон тухайн жилд тусгай зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний тухай шийдвэрийг заавал үзэж байх нь таны хариуцсан нутаг дэвсгэрт хэчнээн зөвшөөрөл олгогдож байгаад хяналт тавихад дөхөмтэй;
- Сүргийн бүтцийн төлөв байдал, тархац, нөөцийг харгалзан тухайн агнуурын бүс нутагт ан хийх эсхүл зарим зүйл агнуурын амьтныг агнах, барихыг тодорхой хугацаагаар хориглосон тогтоол шийдвэр;
- Төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлтэй ховор амьд амьтны цуглуулга (амьтны хүрээлэн эсхүл үржүүлэг зохион байгуулж байгаа зэрэг) хийсэн иргэн, хуулийн этгээдийн тухай мэдээлэл;
- Агнуурын амьтан агнах, барих гэрээ, эрхийн бичиг, тусгай зөвшөөрөл, тодорхойлолтын загвар;
- Тухайн зүйл амьтны амьдрах орчин, экологи, эдийн засаг, эрх зүй болон нийгмийн ач холбогдлоор нь үнэлж, тусгай аргачлалын дагуу тооцсон “амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”;
- Байгаль хамгаалал, ан агнуурын нөөцийг хамгаалах чиглэлээр байгуулагдсан нөхөрлөл, төрийн бус байгууллагуудын байршил, хаяг, тухайн байгууллагуудын ажиллагсад, гишүүдийн нэр, харилцах утасны дугаар;
- Тухайн нутаг дэвсгэрт үйлдвэрлэлийн болон тусгай зориулалтаар ан агнах аж ахуйн нэгжийн талаарх мэдээлэл, ан хийх хугацаа, түүнд хяналт тавих график;
- Зөрчлийн тухай хуулиар амьтан агнах, барихыг хориглосон зүйл заалтыг зөрчиж арга хэмжээ тооцсон, зөрчлийн хэрэгт шалгагдаж байгаа болон хууль бусаар ан агнаж болзошгүй этгээдийн судалгаа;

1 Цагдаагийн албаны тухай хууль.
2 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль. 2019.
3 Байгууллагын нууцын тухай хууль. 1995. //Төрийн мэдээлэл. 1995. №4.
4 Хувь хүний нууцын тухай хууль. 1995. //Төрийн мэдээлэл. 1995. №4.

- Ан агнах зориулалтаар галт зэвсэг эзэмшигчид болон ан агнах сонирхолтой иргэдийн судалгаа;
- Хариуцсан нутаг дэвсгэртээ эргүүл, хяналт шалгалт явуулах болон отолт, боолт хийж болох газруудын байршил, газрын зураг;
- Байгаль орчныг хамгаалах чиглэлээр ЦЕГ-ын даргын гаргасан тушаал, шийдвэр, албан даалгавар болон Байгаль орчныг хамгаалах төрийн захиргааны төв байгууллага, Улсын мэргэжлийн хяналтын газар, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ, санамж бичиг, хамтран ажиллах журам;
- Амьтныг хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, Олон улсын гэрээ конвенц, Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллагын тогтоол, тушаал, журам, заавар, хөтөлбөр зэргээр судалгааг бүрдүүлэх нь зохимжтой.

Амьтан агнах, барих зарим арга, зэвсэг хэрэгслийн талаарх танин мэдэхүйн ойлголт

Хууль бусаар ан агнах гэмт хэргийг мөрдөхөд амьтан агнах уламжлалт арга болон «Амьтны тухай хууль”-аар амьтан агнах, барихад хориглох арга, зэвсэг хэрэгслийн талаар мэддэг байх нь хэргийг шалгахад ихээхэн дөхөмтэй байдаг.

Амьтан агнах уламжлалт аргууд

Амьтныг агнах уламжлалт олон арга байдаг. Тухайлбал, үргээх, отох, сахих, мөрдөх, өнгийх, дуудах, тусгай хэрэгсэл ашиглан занга, сааль, хавх, хаж, урхи тавьж агнана.

Амьтныг үргээж агнах, барих арга. Энэ аргаар туурайтан амьтан, үслэг ангийн алийг ч агнаж барьж болно. Үргээх аргыг ихэвчлэн ой тайгын бүсэд хэрэглэдэг. Ан амьтан байх газар оронд элдэв дуу чимээ гарган үргээж, амьтныг ой тайга, уул хад зэрэг бартаа саадтай газраас гарган отон сууж агнах арга юм.

Үргээх аргад хэд хэдэн анчин, үргээгчид оролцдогоороо онцлог юм. Агналтад оролцож буй хүмүүсийг үргээгчид, анчид гэж хуваана. Үргээж буй уул хад, ойн модноос амьтан гарч ирэхэд нь отож байж агнадаг учраас үзлэгээр хэчнээн хүн оролцсон, буудагч нарын байрлалыг тогтоох нь зүйтэй. Отооны сууринд сууж байгаа анчид тамхины иш, гутлын мөр, дах дэгтий (хэрвээ өмсөж байсан бол)-ний үс, үлдэгдэл, мөр үлдэх магадлалтай. Үргээлгийг морьтой болон явганаар хийдэг. Үргээлгэ нь гол төлөв 1,5-3 км орчим зайд явагдана.

Зарим зэрлэг амьтад болон гэрийн малын бэлчээр идээшил нутаг давхацдаг бөгөөд үүнтэй холбоотойгоор амьтад гэрийн малаас үргэдэггүй. Энэхүү онцлогийг ашиглан ан хийх арга байна.

Сахиж авлах арга. Амьтныг сахиж буудах арга нь идэвхтэй авлах аргын нэг бөгөөд энэ аргаар чоно, үнэг, хярс, бор гөрөөс, буга, аргаль, янгир зэрэг амьтдыг агнадаг. Агнуурын туурайтан амьтныг хужир, мараа, усанд ордог цэг эсвэл тогтмол идээшилдэг газар, махчин амьтдыг гэрийн болон бусад амьтны сэг зэм дээр сахиж буудаж агнахыг хэлнэ.

Тарвагыг нүхэнд нь хөөж оруулаад сахин агнаж болно. Сахиж буудахад тухайн амьтнаас анчин хүн биеэ халхалж хад чулуу, бут сөөг эсвэл зориудын нуувч бэлтгэн нуугдаж суудаг учраас үзлэгээр анчдын нуувч, хэвтрийг олж тогтоох нь чухал бөгөөд тэнд гутлын мөр болон ямар нэгэн эд зүйл үлдсэн байж болзошгүй. Түүнчлэн шөнө орой сартай үед сахиж агнах дэлгэц ашигладаг. Тэгвэл тэр дэлгэцийн үлдэгдэл зэрэг зүйл байж болзошгүй юм.

Мөрдөж агнах арга. Энэ аргыг ихэвчлэн өвөл, хавар, намрын улиралд хэрэглэнэ. Шинэхэн цас орсны дараах өглөө анчин эртлэн явж амьтны мөрийг мөшгөн хөөнө. Амьтны мөр олоод морьтой эсвэл явганаар мөрдөнө. Мөрдөх аргад олон хүн оролцдоггүй. Анчид өөрсдөө тухайн амьтны мөрийг таньж мөрдөхөөс гадна, анч нохой дагуулж мөрдүүлдэг. Амьтан мөрдөж агнадаг анчин нэлээд туршлагатай хүн байдаг. Ямар амьтны мөр болох, хэдүүлээ, хаашаа, аль чиглэлд явж байгаа, мөрийн шинэ хуучин эсэх, амьтанд дөхөж

очиж байгаа эсэх зэргийг таньж мэддэг хашир туршлагатай анчин байдгаараа онцлогтой.

Дуудаж агнах арга. Энэ арга нь амьтны биологийн зарим онцлогийг ашигладаг. Энэ аргаар туурайтан болон мэрэгч, махчин амьтдыг агнана. Амьтны ороо хөөцөлдөөний үед дуудаж агнах аргыг түгээмэл ашиглаж, ан хийдэг байна. Тухайлбал, буга согооны орооны үед модны хаяагаар бугын урамдлага хийх, чонын адил улих, аргаль угалзын мөргөлдөөнөөс үүсэх чимээ гаргах (эсгий гутал хавсран цохих) зэрэг дуу авиа гаргаж, тухайн амьтныг ирэх үед нь агнана. Өнөө үед зориулалтын шүгэл болон тусгайлан бэлдсэн үнэр, мэн ашигладаг болсон байна.

Өнгийж агнах арга. Тарвага, туурайтан амьтдыг агнахад энэ аргыг түгээмэл ашигладаг бөгөөд уулын орой, гүвээ, толгодын оройгоор сэмхэн өнгийж, тухайн амьтнаа агнах аргыг хэлнэ.

Аливаа амьтныг агнахад ямар нэгэн зэвсэг хэрэгсэл, арга ашиглан агнадаг. Жишээлбэл, ой хөвч, тайгад ан хийж байгаа анчид нохойг амьтан үргээх, хоргоох, бариулах зэрэгт тусгайлан сургаж, ан хийхэд ашиглана. Ихэнхдээ 2-3 нохой дагуулж явна. Анчид өвлийн цагт цана, чарга ашиглах нь бий.

Амьтны тухай хуулиар хориглосон зарим арга хэрэгслийн тухай

Агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих. Сааль гэдэг нь өөрөө харвадаг агнуурын нэг төрлийн зэвсэг юм. Хавчаахай хэлбэрийн сумтай, харвах нумтай хэрэгслийг ой модонд бэхэлж, сумыг нарийн оосроор татаж, амьтны хөл хүрмэгц мултарч харвахаар зам жимийг отуулан сойно. Сааль нь хүн төрөлхтний бүтээсэн анхны оньст зэвсэг юм.



Сааль сойлттой байгаа нь



Сааль харваж буй байдал

Саалийг Хөвсгөлийн тайгад цаатнууд ихэд хэрэглэдэг байсан боловч сүүлийн үед ашиглахаа больсон. Одоогоор ОХУ-ын иргэд улсын хил зөрчиж, манай улсын ой тайгад нэвтрэн сааль тавьж ан агнаж байгаа тухай мэдээлэл мэр сэр гарах болсон. Сааль тавих нь ихээхэн аюултай агнуурын зэвсэг тул хуулиар хоригложээ.

Буу сойх. Арга ажиллагаа механизм нь саальтай ижилхэн бөгөөд гагцхүү нум сумны оронд галт зэвсэг ашиглаж байгаагаараа онцлог. Буу сойх аргыг Сибирийн оросууд ан агнахдаа ихэвчлэн хэрэглэдэг. Манай улсад буу сойж ан агнаж байгаа баримт мэдээ одоогоор үгүй байна. Энэ арга нь тун аюултай учир Амьтны тухай хуульд амьтан агнах, барихад хориглох арга, зэвсэг хэрэглийн жагсаалтад оруулсан байдаг. Сааль, буу зэргийг сойсон анчид тухайн орон нутгийнхаа хүмүүст сааль буу тавьсан талаараа зарладаг байсан уламжлал нэгэнтээ алдагдсан байна.

Агнуурын амьтны жим дээр нүх ухах. Амьтад хужир мараа, өвс, усандаа нэг зам жимээр явдаг онцлогийг ашиглаж, амьтны зам жим дээр нүх ухаж, амсрыг нь өвс тэргүүтнээр таглаж, амьтныг гэнэдүүлэн унагаж, агнадаг агнуурын нэг төрлийн арга. Манай орны хангайн бүсийн анчид нүх ухаж, унагах дээрх аргыг “унанги” гэж нэрлэдэг бол ихэнх газарт “бүдэргэ” гэж нэрлэнэ. Түүнчлэн нүхийг ханан шөргөөр таглан өвсөөр хучиж, амьтны хөлийг тэгнүүлэн унжуулж барьдаг байна. Түүнийг “салтайвч өмсгөх” ч гэж нэрлэнэ. Энэ аргаар буга, хандгай, гахай зэрэг тураг анг ихэвчлэн агнана. Ухсан нүхэндээ шор хийх ч тохиолдол бий. Дээрх арга нь ихээхэн аюултай аргад тооцогддог бөгөөд амьтныг тарчлаан зовоож үхүүлдэг, түүнчлэн хүн ч түүнд унаж аюулд орж болзошгүй тул хуулиар хориглодог.

Занга. Амьтныг дарж, цохиж, боож барьдаг ангийн зэвсэг. Янз бүрийн зүйлийн амьтны бие чац, хүч чадлын байдлаас хамааран дарах, цохих, томогт, торог, бөгжин, хажаан хориг, хавчуур, хөмрөг, өмсгөл, шорой хадагт зэрэг олон төрлийн нэртэй занга бий. Занга нь агнуурын өөрөө баригч хэрэглийн нэг бөгөөд зөөврийн болон зөөврийн бус гэж байдаг. Зөөврийн бус зангыг энгийн бага ажиллагаа шаардагдах, хямд төсөр материалаар хийж, агнуурын эдэлбэр нутагт байрлуулж хэрэглэнэ.

Занганы ерөнхий байдал нь ямар нэгэн гуалин модны тайрдсаар хийсэн дарагч, цохигч хэсгүүд, оньс тэвхний тусламжтайгаар сойгддог, амьтан хөндөхөд бууж цохих, дарах зэргээр амьтныг авлахад зориулагдсан байна. Уг хэрэглийн бүтцийг хэрэм агнах занган дээр тайлбарлавал, 80 см урттай, 25 см өргөнтэй хоёр банзан хэрчим, сойх тэвх, тотго хэлнээс бүрдэнэ. Зангыг 1-1.5 м өндөрт ургаа модны мөчирт асааж байрлуулна. Зангыг сойсны дараа

3-4 м-ийн урттай, 10-15 см шургаагийг хүндрүүлэгч болгон ашиглана. Дээрх хэрэгслээр гол төлөв хэрэм, чандага, цагаан үен, солонго, суусар, булга мэтийн үслэг жижиг амьтдыг агнадаг.



Занга

Хавх тавих. Хавх нь өргөн тархсан агнуурын уламжлалт багаж зэвсгийн нэг бөгөөд тусгай төмөр хүрээнд бэхэлсэн 2 малтмал төмөр (хавирга), тэдгээрийг босгож хавчих шахуурга бүхий уян хатан хос гараас бүрдэнэ.

Хавх нь агнах ангийн төрлөөс шалтгаалан янз бүрийн дугаартай байх бөгөөд тухайн амьтны нэрээр нь нэрлэх тохиолдол бий. Тухайлбал, чонын хар хавх нь томоохон амьтанд зориулсан №7, дорго, шилүүсэнд №5-6, тарваганд №4-5, үнэг, хярсанд №2-3, зурам, хэрэмд №0-1 дугаарын хавхыг хэрэглэнэ.

Хавхыг амьтны жим, нүхний амсарт тулган булж, амьтныг барьж, агнадаг ихээхэн дэлгэрсэн арга юм. Том амьтанд зориулан тавьж буй хавхыг аргамжих юм уу гараас нь тээш (хүндрүүлэгч) зүүж булна. Хавхны хүндрүүлэгч нь мод гадас, чулуу, цул төмөр гэх мэт биетүүд байж болно.

Хавхыг байрлуулах байдлаар нь мөрний, нүхний, модны хавх гэж ангилна. Мөрний хавхыг амьтан гүйдэг жим зөрөг дээр тавьдаг бол нүхний хавхыг түүний амсарт нь тулгаж тавина. Харин модны хавхыг модны голд цүүцэн хэлбэртэй ишээр нь шаантаглаж бэхэлнэ. Дулааны улиралд том амьтдыг барих зориулалтаар усан дотор хавх бас тавьдаг байна.

Хавх тавьсан байдал



Жижиг үслэг амьтанд тавьсан хавх

Урхи. Амьтан, шувуудыг барьж, агнах зориулалтай чангардаг гогцоо, оосор бүхий нэгэн төрлийн агнуурын хэрэгсэл юм. Урхийг янз бүрийн материал, хагас гантай төмөр, зэс утас эсвэл адууны сүүл хялгасаар ч хийж болно. Урхийг амьтны нүх (тарвага, зурам г.м), ангийн ус уух, нуур голын хөвөө, эрэгт тавьдаг бөгөөд хөлийн, үзүүрийн гэсэн төрөлтэй байна. Хөлийн урхи нь шууд, мунат, чиргүүлт, аргамжаат, дүүжинт гэх мэт хэд хэдэн янз байдаг. Урхийг ганцаарчилсан эсвэл бүлгээр буюу хосоор нь гэж ангилна.



Тор зүүсэн байдал



Урхи

Хаж. Эрт үеэс хэрэглэж байсан агнуурын хэрэгсэл юм. Говь, талын анчид ихэнхдээ зээр агнахад хэрэглэдэг байжээ. Хажин мод, чулуун муна, чиргүүл, аргамжаатай тавьж байсан бөгөөд амьтны булчин шөрмөсийг хэрчиж, амьтныг тарчилган зовоодог тул хэрэглэхийг эртнээс хорилложээ.

Химийн болон тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах. Аливаа амьтныг агнаж, барихад химийн хүчтэй үйлчлэх элдэв хорт бодис, үнэртүүлэгч, нойрсуулагч, үхүүлэх болон үй олноор нь хоморголон устгах тэсрэх дэлбэрэх бодис ашиглахыг хуулиар хориглодог. Энэ арга нь амьтны нөхөн үржихүй, үр удам, амьдрах орчинд ихээхэн хор хөнөөлтэй.

Загасыг цахилгаан гүйдэл, хаалт, хашлага ашиглан агнахуй. Загас амьдарч буй усан орчинд янз бүрийн цочроогч (цахилгаан гүйдэл, гэрэл г.м) ашиглан загасыг барьж, агнахыг хуулиар хориглосон байдаг. Тухайлбал, усан дээр гэрэлт бамбар тусгахад жижиг загаснууд сүрэглэн нягтран бөөгнөрч заарцаглах үед хөөрцгөөр соруулж авладаг арга байх бөгөөд үүнийг хоригложээ. Тодорхой хэсэг газарт, цүнхээл, голын эрэг тохойд цахилгаан соронзон орон үүсгэж, тухайн орчинд байгаа загасыг хөдөлгөөнгүй болгох (зарим газарт хуучин аккумлятор хаяж соронзон орон үүсгэх г.м) эсхүл цахилгаан гүйдлээр цохиулах зэрэг хууль бус аргаар загасыг их хэмжээгээр агнах тохиолдлууд гарсаар байна.

Хаалт, хашлага ашиглан загас агнах гэдэг нь голын эхэнд эсвэл наран ээвэр гүехэн газарт (загасны идээшлэх, үржих, өвөлжих газрууд г.м) юм уу нүүдлийн замд (тодорхой нарийнхан газруудад) хаалт, хашлага тавьж, загаснуудыг бөөгнөрүүлэн барьж, агнадаг аргыг хэлдэг. Цөөхөн зүйл загаснууд тодорхой орчин нөхцөлд тогтвортой амьдардаг бол олонх зүйл загаснууд улирлаар нүүдэллэж (үржилд орох, дүрсээ шахах, идээшлэх, өвөлжих г.м) амьдардаг. Загасны энэхүү амьдралын онцлогийг ашигладаг арга юм.

Загасны тор, гувчуур - Загас агнуурын нэгэн төрлийн торон зэвсэг юм. Тор нь агнах загаснаас шалтгаалан олон янз байна. Агнуурын нөөц бүхий гол нууруудын загасны зүйлийн тэнцвэрт харьцааг алдагдуулахгүйгээр агнуурын загасны насны бүлгэмдэл, тэдгээрийн харьцаанд тохируулж, загас олборлох загалмайн торны нүдний хэмжээг тохируулан тавьдаг. Өөрөөр хэлбэл, тус торонд нас, бие гүйцээгүй юм уу ер нь жижиг загас орохгүй байхаар тохируулан тавьж болно.

Загалмайн тороор голчлон том загасыг загалмайгаар нь тээглүүлж барина. Загалмайн тор нь дээд талдаа хөвөгчтэй, доод талдаа хүндрүүлэгчтэй байх бөгөөд хэц маягаар татаж тавина. Тус торыг гүн усанд нарийн цээл голын урсгалыг хааж, хөндлөн татаад, хоёр талд нь гадаслаж бэхэлнэ. 1-2 хоногийн дараа нэг талаас нь татаж авах юм уу эсвэл торыг авалгүй, түүнд тээглэсэн загасыг түүж авч болно. Мөн торны дээд үед хөвүүр хийж, доод хэсэгт чулуу дүүжилж усанд хана мэт босгон тавьж болдог. Үйлдвэрлэлийн зориулалтаар загас олборлох загалмайн торыг MNS 5974:2009 стандарт шаардлагын дагуу 40х40, 50х50 хэмжээтэй, 1.5-2 м, 2-4 м, 4-6 м өргөнтэйгөөр зарим бүс нутаг (Хөвсгөл, Архангай, Баян-Өлгий, Увс, Завхан, Дорнод аймаг г.м)-ийн гол, нууруудад ялгаатай тавина.

Ахуйн хэрэгцээнд загас барихад тор хэрэглэх. Ахуйн хэрэгцээнд загас барихад Амьтны тухай хуульд зааснаар Монгол Улсын иргэн нэг удаагийн эрхийн бичгээр “агнуурын загас арван ширхгээс илүүгүй”, харин Монгол Улсад түр буюу байнга оршин суугаа гадаадын иргэн мөн төлбөр төлж зөвхөн ахуйн зориулалтаар загас барьж болно. Ахуй хэрэгцээнд загас барихдаа аливаа ямар нэгэн тор хэрэглэхийг хуулиар хориглосон.

Агнуурын амьтдыг агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх. Амьтныг авто тээврийн хэрэгслээр хөөж бахардуулах, нисдэг тэрэг ашиглан ан хийх нь хуулиар хориглосон аргын нэг юм. Манай улсад нисдэг тэргээр үнэг агнаж, онгоц осолдсон хэрэг гарч байсан.

Туурайтан амьтныг цасанд умбуулах, мөсөнд халтиргах, хясаа, эрэг ганга руу нисгэх. Туурайтан амьтныг хунгар цасанд умбуулж, гол мөрөн, нуур цөөрмийн мөсөнд халтиргах, хад асга, хясаа, эрэг ганга руу шахаж нисгэж агнах нь хуулиар хориглосон аргууд юм.

Зориулалтын бус буу сумаар ан агнах. Амьтны тухай хуульд “ангийн буу” гэж хийц, үзэмж, загвараараа байлдааны зэвсгээс ялгаатай, замагтай бууны хүхээнд нэг, дайзанд дөрвөөс илүүгүй, өөрөө цэнэглэгч (хагас автомат) бууны хүхээнд нэг, дайзанд таваас илүүгүй сумны багтаамжтай галт зэвсэг гэж тодорхойлжээ.

Харин зориулалтын бус буу сум гэдэг нь ангийн буунаас өөр галт зэвсэг, сумыг ойлгоно гэж заасан боловч байлдааны зориулалтаар үйлдвэрлэсэн бууг ангийн болгож өөрчилсөн галт зэвсгүүд ихэвчлэн иргэдийн гар дээр байна. Тухайлбал, Вепрь, Сайга, Тигр зэрэг ОХУ-д үйлдвэрлэсэн ангийн гэх буу нь АКМ, СВД зэрэг байлдааны зориулалттай галт зэвсгийг өөрчилсөн хувилбар юм. “Ан агнах зориулалттай галт зэвсгийн сум” гэж зүрхэвчгүй, тугалган хошуутай, нисэлтийн хурд нь ан агнахад зориулсан, ан агнах зориулалтаар үйлдвэрлэсэн галт биш сум байна.

Гэрэлтүүлэх хэрэгсэл ашиглаж агнах. Амьтад шөнийн цагаар ихэвчлэн гөрөөлж идээшлэх бөгөөд харанхуйд хурц гэрэл тусган гэрэлтүүлж, амьтны нүдийг гялбуулан түр зуур хөдөлгөөнгүй зогсох үед нь агнадаг арга. Шөнийн харанхуйд цагаан зээрийн сүрэг илүү ойртуулдаг бөгөөд хурц гэрэл тусгаж агнадаг ажээ. Ийм агналт ихэвчлэн шөнийн цагаар илүү амжилттай болдог байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХУУЛЬ БУСААР АН АГНАХ ЗӨРЧЛИЙГ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Хичээлийн товч танилцуулга, нэр томьёоны тайлбар

Хамрах хүрээ	Мэргэжлийн хяналт, гааль, хил хамгаалах байгууллагын алба хаагч нар	Сургалтын хэлбэр	Лекц
Сургалт явуулах газар	Сургалтын танхим (заал)	Хугацаа	2 цаг
Хичээлийн товч танилцуулга	Суралцагчдад гэмт хэрэг, зөрчлийн хууль зүйн ойлголт, онцлогийг тайлбарлаж, ойлгуулах, мэдлэгийг суралцагчийн оролцооны аргаар хамтран бүтээх		
Сургалтын арга зүй	Суралцагчийн оролцооны аргууд: тонгоруу анги, өөрөөр нь яриулах, эерэг ба сөрөг байдлаар дүгнүүлэх болон тайлбарлан ойлгуулах, сонсгож таниулах		
Хичээлийн товч агуулга			
• Зөрчлийн ойлголт • Зөрчлийн шинж, бүрэлдэхүүн			
Сургалтын хэрэглэгдэхүүн	- Цахим танилцуулга - Фондын лекц - Хичээлийн хөтөлбөр, нэгж хичээлийн удирдамж - Бусад		

Нэр томьёоны тайлбар		
Зөрчлийн шинж	**Зөрчлийн холбогдогч**	**Зөрчлийг шалгах субъект**
Нийгмийн харилцааг хамгаалж буй хэм хэмжээ болох зөрчлийн объект, хуульд заасан журмыг зөрчиж байгаа объектив үйлдэл, эс үйлдэл, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд буюу субъект, хууль, журмын заалтыг зөрчиж буйг ухамсарласан болон болгоомжгүйгээр үйлдэх, эс үйлдэл хийж байгаа субъектив санаа зорилго зэрэг бүрэлдэхүүнээс зөрчлийн шинж бүрдэнэ.	Зөрчил үйлдсэн, зөрчил үйлдэх үедээ хэрэг хариуцах чадвартай, насанд хүрсэн, Монгол Улсын иргэн, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд байна.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтныг ойлгоно. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.2, 6.10, 6.11-д заасан эрх бүхий албан тушаалтан болох - Хилийн төлөөлөгч, орлогч, туслагч; - Мэргэжлийн хяналтын улсын байцаагч; - Гаалийн улсын байцаагч нь Зөрчлийн тухай хуульд тодорхойлсон амьтан хамгаалах журмын талаарх зөрчлийг шалган шийдвэрлэнэ. Эрх бүхий албан тушаалтны эрх зүйн байдлыг тус тусын хуулиар тогтооно.

Сэдвийн хүрээнд боловсруулсан хяналтын асуулт, гэрийн даалгавар, бие даалтын сэдэв, агуулга	Хяналтын асуулт
	• Гэмт хэрэг, зөрчлийн ялгааг тайлбарлана уу? • Зөрчлийн бүрэлдэхүүний шинжийг нэрлэнэ үү? • Зөрчлийн тухай хуульд заасан зөрчлийг нэрлэнэ үү?
	Бие даалтын сэдэв, агуулга
	Зөрчлийн бүрэлдэхүүний шинжийн талаар дэлгэрүүлэн тодорхойлох

Зөрчлийн тухай ойлголт

Зөрчлийг шалган шийдвэрлэхэд тухайн зөрчлийн шинж, бүрэлдэхүүн, агуулга учир зүйг сайтар ойлгож мэдэх нь зөрчлийг бодитой, хууль зүйн дагуу шийдвэрлэх суурь нөхцөл болдог.

Монгол Улсын хууль, түүнд нийцүүлэн захиргааны хэм хэмжээ тогтоон гаргасан актыг зөрчиж буй үйлдэл, эс үйлдэхүйг зөрчил гэж үздэг. Гэм хор учруулсан ямар үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцох, тэдгээр зөрчлүүд нь бусад төрлийн зөрчлөөс ялгагдах ямар онцлог, шинжтэй болох, мөн тухайн зөрчилд хүлээлгэх хууль зүйн хариуцлагын төрөл, хэлбэр, хэмжээг Монгол

Улсын Зөрчлийн тухай хууль болон бусад хууль, мөн захиргааны хэм хэмжээний актаар тус тус тогтоодог.

Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн зорилго нь Үндсэн хуулиар олгосон хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдсөн эрхийг сэргээх зорилтын хүрээнд зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд оршино.

Гэмт хэрэг ба зөрчлийн ялгаа

Гэмт хэрэг, зөрчил нь эрх зүйн зөрчлийн төрлүүд бөгөөд хуульд заасан гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй юм.	
Гэмт хэрэг	**Зөрчил**
Ялгаа нь	
Эрүүгийн хуульд заасан байна.	Зөрчлийн тухай хуульд заасан байна.
Объектив шинж буюу үйлдэл, гэм хор, хор уршгаараа ялгагдана	

Зөрчлийн тухай хууль нь ерөнхий ба тусгай ангиас бүрдэх бөгөөд ерөнхий ангид зөрчлийн хуулийн зорилго, зарчим, үйлчлэх нутаг дэвсгэр, хугацаа, хөөн хэлэлцэх хугацаа, зөрчил, шийтгэл, албадлагын арга хэмжээний талаар тусгагдсан бол тусгай ангид зөрчлийн шинж, төрөл, онцлогоор нь 13 бүлэг болгон тодорхойлсон байдаг.

Зөрчлийн тухай хуульд заасан зөрчлийн шинж нь тухайн нийгмийн харилцааг хамгаалж буй хэм хэмжээ болох зөрчлийн объект, хуульд заасан журмыг зөрчиж байгаа объектив үйлдэл, эс үйлдэл, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд буюу субъект, хууль, журмын заалтыг зөрчиж буйг ухамсарласан болон болгоомжгүйгээр үйлдэх, эс үйлдэл хийж байгаа субъектив санаа зорилго зэрэг бүрэлдэхүүнээс бүрдэнэ.

Амьтан хамгаалах эрх зүйн зохицуулалтад Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан зүйл заалт томоохон байр суурийг эзэлдэг бөгөөд Зөрчлийн тухай хуулиар амьтан хамгаалах журмыг зөрчих зөрчлийг тус хуулийн 7 дугаар бүлгийн 7.3 дугаар зүйл. Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль зөрчих, 7.6 дугаар зүйл. Амьтны тухай хууль зөрчих зөрчил, 16 дугаар бүлгийн 16.1 дүгээр зүйл. Монгол Улсын хилийн тухай хууль зөрчих зэрэг зүйлд тус тус тусгасан байдаг.

АМЬТАН ХАМГААЛАХ ЖУРМЫН ТАЛААР ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ТУСГАГДСАН ЗҮЙЛ, ТҮҮНИЙ ШИНЖ

Хичээлийн товч танилцуулга, нэр томьёоны тайлбар

Хамрах хүрээ	Мэргэжлийн хяналт, гааль, хил хамгаалах байгууллагын алба хаагч нар	Сургалтын хэлбэр	Лекц
Сургалт явуулах газар	Сургалтын танхим (заал)	Хугацаа	4 цаг
Хичээлийн товч танилцуулга	Суралцагчдад Зөрчлийн тухай хуульд заасан Амьтны тухай хууль зөрчих, Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль зөрчих, Монгол Улсын хилийн тухай хууль зөрчих зэрэг зөрчлийн хууль зүйн ойлголт, онцлогийг тайлбарлаж, ойлгуулах, мэдлэгийг суралцагчийн оролцооны аргаар хамтран бүтээх		
Сургалтын арга зүй	Суралцагчийн оролцооны аргууд: тонгоруу анги, өөрөөр нь яриулах, эерэг ба сөрөг байдлаар дүгнүүлэх болон тайлбарлан ойлгуулах, сонсгож таниулах		
Хичээлийн товч агуулга			
• Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль зөрчих • Амьтны тухай хууль зөрчих • Монгол Улсын хилийн тухай хууль зөрчих			
Сургалтын хэрэглэгдэхүүн	- Цахим танилцуулга - Фондын лекц - Хичээлийн хөтөлбөр, нэгж хичээлийн удирдамж - Бусад		

Нэр томьёоны тайлбар		
Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенц	**Хилийн дэглэм**	**Хил орчмын дэглэм**
Конвенцийн зорилго нь Олон улсын хэмжээнд зэрлэг амьтан, ургамлын аль нэгэн зүйл олон улсын худалдаанд хэт их хэмжээгээр өртөж, устах аюулд орохоос хамгаалах, тухайн зүйлийг олон улсын хяналт зохицуулалттайгаар худалдаалахад чиглэгддэг олон улсын эрх зүйн гэрээ, хэлэлцээр юм Конвенцид Монгол Улс 1995 онд нэгдэн орсон.	Монгол Улсын хилийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасан “Улсын хилийг арчлан хамгаалах, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх, хилийн ус, хил дамнасан байгууламжийг ашиглах, хил дээр ан агнуур, ажил, үйлдвэрлэл явуулах, байгаль орчин, амьтныг хамгаалах журмаас бүрдэнэ”.	Монгол Улсын хилийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д заасан “Улсын хил орчмын дэглэмийн агуулга нь хилийн зурвас, боомт, бүсэд мөрдөх журмаас бүрдэнэ”.

Сэдвийн хүрээнд боловсруулсан хяналтын асуулт, гэрийн даалгавар, бие даалтын сэдэв, агуулга	Хяналтын асуулт
	• Амьтныг хамгаалах талаар Зөрчлийн тухай хуульд заасан зөрчлийг нэрлэнэ үү? • Зөрчлийн бүрэлдэхүүний шинжийг нэрлэнэ үү?
	Бие даалтын сэдэв, агуулга
	Зөрчлийн бүрэлдэхүүний шинжийн талаар дэлгэрүүлэн тодорхойлох

Энэ сэдэвт Амьтан хамгаалах талаар Зөрчлийн тухай хуульд заасан зүйл заалтын үндсэн шинж, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан уг зөрчлийг шалган шийдвэрлэх субъект, хөөн хэлэлцэх хугацаа зэрэг онцгойлон анхаарууштай асуудлуудыг оруулсан болно.

Зөрчлийн тухай хуулийн 7.3 дугаар зүйл. Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль зөрчих

Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль зөрчих

1.Монгол Улсын хуулиар ховор, нэн ховор амьтны жагсаалтад ороогүй боловч Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, эсхүл тэдгээрийн гаралтай эд зүйлийг зохих зөвшөөрөлгүйгээр улсын хилээр нэвтрүүлсэн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Энэ зөрчлийн зүйлд заасан Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенци гэдэг нь олон улсын хэмжээнд зэрлэг амьтан ургамлыг хамгаалах зорилго бүхий олон улсын эрх зүйн гэрээ, хэлэлцээр юм.

“Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)”-д Монгол Улс 1995 онд нэгдэн орсон. Конвенцийн зорилго нь зэрлэг амьтан, ургамлын аль нэгэн зүйл олон улсын худалдаанд хэт их хэмжээгээр өртөж, устах аюулд орохоос хамгаалах, тухайн зүйлийг олон улсын хяналт зохицуулалттайгаар худалдаалахад чиглэгддэг. Тус конвенц олон улсын хэмжээнд худалдаалахад хяналт тавивал зохих зүйлийн жагсаалтыг гаргадаг бөгөөд гишүүн орнууд тэдгээр зүйлийг хэт ихээр олборлож худалдаалахгүй байх үүргийг хүлээсэн байдаг. Тус конвенцийн I хавсралтад 675 амьтан, ургамлын зүйлийг багтаасан бөгөөд тэдгээрийг худалдаалахыг хориглосон, II хавсралтад 3700 орчим зүйл амьтан, 21000 зүйл ургамал багтаасан ба тэдгээрийг тодорхой хяналтад дор худалдаалах талаар тусгасан байдаг.

Монгол Улсаас тус конвенцийн I, II хавсралтад нийтдээ 14 зүйл хөхтөн, 72 зүйл шувуу, 8 зүйл ургамал, 2 зүйл загас тус бүр 1 зүйл шавж, мөлхөгч амьтад бүртгэгдсэн байна.

Энэхүү конвенц нь импортлогч болон экспортлогчид байгалийн нөөц баялгийг ашиглахдаа олон улсын хамтын ажиллагааны түвшинд тэгш хамтран ажиллах үүрэг, хариуцлага хүлээх, дэлхийн улс орнуудын хууль тогтоомж, эрх зүйн тогтолцоог уялдуулан зохицуулах механизм болж байдаг төдийгүй, зэрлэг

амьтан, ургамлын худалдааны талаарх мэдээ материалыг цуглуулан нэгтгэж, дүн шинжилгээ хийх, худалдаанд хяналт тавих шалгуурт үндэслэн зэрлэг амьтан, ургамлын зүйлийг ангилах арга хэрэгсэл ч болдог.

Зохих зөвшөөрөлгүйгээр улсын хилээр нэвтрүүлсэн гэдэг нь конвенцийн хавсралтад заагдсан зэрлэг амьтан, тэдгээрийн гаралтай эд зүйлийг гадаад улсад гаргах, зөвшөөрөлгүйгээр улсын хилээр нэвтрүүлсэн үйлдлийг ойлгоно. Улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу конвенцийн Монголын талын Удирдан зохицуулах зөвлөл олгодог.

Зөрчлийн холбогдогч нь конвенцийн хавсралтад заагдсан зэрлэг амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг зөвшөөрөлгүйгээр нэвтрүүлсэн зөрчил үйлдсэн, зөрчил үйлдэх үедээ арван зургаан насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай Монгол Улсын иргэн, гадаадын улсын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд байна.

Шийтгэл: Зөрчил үйлдсэн хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний (нэг сая) төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний (арван сая) төгрөгөөр торгох шийтгэл оногдуулна.

Зөрчлийн хөөн хэлэлцэх хугацаа: Зөрчил үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн бол зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахгүй болно.

Зөрчлийг шалгах субъект: Энэ зөрчлийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.2, 6.10, 6.11-т заасан эрх бүхий албан тушаалтан болох

- Хилийн төлөөлөгч, орлогч, туслагч;
- Мэргэжлийн хяналтын улсын байцаагч;
- Гаалийн улсын байцаагч зөрчлийг шалган шийдвэрлэнэ.

Эрх бүхий албан тушаалтны эрх зүйн байдлыг тус тусын хуулиар тогтооно.



Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйл. Амьтны тухай хууль зөрчих зөрчил

Зөрчлийн тухай хуулийн 2.6 дугаар зүйл. Амьтны тухай хууль зөрчих зөрчил

1. Хугацаа дууссан гэрээ, зөвшөөрлөөр, эсхүл гэрээ, зөвшөөрөлгүйгээр амьтныг:

1.1.Ашигласан;

1.2.Барьсан;

1.3.Агнасан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Зөрчлийг шалгах субъект: Амьтны тухай хууль зөрчих зөрчлийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.10-д заасан мэргэжлийн хяналтын улсын байцаагч дангаараа зөрчлийг шалган шийдвэрлэнэ.



Хугацаа дууссан гэрээ, зөвшөөрөл гэдэг нь зөвшөөрөл гэрээгээр тогтоосон хүчинтэй байх хугацаа нь дууссан байхыг ойлгоно.

Амьтныг агнах, барих хугацааг нарийвчлан эрхийн бичиг, тусгай зөвшөөрөл гэрээнд заадаг. Тухайлбал, Амьтны тухай хуульд зааснаар Монгол Улсын иргэнд ахуйн зориулалтаар шувуу, тарвага агнаж, загас барихад гурав хүртэл хоног, бусад агнуурын амьтан агнах, барихад тав хүртэл хоногийн хугацаагаар нэг удаагийн эрхийн бичгийг олгоно.

Засгийн газрын 2013 оны 93 дугаар тогтоолоор баталсан “Ховор амьтан агнах, барих тусгай зөвшөөрөл олгох журам”-д зааснаар агнуурын ховор загас барих нэг удаагийн тусгай зөвшөөрлийн хугацаа 14 хоног хүртэл байна.

Гэрээ, зөвшөөрөлгүй гэдэг нь Амьтны тухай хуульд зааснаар иргэн ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад эрхийн бичиг, иргэн, хуулийн этгээд тусгай зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад тусгай зөвшөөрөл аваагүй, үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад гэрээ байгуулаагүй байхыг ойлгоно.

Ашигласан гэдэг нь зохих зөвшөөрлийн хугацаа дууссан, гэрээ зөвшөөрөлгүйгээр аливаа зорилгоор ашиглаж буй үйлдлийг ойлгоно. Хуульд зааснаар иргэн, хуулийн этгээд нэн ховроос бусад амьтныг эрдэм шинжилгээний ажил, соёл урлаг, гоо зүйн зориулалт, хөрс бүрдүүлэх, байгалийг ариутгах, ургамалд тоос хүртээх зэрэг амьдралын үйл ажиллагааны хэрэгтэй чанарыг ашиглах, амьдралын үйл ажиллагааны бүтээгдэхүүнийг авах гэх мэт зорилгоор тодорхой нөхцөл, болзол бүхий гэрээ, зөвшөөрлийн үндсэн дээр ашиглаж болдог.

Амьтныг ашиглах зорилгоор агнаж, барьж болдог. Гэхдээ гагцхүү төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зохих зөвшөөрөл авсан байх ёстой.

Зөрчлийн холбогдогч нь хугацаа дууссан гэрээ, зөвшөөрлөөр, эсхүл гэрээ, зөвшөөрөлгүйгээр амьтныг ашигласан, барьсан, агнасан зөрчил үйлдсэн, зөрчил үйлдэх үедээ арван зургаан насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай Монгол Улсын иргэн, гадаадын улсын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд байна.

Шийтгэл: Зөрчил үйлдсэн хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулна.

Зөрчлийн хөөн хэлэлцэх хугацаа: Зөрчил үйлдсэнээс хойш зургаан сар өнгөрсөн бол зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахгүй болно.

Зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого гэж зөрчил үйлдэн олж авсан мөнгө, эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, тэдгээрийг арилжаалж бий болгосон бусад эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, тэдгээрийг түрээслэх, ашиглах замаар олсон бүх төрлийн орлогыг ойлгоно.

Зөрчил үйлдэхдээ ашигласан зэвсэг, хэрэгсэл, эд зүйл, тээврийн хэрэгсэл, уналга, зөрчилтэй бараа, бүтээгдэхүүн, эд зүйлийг хураана.

Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл нь зөрчил үйлдсэн хүний амьжиргааны эх үүсвэр болсон эд зүйл, хэрэгсэл бол тэдгээрийг хураахгүй.

Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйл. Амьтны тухай хууль зөрчих

2.Амьтныг ашиглах, барих, агнах зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



Амьтныг ашиглах, барих, агнах зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн гэдэг нь хууль, журмаар өөрт олгогдсон эрхийн бичиг, гэрээг бусдад ашиглуулахаар шилжүүлж байгаа үйлдлийг ойлгоно.

Шийтгэл: Зөрчил үйлдсэн хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулна.

Зөрчлийн хөөн хэлэлцэх хугацаа: Зөрчил үйлдсэнээс хойш зургаан сар өнгөрсөн бол зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахгүй.

Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйл. Амьтны тухай хууль зөрчих

3.Ан агнах, загас барих гэрээ, тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг буcдад шилжүүлсэн, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ан агнасан, барьсан, зохих гэрээ байгуулахгүйгээр үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнасан, барьсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Ан агнах, загас барих гэрээ, тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг бусдад шилжүүлсэн гэдэг нь Амьтны тухай хуулиар ан агнах, барих тусгай зөвшөөрөл, гэрээ, эрхийн бичгийг бусдад эзэмшүүлж, ашиглуулахаар шилжүүлж буй үйлдлийг ойлгоно.

Энэ үйлдэл нь Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “амьтныг ашиглах, барих, агнах зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн” үйлдлээс ялгагдах шинж нь “амьтныг ашиглах” зөвшөөрлөөс бусад тусгай зөвшөөрөл, гэрээ, эрхийн бичгийг шилжүүлж байгаа үйлдэл болон зөрчил гаргасан хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож шийтгэлийн хэмжээг чангаруулж байгаа санкцаараа тус тус ялгагдана.

Иймд амьтныг ашиглахад олгох зөвшөөрлийг бусдад шилжүүлэх болон ан агнах, загас барих гэрээ, тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг бусдад шилжүүлэх ялгааг сайтар ойлгож мэдэх хэрэгтэй.

Гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ан агнасан, барьсан гэдэг нь үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих гэрээнд заасан агнах, барих агнуурын амьтны нэр, тоо хэмжээг хэтрүүлэн агнаж барьж байгаа хууль бус үйлдэл юм. Төрийн захиргааны төв байгууллага жил бүр үйлдвэрлэлийн зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг тухайн нутаг дэвсгэрийн агнуурын амьтны нөөц, хэрэгцээг харгалзан аймаг, нийслэл тус бүрээр тогтоодог.

Ан амьтан агнах гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн агнасан, барьсан этгээдэд нөхөн төлбөр ногдуулна.

Зохих гэрээ байгуулахгүйгээр үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнасан, барьсан гэдэг нь хууль, журамд заасны дагуу гэрээ, хэлцэл хийхгүйгээр үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнаж, барьж байгаа идэвхтэй үйлдэл, үйл ажиллагаа юм.

Орон нутаг буюу сумын Засаг дарга тухайн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр, агнуурын амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх санхүүгийн чадавх, мэргэжлийн боловсон хүчин, ан хийх анчидтай байх зэрэг шалгуурыг үндэслэн хуулийн этгээдтэй үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих гэрээ байгуулдаг.

Зөрчлийн холбогдогч нь зөрчил үйлдсэн, зөрчил үйлдэх үедээ арван зургаан насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай Монгол Улсын иргэн, гадаадын улсын

иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд байна. Зохих гэрээ байгуулахгүйгээр үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнасан, барьсан гэдэг зөрчлийн холбогдогч нь гэрээ байгуулсан хуулийн этгээд байна.

Шийтгэл: Зөрчил үйлдсэн хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Зөрчлийн хөөн хэлэлцэх хугацаа: Зөрчил үйлдсэнээс хойш зургаан сар өнгөрсөн бол зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахгүй болно.

Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйл. Амьтны тухай хууль зөрчих

4.Агнуурын бүс нутгаас бусад газарт, эсхүл амьтныг агнах хориотой үед, эсхүл хориглосон хугацаанд, эсхүл хориглосон арга хэрэгслээр амьтныг барьсан, агнасан, тээвэрлэсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



Агнуурын бүс нутгаас бусад газарт гэдэг нь агнуурын нөөцийг тогтвортой ашиглах, хамгаалах зориулалт бүхий амьтны байршил, тархац нутаг бүхий нутгаас өөр газарт амьтан агнах, барих үйлдэл юм.

“Агнуурын бүс нутаг” гэдэг нь агнуурын нөөц арвинтай газрыг судалгаа, шинжилгээний үндсэн дээр тогтоож зөвхөн тухайн газарт ан агнуулах, харин агнуурын амьтны нөөц багатай бусад газарт ан хийлгэхгүй байх зорилго агуулсан ан амьтныг хамгаалах нэг хэлбэр юм.

Амьтныг агнах хориотой үед гэдэг нь хуулиар агнах барихыг хориглоогүй ч тархац, нөөц, хэвийн өсөлт үржил, амьдрах орчин нөхцөл хомсдох, муудан доройтох, ган зуд болсны улмаас төрийн захиргааны төв байгууллагаас тодорхой хугацаанд агнах, барихыг хориглосон амьтны талаар гарсан шийдвэрийн үеийг хориотой үед оруулж тооцдог. Амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах талаар Засгийн газар Амьтны тухай хуульд заасны дагуу сургийн бүтцийн төлөв байдал, тархац, нөөцийг харгалзан тухайн агнуурын бүс нутагт ан хийх, эсхүл зарим зүйл агнуурын амьтныг агнах, барихыг тодорхой хугацаагаар хориглох шийдвэрийг гаргах эрхийг хэрэгжүүлдэг.

Хориглосон хугацаанд гэдэг нь Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан хугацааг ойлгоно. Агнуурын амьтныг өсөж үржих, ороо хөөцөлдөөнд орох, үр зулзагаа гаргах, өсгөж бойжуулах зэрэг биологийн онцлог хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барихыг хориглодог. Тухайлбал, Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлд:

9.1.1.бор гөрөөс, цагаан зээр, зэрлэг гахайг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрөөс дараа оны 8 дугаар сарын 31-ний өдөр хүртэл;

9.1.2.ойн булга, хадны суусар, элбэнх, шилүүс, нохой зээх, шар үнэг, хярс үнэг, бараан хэрэм, ойн солонго, усны булга, өмхий хүрэн, мануул мий, хотны үен, цагаан үен, чандага туулай, бор туулайг жил бүрийн 2 дугаар сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл;

9.1.3.урт сүүлт зурам, тарвагыг жил бүрийн 10 дугаар сарын 16-ны өдрөөс дараа оны 8 дугаар сарын 20-ны өдөр хүртэл;

9.1.4.заарт хархыг жил бүрийн 2 дугаар сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл;

9.1.5.халздай доргыг жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны өдрөөс дараа оны 1 дүгээр сарын 31-ний өдөр хүртэл.

9.2.Ахуйн болон тусгай зориулалтаар дор дурдсан хугацаанд шувуу агнах, загас барихыг хориглоно:

9.2.1.шивэр хөтүү, дагуур ятуу, эрээнхавирга хахилаг, говийн ногтруу, хар хур, эгэл сойрыг жил бүрийн 3 дугаар сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэл;

9.2.2.галуу, нугас болон ус, намгийн бусад агнуурын шувууг жил бүрийн 4 дүгээр сарын 20-ны өдрөөс 8 дугаар сарын 31-ний өдөр хүртэл, 10 дугаар сарын 20-ны өдрөөс дараа оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэл;

9.2.3.дархадын цагаан загасыг жил бүрийн 8 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдөр хүртэл;

9.2.4.Буйр нуурын загасыг жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэл;

9.2.5.омоль загасыг жил бүрийн 8 дугаар сарын 30-ны өдрөөс 10 дугаар сарын 30-ны өдөр хүртэл;

9.2.6.зарам загасыг жил бүрийн 9 дүгээр сарын 05-ны өдрөөс дараа оны 1 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл;

9.2.7.алтайн сугас загасыг жил бүрийн 6 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 31-ний өдөр хүртэл;

9.2.8.энэ хуулийн 9.2.3-9.2.7-д зааснаас бусад загасыг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэл.

9.4.Тусгай зориулалтаар агнуурын ховор амьтныг агнах, барихыг хориглох хугацааг энэ хуулийн 9.7,9.8-д заасны дагуу тогтооно.

9.6.Энэ хуулийн 9.1, 9.2, 9.4, 9.5-д зааснаас бусад агнуурын амьтан агнах, барихыг хориглох хугацааг эрдэм шинжилгээний байгууллагын саналыг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

9.7.Энэ хуулийн 7.5-д заасан үндэслэлээр агнах ховор амьтныг дор дурдсан хугацаанд олзворын ангийн зориулалтаар агнахыг хориглоно:

9.7.1.угалзыг жил бүрийн 10 дугаар сарын 01-ний өдрөөс дараа оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл;

9.7.2.тэхийг жил бүрийн 10 дугаар сарын 16-ны өдрөөс дараа оны 7 дугаар сарын 14-ний өдөр хүртэл;

9.7.3.хар сүүлтийн зээрийн ооныг жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс дараа оны 8 дугаар сарын 31-ний өдөр хүртэл;

9.7.4.халиун бугыг жил бүрийн 9 дүгээр сарын 30-ны өдрөөс дараа оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл.

9.8.Энэ хуулийн 7.5-д заасан үндэслэлээр барих ховор амьтныг дор дурдсан хугацаанд судалгаа, шинжилгээнээс бусад тусгай зориулалтаар амьдаар барихыг хориглоно:

9.8.1.аргаль хонь, янгир ямааг жил бүрийн 10 дугаар сарын 20-ны өдрөөс дараа оны 8 дугаар сарын 20-ны өдөр хүртэл;

9.8.2.хар сүүлтийн зээрийг жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдрөөс дараа оны 7 дугаар сарын 15-ны өдөр хүртэл;

9.8.3.халиун бугыг жил бүрийн 10 дугаар сарын 20-ны өдрөөс дараа оны 6 дугаар сарын 20-ны өдөр хүртэл;

9.8.4.идлэг шонхор шувууг жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны өдрөөс дараа оны 6 дугаар сарын 20-ны өдөр хүртэл;

9.8.5.цармын бүргэдийг жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс дараа оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл;

9.8.6.тул загасыг жил бүрийн 10 дугаар сарын 30-ны өдрөөс дараа оны 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэл.

Зарим агнуурын амьтан агнах, барихыг хориглох хугацааг эрдэм шинжилгээний байгууллагын саналыг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно. Судалгаа, шинжилгээ, халдварт өвчнийг эрүүлжүүлэх зорилгоор агнуурын амьтныг агнах, барих тохиолдолд энэ хуульд заасан хугацааг харгалзахгүй байж болдог.

Хориглосон арга хэрэгслээр амьтныг барьсан, агнасан гэдэг нь амьтны тухай хуулиар хориглосон арга, зэвсэг хэрэгслээр агнаж, барьж буй үйлдлийг ойлгоно. Хориглосон арга зэвсэг хэрэгсэлд дараах арга, зэвсэг хэрэгсэл хамаарна. Үүнд:

- Химийн болон тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах;
- Агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих;
- Туурайтан амьтныг агнахад цасанд умбуулах, мөсөнд халтиргах, хясаа, эрэг, ганга руу нисгэх, хавх тавих;
- Тарвагыг нүхэнд нь утах, ус цутгах, хавх, урхи тавих, нохойгоор зориудаар бариулах;
- Агнуурын амьтныг агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх;
- Загас барихад буу, бамбар, цахилгаан гүйдэл, хаалт, хашилга, гувчуур хэрэглэх;
- Ахуйн хэрэгцээнд загас барихад тор хэрэглэх;
- Ан агнах зориулалтын бус буу, сумаар;
- Гол, мөрөнд бүх төрлийн завиар загасчлах.

Тээвэрлэсэн гэдэг нь нэг цэгээс нөгөө цэгт тээврийн хэрэгсэл ашиглан зөөж тээвэрлэж буй үйлдлийг ойлгох бөгөөд тээврийн хэрэгсэлд автомашинаас гадна, төмөр зам, нисэх онгоц, ердийн хөсөг ч хамаарна.

Шийтгэл: Зөрчил гаргасан хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Зөрчлийн хөөн хэлэлцэх хугацаа: Зөрчил үйлдсэнээс хойш зургаан сар өнгөрсөн бол зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахгүй болно.

Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйл. Амьтны тухай хууль зөрчих

5.Агнуурын амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг тусгай зөвшөөрөл, гарал үүслийн бичиг, дагалдах тодорхойлолтгүйгээр худалдсан, худалдан авсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



Тусгай зөвшөөрөл гэдэг нь иргэн, хуулийн этгээд тусгай зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад тусгай зөвшөөрөл олгож буй баримтыг ойлгоно. Тусгай зөвшөөрлийг зөвхөн тусгай зориулалтаар буюу агнуурын амьтныг эрдэм шинжилгээ, соёл урлаг, эмчилгээ, нутаг дэвсгэрт агнуурын амьтны сүргийн бүтцийг зохицуулах, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор болон иргэн спорт агнуур болон олзворын ангийн чиглэлээр агнуурын амьтан агнах барихад олгодог.

Тусгай зөвшөөрлийн загварыг төрийн захиргааны төв байгууллага батлан гаргана.

Гарал үүслийн бичиг гэдэг нь ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг нийслэл, өөр аймаг, сум, тэдгээрийн хооронд тээвэрлэх, худалдахад зохих журмын дагуу агнасан болохыг гэрчилсэн баримт юм. Амьтны тухай хуульд ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тухайн сум дахь байгаль хамгаалагч гарал үүслийн тодорхойлолт олгоно гэж заасан бөгөөд тодорхойлолтын загвар, олгох журам, тодорхойлолт олгогдвол зохих ан амьтан, тэдгээрийн түүхий эдийн жагсаалтыг төрийн захиргааны төв байгууллага батлан гаргадаг.

Амьтны тухай хуульд зааснаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/75 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар “Ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн гарал үүслийн тодорхойлолт олгох, хяналт тавих журам”, 2 дугаар хавсралтаар “Ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн гарал үүслийн тодорхойлолтын загвар”-ыг баталсан. Уг тушаалын дагуу ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн гарал үүслийн тодорхойлолт нь гарал үүслийн бичиг эсхүл зүүлт гэсэн хоёр хэлбэртэй байна. Зүүлт нь ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн гарал үүслийн тодорхойлолтын нэгэн адил хүчин төгөлдөр баримт зөвшөөрөл юм. Зүүлт нь цоожлогддог, гаднын нөлөөнд тэсвэртэй материалаар хийгдэх ба зарим жил өнгөөр ялгаатай хэвлүүлж болохоор тушаалд заажээ.

Журамд зааснаар гарал үүслийн бичгийг загас болон ангийн мах зэрэг ан амьтны гаралтай түргэн муудах түүхий эдэд олгох бөгөөд хүчинтэй байх дээд хугацаа нь 6 сараас илүүгүй байдаг.

Дагалдах тодорхойлолтгүйгээр худалдсан, худалдан авсан гэдэг нь зохих журмын дагуу буюу хууль ёсоор агнасан ан амьтны гаралтай түүхий эдийг хууль бусаар агнасан амьтны түүхий эдээс ялгах, худалдааг хяналттай байлгах зорилгоор амьтны түүхий эдэд дагалдах тодорхойлолтыг олгох бөгөөд түүнгүйгээр худалдаалж буй үйлдлийг ойлгоно.

Амьтны тухай хуулийн 12 дугаар зүйлд тодорхойлолт аваагүй амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглоно гэж заасан байдаг. Ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тухайн сум дахь байгаль хамгаалагч гарал үүслийн тодорхойлолт олгоно. Тодорхойлолтыг тухайн жилд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас баталсан ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнах агнуурын амьтны нэр, тоо хэмжээний жагсаалтад орсон амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдэд ан агнах эрхийн бичиг, гэрээг үндэслэн олгоно.

Дээрх зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна. Тодорхойлолт аваагүй амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг цуглуулсан, худалдсан, худалдан авсан этгээдийг тухайн зүйл амьтныг агнасан, барьсантай адилтган үзэж, нөхөн төлбөр ногдуулна.

Шийтгэл: Зөрчил гаргасан хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйл. Амьтны тухай хууль зөрчих
6.Амьтныг зөвшөөрөлгүйгээр нутагшуулсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



Амьтныг зөвшөөрөлгүйгээр нутагшуулсан гэдэгт зохих зөвшөөрөлгүйгээр амьтныг нутагшуулж буй үйлдэл, үйл ажиллагаа юм.

Аливаа амьтныг мэргэжлийн байгууллагын дүгнэлт, судалгаа шинжилгээний үндсэн дээр тухайн газар нутагт нутагшуулах ажлыг зохион байгуулдаг. Судалгаа шинжилгээ, зөвшөөрөлгүйгээр амьтныг нутагшуулснаар байгалийн тэнцэл алдагдах, халдварт өвчин гарч мал, гэрийн тэжээвэр амьтанд өвчин халдварлах, улмаар хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлөх, иргэн, хуулийн этгээдэд ямар нэгэн хохирол учирч болзошгүй учраас заавал мэргэжлийн байгууллагын санал, дүгнэлтэд тулгуурлан зохих зөвшөөрлийг олгодог.

Амьтны тухай хуульд сэргээн нутагшуулах гэсэн заалт байдаг. Энэ нь амьтныг хамгаалах, өсгөх үржүүлэх зорилгоор устах аюулд орсон, ховордсон амьтны зүйлийг урьд амьдарч байсан нутагт нь зориудаар зөөвөрлөн нутагшуулах үйл ажиллагааг гэж хуулийн нэр томьёоны тодорхойлолтод зааж хуульчилсан байдаг.

Амьтныг сэргээн нутагшуулахад ч гэсэн шинжлэх ухааны байгууллагын гаргасан дүгнэлтийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрөл, баталсан аргачлалын дагуу мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

Шийтгэл: Зөрчил гаргасан хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Зөрчлийн хөөн хэлэлцэх хугацаа: Амьтны тухай хууль зөрчих зөрчлийн 7.6 дугаар зүйлийн 6-д зааснаар зөрчил үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн бол зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахгүй болно.

Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйл. Амьтны тухай хууль зөрчих

7.Харь амьтныг зөвшөөрөлгүйгээр нутагшуулсан, өсгөж үржүүлсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



Харь амьтныг зөвшөөрөлгүйгээр нутагшуулсан, өсгөж үржүүлсэн. “Харь амьтан” гэж улсын хилийн гаднаас зориудаар болон санамсаргүй байдлаар зөөвөрлөгдөн ирж, нутагшиж байгаа амьтны зүйлийг ойлгоно. Харь амьтныг төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр нутагшуулах, өсгөж үржүүлэхийг хориглодог. Харь амьтныг өөрийн улсад оруулж ирэх бол зохих зөвшөөрлийг авсан байх ёстой. Харь амьтныг ашиглах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлан гаргадаг.

Шийтгэл: Зөрчил гаргасан хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Зөрчлийн хөөн хэлэлцэх хугацаа: Амьтны тухай хууль зөрчих зөрчлийн 7.6 дугаар зүйлийн 7-д зааснаар зөрчил үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн бол зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахгүй болно.

Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйл. Амьтны тухай хууль зөрчих

8.Энэ зүйлийн 5 дахь хэсэгт зааснаас бусад амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг гарал үүслийн тодорхойлолтгүйгээр худалдсан, худалдан авсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



Энэ зүйлийн 5 дахь хэсэгт зааснаас бусад амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг гарал үүслийн тодорхойлолтгүйгээр худалдсан, худалдан авсан гэдэгт Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан агнуурын амьтнаас бусад амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг гарал үүслийн тодорхойлолтгүйгээр худалдсан, худалдан авсан үйлдлийг тодорхойлсон байна.

Манай улсын нутагт дэвсгэрт байгалийн жамаараа оршин байдаг, унаган, нүүдлийн амьтдыг агнуурын болон агнуурын бус амьтад гэж хуваан үздэг. Агнуурын амьтан гэдэг нь арьс, үс, мах болон бусад түүхий эдийг нь ашиглахаар агнаж ирсэн уламжлалтай, агнуурын нөөцтэй амьтныг ойлгоно.

Сүүлийн жилүүдэд агнуурын бус, агнаж барьж ирсэн уламжлалгүй амьтдыг агнах, барих үйлдэл нэмэгдэх болсон. Иймд агнуурын бус амьтдыг хууль бусаар агнах, барих, тэдгээрийн түүхий эдийг зөвшөөрөлгүйгээр худалдаалах үйлдлийг эрх зүйгээр хамгаалж байгаагийн илрэл юм.

Шийтгэл: Зөрчил гаргасан хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Зөрчлийн хөөн хэлэлцэх хугацаа: Амьтны тухай хууль зөрчих зөрчлийн 7.6 дугаар зүйлийн 8-д зааснаар зөрчил үйлдсэнээс хойш зургаан сар өнгөрсөн бол зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахгүй болно.

Зөрчлийн тухай хуулийн 16.1 дүгээр зүйл. Монгол Улсын хилийн тухай хууль зөрчих

Зөрчлийн тухай хуулийн 16.1 дүгээр зүйл. Монгол Улсын хилийн тухай хууль зөрчих

1.Монгол Улсын:

1.1.хилийн болон хил орчмын дэглэм;

1.2.хилийн боомтод мөрдөх журам зөрчсөн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Хилийн боомтод хяналт шалгалтын тогтоосон дарааллыг зөрчсөн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Зөвшөөрөлгүйгээр хилийн боомтын хяналт шалгалтын бүсэд үйл ажиллагаа явуулсан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



Хилийн болон хил орчмын дэглэм зөрчих гэдэг ойлголтыг Монгол Улсын хилийн тухай хуульд заасан зүйл заалтаар тайлбарлана.

Хилийн дэглэм нь тус хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасан “Улсын хилийг арчлан хамгаалах, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх, хилийн ус, хил дамнасан байгууламжийг ашиглах, хил дээр ан агнуур, ажил, үйлдвэрлэл явуулах, байгаль орчин, амьтныг хамгаалах журмаас бүрдэнэ”,

Хил орчмын дэглэм гэдэг нь мөн хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д заасан “Улсын хил орчмын дэглэмийн агуулга нь хилийн зурвас, боомт, бүсэд мөрдөх журмаас бүрдэнэ” гэж тус тус тодорхойлжээ.

Хилийн орчмын дэглэмийн бүрэлдэхүүн хэсгийн нэг болох хилийн зурваст мөрдөх журам, хориглох зүйлийг тусгайлан зааж өгсөн бөгөөд түүнд амьтныг хамгаалахтай холбоотой дараах заалт байдаг. Үүнд:
Монгол Улсын хилийн тухай хуулийн 26.3.7-д “Улсын хилийн шугамаас 2000 метрийн дотор агнуурын амьтан агнах, барих, амьтныг хөөж хил давуулах”, энэ хуулийн 26.3.10-д “Хуулиар хориглосон арга, зэвсэг хэрэгслээр агнуурын амьтан агнах, барих”-ыг хориглосон тул Зөрчлийн тухай хуулийн 16.1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт заасан зөрчилд “Улсын хилийн шугамаас 2000 метрийн дотор агнуурын амьтан агнах, барих, амьтныг хөөж хил давуулах”, “Хуулиар хориглосон арга, зэвсэг хэрэгслээр агнуурын амьтан агнах, барих”-ыг хориглох заалт хамаарна.

Шийтгэл: Зөрчил гаргасан хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Зөрчлийн хөөн хэлэлцэх хугацаа: Зөрчил үйлдсэнээс хойш зургаан сар өнгөрсөн бол зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахгүй болно.

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

Хичээлийн товч танилцуулга, нэр томьёоны тайлбар

Хамрах хүрээ	Мэргэжлийн хяналт, гааль, хил хамгаалах байгууллагын алба хаагч нар	Сургалтын хэлбэр	Лекц
Сургалт явуулах газар	Сургалтын танхим (заал)	Хугацаа	4 цаг
Хичээлийн товч танилцуулга	Суралцагчид Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны ойлголт, онцлогийг тайлбарлаж, ойлгуулах, мэдлэгийг суралцагчийн оролцооны аргаар хамтран бүтээх		
Сургалтын арга зүй	Суралцагчийн оролцооны аргууд: тонгоруу анги, өөрөөр нь яриулах, эерэг ба сөрөг байдлаар дүгнүүлэх болон тайлбарлан ойлгуулах, сонсгож таниулах		
Хичээлийн товч агуулга			
• Үзлэг хийх • Мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах ажиллагаа • Эд зүйл, баримт бичиг хураан авах ажиллагаа • Эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаа • Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах • Мэдүүлэг авах ажиллагаа • Шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах ажиллагаа • Шинжилгээ хийлгэх ажиллагаа			
Сургалтын хэрэглэгдэхүүн	- Цахим танилцуулга - Фондын лекц - Хичээлийн хөтөлбөр, нэгж хичээлийн удирдамж - Бусад		

Нэр томьёоны тайлбар	
Зөрчил шалгах ажиллагаа	**Эрх бүхий албан тушаалтан**
Зөрчлийг түргэн шуурхай илрүүлэх, зөрчил гаргагч этгээдийг олж тогтоох, таслан зогсоох зорилгоор зөрчлийн хэрэгт ач холбогдол бүхий баримт сэлт, мэдээллийг олж авах, цуглуулах, шалгах үед заавал авч хэрэгжүүлэх хууль ёсны ажиллагаа.	Мэргэжлийн хяналтын улсын байцаагч – Төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэгч субъект Хилийн төлөөлөгч, хилийн төлөөлөгчийн орлогч, туслагч – хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гарсан зөрчлийг шийдвэрлэх чиг үүрэг бүхий албан тушаалтан Гаалийн улсын байцаагч – Гаалийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэгч субъект

Сэдвийн хүрээнд боловсруулсан хяналтын асуулт, гэрийн даалгавар, бие даалтын сэдэв, агуулга	Хяналтын асуулт
	• Зөрчлийн шалган шийдвэрлэх ажиллагааг тайлбарлана уу? • Зөрчил шалган шийдвэрлэх тодорхой ажиллагааг нэрлэнэ үү?
	Бие даалтын сэдэв, агуулга
	Зөрчлийн бүрэлдэхүүний шинжийн талаар дэлгэрүүлэн тодорхойлох

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа

Ан амьтантай холбоотой зөрчлийг шуурхай, бодитой, хууль зүйн дагуу шалгаж, шийдвэрлэх нь эрх бүхий албан тушаалтны үндсэн үүрэг мөн.

Зөрчил шалгах ажиллагаа гэдэг нь зөрчлийг түргэн шуурхай илрүүлэх, зөрчил гаргагч этгээдийг олж тогтоох, таслан зогсоох зорилгоор зөрчлийн хэрэгт ач холбогдол бүхий баримт сэлт, мэдээллийг олж авах, цуглуулах, шалгах үед заавал авч хэрэгжүүлэх хууль ёсны ажиллагаа мөн.

Зөрчил шалгах тодорхой ажиллагаа нь нэг талаас зөрчил шалгах процессыг хэвийн, тасралтгүй явуулах гол арга төдийгүй зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангах чухал хөшүүрэг юм.

Уг ажиллагаа нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зорилт, зарчмыг хэрэгжүүлэх нөхцөлөөс үүдэлтэй дараах зайлшгүй байдалд үндэслэгдсэн байдаг. Тухайлбал;

- Зөрчил үйлдэгдсэн, эс үйлдэгдсэн эсэхийг илрүүлэн тогтоох;
- Зөрчил үйлдсэн этгээдийг олж тогтоох;
- Зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, орчныг судлан тогтоох;

- Гэм буруугийн хэлбэр, хамааралт байдлыг шалган тогтоох;
- Зөрчлийн бүрэлдэхүүнийг шалган тогтоох;
- Зөрчлийн шалтгаан, нөхцөл, хүчин зүйлийг шалган тогтоох;
- Зөрчлийн ул мөр, нотлох баримтыг цуглуулж бэхжүүлэх, шалгах үнэлэх;
- Шийтгэл оногдуулах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэх ажиллагаа нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, шаардлагад тулгуурлан явагдана.

Амьтны тухай хууль зөрчих зөрчлийг мэргэжлийн хяналтын улсын байцаагч[1], Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль зөрчих зөрчлийг шалгах эрх бүхий албан тушаалтан нь хуульд заасан харьяаллаар хилийн төлөөлөгч, орлогч, туслагч[2], мэргэжлийн хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагч[3] байна.

Эрх бүхий албан тушаалтан:

- Чиг үүргээ хэрэгжүүлэх явцад энэ хуулиар шалган шийдвэрлэхээр харьяалуулсан зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг өөрөө илрүүлсэн;
- Хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас зөрчлийн талаар гомдол гаргасан, мэдээлсэн;
- Зөрчил үйлдсэн хүн өөрийгөө илчилж ирсэн;
- Байгууллага, албан тушаалтнаас харьяаллын дагуу зөрчлийн талаарх холбогдох баримтыг шилжүүлэн ирүүлсэн тохиолдолд прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулна.

Эрх бүхий албан тушаалтан зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг илрүүлсэн, эсхүл гомдол, мэдээллийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор шалгаад,

- Гомдол мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэх;
- Гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзах;
- Хялбарчилсан журмаар зөрчлийг шалган шийдвэрлэх;
- Зөрчлийн хэрэг нээх шийдвэрийн аль нэгийг гаргана.

1 **Мэргэжлийн хяналтын улсын байцаагч** – Төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэгч субьект

2 **Хилийн төлөөлөгч, хилийн төлөөлөгчийн орлогч, туслагч** – хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гарсан зөрчлийг шийдвэрлэх чиг үүрэг бүхий албан тушаалтан

3 **Гаалийн улсын байцаагч** – Гаалийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэгч субъект

Зөрчил шалгах тодорхой ажиллагаа явуулах журам

Эрх бүхий албан тушаалтан дээр дурдсан тодорхой шалгах ажиллагаа явуулж, нотлох баримт цуглуулж, бэхжүүлнэ.

Үзлэг хийх

Үзлэг хийх ажиллагаа нь зөрчил шалгах ажиллагааны нэгэн төрөл юм. Энэ нь нотлох баримтыг олж тогтоох чухал хөшүүрэг гэж үзэж болно.

Үзлэг гэдэг нь зөрчлийн талаарх нотлох баримтыг тогтоох, зөрчил үйлдэгдсэн байдал, зөрчлийн ул мөр, эд мөрийн баримтыг олох, зөрчлийн хэрэгт ач холбогдол бүхий байдлыг тодруулах зорилгоор эрх бүхий албан тушаалтнаас зөрчил үйлдэгдсэн газар, хүн, хуулийн этгээдийн эзэмшил газар, барилга

байгууламж, тээврийн хэрэгсэл, хүний бие, эд зүйлд хийж буй зөрчил шалгах ажиллагаа юм.

Амьтантай холбоотой зөрчлийг шалгах ажиллагаанд хүний биед хийх үзлэгийг Зөрчил шалган шийдвэрлэх хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.2-д заасан хилийн төлөөлөгч, орлогч, туслагч, 6.11-д заасан гаалийн улсын байцаагч бүхий эрх бүхий албан тушаалтан хийнэ.

Эрх бүхий дээрх албан тушаалтан нь хүний биед үзлэг хийхдээ тухайн хүнд байгаа зүйлийг нь гаргуулах эсхүл гадна талаас нь харах, гараар тэмтрэх, тусгай багаж ашиглах аргаар хийж болохын зэрэгцээ тухайн хүний өмссөн хувцас, биедээ авч яваа эд зүйлийг хамтад нь үзнэ.

Орон байр буюу хүн, хуулийн этгээдийн эзэмшил газар, барилга байгууламжид хийх үзлэгийг гагцхүү прокурорын зөвшөөрлөөр хийнэ.

Эд зүйл, баримт бичиг, ачаа тээш, мал, амьтан, тээврийн хэрэгсэлд үзлэг хийхэд эзэмшигчийг байлцуулна. Эзэмшигчийг оролцуулах боломжгүй бол хөндлөнгийн гэрчийг байлцуулах эсхүл гэрэл зураг, дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлнэ.

Амьтантай холбоо бүхий зөрчилд амьд амьтан барьсан эсхүл зэрлэг амьтан нь хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй гэж үзвэл, мөн нарийн мэргэжил, мэдлэг шаардагдахаар байвал үзлэгт холбогдох мэргэжилтнийг оролцуулж болно.

Үзлэгээр хуулиар хориглосон эд зүйл илэрвэл хураан авах бөгөөд эд зүйлийг шинжлүүлэх зорилгоор хэв загвар, дээж авах, эд хөрөнгө битүүмжлэх, эд зүйл, баримт бичиг хураан авах ажиллагааг явуулж болно. Хэрэв үзлэг хийлгэхээс татгалзсан, эсэргүүцэл үзүүлсэн бол үзлэгийг эрх бүхий албан тушаалтан албадан гүйцэтгэнэ.

Мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах ажиллагаа

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад байгууллага, албан тушаалтнаас тухайн зөрчилтэй холбоотой мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах зайлшгүй шаардлага гардаг.

Эрх бүхий албан тушаалтан нь зөрчил шалган ажиллагаанд ач холбогдол бүхий бичиг баримтыг байгууллага, хувь хүнээс гаргуулан авч болно. Харин уг баримт бичиг нь байгууллага, хувь хүний нууцтай холбоотой мэдээлэл, баримт бичиг бол прокурорын зөвшөөрлөөр гаргуулан авна.

Мэдээлэл, баримт бичиг гаргаж буй хүн, байгууллага, албан тушаалтан нь прокурорын зөвшөөрөл эсхүл эрх бүхий албан тушаалтны даалгаварт заасан хугацаа, хэлбэрийн дагуу мэдээлэл, баримт бичгийг гарган өгч, нууцыг хадгална.

Эд зүйл, баримт бичиг хураан авах ажиллагаа

Зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого, эд зүйл, зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, уналга эсхүл зөрчил шалгах ажиллагаанд ач холбогдолтой эд зүйл, баримт бичгийг хураан авна.

Зөрчил шалгах ажиллагаанд хураан авах ажиллагаа чухал байр суурийг эзлэх бөгөөд ямар нэг газар буюу аль нэг этгээдэд зөрчлийн нөхцөл байдлыг тогтооход ач холбогдолтой эд зүйл буюу баримт байна гэх үндэслэл бүхий мэдээлэл байвал газар дээр нь үзлэг хийснээр олдсон зүйлийг хууль заасан журмын дагуу хурааж авна. Хураан авах нь зөрчлийн хэргийг түргэн шуурхай илрүүлэх, зөрчилд шууд холбогдол бүхий баримт сэлтийг нотлох баримт болгон бэхжүүлэхэд онцгой ач холбогдолтой.

Хураан авах гэдэг нь эрх бүхий албан тушаалтан зөрчил үйлдэж олсон эд зүйл, ашигласан зэвсэг, хэрэгсэл, зөрчилд шууд холбогдол бүхий эд зүйлсийг хаана, хэнд, ямар газарт байгаа нь мэдээллээр болон үзлэгээр илэрсэн үед тэдгээрийг өмчлөгч болон эзэмшигчээс нь шаардаж гаргуулахад чиглэгдсэн ажиллагаа мөн.

Эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаа

Эд хөрөнгө битүүмжлэх нь зөрчил шалгах тодорхой ажиллагааны нэг төрөл болно. Зөрчлийг шалгах ажиллагааны явцад зөрчлийн улмаас хохирогчид учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, орлого хураах албадлагын арга хэмжээг хангах зорилгоор зөрчил гаргагчийн эд хөрөнгийг шүүх, прокурорын шийдвэрээр битүүмжилнэ.

Эд хөрөнгө битүүмжлэх гэдэг нь зөрчилд холбогдсон бөгөөд эд хөрөнгийн хариуцлага хүлээх этгээдийн эд хөрөнгө захиран зарцуулах эрхийг хязгаарлах замаар тухайн эд хөрөнгийг түр хугацаанд данслан бүртгэж, хамгаалалт тогтоон лацдаж, захиран зарцуулах эрхийг хязгаарласан арга хэмжээ юм. Энэ нь тухайн эд хөрөнгийг цаашид улсын орлого болгон хурааж болзошгүй нөхцөлд устаж үрэгдэх, бусдад худалдагдах, алга болгохоос сэргийлж, битүүмжлэн хамгаалж буй хэлбэр мөн.

Эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааг хураан авах, үзлэг хийх ажиллагаатай хамтатган явуулж болно. Эд хөрөнгийг битүүмжлэхдээ эд хөрөнгийг бусдад шилжүүлэх, устгах, өөрчлөх, захиран зарцуулах, хөдөлгөхийг хориглож, тухайн хүнд өөрт нь эсхүл бусад боломжтой хүнд хадгалах, хамгаалах үүрэг хүлээлгэнэ. Хураан авах эд хөрөнгө нь овор хэмжээ эсхүл бусад шалтгаанаар зөрчлийн хэрэгт хадгалах боломжгүй бол байгаа газарт нь битүүмжилнэ.

Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах ажиллагаа

Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах гэдэг нь эрх бүхий албан тушаалтан зөрчил шалгах ажиллагааны явцад зөрчил үйлдэхэд ашигласан хөрөнгө, үйлдэж олсон байж болзошгүй хөрөнгө эсхүл зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдолтой хөрөнгийг нуух, устгах, эрх шилжүүлэх үндэслэл бүхий сэжиг илэрвэл прокурорт хүсэлт гарган зөвшөөрөл авч, үл хөдлөх болон эдийн бус хөрөнгө, санхүүгийн хэрэгсэл, зохиогчийн эрх, патент, гэрчилгээ, лиценз, тусгай зөвшөөрөл, тээврийн хэрэгслийн бүртгэл, банк болон бусад санхүүгийн байгууллагад байгаа хөрөнгө, мөнгөн хөрөнгийн гүйлгээний шилжилт хөдөлгөөнийг хязгаарлахыг зохих байгууллагад даалгахыг хэлнэ.

Шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах гэж байгаа хөрөнгө нь:

а) Зөрчил үйлдэхэд ашигласан;
б) Зөрчил үйлдэж олсон байж болох;
в) Зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдолтой хөрөнгө мөн эсэх;
г) Дээрх хөрөнгийг нуух, устгах, эрх шилжүүлэх үндэслэл бүхий сэжиг байгаа эсэхийг эрх бүхий албан тушаалтан, прокурор нь баримт сэлт, мэдээлэл дээр тулгуурлан хүсэлт гаргана.

Учир нь хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлаж буй үйл ажиллагаа нь Үндсэн хуульд заасан хүний өмчлөх эрхийг хязгаарлаж байгаа үйлдэл юм.

Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр явуулах тул эрх бүхий албан тушаалтан нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.2 дугаар зүйлд заасны дагуу прокуророос зөвшөөрөл авах ажиллагааг баримтална.

Мэдүүлэг авах ажиллагаа

Зөрчил шалгах ажиллагааны нэг үндсэн төрөл бөгөөд түүний зорилго нь зөрчлийн талаарх мэдээлэл бодитой эсэхийг нягтлан шалгах, нотлогдвол зохих зүйлийг тодруулах, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны оролцогч нараас нөхцөл байдлыг шалган тогтооход оршино.

Мэдүүлэг нь дараах онцлогтой. Үүнд:

1. Хүний ухамсарт тусгагдсан объектив талын тусгал байдаг тул түүнийг сэргээн санаж илэрхийлэх үйл явц юм.
2. Мэдээллийг дамжуулах, хүлээн авахад чиглэгдсэн бөгөөд мэдүүлэг авч байгаа болон мэдүүлэг өгч байгаа этгээдийн хоорондын харилцан хамаарал бүхий харилцаа юм. Энэ нь хэдийгээр харьцангуй императив шинжтэй албан ёсны харилцаа боловч мэдүүлэг авч байгаа албан тушаалтан нь зөрчлийг тулган хүлээлгэх замаар мэдүүлгийг хөтлөн удирдана гэсэн үг биш юм.
3. Нэг талаас зөрчлийн нөхцөл байдалд холбогдох үйл явдлын талаар тодорхой этгээд, эрх бүхий албан тушаалтанд мэдүүлэг өгөх замаар дамжуулах, нөгөө талаас эрх бүхий албан тушаалтан нь уг мэдээллийг хуульд заасан журмын дагуу хүлээн авч бэхжүүлэхэд чиглэгдсэн хоёр талт үйл ажиллагааны нийлбэр цогц болно.

Зөрчил шалгах ажиллагаанд мэдүүлэг шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд зөрчлийн хавтаст хэргийн материалын зонхилох хэсгийг оролцогч нарын мэдүүлэг эзэлдэг нь үүний нэг илрэл юм.

Шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах ажиллагаа

Шинжилгээ хийх зорилгоор хүн, эд зүйл, баримт бичиг, ургамал, мал амьтнаас хэв загвар, дээж авч болно. Энэ ажиллагаа шинжилгээний өвөрмөц нэг хэлбэр бөгөөд процессын хувьд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны нэг бие даасан төрөл болдог.

Зөрчил үйлдэгдсэн газар, орчинд зөрчлийн ул мөр ямар нэг хэмжээнд хадгалагдаж үлдсэн байдаг. Энэхүү ул мөрийг бэхжүүлэх, улмаар хэрэгт холбогдох нотолгооны эд зүйлс, баримт сэлтийг олж илрүүлэхэд уг ажиллагаа чухал юм.

Харьцуулан шинжлэхээр хэв, хэлбэр авах гэдэг нь зөрчилд холбогдогч, гэрч, хохирогчоос шаардлагатай ул мөрийг техник хэрэгсэл ашиглан бэхжүүлэн авсныг зэрэгцүүлэн-жиших замаар шинжлэн тогтооход чиглэгдсэн ажиллагаа юм.

Шаардлагатай ул мөр гэдэгт тухайн холбогдох этгээдийн хуруу, алга, хөл, гутлын мөрийн дардас, үсний үлдэц, гарын үсэг, шүлс, хумс, шүдний хэв, үнэр зэрэг шинжилгээний объект хамаарна.

Харьцуулан шинжлэхээр хэв, хэлбэр авах ажиллагаа нь шинжилгээтэй нэгэн адил тусгай мэдлэг, нарийн мэргэжил шаарддаг утгаараа мэргэжилтний оролцоотой хийгддэг.

Шинжилгээ хийлгэх ажиллагаа

Эрх бүхий албан тушаалтан, хүн, эд зүйл, баримт бичиг, ургамал, мал амьтанд шинжилгээ хийлгэнэ.

Зөрчлийн хэрэг бүртгэлтийн үед шинжээч оролцуулах буюу шинжилгээ хийх нь зөрчил шалгах ажиллагааны чухал бүрэлдэхүүн хэсэг юм.

Зөрчлийн нөхцөл байдлыг тогтооход хууль зүйн арга, хэрэгслээр шийдвэрлэх боломжгүй тохиолдол гардаг. Энэ үед тусгай мэдлэг, ур чадвар шаардагдах эсхүл шинжлэх ухаан, техник, технологийн ололт амжилт, хөгжил дэвшлийг ашиглан нарийвчилсан үзлэг, шинжилгээ хийлгэх шаардлага тулгардаг.

Шинжилгээ гэдэг нь эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүгчээс тусгайлан томилсон шинжээч буюу шинжилгээний байгууллагаас хэрэгжүүлэх нарийн мэргэжлийн онцгой ажиллагаа бөгөөд зөрчил шалгах ажиллагааг хэрэгжүүлэгч эрх бүхий албан тушаалтан, шүүгчээс гаргасан тогтоол, захирамжид заасны дагуу шинжээч, шинжилгээний байгууллага нь тавигдсан асуултад хариулж, тухайн объектыг шинжлэн судалж дүгнэлт гаргах ажиллагаа юм.

Шинжилгээг дараах зорилгоор хийнэ.Үүнд:

- Зөрчлийн нөхцөл байдлыг техник-технологийн ололтыг ашиглан шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоох;
- Зөрчлийн ул мөр, баримт сэлтийг бэхжүүлэх, хэрэгт ач холбогдол бүхий зарим мэдээ сэлт, мэдээллийн үнэн бодит эсэхийг нарийн шинжилгээ хийх замаар олж илрүүлэх;
- Нотлох ажиллагаанд зайлшгүй хийх ёстой шинжлэх ухааны тусгай мэдлэг шаардсан (хими, биологи, эмнэлэг, техникийн г.м) асуудлаар үнэлэлт, дүгнэлт гаргах зэрэг болно.

Шинжилгээний объект гэж шинжилгээ хийж байгаа ул мөр, эд мөрийн баримт, бичиг баримт, эд юмс, амьтан, хүний бие, харьцуулан судлах хэв загвар, зөрчлийн хэрэгт авагдсан бусад материалыг хэлнэ.

ТОДОРХОЙ ЗӨРЧЛИЙГ ШАЛГАХ АРГАЧЛАЛ

Хичээлийн товч танилцуулга, нэр томьёоны тайлбар

Хамрах хүрээ	Мэргэжлийн хяналт, гааль, хил хамгаалах байгууллагын алба хаагч нар	Сургалтын хэлбэр	Лекц
Сургалт явуулах газар	Сургалтын танхим (заал)	Хугацаа	4 цаг
Хичээлийн товч танилцуулга	Суралцагчдад Зөрчил шалган шийдвэрлэх тодорхой ажиллагаа явуулах онцлогийг тайлбарлаж, ойлгуулах, мэдлэгийг суралцагчийн оролцооны аргаар хамтран бүтээх		
Сургалтын арга зүй	Суралцагчийн оролцооны аргууд: тонгоруу анги, өөрөөр нь яриулах, эерэг ба сөрөг байдлаар дүгнүүлэх болон тайлбарлан ойлгуулах, сонсгож таниулах		
Хичээлийн товч агуулга			
• Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа • Зөрчил шалган шийдвэрлэх тодорхой ажиллагаа явуулах онцлог			
Сургалтын хэрэглэгдэхүүн	- Цахим танилцуулга - Фондын лекц - Хичээлийн хөтөлбөр, нэгж хичээлийн удирдамж - Бусад		

Нэр томьёоны тайлбар	
Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх	**Шинжилгээнд зориулж дээд авах**
Мэргэжлийн хяналтын улсын байцаагч хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх явцад энэ хуулиар шалган шийдвэрлэхээр харьяалуулсан зөрчлийн шинжтэй үйлдлийг илрүүлсэн тул прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулна. Эрх бүхий албан тушаалтан ажлын 5 өдрийн дотор шалгаж, дараах шийдвэрийн аль нэгийг гаргана. Үүнд: - Гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэх; - Гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах; - Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх; - Зөрчлийн хэрэг нээх.	Шинжилгээ хийх зорилгоор хүн, эд зүйл, баримт бичиг, ургамал, мал амьтнаас хэв загвар, дээж авч болно. Энэ ажиллагаа шинжилгээний өвөрмөц нэг хэлбэр бөгөөд процессын хувьд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны нэг бие даасан төрөл болдог. Зөрчил үйлдэгдсэн газар, орчинд зөрчлийн ул мөр ямар нэг хэмжээнд хадгалагдаж үлдсэн байдаг. Энэхүү ул мөрийг бэхжүүлэх, улмаар хэрэгт холбогдох нотолгооны эд зүйлс, баримт сэлтийг олж илрүүлэхэд уг ажиллагаа чиглэгдэнэ.

Сэдвийн хүрээнд боловсруулсан хяналтын асуулт, гэрийн даалгавар, бие даалтын сэдэв, агуулга	Хяналтын асуулт
	• Зөрчлийн шалган шийдвэрлэх тодорхой ажиллагааг тайлбарлана уу? • Зөрчил шалган шийдвэрлэхэд явуулах тодорхой ажиллагааг нэрлэнэ үү?
	Бие даалтын сэдэв, агуулга
	Зөрчлийн шалгах тодорхой ажиллагааны талаар дэлгэрүүлэн тодорхойлох

Зөрчил шалган шийдвэрлэх арга зүйн нь тодорхой зөрчил бүрийг илрүүлэх, шалгах, шийдвэрлэхэд ач холбогдолтой нотлох баримтыг цуглуулах, эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг хөнгөвчлөх, хууль зүйн дагуу явуулахад ихээхэн ач холбогдолтой байдаг.

Арга зүй болгон зөрчил бүрд таарч тохирно гэсэн ойлголт байж болохгүй. Харин тэдгээр арга зүй, аргачлалаас сонгон хэрэглэх зөвлөмжийг гаргах нь үр дүнтэй байдаг. Иймд Зөрчлийн тухай хуульд заасан зөрчлийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан процесс ажиллагааны дагуу шалгахад анхаарах зүйл, хийгдэх ажиллагааны дэс дараалал, хууль зүйн үндэслэл зэргийг тодорхой бодит жишээ, тохиолдолд тулгуурлан тайлбарлаж, зөвлөмж болон зөрчил шалгах аргачлалыг боловсруулсан болно.

Энд дурдаж буй бодит жишээг үнэн бодитоор үйлдэгдсэн зөрчлөөс сэдэвлэн авсан боловч хүний нэр хүнд, эрх, эрх чөлөөг хөндөхгүй байх үүднээс тухайн хүний нэрийн эхний үсэг, он сар өдрийг зохиомлоор тавьсан болно.

Амьтны тухай хууль зөрчих зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа

Зөрчил илрүүлэх, шалгах хууль зүйн үндэслэл

Мэргэжлийн хяналтын байгууллагын эрх бүхий албан тушаалтны зөрчил илрүүлэх, шалгах хууль зүйн үндэслэл, эрх хэмжээ, чиг үүрэг нь Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиас гадна, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар зохицуулагдана. Төрийн хяналт шалгалтын тухай хуульд зааснаар хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хуульд заасан үндэслэл, журмын дагуу хяналт шалгалтыг хийх бөгөөд хяналт шалгалтыг төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн гэж ангилан явуулна.

Хяналт шалгалт нь иргэн, хуулийн этгээдийн явуулж байгаа аливаа үйл ажиллагаа хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэхэд чиглэсэн, хянан шалгалтын арга хэмжээний цогцолбор байна.

Байгаль хамгаалах чиглэлийн хууль тогтоомж, ялангуяа Амьтны тухай хууль хэрхэн хэрэгжиж байгаад хяналт тавих нь өөрийн өвөрмөц онцлогтой байдаг. Учир нь энэ хуулийн хэрэгжилт хэрхэн хангагдаж байгаа байдал, үйлдэгдэж буй зөрчил нь бусдын нүдэн дээр тэр бүр ил үйлдэгдээд байдаггүй, далд байдаг учраас хяналт шалгалтыг төлөвлөгөөтэйгөөр тогтмол эсхүл цаг хугацааны хувьд гэнэтийн буюу төлөвлөгөөт бус гэсэн хэлбэрээр явуулдаг.

Иймд хөдөө орон нутагт амьтныг агнах, барихыг хориглосон цаг хугацаа, зөрчил ихээр үйлдэгдэж болзошгүй газар оронд шалгалтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан хяналт шалгалтын арга хэлбэрээр, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан зөрчлийг эрх бүхий албан тушаалтан өөрийн хяналт шалгалтаар илрүүлэх, гомдол мэдээллийн дагуу зөрчил шалгах нь зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтны хууль зүйн үндэслэл болно.

Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу зохион байгуулна.

Зөрчил илрүүлж, шалгах ажиллагаа

Зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан дараах ажиллагааг хуульд заасан журмын дагуу явуулна. Үүнд:

- Зөрчил үйлдэгдсэн газар, хүн, хуулийн этгээдийн эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, хүний бие, эд зүйлд үзлэг хийх,
- Баримт бичиг, мэдээлэл гаргуулан авах,
- Эд зүйл, баримт бичгийг хураан авах,
- Эд хөрөнгийг битүүмжлэх,
- Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах,
- Мэдүүлэг авах,
- Шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах,
- Шинжилгээ хийлгэх зэрэг болно.

Бодит жишээ 11

Мэргэжлийн хяналтын байгууллагаас Амьтны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутагт 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдрөөс 5 дугаар сарын 03-ны өдөр хүртэлх хугацаанд хяналт шалгалтыг явуулжээ.

Хяналт шалгалтаар Мөнгөнморьт сумын Цагаан чулуут гэдэг нэртэй Хэрлэн голын эрэг газарт 2019 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр “Ниссан патроль” маркийн хар өнгийн 12-34 УАА улсын дугаартай, тээврийн хэрэгсэлтэй, гурван хүн отоглон буудаллаж байх үед хяналтын шалгалтын багийнхан таарчээ.

Мэргэжлийн хяналтын улсын байцаагч Б нь тэдгээр хүмүүстэй уулзаж ямар зорилгоор, хаанаас хаа хүртэл аялж байгаа талаар асууж ярилцахад Улаанбаатар хотоос найз дээрээ хэд хоног амрахаар ирээд байгаа, одоо голын дэргэд түр саатаж алжаалаа тайлж байна хэмээн хариулжээ. Тэдгээр аялагчид бүгд усны гутал өмссөн, хоёр хүний усны гутал нойтон, тээврийн хэрэгслийн арын тэвшний нөөц дугуйны дээд хэсэгт хүрэн улаан өнгийн толбо үүссэн, мөн машины дэргэд байгаа бор ногоон өнгийн цүнхний цахилгааны хагас татагдсан хэсгээр загасны уургын бариул цухуйж байжээ.

Мэргэжлийн хяналтын улсын байцаагч Б нь та бүхэн загас барьж байгаа юм биш үү гэхэд нэг нь бид загас бариагүй ээ гэж хариулсан байна. Улсын байцаагч Ц нь тэдгээр хүмүүс сэжигтэй байна гэж үзээд шалгалтын ажиллагааг явуулжээ.

Тайлбар. Мэргэжлийн хяналтын улсын байцаагч Ц нь дээрх үйлдэлд Амьтны тухай хууль зөрчих зөрчил үйлдэгдсэн байж болзошгүй сэжиг байгааг таамаглаж, шалгах ажиллагаа хийх шийдвэр гаргажээ.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн "Хяналт шалгалт хийх нийтлэг үндэслэл, журам"-ын 5.6 дахь хэсэгт заасны дагуу хяналт шалгалт эхлэхээс өмнө эрх бүхий албан тушаалтан шалгуулах этгээдэд шалгалтын зорилго, бүрэлдэхүүнийг танилцуулж, удирдамж, хяналтын хуудасны нэг хувийг өгөх бөгөөд улсын байцаагч албаны үнэмлэхээ үзүүлнэ. Мөн хуулийн 3.1.2-д тодорхойлсон "хяналт шалгалтын арга, хэлбэр"-ийн нэг болох тухайн хяналт шалгалтад хамаарах баримт бичгийг хянан үзэх заалтын дагуу тэдгээр иргэдийн бичиг баримтыг үзүүлэхийг хүсэж, уг хүмүүсийн хэн болохыг тодорхойлох иргэний үнэмлэх болон бусад бичиг баримтыг үзэж шалгана.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.4 дүгээр зүйлийн 1.эрх бүхий албан тушаалтан 1.1.хуулиар харьяалуулсан зөрчлийг өөрөө илрүүлсэн, 1.5. зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулах эрх хэмжээний хүрээнд зөрчил шалгах ажиллагааг эхлүүлэн явуулна.

Мэргэжлийн хяналтын улсын байцаагч Б тээврийн хэрэгслийн арын тэвшний нөөц дугуйны дээд хэсэгт үүссэн хүрэн улаан өнгийн цус мэт толбо, загасны уургын үзүүр цүнхнээс цухуйж байгаа, тэдгээр хүмүүсийн зорчиж байгаа цаг хугацаа, усны гутал норсон байсан зэрэгт дүгнэлт хийж, Амьтны тухай хууль зөрчих зөрчил үйлдэгдсэн байж болзошгүй гэж үзэж, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар зөрчил үйлдэгдсэн газар, тээврийн хэрэгсэл, эд зүйлд үзлэг хийх, эд зүйл, баримт бичгийг хураан авах, мэдүүлэг авах, шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах зэрэг ажиллагааг хийнэ.

Үзлэг хийх. "Эрх бүхий албан тушаалтан (Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.1 дүгээр зүйл) энэ хуульд заасны дагуу зөрчил шалгах ажиллагаа явуулж, нотлох баримт цуглуулж, бэхжүүлнэ", "зөрчил үйлдэгдсэн газар, тээврийн хэрэгсэл, эд зүйлд үзлэг хийх" гэж заасны дагуу үзлэг хийнэ. Үзлэг хийхэд анхаарах зүйл:

1. Хөндлөнгийн гэрчийг байлцуулах;
2. Гэрэл зураг, дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлэх техник хэрэгслийг бэлтгэх;
3. Үзлэг хийх явцад шаардлагатай бол шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах;

4. Шаардлагатай бол эд хөрөнгө битүүмжлэх, эд зүйл, баримт бичиг хураан авах ажиллагааг хамтад нь явуулах;
5. Эрх бүхий албан тушаалтны шаардлагаар үзлэг хийлгэхээс татгалзсан, эсэргүүцэл үзүүлсэн бол үзлэгийг албадан гүйцэтгэх;
6. Шинжилгээнд зориулан авсан хэв загвар, дээж авсан бол түүнийг хадгалах, шилжүүлэх, устгах, тээвэрлэх талаар Засгийн газрын гаргасан журмыг баримтлах;
7. Шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах ажиллагаанд мэргэжилтнийг оролцуулах зэргийг анхаарна.

Зөрчил үйлдэгдсэн газарт үзлэг хийхэд нотолгооны ач холбогдолтой амьтны сэг зэм, яс, үс, толгой, шийр, арьс, эвэр туурай зэрэг амьтны эд эрхтэн, түүнээс гадна сэжигтэй этгээдийн үлдээсэн ул мөр байж болох сумны хонгио, хутга, тамхины иш зэрэг эд зүйл, хэрэг, зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, морь, тэмээ, түүний ул мөр зэрэг байгаа эсэхийг сайтар нягтлан илрүүлж, бэхжүүлэн авахад онцгой анхаарна. Үзлэгийг хөдөө хээр, хойшлуулшгүй тохиолдолд хийж, дараа нь прокурорт мэдэгдэнэ. Хөндлөнгийн гэрч оролцуулах боломжгүй тохиолдолд дүрс бичлэг, гэрэл зургаар бэхжүүлнэ.

Зөрчил үйлдэгдсэн газарт хийх үзлэгийн тэмдэглэл, агуулга (Загвар жишээ)

Үзлэгээр илэрсэн зүйл:
Үзлэгийг 2019 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 15 цаг 00 минутад эхлүүлж, цэлмэг цаг агаартай, агаарын дулаан 10 хэм байх үед байгалийн гэрэлд явуулав.

Үзлэг явуулж буй газар нь хөдөө хээр, төв суурин газраас алслагдсан хөндлөнгийн гэрч оролцуулах боломжгүй байсан тул Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн үзлэг хийх 4.3 дүгээр зүйлийн 7 дахь "гэрэл зураг, дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлж болно" гэсэн заалтын дагуу фото зургийн аппарат, Garmin 64s маркийн GPS байршил тогтоогч багаж, Phantom-4 маркийн нисдэг камер (дрон) ашиглан фото зураг авч, бичлэг хийн зөрчил шалгах ажиллагааны явцыг бэхжүүлэв.

ҮЗЛЭГЭЭР ИЛЭРСЭН НӨХЦӨЛ БАЙДАЛ:
Зөрчлийн үзлэг хийж буй газар нь Төв аймгийн Мөнгөнморьт сумаас ертөнцийн зүгээр зүүн урд зүгт 45 км-т ертөнцийн зүгээр Хэрлэн голын зүүн талаараа ой модтой уул, баруун талаараа задгай хээр, тал бүхий Цагаан чулуут гэдэг нэртэй газар байлаа.

Үзлэг явуулж буй газрын орчин нь Хэрлэн голын ус тохойрсон эрэг газарт эргэн тойрон бургас, торлог бут, хад чулуутай хэвгийдүү газар байх бөгөөд нэлэнхийдээ борог өвстэй, цасгүй, хуурай, голын урсац их биш байв.

Зөрчил илрүүлсэн газрын голын зүүн эрэгт орших хадархаг газрыг үл хөдлөх цэг болгон авч орон зайн байршил тогтоогч Garmin 64s маркийн GPS багажаар тогтооход E46 57 36.51; N101 41 39.45 солбицолд байв. Уг хадархаг газраас үзлэг явуулж буй газар 30 м зайтай байлаа. Уг газарт ертөнцийн зүгээр хойшоо чиглэлд зогссон "Ниссан патроль" маркийн хар өнгийн 12-34 УАА улсын дугаартай, зүүн гар талын жолооны хүрдтэй, тээврийн хэрэгсэл байна. Уг тээврийн хэрэгслийн баруун хойд дугуйны дэргэд 35х65 см хэмжээтэй бор ногоон өнгийн цүнх байна. Цүнхний амны цахилгаан хагас татагдсан, цүнхний амнаас загасны хар өнгийн уургын хойд хэсэг нь цухуйсан байв.

Тээврийн хэрэгслээс 7 м зайд гурван чулуу зэрэгцүүлэн тавьж, дунд нь хуурай мөчир жижиглэн гал түлэхээр бэлтгэсэн байв. Уг чулуунаас хойшоо чиглэлд 10 м зайтай газар бургасан дунд бор шаргал өнгөтэй, 4 м урттай загасны уурга 2 ш, түүний дэргэд 5 ш загас байв.

Барьсан загасыг хэмжиж үзэхэд, их бие үзүүрээсээ сүүл хүртэл 50 см урттай, өргөн нь 14 см хэмжээтэй 2 загас, 35 см урттай, өргөн нь 10 см хэмжээтэй 3 загас байна. Загасны өнгө дүрс нь ..... өнгө дүрс, амьтны морфологи шинжээр шинэхэн барьсан зэвэг загас байна.

Үзлэгийг тээврийн хэрэгсэлд үргэлжлүүлэн хийж машины үйлдвэрийн тэмдэглэгээг шалгахад (машины урд копут дотор) NISSAN MOTORS CORPORATION MODEL LA-V73W LRHVQ SHASSIS V73W 0P0185 дугаартай байв. Машины гадна кузов хар өнгөтэй, төмөр цайвар өнгийн ачаатай, машины арын хаалганд нөөц дугуйтай, 12-34 УАА тээврийн хэрэгслийн улсын дугаартай, суудлын жип машин байна. Машины гадна хэсэг нэлэнхийдээ шавар, шороо болсон, гадна талын кузов ямар нэгэн механик эвдрэл, хонхойлт үүсээгүй, баруун урд дугуйны шаврын хаалт хугарч унжсан. Машины дөрвөн дугуйн хээ тод, гэрэлтүүлэх болон дохионы хэрэгсэл, шил арчигч бүрэн ажиллагаатай техникийн хувьд бүрэн бүтэн байна.

Машины арын хаалганы нөөц дугуйн дээр 5х7 см хэмжээтэй хүрэн улаан өнгийн цус мэт зүйлээр бохирлогдсон байв. Уг бохирлогдсон зүйлийг шинжлүүлэх зорилгоор бага зэрэг спирт шингээсэн хөвөнгөөр арчин дээж авч, цаасан дугтуйд хийгээд амсарт нь тэмдэг дарж битүүмжлэв.

Машины дотор талд үзлэгийг явуулж жолооч талын хаалгыг нээхэд машины түлхүүр асаалтын үүрэндээ байх бөгөөд түлхүүрийг түлхэн асаахад хэвийн ажиллагаатай асаж байв. Машины арын хаалгыг онгойлгож үзэхэд багажид бор ногоон өнгийн 3 ш аяны хөнжил, түүний доор ангийн зориулалттай Дробовинк буу 1 ш, бага калибрийн Тоз-8 буу 1 ш, Чех калибр ZKM-452 (дурантай 9 мм) 1 ш тус тус байв. Бууны дэргэд 17 мм дайзтай сум 10 ш, дробовинк бууны цаасан бортоготой сум 3 ш, 5.6х15 мм хэмжээтэй калибрийн сум 1 хайрцаг буюу 24 ш байна.

Эдгээр галт зэвсгийг эзэмших гэрчилгээг байгаа эсэхийг тээврийн хэрэгслийн жолооч Д-ээс тодруулахад бүгд байгаа гээд машины урд талын хайрцгаас 3 ш галт зэвсэг эзэмшигчийн гэрчилгээг гаргаж үзүүлэхэд Иргэн С овогтой Д гэрчилгээний дугаар 435, ОХУ-д үйлдвэрлэсэн Дробовинк буу №34556, иргэн С овогтой Д гэрчилгээний дугаар 743 ОХУ-д үйлдвэрлэсэн Тоз-8 калибр №44456, Иргэн Г овогтой Ш, гэрчилгээний дугаар 956, Чех калибр ZKM-452 №67778 дугаартай галт зэвсэг эзэмших гэрчилгээтэй.

Гэрчилгээ дээрх дугаар үзлэгээр илэрсэн галт зэвсэг дээрх дугаартай тохирч байна. Галт зэвсгийн эзэмшигч нараар бууны сумны хүхээгт сум байгаа эсэх, аюулгүй байдлыг шалгуулахаар Чех калибр ZKM-452 №67778 дугаартай галт зэвсгийн замгийг татахад сумны хүхээгт 1 ш сум байсныг авч аюулгүй болгосны дараа уг буугаар буудлага үйлдэгдсэн эсэхийг шалгах зорилгоор бууны гол төмрийн хошууны амсрыг үнэртэж үзэхэд дарь үнэртэж байв. Нөгөө хоёр бууны гол төмрийн амсраас дарь үнэртэхгүй байв. Буугаар буудлага үйлдэгдсэн эсэхийг тогтоох зорилгоор гол төмрийн амсрыг хөвөнгөөр бөглөж, хураан авлаа.

Мөн багажид 2 цаасан хайрцагтай зүйл байв. Нэг цаасан хайрцгийг нээж үзэхэд хоол хүнсний зүйлс болох талх, лаазалсан мах, зөөврийн хийн тулга, 5 ш баллонтой хийн газ байна. Нөгөө хайрцгийн тагийг нээж үзэхэд хүрэн улаан өнгөтэй, цээж, бөгсөн бие болгон шинэхэн бэлтгэсэн амьтны мах (гадна шинж тэмдгээр ямар амьтны мах гэдэг нь танигдахгүй) байв. Махыг бэлтгэсэн байдал, цээж хэсэгтээ хүрэн улаан өнгийн цус хурж, нөжирсөн, уг хэсэгтээ хавирга хугарсан зэргээс үзэхэд буудаж агнасан байж болзошгүй шинж тэмдэг байна. Уг махны жинг үзэх зорилгоор гар жингээр жигнэж үзэхэд 25 кг болж байв.

Уг хайрцагт 0.5 гр-ын цэнхэр өнгөтэй "Вояж" гэсэн шошготой усны хуванцар савand хар хүрэн өнгийн шингэн зүйл дүүртэл нь хийсэн байв.

Уг махыг ямар амьтны мах болох, савтай шингэнийг юуны шингэн болох талаар тээврийн хэрэгслийн жолооч Д-ээс асуухад ямааны мах байгаа юм, савтай шингэн нь яргуй идсэн ямааны цус байгаа гэж хариулав.

Машины баруун хойд дугуйны дэргэд байх 35х65 см хэмжээтэй бор ногоон өнгийн цүнхийг онгойлгож үзэхэд хар өнгөтэй, 55 см урттай эвхсэн загасны уурга 1 ш, дамартай цагаан өнгийн сатурик 2 ш, жижиг төмөр хайрцагт загасны дэгээнүүд, 28 см урттай төмөр хутга, бор ногоон өнгийн гар чийдэн, 2 ш хуруу зай, 15 см радиустай дугуй хар өнгийн гэрэлтүүлэх хэрэгсэл, 2 м урт цахилгааны залгуур утастай байв.

Үзлэгийн явцыг "Canon EOS600D" маркийн дижитал тоон технологид суурилагдсан, өнгөт фото зургийн аппаратаар баримжаалсан 3, тоймчилсон 5, зангилаа болон нарийвчилсан 17, нийт 25 кадр гэрэл зураг авч, зөрчлийн газрын схем зураг үйлдэж, нисдэг камер (дрон) ашиглаж 5 минутын бичлэг хийж, бэхжүүлсэн болно.

Үзлэгийн явцад илрүүлсэн зүйл:

- *Ангийн зориулалттай Дробовинк буу 1 ш;*
- *Бага калибрын буу Тоз-8 буу 1 ш;*
- *Чех калибр ZKM-452 (дурантай 9 мм) 1 ш;*
- *17 мм дайзтай сум 10 ш;*
- *Дробовинк бууны цаасан бортоготой сум 3 ш;*
- *5.6х15 мм хэмжээтэй калибрийн сум 1 хайрцаг буюу 24 ш;*
- *Загасны уурга (хар өнгийн) 5 м урттай 1 ш;*
- *Загасны уурга (бор шаргал өнгийн) 4 м урттай 2 ш, нийт 3 ш;*
- *Цагаан өнгийн сатурк 2 ш;*
- *Жижиг төмөр хайрцагт загасны дэгээнүүд;*
- *Төмөр хутга 28 см урттай;*
- *Гэрэлтүүлэх хэрэгсэл 15 см радиустай дугуй (хар өнгийн), (2 м урт цахилгааны залгуур утастай);*
- *Их бие үзүүрээсээ сүүл хүртэл 50 см урттай өргөн нь 14 см хэмжээтэй 2 загас,*
- *35 см урттай, өргөн нь 10 см хэмжээтэй 3 загас. Нийт 5 загас;*
- *Цаасан хайрцагтай 25 кг амьтны мах;*
- *"Вояж" гэсэн бичигтэй цэнхэр өнгийн 0.5 гр-ын хуванцар савтай хар хүрэн өнгийн шингэнтэй зүйл.*

Машины нөөц дугуй дээрх цус мэт хүрэн улаан өнгийн толбоноос хөвөнд шингээн авч цаасан дугтуйд хийж битүүмжлэн шинжилгээнд зориулж авсан дээж 1 ш зэргийг эд мөрийн бариптаар хураан авлаа.

Үзлэгийн тэмдэглэлийг "Toshiba" маркийн зөөврийн компьютер, "Samsung ML1670" маркийн принтер, автомашинаас цахилгаан өсгөгч багаж (инвертер) зэргийг ашиглан хэвлэв.

Үзлэгийн тэмдэглэлийг оролцогчдод уншуулж танилцуулахад үзлэгийн явцтай холбогдуулж ямар нэгэн санал хүсэлт гаргаагүй тул үзлэгийг 18 цаг 30 минутад дуусгаж, оролцогчдоор гарын үсэг зуруулав.

Тэмдэглэл үйлдсэн: Улсын байцаагч..... (Ц)

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх

Мэргэжлийн хяналтын улсын байцаагч Ц нь хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх явцад энэ хуулиар шалган шийдвэрлэхээр харьяалуулсан зөрчлийн шинжтэй үйлдлийг илрүүлсэн тул прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулна.

Улсын байцаагч Ц нь ажлын 5 өдрийн дотор шалгаж, дараах шийдвэрийн аль нэгийг гаргана. Үүнд:

- Гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэх;
- Гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах;
- Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх;
- Зөрчлийн хэрэг нээх.

Мэргэжлийн хяналтын улсын байцаагч зөрчлийн хэрэг нээх шийдвэрийг гаргажээ.

Дээрх тохиолдол хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх боломжгүй. Учир нь холбогдогч нар загас барьсан ил үйлдэл байгаа ч зөвшөөрлийн бичигтэй гэж загас барих эрхийн бичиг үзүүлсэн, авч яваа мах, эд зүйлээ ямааны мах, цус гэж тайлбарлаж, зөрчил үйлдсэнээ сайн дураараа хүлээн зөвшөөрөөгүй, учруулсан хохирлыг шууд тогтоох боломжгүй тул зөрчлийн хэрэг нээж, нотлох ажиллагааг зөрчлийн хэрэг бүртгэлт явуулна.

Мэдүүлэг авах ажиллагаа. Үзлэгийг явуулж дууссаны дараа Эрх бүхий албан тушаалтан буюу Мэргэжлийн хяналтын улсын байцаагч Ц нь зөрчил үйлдсэн байж болзошгүй тэдгээр гурван иргэнээс Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар зөрчил гарсан байдлыг тодруулах, зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт, мэдээллийг олох зорилгоор мэдүүлэг авна.

Мэдүүлэг авах ажиллагааг хийхэд дараах зүйлсийг анхаарна. Үүнд:

- Холбогдогчоос мэдүүлэг авахын өмнө түүнд үнэн зөв мэдүүлэг өгөхийн ач холбогдлыг тайлбарлаж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаатай холбоотой нууцыг хадгалах талаар мэдэгдэнэ;
- Эрх бүхий албан тушаалтан хүнийг албадан ирүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг (эх), үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах эрхгүй;
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар эсхүл хүний нэр төрийг гутаан доромжлон харьцаж мэдүүлэг авахыг хориглоно;
- Доор дурдсанаас бусад тохиолдолд мэдүүлгийг шөнийн цагаар авахыг хориглоно:
  - Шөнийн цагаар явагдаж байгаа үйлдвэрлэл, ажил, үйлчилгээний газарт гарсан зөрчлийг газар дээр нь шийдвэрлэх бол;
  - Олон нийтийн аюулгүй байдал, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд аюул учирч болох нөхцөл байдал үүссэн эсхүл үүсэж болзошгүй бол;
  - Зөрчлийн ул мөр устах, холбогдогч оргон зайлж болзошгүй;
  - Гудамж, талбай, олон нийтийн газарт шөнийн цагаар үйлдэгдсэн зөрчлийг хялбаршуулсан журмаар газар дээр нь шалган шийдвэрлэх бол.
- Мэдүүлэг авах ажиллагааг 3 цагаас илүү хугацаагаар явуулах бол 30 минутын завсарлага авна. Нэг удаагийн мэдүүлэг авах ажиллагаа нийт 6 цагаас хэтэрч болохгүйг анхаарна.

Мэдүүлэг авах процесс ажиллагаа:

- Тухайн хүн хүсвэл мэдүүлгийг бичгээр авч болно.
- Эрх бүхий албан тушаалтан мэдүүлгийг асуулт асууж, хариулт авах хэлбэрээр явуулна.
- Мэдүүлэг өгч байгаа хүн тоо болон санахад төвөгтэй бусад зүйлийн талаар мэдүүлэг өгөх бол эрх бүхий албан тушаалтны зөвшөөрснөөр баримт бичиг, бичлэг ашиглаж болно. Ашигласан баримт бичиг, бичлэгийн тухай тэмдэглэлд тусгаж, боломжтой бол мэдүүлгийн тэмдэглэлд хавсаргана.
- Мэдүүлэг өгч байгаа хүнд эд мөрийн баримтыг үзүүлэх, тухайн зөрчлийн талаар бусад хүнээс өгсөн мэдүүлгийг танилцуулж, энэ талаар мэдүүлэг авч болно.
- Мэдүүлэг авч дуусмагц тэмдэглэлийг мэдүүлэг өгч байгаа хүнд танилцуулж, нэмэлт оруулах, засвар хийх боломж олгоно.
- Мэдүүлэг өгөхөөс татгалзсан бол энэ тухай тэмдэглэлд тусгана.

- Эрх бүхий албан тушаалтан мэдүүлгийг тэмдэглэлээр бэхжүүлж, мэдүүлэг өгсөн хүн гарын үсэг зурж баталгаажуулна.
- Мэдүүлэг өгч байгаа хүнд мэдэгдэн дуу, дүрс, дуу-дүрсний бичлэг хийж болно.
- Мэдүүлгийг авахдаа тухайн хүнийг эрх бүхий байгууллагад ирүүлж эсхүл тухайн хүний байгаа газарт авч болно.

Мэдүүлэг авах ажиллагааны загвар жишээ. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 3.1 дүгээр зүйлийн 2.1. дэх хэсэгт заасны дагуу ямар зөрчилд холбогдон шалгагдаж байгааг холбогдогчид мэдэгдэж, энэ зүйлийн 2.2 дахь хэсэгт дурдсан өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрхтэйг тайлбарлан өгнө.

Холбогдогчоос мэдүүлэг авахын өмнө түүнд үнэн зөв мэдүүлэг өгөхийн ач холбогдлыг тайлбарлаж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаатай холбоотой нууцыг хадгалах талаар мэдэгдэнэ. Тухайлбал;

Асуулт: Таныг Амьтны тухай хууль зөрчих зөрчил үйлдсэн хэмээн үзэж шалгах гэж байна. Та өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй тул мэдүүлэг авах ажиллагаанд өмгөөлөгч оролцуулах уу?

Хариулт: За би Зөрчлийн тухай хуульд заасан Амьтны тухай хууль зөрчих зөрчилд намайг холбогдуулан шалгаж байгааг ойлгож мэдлээ. Би өмгөөлөгч авна.

Асуулт: Та болсон асуудлын талаар үнэн зөв мэдүүлэг өгөх нь чухал ач холбогдолтой бөгөөд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаатай холбоотой нууцыг хадгалах талаар танд мэдэгдэж байна.

Хариулт: Ойлгож мэдлээ.

Асуулт: Та 2019 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр 15 цагийн орчимд Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг Цагаан чулуут гэдэг газар Хэрлэн голын хөвөөнд Ниссан патрол маркийн 12-34 УАА улсын дугаартай тээврийн хэрэгсэлтэй явж байгаад Мэргэжлийн хяналтын улсын байцаагч нартай тааралдсан. Та ямар зорилгоор тэнд, хэн хэн гэдэг хүмүүстэй явж байсан бэ?

Хариулт: Би тэр өдөр өөрийн найз Г. Ч нартай хамт Хэрлэн голын эрэг орчим амрахаар аялж явсан юм. Би өөрийнхөө машиныг унаж явсан.

Асуулт: Таны аялж явсан газар болон тээврийн хэрэгсэлд үзлэг хийж үзлэгээр 5 ш зэвэг загас барьж, бургасан дунд уурга дэгээний хамт нуусан, мөн машин

дотор амьтны мах эвдэж жижиглэн хийсэн байсан нь үзлэгээр тогтоогдсон. Энэ ямар амьтны мах вэ? Танд болон тантай хамт явсан хүмүүст загас барих эрхийн бичиг байгаа юу?

Хариулт: Загас барьсан нь үнэн, гэхдээ нуугаагүй ээ зүгээр тэнд тавьчихсан байсан. Загас барих эрхийн бичиг байсан. Түүнийг танай нэг байцаагч хураан авсан.

Тэр хайрцагт хийсэн мах ямааны мах юм. Айлаас худалдаж авсан байсан.

Асуулт: Загасыг хэн барьсан бэ?

Хариулт: Загасыг би бариагүй ээ. Манай найз Г барьсан юм, тэр уурга дэгээ бүгд түүнийх, тэр загас барих эрхийн бичигтэй хэдэн загас барьчихъя гэж хэлээд Хэрлэн гол руу бид очсон юм. Зөвшөөрөлтэй л загас барьсан.

Асуулт: Зөрчлийн газрын үзлэгээр цаасан хайрцагт хийсэн байсан мах буудагдаж бэлтгэгдсэн шинжтэй цус хурсан байсан. Мөн цэвэр усны Вояж гэсэн саванд байсан хүрэн улаан өнгийн шингэн зүйл юун шингэн бэ?

Хариулт: Тэр усны саванд байгаа шингэн зүйл бол яргуй идсэн ямааны цус юм. Айлаас авсан ямаагаа төхөөрөхдөө цусыг нь саванд авсан байсан юм. Ямааг юу гэж буудах вэ дээ. Зүгээр л мал төхөөрдөг шиг л төхөөрсөн.

Асуулт: Та бор гөрөөс агнасан юм биш үү. Та бүхний авч явсан буунуудаас чех калибрь буу буудлага үйлдэгдсэн байсан. Дарь үнэртэж байсан. Та буудсан юм биш үү.

Хариулт: Үгүй ээ ан амьтан агнаагүй. Бууны овоо харааг шалгах гээд бай л буудсан юм.

.....

Асуулт: Таны авч явсан цаасан хайрцагтай махыг шинжилгээнд өгч шинжлүүлэхэд бор гөрөөсний мах, ундааны саванд байсан шингэн бор гөрөөсний цус, таны тээврийн хэрэгслийн арын нөөц дугуй дээрх цус мэт толбо бор гөрөөсний цусны толбо гэж гарсан байгааг танд танилцуулъя. Та болсон асуудлын талаар үнэн зөвөөр ярина уу?

Хариулт: За би үнэнээ ярья. Тэр өдрийн өмнөх шөнө бид гурав хотоос гарч Мөнгөнморьт руу явж Хэрлэнгийн Петровисын амралтын орчим явж байгаад гэрэлтүүлж нэг бор гөрөөс буудсан. Манай найз Ч машин барьж, Г гэрэлтүүлж, би буудсан. Тэгээд махыг нь эвдэж янзлаад цаасан хайрцагт хийгээд жаахан цус аваад архи нэмж хийгээд цэвэр усны саванд хийсэн. Тэгээд өглөө үүрээр

шахуу жаахан амарч байгаад гол уруудаж Цагаан чулуут гэдэг газарт ирж загас барьж байгаад баригдсан.

Загасыг Г барьсан өөрөө зөвшөөрлийн бичигтэй л гээд байсан. Өөр хүний нэртэй хугацаа дууссан, эрхийн бичиг засварлаад авч яваа гэдгийг нь мэдээгүй байсан...

Дээрх байдлаар мэдүүлгийг асуулт тавьж хариулах замаар авна. Мэдүүлэг авахдаа тухай хүний зан байдал, хариулт зэрэгт тохируулан асуух асуултаа боловсруулан асуултыг оновчтой тавина.

Шинжилгээ хийх, шинжээч томилох. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.11 дүгээр зүйлийн 1. “эрх бүхий албан тушаалтан хүн, эд зүйл, баримт бичиг, ургамал, мал амьтанд шинжилгээ хийлгэнэ”, 3. “эрх бүхий албан тушаалтан эд зүйл, хөрөнгөд үнэлгээ тогтоох, тусгай мэдлэг шаардагдах асуудлыг тодруулах зорилгоор хүсэлт гаргаж шинжилгээ хийлгэж болно”, 4. “тусгай мэдлэг, мэргэжил эзэмшсэн эрх бүхий албан тушаалтан өөрөө бие даан шинжилгээ хийж, магадалгаа гаргаж болно” гэсэн заалтуудын дагуу хураан авсан амьтны мах, цус мэт бохирлогдсон зүйлийн дээжийг шинжлүүлнэ.

Шинжилгээ хийлгэхэд анхаарах зүйл. Шинжилгээ хийлгэхэд дараах зүйлийг анхаарч хуульд заасан журмын дагуу явуулах нь хэргийг хууль зүйн хүрээнд зөв явуулах ач холбогдолтой юм. Үүнд:

1. Шинжилгээ хийлгэх тогтоол, шийдвэрт шинжилгээ хийлгэх үндэслэл, шинжилгээний байгууллагын болон шинжээчийн нэр, шинжээчид тавих асуулт, шинжилгээ хийж дүгнэлт гаргах хугацаа, шинжээчийн мэдэлд шилжүүлэн өгсөн шинжилгээний объектын талаарх мэдээллийг тусгана;
2. Шинжилгээ хийлгэх шийдвэрээ шинжилгээний байгууллага, шинжээчид шинжилгээний объект эсхүл түүний дээжийн хамт хүргүүлнэ;
3. Шинжилгээний объектыг хүргэх, тээвэрлэх боломжгүй тохиолдолд шинжээчийг шинжилгээний объект байгаа газарт чөлөөтэй нэвтрүүлэх, шинжилгээ хийх нөхцөлөөр хангана;
4. Шинжээчид түүний тусгай мэдлэгийн хүрээний асуултыг тавина;
5. Шинжилгээг шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэх бол шинжилгээний зардлыг урьдчилан шийдвэрлэсэн байна;
6. Тусгай хадгалалт, хамгаалалт шаардлагатай хөрөнгө, орлого, эд зүйл, шинжилгээний объектыг шүүх, прокурор, эрх бүхий албан тушаалтан, шинжилгээний байгууллагын шинжээчийн саналаар тухайн байгууллагаас өөр байгууллагад хадгалуулж болно;
7. Хураан авсан эд зүйл, шинжилгээний объект нь хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал амьтанд хортой нөлөө үзүүлэх эсхүл түргэн муудах,

гэмтэх, устах эсхүл зөрчлийг шийдвэрлэгдэх хүртэл чанар нь муудах хөрөнгө, орлого, эд зүйлийг эзэмшигчид нь буцаан өгөх боломжгүй тохиолдолд шүүхэд хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ.

Шинжилгээ хийх тогтоол үйлдэх загвар жишээ
Шинжээч томилох тухай

2020 оны 2 дугаар сарын 02-ны өдөр Дугаар.... Улаанбаатар хот

Мэргэжлийн хяналтын улсын байцаагч, Ц би Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 2 дэх хэсэгт зааснаар зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 184200001 дугаартай хэрэгт ОЛСОН НЬ:

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн харьяат Г.Ч.Б нар нь 2019 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр Төв аймгийн Мөнгөнморьт сумын Цагаан чулуут гэдэг газарт хувийн 12-34 УАА дугаартай Ниссан патроль маркийн тээврийн хэрэгслээр амьтны эд эрхтэн болох өвөрсдийн хэлж мэдүүлснээр ямааны мах гэх эвдэж жижиглэсэн 2 ш хаа, 2 ш гуяа, ямааны цус гэж хэлсэн "Вояж" цэвэр усны 0.5 гр-ын хуванцар саванд хийсэн хүрэн улаан өнгийн цус мэт шингэн авч явж байсан зөрчилд амьтны эд эрхтэн, төрөл зүйлийг тодорхойлох шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулах шаардлагатай байх тул Монгол Улсын Зөрчлийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулийн ..... зүйл, Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 19 дүгээр зүйлийг тус тус удирдлага болгон ТОГТООХ НЬ:

1. *Зөрчлийн 184200001 дугаартай хэрэгт шинжилгээ хийхийг шинжээч Шинжлэх ухааны академийн Ерөнхий болон Сорилын биологийн хүрээлэнгийн Хөхтний экологийн лабораторийн эрхлэгч, эрдэм шинжилгээний ажилтан .....нд даалгасугай.*

2. *Шинжээчид дүгнэлт гаргуулахаар дараах асуултыг тавьсугай.*
   - *Шинжилгээнд хүргүүлж байгаа амьтны түүхий эд эрхтэн (эвдэж жижиглэсэн хаа 2 ш, гуяа 2 ш) нь мал, амьтны эд, эрхтэн мөн эсэх*
   - *Дээрх эд эрхтэн нь амьтных мөн бол ямар зүйл болон хэдэн зүйлийн амьтны эд эрхтэн болох, тэдгээрийн шинжлэх ухааны нэршил*
   - *Хэрвээ эд эрхтэн нь нэг зүйлийн амьтны эд эрхтэн мөн бол хэдэн бодгаль амьтны ямар ямар эд эрхтэн болох*

- *Шинжилгээнд хүргүүлсэн зүйлс нь зэрлэг амьтны эд эрхтэн мөн бол тухайн амьтад нь манай орны аль хэсэгт тархсан болох*
- *Уг эд эрхтний хэсгээр тухайн амьтны нас, хүйс, хэдийд агнагдсан хугацааг тогтоох боломжтой эсэх*
- *Шинжилгээнд хүргүүлж буй савтай шингэн нь цус мөн эсэх. Хэрвээ мөн бол мал, амьтны алин нь болох*
- *Амьтны цус мөн бол ямар төрөл зүйлийн амьтны цус болох*
- *Шинжилгээнд хүргүүлсэн амьтны эд эрхтний цус мөн эсэх*

3.Тогтоолыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор дүгнэлт гаргахыг шинжээч ..... нд даалгасугай.

4.Шинжээчийн мэдэлд шинжилгээ хийлгэх тогтоолын хамт дараах эд зүйлийг түр хүргүүлсүгэй. Үүнд:

- *Амьтны эвдэж жижиглэсэн хаа 2 ш*
- *Амьтны эвдэж жижиглэсэн гуяа 2 ш*
- *“Вояж” шошготой цэвэр усны савand хийсэн хүрэн улаан өнгийн шингэн 1 ш зүйлийг хүргүүлсүгэй.*

Шинжээч..... нд хуульд заасан дараах эрх, үүргийг тайлбарласугай.

Дээрх байдлаар амьтны эд эрхтэн, галт зэвсэг, бичиг баримт (засварлагдсан эсэх талаар) бусад эд зүйлд шинжилгээ хийлгэхээр шинжээч томилж болно.

Мэргэжлийн хяналтын улсын байцаагч нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “Тусгай мэдлэг, мэргэжил эзэмшсэн эрх бүхий албан тушаалтан өөрөө бие даан шинжилгээ хийж, магадалгаа гаргаж болно” гэсэн заалтыг хэрэгжүүлж болно.

Дээрх жишээн дээрх зөрчилд холбогдогч нарын барьсан загасыг ямар төрөл зүйлийн загас болох талаар магадалгаа гаргаж, тогтоож болно.

Шинжилгээнд зориулж дээд авахад анхаарах зүйл. Шинжилгээнд зориулж дээж авахдаа түүнийг муутгахгүй, хэлбэр, хэмжээ дүрс байдлыг алдагдуулахгүй байх арга хэмжээ авч зориулалтын хадгалах сав, баглаа боодлыг урьдчилан бэлтгэсэн байх ёстой. Бусад зөрчлийн хэргийн дээж, эд зүйлстэй холилдож андуурагдахгүй байх зорилгоор гадна сав, баглаа боодол дээр ямар зөрчлийн газрын, ямар эд зүйл юу болох талаар тодорхой бичиж тэмдэглэн, лацдаж тэмдэг дарж баталгаажуулан хадгалж, шинжилгээний байгууллагад хүргүүлнэ.

Хураан авсан, эд зүйлийн талаар авах арга хэмжээ. Улсын байцаагч дээрх холбогдогч нараас хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд зүйлийн хадгалалт, хамгаалалтыг бүрэн хариуцна. Зөрчлийн хэргийг харьяаллын дагуу эсхүл шүүхэд шилжүүлэхдээ хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд зүйлийн хамт хүргүүлнэ.

Эрх бүхий албан тушаалтны хураан авсан зүйлийг устгуулахаар зохих байгууллагад шилжүүлж болно. Ингэхдээ устгасан ажиллагааны талаарх эрх бүхий байгууллагын тэмдэглэл, эд зүйлийн жагсаалтыг зөрчлийн хэрэгт хавсаргана.

Эрх бүхий албан тушаалтан нь хураан авсан эд зүйлийн талаар дараах шийдвэрийн аль нэгийг гаргана. Үүнд:

- Эзэмшигчид нь буцаан олгох;
- Устгах;
- Улсын орлого болгох;
- Зөрчлийн хэрэгт хадгалах.

Нотлох ажиллагаа

Эрх бүхий албан тушаалтан гаргасан шийдвэрийнхээ үндэслэлийг нотлох үүрэг хүлээнэ. Зөрчил шалган шийдвэрлэхийн тулд тухайн зөрчлийг дараах баримтуудаар нотолно. Үүнд:

- Гэрч, хохирогч, холбогдогчийн мэдүүлэг;
- Шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг;
- Бичмэл болон эд мөрийн баримт, баримт бичиг;
- Гэрэл зураг, зураглал, дуу, дүрс, дуу-дүрсний бичлэг;
- Хэв загвар, дээж;
- Зөрчил шалгах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл;
- Хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас ирүүлсэн зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл;
- Стандартаар баталгаажсан хэмжилт-хяналтын төхөөрөмжийн мэдээлэл;
- Бусад холбогдох баримтууд хамаарна.

Мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтын явцад хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, бэхжүүлсэн баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцно.

Зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан аливаа баримтат мэдээллийг зөрчлийн нотлох баримт гэнэ.

Нотлох баримтыг хууль бус арга, хэрэгслээр цуглуулж, бэхжүүлэхийг хориглоно. Хуульд заасан журам зөрчиж цуглуулсан, бэхжүүлсэн нотлох баримт нотлох чадвараа алдах бөгөөд энэ хуульд заасан шийдвэрийн үндэслэл болохгүйг анхаарах хэрэгтэй.

Эрх хязгаарлах арга хэмжээ

Зөрчил шалган шийдвэрлэж буй эрх бүхий албан тушаалтан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хэвийн явагдах нөхцөлийг хангах зорилгоор энэ хуульд заасан журмын дагуу эрх хязгаарлах арга хэмжээг авна.

Бидний авсан жишээ дээр холбогдогчийн баримт бичгийг хураан авч, эрхийг зохих хэмжээгээр хязгаарлаж байна. Үүнд; холбогдогчийн жолоодох эрхийн үнэмлэх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, галт зэвсэг ашиглах гэрчилгээ зэрэг баримт бичгийг хураан авч, хураан авсан тухай баримтыг холбогдогчид өгнө. Холбогдогч хураалгасан баримт бичгийг ашиглах зайлшгүй шаардлагатай бол эрх бүхий албан тушаалтанд хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ.

Зөрчлийн хэргийг танилцуулж, хэрэг бүртгэлтийг дуусгах

Эрх бүхий албан тушаалтан зөрчлийг нотлох ажиллагааг хангалттай хийж, хуульд заасан журмын дагуу явуулж нотлогдсон гэж үзвэл зөрчлийн хэрэг бүртгэлтийг дуусгахаас өмнө оролцогч, тэдгээрийн өмгөөлөгчийг зөрчлийн хэрэгтэй танилцах боломжоор хангаж, танилцуулна.

Зөрчлийн хэрэг бүртгэлтийг дуусгаж зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгох эсхүл шийтгэл оногдуулах гэсэн шийдвэрийн аль нэгийг гаргана.

Хууль зүйн хариуцлага

Зөрчлийн тухай хуулийн 7.6-д заасан Амьтны тухай хууль зөрчих зөрчлийн холбогдох заалтаар мэргэжлийн хяналтын улсын байцаагч шийтгэл оногдуулна. Хууль бусаар олсон хөрөнгө, учирсан хохирол, зөрчил үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, галт зэвсэг, загасны уурга хэрэгслийг буцаан өгөх, хураах шийдвэрийн аль нэгийг гаргана.

Хохирол, нөхөн төлбөр, торгуулийн орлого заасан хугацаанд төлөгдөөгүй бол албадан гүйцэтгүүлэхээр шүүхэд иргэний журмаар хандаж нэхэмжлэл гаргана.

Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль зөрчих зөрчил шалгах анхаарах асуудал

Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль зөрчих зөрчил нь Монгол Улсын хил дээр үйлдэгддэг учраас энэ зөрчлийг шалгах субъект нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.2-т заасан хилийн төлөөлөгч, орлогч, туслагч, 6.10-т заасан мэргэжлийн хяналтын улсын байцаагч, 6.11-т заасан гаалийн улсын байцаагч зөрчлийг шалган шийдвэрлэнэ.

Зөрчлийг шалгахад эрх бүхий албан тушаалтны эрх зүйн байдлыг тус тусын хуулиар тогтооно. Тухайлбал, Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн эрх зүйн байдал нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар, хилийн төлөөлөгч, орлогч, туслагчийн эрх зүйн байдал Монгол Улсын хилийн тухай хуулиар, гаалийн улсын байцаагчийн эрх зүйн байдал Гаалийн тухай хуулиар зохицуулагдана.

Улсын хилээр гарах хөдөлгөөний чиглэлд
- Мэргэжлийн хяналт;
- Гааль;
- Улсын хил хамгаалах байгууллага.

Улсын хилээр орох хөдөлгөөний чиглэлд
- Улсын хил хамгаалах;
- Мэргэжлийн хяналт;
- Гаалийн байгууллага гэсэн дарааллаар хяналт тавина.

Иймд Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуулийн хэрэгжилтэд аль ч байгууллагын эрх бүхий албан тушаалтан өөрийн хяналтын хүрээнд илрүүлж, зөрчлийн тухай хуулиар шийтгэл оногдуулах эрхтэй.

Зөрчлийн тухай хуулийн 7.3-д заасан зөрчлийн үндсэн шинж нь зохих зөвшөөрөлгүйгээр улсын хил нэвтрүүлсэн үйлдэл байна. Иймд зөвшөөрлийг хэн, хаанаас олгодог, ямар бичиглэл тэмдэглэгээ хийгдэг талаар зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан нар зохих мэдлэгтэй байх ёстой.

CITES-ийн зөвшөөрөл

Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенц (CITES) (цаашид “Конвенц” гэх)-ийг хэрэгжүүлэх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг олон улсад худалдаалах зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулдаг.

Энэ хуульд зааснаар Конвенцийг хэрэгжүүлэх үүрэг бүхий орон тооны бус Удирдан зохицуулах зөвлөл нь Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, импортлоход гаалийн хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох, уг зөвшөөрлийг хүчингүй болгох эрх, үүрэгтэй.

Зөвшөөрөл, гэрчилгээ олгох явц, дараалал



Удирдан зохицуулах зөвлөл уг хүсэлтийг хүлээн авч зөвшөөрөл, гэрчилгээ олгох асуудлыг шийдвэрлэнэ. Удирдан зохицуулах зөвлөл нь дараах нөхцөлийг харгалзан зөвшөөрөл, гэрчилгээ олгоно. Үүнд:

1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд Конвенцийг хэрэгжүүлэх үүрэг бүхий орон тооны бус Шинжлэх ухааны зөвлөлийн гаргасан:
   - Конвенцийн I, II хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, далай тэнгисээс олборлон оруулахад тухайн амьтан, ургамал оршин тогтноход хор хохирол учрах эсэх талаарх дүгнэлт;

- Конвенцийн I хавсралтад орсон амьтныг импортолж буй этгээд тухайн амьтныг арчилж маллах зохих нөхцөл бүрдүүлснийг нотолсон тодорхойлолт;
- Конвенцид нэгдэн орохоос өмнө олж авсан, Конвенцийн I хавсралтад орсон амьтныг гаршуулж тэжээсэн, ургамлыг тарьж ургуулсан, тэдгээрийн гаралтай эд зүйл болохыг нотолсон дүгнэлт авсан эсэх;

2. Хэрэв шаардлагатай гэж үзвэл Конвенцийн I, II хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн олон улсын худалдаа хийхэд байгаль орчинд хор хохирол учрах эсэх талаарх дүгнэлт авсан эсэх;
3. Тухайн амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг хууль тогтоомжид заасны дагуу олж авсан тухай нутгийн захиргааны холбогдох байгууллага, албан тушаалтны тодорхойлолт;
4. Ре-экспортлох гэж буй амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг энэ хууль болон зохих зөвшөөрлийн дагуу импортолсон эсэх;
5. Амьтан, ургамлын тээвэрлэлт нь зохих журмын дагуу хийгдсэн болон шаардагдах нөхцөлийг бүрдүүлсэн эсэх;
6. Конвенцийн I хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох зөвшөөрөл олгохдоо импортлогч улсын эрх бүхий байгууллагаас импортын зөвшөөрөл урьдчилан авсан эсэх;
7. Тухайн амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг олж авахдаа Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан барих зөвшөөрлийн хураамжийн тухай, Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай хуульд заасан төлбөр, хураамж тушаасан баримт бичиг зэрэг болно.

Зөвшөөрөл, гэрчилгээ нь олгогдсон өдрөөс хойш 6 сарын дотор хүчинтэй. Зөвшөөрөл, гэрчилгээг бусдад шилжүүлэхийг хориглоно. Бусдад шилжүүлсэн, хүчинтэй байх хугацаа дууссан, зөвшөөрөл, гэрчилгээг хүчингүйд тооцно.

Зөвшөөрөл, гэрчилгээ олгох журам болон загварыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн А/75 дугаар тушаалын 5 дугаар хавсралт Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенц (CITES)-ийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, импортлох, реэкспортлох зөвшөөрлийн загварыг доорх зургаар харуулав.

CITES-ийн зөвшөөрлийн задаргаа

CITES-ийн ЗӨВШӨӨРЛИЙН БИЧГИЙН ЗАГВАР

CONVENTION ON INTERNATIONAL TRADE IN ENDANGERED SPECIES OF WILD FAUNA AND FLORA

ЗЭРЛЭГ АМЬТАН БА УРГАМЛЫН АЙМГИЙН ХОВОРДСОН ЗҮЙЛИЙГ ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД ХУДАЛДААЛАХ ТУХАЙ КОНВЕНЦИ

PERMIT / CERTIFICATE №

EXPORT
RE-EXPORT
IMPORT
OTHER

Original

2. Valid until
Хүчинтэй байх хугацаа

3. Importer (name and address)
Импортлогчийн нэр, хаяг

4. Exporter (name and address, country)
Экспортлогчийн нэр, хаяг, улсын нэр

Signature of the applicant
Хүсэлт гаргагчийн гарын үсэг

3a. Country of importer
Импортлогч улсын нэр

5. Special conditions
Тусгай нөхцөл

For live animals, this permit or certificate is only valid if the transport conditions conform to the Guidelines for Transport of Live Animals or, in the case of air transport, to the IATA Live Animals Regulations.

6. Name, address, national seal/stamp and country of Management Authority

MINISTRY OF ENVIRONMENT AND TOURISM
Government Building #2
United Nations Street 5/2,
Ulaanbaatar-15160, MONGOLIA
Tel: 976-51-261726
Fax: 976-11-321401
E-mail: mne@mongol.net

5a. Purpose of the transaction (see reverse)
Худалдаажих зорилго

5b. Security stamp №
Маркны дугаар

7/8. SCIENTIFIC NAME (genus and species) AND COMMON NAME OF ANIMAL OR PLANT
Шинжлэх ухаан (төрөл зүйл)-ын болон ерөнхий нэр

9. Description of specimens, including identifying marks or numbers (age/sex if live)
Зүйлийн бичгийн тодорхойлолт, тэмдэг, дугаар (хэрэв амьд бол наслалт)

10. Appendix No and source
Хавсралтын дугаар, гарал үүсэл

11. Quantity (including unit)
Тоо хэмжээ (хэмжих нэгж)

11a. Total exported/ Quota
Экспортын тоо/ Зөвшөөрөгдөх тоо

A
B
C

12. Country of origin ★
Экспорт экспортлогчоо улсын нэр ★

Permit No
Зөвшөөрөлийн дугаар

Date
Он сар өдөр

12a. Country of last re-export
Адаглаж буулга ул оноогдсоноо улсын нэр

Certificate No
Зөвшөөрлийн дугаар

Date
Он сар өдөр

12b. Number of the operation ★★ or date of acquisition ★★★
Тоо ашиглалтаны дугаар ★★ эсвэл олж эзэмшсэн хугацаа ★★★

★ Country in which the specimens were taken from the wild, bred in captivity or artificially propagated (only in case of re-export)
Зүйлсийн бүрэн эсвэл ихэнх хэсэг нь гарсан, үржүүлсэн, тариалсан эсвэл (хэвлэн ул-экспортлох тохиолдолд)

★★ Only for specimens of Appendix-I species bred in captivity or artificially propagated for commercial purposes
Худалдааны орлого олохоор боловсон, үржүүлсэн, тариалсан Хавсралт-I-ийн зүйлсийн амьтдын болон ургамлын

★★★ Pre-Convention specimens
Конвенцийн хүчинтэй болохоос өмнө олж авсан зүйлийн бүтээгдэхүүн

13. THIS PERMIT IS ISSUED BY:
Зөвшөөрөлийг батлагч этгээдийн

Stamp

Security stamp, signature and official seal
Батлагчаа маркн, гарын үсэг, тамга

Place
Олгосон газар

Date
Он сар өдөр

14. EXPORT ENDORSEMENT:
Хил, гаалийн байгууллагын экспортын зөвшөөрөл:

15. Bill of Lading/Air Waybill Number
Ачаалах бараа /Ачаатын дугаар

Block Бүлэг	Quantity Тоо хэмжээ
A	

ЗАГВАР

Энэ хэсэгт ерөнхий мэдээлэл байна

Энэ хэсэгт эд зүйлийн (барааны) мэдээлэл байна

Энэ хэсэгт баталгаажуулалт байна

CITES-ийн зөвшөөрлийг шалгахад анхаарах зарим зүйл

CITES-ийн Удирдан зохицуулах зөвлөлөөс олгосон зөвшөөрөл нь 6 сар хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр байна. Иймд зөвшөөрлийн бичгийн хугацааг сайтар үзнэ. Хэрэв хугацаа дууссан бол хүчингүйд тооцож, зохих зөвшөөрөлгүйгээр улсын хилээр нэвтрүүлсэн зөрчил гэж үзнэ.

CITES-ийн зөвшөөрөлд байвал зохих мэдээлэл:

CITES – ийн нэр, лого	Эд зүйлийн төрөл
Үл давтагдах серийн дугаар	CITES-ийн хавсралт
Бичиг баримтын төрөл	Эх сурвалж
Хүчин төгөлдөр байх хугацаа	Тоо хэмжээ (хэмжих нэгж)
Экспортлогчийн хаяг	Квот болон экспортын хэмжээ

Экспортлогчийн гарын үсэг	Хэрэв ре-экспортлох бол эхний экспортлогч улс, экспортын зөвшөөрлийн дугаар олгосон огноо, мөн сүүлийн ре-экспортлох улсын дээрх мэдээлэл
Импортлогчийн хаяг	Экспортлох боомт
Удирдан зохицуулах зөвлөлийн хаяг	Экспортлох өдөр
Худалдааны зорилго	Экспортын баталгаажуулалт эд зүйлийн тоо
Зүйлийн шинжлэх ухааны нэр	Экспортыг баталгаажуулсан гарын үсэг (гаалийн байцаагчийн)
Хянаж шалгасан байгууллагын тамга	

Бичиг баримтыг Конвенцид заасан ажлын 3 хэлний аль нэгээр үйлдэнэ.
(Англи, Франц, Испани)

Энэ зөрчлийг илрүүлсэн тохиолдолд шалган шийдвэрлэх ажиллагаа нь зөвхөн зөвшөөрлийн бичиг байгаа эсэх, хэрэв байгаа бол уг бичиг нь хүчинтэй эсэх, ямар нэгэн засвар, хуурамчаар дуурайлгасан зэргийг шалгахаас гадна, тухайн зөвшөөрлийн бичигт байгаа амьтны гаралтай эд, түүгээр хийсэн бүтээгдэхүүн эд зүйлийн тоо хэмжээ нь тухайн зүйл амьтны нэр, тоо хэмжээтэй тохирч байгаа эсэхийг нягтлан үзэж хянана.

Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд хамгаалах тухай Конвенцийн хэрэгжилт нь зөвхөн манай орноос экспортлон гаргаж байгаа амьтны гаралтай эд, бүтээгдэхүүн эд зүйл төдийгүй гаднаас импортоор орж байгаа зүйлд төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд давхар хяналт тавьж байх ёстой.

Монгол Улсын хилийн тухай хууль зөрчих зөрчил

Монгол Улсын хилийн тухай хууль зөрчих зөрчлийн диспозицид амьтныг агнах, барих талаар шууд заалт байхгүй хэдий ч Монгол Улсын хилийн тухай хуулийн хилийн болон хил орчмын дэглэмд хилийн зурваст амьтныг агнах, барихыг хориглосон хэм хэмжээ тусгагдсан байгааг сайтар анхаарч хилийн бүсэд гарч буй хууль бусаар амьтныг агнах, барих зөрчлийг илрүүлэн шалгаж, хуульд заасан зохих хариуцлагыг оногдуулж байх нь зүйтэй.

Энэ төрлийн хэрэг, зөрчлийг хэрхэн шалгах, зарим анхааруштай асуудлуудын талаар дараах жишээ дээр тулгуурлан тайлбарлаж, тоймлон бэлтгэлээ.

Бодит жишээ 12

Хилийн цэргийн ... дугаар ангийн харьяа Дорноговь аймгийн Өргөн сумын нутагт байрлах Харагчин хилийн ... дугаар застав хариуцсан хэсгийн хилийн шугам дээр 2019 оны 10 дугаар сарын 07-ны өдөр УАЗ-31519 маркийн цагаан саарал өнгийн 90-09 ДГА улсын дугаартай тээврийн хэрэгслийг ашиглан ан амьтан агнасан хэрэг гарчээ.

Заставын харуулын цамхаг дээр 14 цагаас 16 цаг хүртэл цагийн манааны үүрэг гүйцэтгэж байсан хилийн цэргийн байлдагч Ч өдрийн 13 цаг 30 минутын үед заставын баруун хойно 3 удаа буун дуу сонсогдсон талаар заставын даргадаа мэдэгджээ. Заставын дарга тусгай томилгоот бүлгийг ахлан буун дуу гарсан зүгт буюу нутгийн гүнээр 8 км орчим явахад ямар нэг сэжигтэй зүйл илэрсэнгүй.

Ингээд өндөрлөг газарт зогсож тусгай томилгоот бүлгийн ахлагч дурандаж байгаад хилийн харуулын ард талд машины цонх наранд гялбахыг харжээ. Тухайн зүг рүү чиглээд 3 км орчим яваад очиход цагаан саарал өнгийн УАЗ 469 маркийн автомашинтай хүмүүс, түүний ойролцоо 1 зээр агначхаад хажууд нь зогсож байв.

Машинтай хүмүүс тусгай томилгоот бүлгийн машиныг хараад зугтаасан. Зугтахдаа зээр агнасан бололтой буу барьсан хүнийг машиндаа суулгаж аваад явсан. Араас нь 2 км орчим хөөж яваад барьж авав.

Бүлгийн ахлагч машинд байгаа хүмүүсийг буухыг шаардахад 4 эрэгтэй хүн бууж ирсэн. Машин дотор үзлэг хийхэд Вепрь, Сайга маркийн 2 буу байсныг хурааж авсан. Машины багажид 5 тооны хар сүүлт байсан. Буцах замдаа замд орхисон нэг зээрийг авч заставд ирсэн хэрэг гарчээ.

Зөрчил шалган шийдвэрлэхэд анхаарах зүйл

Хил хамгаалах байгууллага нь Монгол Улсын хилийн тухай хуульд зааснаар хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, хилийн аюулгүй байдлыг хангах, улсын хил дээр ан агнуур хийх, байгалийн баялаг ашиглах журмын талаар гаргасан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүрэгтэй байдаг.

Зөрчлийн тухай хуулийн 16.1 дүгээр зүйлд заасан зөрчил эсвэл Эрүүгийн хуулийн 24.5-д заасан гэмт хэргийн алин нь болохыг нотлох ажиллагаа явуулна. Үүнд:

1. Тухайн гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй дуудлага мэдээллийг авсан даруйд хуульд заасан хойшлуулшгүй ажиллагааг явуулна.
2. Хэрэг, зөрчилд холбогдож байгаа хүний бичиг баримтыг үзэж шалгана.
3. Хэрэг, зөрчил үйлдэгдсэн байдал, нотлох баримтыг цуглуулах зорилгоор
   - Автомашин, галт зэвсэг, зөрчил болсон газар, эд зүйлд үзлэг хийх
   - Холбогдож байгаа этгээдээс мэдүүлэг авах
   - Тээврийн хэрэгслийн гэрчилгээ, жолоочийн бичиг баримт, галт зэвсэг эзэмших гэрчилгээ болон агнагдсан амьтан зэрэг эд зүйлс, бичиг баримтуудыг хураан авах
   - Агнагдсан амьтныг ямар төрөл зүйлийн амьтан болох, галт зэвсгээр буудлага үйлдэгдсэн эсэх талаар шинжээч томилох
   - Орон нутгийн засаг захиргаанаас тухайн хүмүүсийн оршин суудаг эсэх талаар лавлагаа баримт бичиг, мэдээлэл гаргуулан авах зэрэг ажиллагааг хийнэ.
4. Хэрэг, зөрчил гарсан газар оронд үзлэг хийхдээ байршил тогтоогчийг ашиглан байршлыг нягт тодорхойлно. Хэрвээ тухайн хэрэг, зөрчил тусгай хамгаалалттай газар нутагт үйлдэгдсэн байвал эрүүгийн гэмт хэрэг болно.
5. Дээрх жишээнд амьтан агнасан газар нь хилийн зурвасаас хэчнээн хэмжээний зайтай газарт болсныг тогтоох нь маш чухал юм. Хэрвээ зөрчлийн хэрэг байвал түүний шинж болох улсын хилийн шугамаас 2000 м-ийн дотор агнуурын амьтан агнах, барихыг хориглох үйлдлийг нотлох баримт болно.
6. Амьтныг тээврийн хэрэгслээр хөөж буудсан үйлдлийг тогтоох нь Амьтны тухай хуульд заасан хориглосон арга, хэрэгсэл болох “агнуурын амьтныг агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх аргаар агнасан” үйлдлийг нотолно.

Дээрх жишээ тохиолдол нь улсын хил орчмын дэглэмийн нэг бүрэлдэхүүн болох Монгол Улсын хилийн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан Улсын хилийн зурвас, түүнд мөрдөх журам, хориглох зүйлийн 26.3.7.“Улсын хилийн шугамаас 2000 метрийн дотор агнуурын амьтан агнах, барих, амьтныг хөөж хил давуулахыг хориглоно”, 26.3.10.“Хуулиар хориглосон арга, зэвсэг хэрэгслээр агнуурын амьтан агнах, барихыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Хэрвээ нэн ховор, ховор амьтан эсхүл улсын тусгай хамгаалалттай газарт амьтан агнасан байвал Эрүүгийн хуулийн 24.5-д заасан гэмт хэрэг болно.

Тийм учраас аливаа ан амьтныг нэн ховор, ховор амьтны аль нь болохыг, хариуцсан хилийн зурвас хэсгээ улсын тусгай хамгаалалтад аль хэсгээрээ хамаарч байдаг талаар хэрэг, зөрчлийг шалгах эрх бүхий албан тушаалтан мэддэг байх зайлшгүй шаардлагатай.

Монгол Улсын хилийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Улсын хил орчмын нутаг дэвсгэрийн байгалийн унаган төрхийг хадгалах, амьтан, ургамлыг хамгаалах зорилгоор тодорхой хэмжээний газар нутгийг хил залгаа улстай тохиролцсоны үндсэн дээр улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангилалд хамруулах асуудлыг хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу шийдвэрлэнэ” хэмээн зааснаас гадна, хил орчмын зарим нутаг дэвсгэр улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамаарч байдаг. Гэмт хэргийн шинжтэй үйлдэл байвал хил хамгаалах байгууллагын эрх бүхий албан тушаалтан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар хойшлуулшгүй ажиллагааг явуулна.

Хууль тогтоомжид хил хамгаалах байгууллагын эрх бүхий албан тушаалтны хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх, тодорхой ажиллагаа явуулах эрх хэмжээ, эрх зүйн зохицуулалтыг доорх хүснэгтээр харуулав.

<table>
<tr><th>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль</th><th>Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль</th><th>Монгол Улсын хилийн тухай хууль</th></tr>
<tr><td>30.7 дугаар зүйл. Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгах</td><td>1.8 дугаар зүйл. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал</td><td>35 дугаар зүйл. Улсын хил хамгаалах байгууллагын чиг үүрэг</td></tr>
<tr><td>2.Дараах эрх бүхий албан тушаалтан мөрдөн шалгах ажиллагааг хойшлуулшгүй тохиолдолд явуулж, прокурорт даруй шилжүүлнэ.
Энэ хуулийн 2.8-д зааснаар эрх бүхий албан тушаалтан гэдэг нь 2.6.хилийн зурваст гарсан гэмт хэрэгт улсын хил хамгаалах байгууллагын эрх бүхий албан тушаалтан</td><td>6.2.хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах</td><td rowspan="3">35.1.5. хил орчмын дэглэмийг сахиулан, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлж, хилийн зөрчлийн асуудлыг хууль д заасны дагуу шийдвэрлэх

35.1.8.хил дамнасан гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох</td></tr>
<tr><td rowspan="2">Эрүүгийн хуулийн 24.5 Хууль бусаар ан агнах</td><td>Зөрчлийн тухай хуулийн 7.3 дугаар зүйл. Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль зөрчих</td></tr>
<tr><td>16.1 дүгээр зүйл. Монгол Улсын хилийн тухай хууль зөрчих</td></tr>
</table>

Хэрэг, зөрчил шалгах тодорхой ажиллагаа явуулах эрх зүйн зохицуулалт		
30.7 дугаар зүйл. Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгах 2.эрх бүхий албан тушаалтан дараах мөрдөн шалгах ажиллагааг хойшлуулшгүй тохиолдолд явуулж, прокурорт даруй шилжүүлнэ.	2.Зөрчил шалгах ажиллагаа	36 дугаар зүйл. Улсын хил хамгаалах байгууллагын бүрэн эрх
1.1.Үзлэг хийх	Зөрчил үйлдэгдсэн газар, хүн, хуулийн этгээдийн эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, хүний бие, эд зүйлд үзлэг хийх	36.1.5.Улсын хилээр нэвтэрч байгаа тээврийн хэрэгсэлд хил зөрчигчийг илрүүлэх зорилгоор үзлэг хийх явцад илэрсэн улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон зүйлийг хураан авч, холбогдох байгууллагад шилжүүлэх
1.2.Шинжилгээнд зориулж дээж, хурууны хээ, ул мөрний хэв авах	Шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах	
1.3.Гэрчээс мэдүүлэг авах	Мэдүүлэг авах	-Зөрчил гаргасан этгээдийн баримт бичгийг шалгах, түүний өмчлөлд эсхүл эзэмшилд байгаа эд зүйл, биед үзлэг хийх
1.4.Хэрэгт ач холбогдол бүхий тээврийн хэрэгсэл, мөнгө, эд зүйлийг хурааж авах	Эд зүйл, баримт бичгийг хураан авах	Эд зүйл, баримт бичгийг түр хугацаагаар хураан авах, битүүмжлэх
		Согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн эсэхийг шалгах
1.5.Эд хөрөнгийг битүүмжлэх	Эд хөрөнгийг битүүмжлэх	Гэмт хэргийг таслан зогсоох, гэмт этгээдийг мөрдөх үед байгууллага, иргэний орон байранд нэвтрэн орох
1.6.Шинжээч томилох	Шинжилгээ хийлгэх	

	Баримт бичиг, мэдээлэл гаргуулан авах	36.1.9.Хилийн төлөөлөгч, орлогч, туслагч нь -Улсын хилийн болон хил орчмын дэглэм зөрчсөн этгээдийг шалгах зорилгоор зургаан цагаас илүүгүй хугацаагаар түр саатуулах
		Түр саатуулагдсан этгээдийн эд зүйл, биед үзлэг хийсэн, эд зүйл, баримт бичгийг хураан авсан тохиолдол бүрд хуульд заасны дагуу тэмдэглэл үйлдэх
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Арван зургаадугаар бүлэг. Нотлох баримт		
16.1 дүгээр зүйлийн 3. Прокурор, мөрдөгч, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээлэл, өргөдлийг шалгах, эрүүгийн хэргээс бусад зөрчил, хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа, мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтын явцад хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, бэхжүүлсэн болон энэ хуулийн Дөчин хоёрдугаар бүлэгт заасан журмаар гадаад улсаас ирүүлсэн баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцож болно.		

Дээрх хүснэгтээс хил орчмын бүс, хилийн зурваст гарсан гэмт хэрэг, зөрчлийг шалгах хил хамгаалах байгууллагын эрх бүхий албан тушаалтны эрх хэмжээ тодорхой харагдаж байна. Иймд аль ч хуулийн заалтыг баримтлан хэрэг, зөрчлийн талаар хийх анхан шатны ажиллагааг хийж болно. Тэдгээр хууль зүйн дагуу хийсэн ажиллагаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан нотлох баримтаар үнэлэгдэх болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХУУЛЬ БУСААР АН АГНАХ, ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙГ ШАЛГАХ, ХЯНАН ШИЙДВЭРЛЭХЭД АНХААРАХ АСУУДЛУУД

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, ТАНИЛЦУУЛГА

Манай улс болон дэлхийн олон улсын хувьд байгаль орчин нь эдийн засаг болон нийгмийн хөгжилд нөлөөлөх чухал хүчин зүйлүүдийн нэг болоод байна. Сүүлийн 15-20 жилийн хугацаанд аж үйлдвэрлэлийн өндөр хөгжилтэй ихэнх орнуудад хүрээлэн буй орчны хамгаалалд чиглэсэн эдийн засаг, техник технологи, эрх зүй ба бусад арга хэмжээний цогц нэгдлийг боловсруулан хэрэгжүүлж байна.

Хэдийгээр байгаль хамгаалах хууль, эрх зүй хөгжиж, хүрээлэн буй орчны бохирдол ба шинжлэх ухаан-техникийн хөгжлийн сөрөг үр дагаврын эсрэг тэмцэх улсын байгууллага, иргэний нийгмийн байгууллага, эвсэл хөдөлгөөнүүд олноор бий болж байгаа ч хүн амын зарим хэсгийн дунд байгалийн баялгийг шавхагдашгүй, байгаль өөрөө сэргэх чадвартай гэсэн хандлага байсаар байгаа бөгөөд энэ нь байгаль хамгаалах хууль тогтоомжийг зөрчих, нийгэмд учруулах аюулын түвшин, шинж чанарыг дутуу үнэлэхэд хүргэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар бүлгийн 2 дугаар зүйлд “Монгол улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж заасан байдаг. Энэ эрхийг эдлэх баталгаануудын нэг нь хүрээлэн буй орчны шинжлэх ухааны үндэслэл бүхий эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний систем гэж олон улсад үзэж байна. Энэхүү систем нь хүн, байгаль орчин, экологийн аюулгүй байдалд халдах онцгой аюултай халдлагаас тэдгээрийг хамгаалах олон талт үйл ажиллагааг хангах үүрэгтэй.

Сургалтын хэрэгцээ шаардлага

Сүүлийн жилүүдийн Монгол Улс дахь хууль бусаар ан агнах, худалдаалах гэмт хэрэг, зөрчлийн шийдвэрлэсэн судалгаанаас үзэхэд, төрийн алба хаагчдын мэдлэг, ур чадвар хангалтгүй, арга зүйн дэмжлэг хязгаарлагдмал байгаа зэрэг нь энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

Хууль бусаар ан агнах, мод бэлтгэх, зөвшөөрөлгүй газар эзэмших, ашигт малтмалыг ашиглах, ойн дагалдах баялгийг дур мэдэн ашиглах, гол мөрний усыг бохирдуулах зэрэг зөрчил нэмэгдэж, дээр нь ой, ангийн баялгийг хууль бусаар их хэмжээгээр хулгайлан ашиглах гэмт хэргүүд гарсаар байгаа боловч илрүүлж хариуцлага тооцох механизм сул байна. Иймд прокуророос энэ төрлийн гэмт хэргийг хянах чиглэлээр ур чадварыг сайжруулах шаардлагатай байна.

Сургалтын зорилго

Прокурорын эрүүгийн хэрэг, зөрчлийг шийдвэрлэхэд хууль бусаар ан агнах тухай мэдлэг, ойлголтыг баяжуулах, гүнзгийрүүлэх, мөн амьтан, тэдгээрийн эд эрхтэн, бүтээгдэхүүнийг хууль бусаар ашиглахтай холбоотой шинэ мэдлэг олгох, урьд олж авсан мэдлэгийг шинэчлэх, түүнчлэн хууль бусаар ан агнах гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд шаардлагатай ур чадварыг олгоход оршино.

Сургалтын зорилт

- Хууль бусаар ан агнах гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгаж, хянан шийдвэрлэж буй үйл ажиллагаанд дүгнэлт өгөх
- Хууль бусаар ан агнах гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, үр дүнтэй хамтран ажиллах
- Сургалтад оролцогчид хууль бусаар ан агнах гэмт хэрэг, зөрчлийн талаарх ойлголт, түүний төрөл, хэлбэр зэргийг авч үзэхийн зэрэгцээ энэ талаар тогтсон, хэвшмэл хандлага ба бодит байдлын талаар мэдээлэл солилцох
- Хууль бусаар ан агнах гэмт хэрэг, зөрчлийн талаар илүү сайн мэдэх, хэрэгтэй мэдээллийг судлахын зэрэгцээ энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил үйлдэгчийн хэвшмэл дүр зураг, тэдний үйлдэл, санаа зорилгыг судалсны үндсэн дээр хууль хэрэгжүүлэх үйл явцад гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, хэрхэн ажиллах арга, тактикт сургах
- Хууль бусаар ан агнах гэмт хэрэг, зөрчлийн аюулын зэрэг болон нөхцөл байдлын үнэлгээ хийх, хэрэг хянан шийдвэрлэхэд прокурорын ур чадварыг нэмэгдүүлэх зэрэг болно.

Арга зүй

Энэ сургалтад насанд хүрэгчдийн сурах онцлог болон тэдний хэрэгцээг харгалзан оролцогчдын үйл ажиллагаанд тулгуурласан арга, аргачлалыг ашиглана. Сургалтыг явуулахдаа дараах зүйлсийг анхаарна. Үүнд:

- Мэдлэг эзэмших нь ямагт идэвхтэй сургалтад суурилсан байдаг.
- Мэдлэгийг эзэмшихийн тулд илүү идэвхтэй оролцоо шаардагддаг. Өөрөө оролцож, хийх замаар олж авсан мэдлэг илүү үлдэцтэй байна.
- Суралцагчдын идэвхтэй оролцооноос сургалтын үр дүн хамаарна. Зорилгод хүрэхийн тулд сургалтын зөвхөн агуулгад бус, сурах үйл явцад анхаарна.

Сургалтын үнэлгээ, хэрэглэгдэхүүн, үйл явц

Үйл ажиллагаа 1. Сэдвийн агуулга өргөн учир лекцийн хэлбэрээр агуулгыг танилцуулах ба ойролцоогоор 60-90 минут зарцуулна.

Үйл ажиллагаа 2. Дараах асуултаас ашиглан дэд сэдэв бүрд хэлэлцүүлэг, ярилцлага хийнэ. Үүнд:

- Хүрээлэн байгаа орчин, түүнийг эрүүгийн хуулиар хамгаалах шаардлага
- Ан, амьтанд халдах гэмт хэрэгт юу юу багтах вэ?
- Гэмт хэргийн зүйлчлэл хийхэд бусад хууль, захиргааны хэм хэмжээний актыг хэрхэн хэрэглэх вэ?
- ЭХХША нь нэг талаас байгаль орчин, нийтийн эрх ашгийг хамгаалахын тулд хууль сахиулагч, хуульч ямар ур чадварт суралцсан байх ёстой вэ?
- Хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулж буй бүх ажиллагааг хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгаж, шийдвэрлэхэд хэрэглэж чадаж байна уу?

Шинэ хууль, хуучин хууль хоёрын хооронд үзэл баримтлалын ямар ялгаа байгааг нээлттэй асууж, чиглүүлэн дэмжих байдлаар аль болох олон санал сонсох.

Үйл ажиллагаа 3. Хэрэглэгдэхүүн хэсэгт өгсөн тохиолдол болон нөхцөлийг ашиглан дараах үйл ажиллагааг зохион байгуулна. Үүнд:

- дүн шинжилгээ хийлгэх
- суралцагч цөөн бол дүрд хувааж тодорхой хэрэг хянан шийдвэрлэх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж болно.

Үйл ажиллагаа 4. Оролцогчдод тодорхой даалгавар өгч ажиллуулна. Мөн оролцогчдыг дараах багуудад хувааж болно. Үүнд:

1. Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл шалгах
2. Хэрэг бүртгэлт
3. Мөрдөн байцаалт
4. Прокурорын хяналт

Багийн даалгавар: Баг бүр хуулиар хүлээсэн чиг үүрэг болон зөрчлийн хэм хэмжээний жагсаалт гаргаж, танилцуулга бэлтгэнэ (Зөрчил, гэмт хэргийг ялгах талаар аль аль нь байж болно гэдгийг багуудад сануулах хэрэгтэй).

Танилцуулга хийх үе: Баг бүрийн танилцуулгыг сонсоно (идэвхтэй, оролцоог хангасан байх аргаар).

Дүгнэлт хийж, тухайн хичээлийг дуусгана.

ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦ

Монгол Улс нь олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлж “Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц (RAMSAR, 1971)”, “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай (Бонны) конвенц (CMS, 1979)”, “Биологийн олон янз байдлын тухай конвенц (CBD, 1993)”, “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES, 1973)” зэрэгт нэгдэн орсны зэрэгцээ амьтны нөөцийг зүй зохистой ашиглах, хамгаалах чиглэлээр өнөөгийн байдлаар “Амьтны тухай хууль (2012)” болон холбогдох 7 эрх зүйн акт мөрдөгдөж байна. Түүнчлэн, “Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах хөтөлбөр (2011)”, “Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр (2015)” зэрэг амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах төрийн бодлого хэрэгжиж байгаа нь амьтныг хамгаалах эрхзүйн орчныг зохих хэмжээнд бүрдүүлсэн байна.

Монгол оронд өөр хоорондоо ялгаатай олон янзын экосистемд дасан зохицсон 141 зүйл хөхтөн амьтан, 502 зүйл шувуу, 21 зүйл мөлхөгч, 6 зүйл хоёр нутагтан, 74 зүйл загас, 13 мянга гаруй зүйлийн сээр нуруугүйтэйн бүртгэгдээд байна[1]. Монгол Улсын «Улаан ном»-ын дөрөв дэх удаагийн хэвлэлд хөхтөн 6, шувуу 18, мөлхөгч 1 зүйл тус тус шинээр нэмэгдэж, нийт 110 зүйл амьтан бүртгэгдсэн[2] байна.

Амьтны аймгийг хамгаалах эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч хууль бусаар ан агнах, амьтны эд эрхтэн, бүтээгдэхүүнийг худалдаалах хэрэг, зөрчил нь жил бүр өсөх хандлагатай байгаа нь хууль хяналтын байгууллагуудын статистик мэдээнээс тодорхой харагддаг.

2012 онд шинэчлэн баталсан Амьтны тухай хуулийн дагуу ан амьтныг зөвхөн агнуурын бүс нутагт агнахаар зохицуулсан ба агнуурын бүс нутгийн амьтдыг иргэн, хувийн хэвшилд хариуцуулан хамгаалуулах замаар зохистой ашиглах бодлогыг хэрэгжүүлэх эрхзүйн орчин бүрдсэн, хуулийн хариуцлагын хэмжээг чангатсан, хяналт шалгалтыг сайжруулах чиглэлээр олон талт ажил, арга хэмжээг зохиож байгаа хэдий ч энэ төрлийн гэмт хэргийн гаралт тогтворжих, цаашид буурах хандлагагүй байна.

Байгалийн амьтан, ургамал ховордох нэг үндсэн шалтгаан нь тэдгээрийн эд эрхтэн, түүгээр хийсэн эм, эд хэрэглэл, гоёл чимэглэлийн зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах, ашиг олох зорилгоор хоморголон агнах юм уу олборлож, улмаар хил давуулан наймаалах үйл ажиллагаа[3] бөгөөд албан ёсны агнууraас хууль бус агнуурын хэмжээ илт давамгай их байгаа боловч түүнд чиглэсэн тодорхой арга хэмжээ авахгүй цаашид үргэлжилбэл 2030 он гэхэд биологийн нөөцийн 20% бүрмөсөн устаж болзошгүй байгааг олон улсын байгууллагууд онцлон сэрэмжлүүлжээ[4].

Хууль бусаар ан агнах гэмт хэргийн бүтэц, тархалт, шинж байдал нь улам бүр өөрчлөгдөж, амьтны эд, эрхтэн худалдаалах үйлдэл илүү давамгайлж, тэдгээр нь хил дамнасан, нарийн зохион байгуулалттай сүлжээ бүхий болж байгааг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжид[5] дурдагдсан нь өнөөгийн хууль бусаар ан агнах гэмт хэргийн шинж байдлыг илтгэж байна. Энэхүү зөвлөмжид тэмдэглэснээр, гэмт хэргийн илрүүлэлт сул, хууль хяналтын байгууллагуудад байгаль орчны чиглэлээр мэргэшсэн боловсон хүчин дутагдалтай, удирдлага зохион байгуулалт хангалтгүй байгаа

1 Байгаль орчны төлөв байдлын тайлан (2017)
2 Мөн тэнд
3 Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн лавлах (2018)
4 Биологийн төрөл зүйлийн үндэсний тайлан. БОНХЯ. УБ., 2009. 5 дахь тал
5 Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж. 2013.01.08 №02/02

нь уг гэмт хэрэгтэй тэмцэх явдал тулгамдсан асуудлын нэг болсныг харуулж байна гэжээ.

Хууль бусаар ан агнах гэмт хэргийн төдийгүй хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг гарч буй үндсэн учир шалтгаануудад (1) Засаглал муу, (2) Авлига, хээл хахууль их, (3) Цагдаа, прокурор болон шүүхэд гаргаж өгөх төсөв бага, (4) Байгууллага, институтийн зүгээс үзүүлэх дэмжлэг хангалтгүй, (5) Улс төрийн эрх мэдэлтнүүд хөндлөнгөөс оролцох явдал их, (6) Алба хаагчдын идэвх санаачилга дутмаг, (7) Орон нутагт үзүүлэх үр ашиг бага, (8) Тус гэмт хэргийн явцад бий болсон эд зүйлийн эрэлт хэрэгцээ хар зах дээр улам нэмэгдэж байгаа явдал, (9) Ядуурал нэмэгдэж буй үзэгдэл доод түвшний гэмт хэрэг үйлдэгчдийг их хэмжээгээр бий болгоход гол хүчин болдог зэргийг оруулж болохоор байна.

Зэрлэг амьтны хууль бус агнуур, тэдгээрийн эд эрхтэн, бүтээгдэхүүний худалдаанд хууль бусаар ан агнах, амьтны эд эрхтнийг хууль бусаар худалдах, худалдан авах, тээвэрлэх, гадаад улсад гаргах үйлдлүүд багтах бөгөөд тэдгээрийн эрүүгийн эрх зүйн нэр томьёоллоор “Хууль бусаар ан агнах гэмт хэрэг” гэж нэгтгэн ойлгоно.

АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛЬ ЗӨРЧИХ ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ

Монгол Улсад зөрчил шалган шийдвэрлэх чиг үүргийг цагдаа, гааль, татвар, мэргэжлийн хяналт, Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо, нийгмийн даатгал зэрэг олон салбар байгууллага хэрэгжүүлдэг бөгөөд өнөөг хүртэл тэдгээрийн үйл ажиллагааны үндэслэл, журмыг Захиргааны хариуцлагын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Гаалийн тухай хууль, Татварын ерөнхий хууль болон Байгаль орчны тухай хууль зэрэг салбарын хуулиудаар зохицуулж иржээ.

Ийнхүү зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг төрийн хяналт шалгалтаас ялгаатай байдлаар зохицуулаагүйгээс салбарын онцлог нэрийн дор салбар бүрд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны өөр өөр стандартыг тогтоон хэрэгжүүлж байсныг өөрчлөх зайлшгүй шаардлагыг харгалзан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар баталсан.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зорилт, нэр томьёо болон эрх зүйн хүрээнд олгож буй боломж

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль нь төрийн алба хаагчдад төдийгүй иргэн, хуулийн этгээдэд дараах боломжийг эрх зүйн хүрээнд олгож байна. Үүнд:

- Төрийн хяналт шалгалт болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хуулийн хүрээнд зааглан зохицуулснаар тус тусын зорилго, онцлог бүхий хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх үндэслэл, журмыг тодорхой хуульчилж, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөхөөс хамгаалах боломжийг нэмэгдүүлсэн;
- Зөрчил шалган тогтоох ажиллагааг хуулиар бус салбарын хүрээнд баталсан журам, дүрмийн дагуу хэрэгжүүлж байгааг өөрчилсөн;
- Зөрчил үйлдсэн этгээдэд хариуцлага оногдуулах эрх бүхий 27 чиглэлийн албан тушаалтан, шүүгчийн шийдвэрлэх зөрчлийн хэргийн харьяаллыг Зөрчлийн тухай хуулийн (шинэчилсэн найруулга) төсөлд заасантай нийцүүлэн тогтоосон;
- Зөрчил шалгах ажиллагааг салбарын хууль болон байгууллагын эрх хэмжээний хүрээнд баталсан журмаар өөр өөр байдлаар хэрэгжүүлж байсныг халж, нэгдсэн стандартаар хэрэгжүүлэх журмыг хуульчилсан;
- Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны оролцогч хэн байхыг тодорхойлон зааж, оролцогчийн буюу хохирогч, холбогдогч, тэдгээрийн өмгөөлөгч болон гэрч, хэлмэрч, орчуулагчийн эрхийг хангах нөхцөлийг хуульчилсан;
- Эрх хязгаарлах арга хэмжээний төрөл, хэрэгжүүлэх үндэслэл, журмыг тодорхойлж, зөрчил шалгах ажиллагааны явцад хүний эрхийг хууль бусаар хязгаарладаг байдлыг халсан;
- Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах процессыг тодорхой хуульчилсан;
- Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх үндэслэл, журмыг тодорхой хуульчилсан;
- Эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрийг давж заалдах эрхийн баталгааг бүрдүүлсэн.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зорилт. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль нь нэг талаас иргэнийхээ өмнө хүлээсэн төрийн үүргийг биелүүлэх, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах зорилгын хүрээнд (1) зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үндэслэл, журмыг тогтоох; (2) зөрчлийг шуурхай шалгах; (3)зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах; (4)энэхүү ажиллагааны явцад хүн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилттой.

Иргэдэд чирэгдэл учруулахгүй, зөрчлийн хэргийг шуурхай шийдвэрлэх зорилгоор дараах тохиолдолд холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, бэхжүүлсэн баримтыг нотлох баримтаар тооцож болох тухай Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд[1] заасан байна. Үүнд:

1. Төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээлэл, өргөдлийг шалгах
2. Зөрчил, хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад
3. Мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтын явцад.

Түүнчлэн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн үндэслэл болгож ашиглах зохицуулалт нь дээр дурдсан хуулиас гадна, эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ гэдэгт юун түрүүнд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль батлагдсантай холбогдуулан түүнтэй нийцүүлэн нийт 23 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиуд баталсан байдаг[2].

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд 11 төрлийн эрх зүйн дэд актыг батлан мөрдүүлэхээр заасан байна. Үүнд:

№	Хуулийн үндэслэл	Дэд актын нэр	Батлах эрх бүхий этгээд
1	1.11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны зардлыг тооцох журам	Засгийн газар
2	4.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг	Зөрчил шалгах ажиллагааны тэмдэглэл, шийдвэрийн маягт	Улсын ерөнхий прокурор
3	4.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	Шинжилгээнд зориулж авсан хэв загвар, дээж авах, хадгалалт, тээвэрлэлт, температурын горим	Засгийн газар
4	4.13 дугаар зүйлийн 7 дахь хэсэг	Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны тэмдэглэлийн маягт	Улсын ерөнхий прокурор

1 Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг

2 Агаарын тухай, Ашигт малтмалын тухай, Аялал жуулчлалын тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай, Валютын зохицуулалтын тухай, Гаалийн тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай, Даатгалын тухай, Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай, Нийгмийн даатгалын тухай, Өрсөлдөөний тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай, Статистикийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Банкны тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Татварын ерөнхий хууль, Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль.

5	5.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг	Эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл, журам	ХЗДХ-ийн сайд, Улсын ерөнхий прокурор
6	5.2 дугаар зүйлийн 7 дахь хэсэг	Саатуулах байрны дэглэм, журам	ХЗДХ-ийн сайд
7	5.5 дугаар зүйлийн 12 дахь хэсэг	Барьцааны мөнгийг хадгалах, буцаан олгох журам	Улсын ерөнхий прокурор, Сангийн болон ХЗДХ-ийн сайд
8	6.2 дугаар зүйлийн 7 дахь хэсэг	Зөрчлийн талаарх мэдээллийг төлбөртэй авах журам	Сангийн болон ХЗДХ-ийн сайд
9	7.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг	Хохирол, нөхөн төлбөрийг тооцох журам	Улсын ерөнхий прокурор
10	7.2 дугаар зүйлийн 7 дахь хэсэг	Шийтгэлийн хуудасны маягт	Засгийн газар
11	7.5 дугаар зүйлийн 12 дахь хэсэг	Хураан авсан эд зүйл, зэвсэг, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам	Засгийн газар

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгохоор хууль тогтоогч тодорхойлсон байна. Үүнд:

- “Зөрчил шалган шийдвэрлэх” гэж зөрчлийн хэрэг бүртгэлт, түүнд тавих прокурорын хяналт, зөрчил шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааг;
- “Зөрчлийн хэрэг бүртгэлт” гэж зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийг тогтоох, шийтгэл оногдуулах эсэхийг шийдвэрлэх зорилгоор эрх бүхий албан тушаалтны явуулах энэ хуульд заасан ажиллагааг;
- “Зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан” гэж эрх бүхий албан тушаалтны шууд харьяалах дээд шатны албан тушаалтныг;
- “Оролцогч” гэж зөрчилд холбогдогч, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг;
- “Хувийн баримт бичиг” гэж Монгол Улсын иргэний үнэмлэх, үндэсний гадаад паспорт, албаны болон жолоодох эрхийн үнэмлэх, гадаадын иргэний паспорт эсхүл тэдгээртэй адилтгах баримт бичгийг тус тус ойлгоно гэжээ.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал ба хөөн хэлэлцэх хугацаа

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлээр зөрчлийг шалган шийдвэрлэх, шийтгэл оногдуулах эрх бүхий албан тушаалтан, шүүхийн харьяалал, тэдгээрийн хянан шийдвэрлэх зөрчлийн харьяаллыг тус тус тогтоосон байна. Шүүгчээс гадна зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтанд дараах этгээд хамаарна. Үүнд:

№	Албан тушаалын нэр	№	Албан тушаалын нэр
1	Консулын эрх бүхий албан тушаалтан	15	Нийгмийн даатгалын байцаагч
2	Хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах	16	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч
3	Төрийн тусгай хамгаалалтын эрх бүхий ажилтан	17	Гал түймрийн улсын хяналтын байцаагч
4	Аймаг, нийслэл, дүүргийн цэргийн штабын дарга	18	Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагч
5	Тагнуулын байгууллагын эрх бүхий ажилтан	19	Монгол банкны хянан шалгагч
6	Олон нийтийн цагдаагийн ажилтан	20	Улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч
7	Гамшгаас хамгаалах улсын хяналтын улсын байцаагч	21	Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагч
8	Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч	22	Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч
9	Ахлах шийдвэр гүйцэтгэгч	23	Статистикийн улсын байцаагч
10	Мэргэжлийн хяналтын улсын байцаагч	24	Нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт хариуцсан байцаагч
11	Гаалийн улсын байцаагч	25	Төмөр замын тээврийн улсын байцаагч
12	Татварын улсын байцаагч	26	Хүүхдийн эрхийн улсын байцаагч
13	Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч	27	Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч
14	Оюуны өмчийн улсын байцаагч		

Зөрчлийн тухай хуульд хөөн хэлэлцэх хугацааг зөрчилд оногдуулах шийтгэлээс хамаарч дараах байдлаар тогтоосон байна. Үүнд:

Зөрчил		Хөөн хэлэлцэх хугацаа
1	10-500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэлтэй зөрчил	Тухайн зөрчил үйлдэгдсэнээс хойш 6 сар өнгөрсөн
2	500-аас дээш 10.000 нэгжтэй хэмжээний төгрөгөөр торгох шийтгэлтэй зөрчил	Тухайн зөрчил үйлдэгдсэнээс хойш 1 жил өнгөрсөн
3	10.000-аас дээш 20.000 нэгжтэй хэмжээний төгрөгөөр торгох шийтгэлтэй зөрчил	Тухайн зөрчил үйлдэгдсэнээс хойш 2 жил өнгөрсөн
4	Баривчлах шийтгэл оногдуулахаар заасан зөрчил	Тухайн зөрчил үйлдэгдсэнээс хойш 6 сар өнгөрсөн
5	Зөрчлийн хөөн хэлэлцэх хугацааг өөр хуулиар тогтоосон бол	Тухайн хуульд заасан хугацаа өнгөрсөн
6	Зөрчлийг хуулийн этгээд үйлдсэн бол	Зөрчлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан торгох шийтгэлийн хэмжээг арав дахин нэмж дүйцүүлэн хөөн хэлэлцэх хугацааг тогтооно.
7	Зөрчлийн тухай хуулийн хуулийн тусгай ангид зөвхөн хуулийн этгээдэд шийтгэл оногдуулахаар заасан зөрчил бол	Зөрчлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан торгох шийтгэлийн хэмжээг арав дахин багасгаж торгох шийтгэлийн хэмжээтэй дүйцүүлэн хөөн хэлэлцэх хугацааг тогтооно.
8	Хүн, хуулийн этгээдийн хууль бус үйлдэл, эс үйлдэхүй эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бөгөөд энэ хуулийн дагуу шийтгэл оногдуулах үндэслэлтэй бол	Хөөн хэлэлцэх хугацааг эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах тухай шийдвэр гарсан өдрөөс эхлэн тоолно.

Эрх бүхий албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаанд гомдол гаргах ба зөрчил хянан шийдвэрлэх шүүх

Прокурорын байгууллагад гаргасан өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч хянан шийдвэрлэх нь иргэдээс Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид заасан өргөдөл гомдол, мэдээлэл гаргах эрхээ хэрэгжүүлэх нөхцөл, боломжийг бий болгодог.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.12 дугаар зүйлд эрх бүхий албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаанд гомдол гаргах боломжийг тусгасан байна. Харин зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч субъектүүдийг дор дурдав.

Эрх бүхий албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаанд гомдол гаргах

1. Оролцогч зөрчлийн хэрэг бүртгэлтийн шатанд эрх бүхий албан тушаалтны шийдвэр үйл ажиллагаа талаарх гомдлыг прокурорт гаргаж болно.
2. Гомдлыг бичгээр гаргана.
3. Прокурор гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор шийдвэрлэж, шийдвэрийг гомдол гаргасан оролцогчид биечлэн танилцуулах эсвэл харилцаа холбооны хэрэгсэл ашиглан хүргүүлнэ.
4. Оролцогч прокурорын шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор тухай нэгжийн дээд шатны прокурорт гомдол гаргаж болно.
5. Тухайн нэгжийн дээд шатны прокурор гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор хянан шийдвэрлэнэ.
6. Прокурор шаардлагатай гэж үзвэл гомдлыг шийдвэрлэх хүртэлх хугацаанд эрх бүхий албан тушаалтны шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлж болно.
7. Тухайн нэгжийн дээд шатны прокурорын шийдвэрт гомдол гаргахгүй

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч субъект нь:

1. Зөрчил хянан шийдвэрлэх шүүх
2. Прокурор
3. Зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан
4. Эрх бүхий албан тушаалтан зэрэг болно.



Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.1 дүгээр зүйл. Зөрчил хянан шийдвэрлэх шүүх

	Чиг үүрэг	Эрүүгийн хэргийн шүүх	Захиргааны хэргийн шүүх
1	Хуульд заасны зөрчлийг харьяаллын дагуу хянан шийдвэрлэх Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 7, 8 дахь хэсэг	Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 5.2 дугаар зүйл, 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 5.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 15.3, 8.6, 8.7, 10.5 дугаар зүйл, 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 15.4, 15.5, 15.7, 15.12 дугаар зүйлд заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулна.	Хэрэг, маргаан хянан шийдвэрлэх явцад Зөрчлийн тухай хуулийн 15.3, 15.4, 15.5, 15.7 дугаар зүйлд заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд тухайн шүүх шийтгэл оногдуулна.
2	Хуульд заасны дагуу эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрт гаргасан гомдол, прокурорын дүгнэлтээр зөрчил хянан шийдвэрлэх (Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.1, 7.6 дугаар зүйл)	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4. 6.5, 6.6, 6.8, 6.9, 6.26 дахь заалтад заасан эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрт гаргасан оролцогчийн гомдол, прокурорын дүгнэлтээр зөрчил хянан шийдвэрлэнэ.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.7, 6.10, 6.11, 6.12, 6.13, 6.14, 6.15, 6.16, 6.17, 6.18, 6.19, 6.20, 6.21, 6.22, 6.23, 6.24, 6.25, 6.27 дахь заалтад заасан эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрт гаргасан оролцогчийн гомдол, прокурорын дүгнэлтээр зөрчил хянан шийдвэрлэнэ.

	Чиг үүрэг	Эрүүгийн хэргийн шүүх	Захиргааны хэргийн шүүх
3	Хуульд заасан харьяаллын дагуу эрх бүхий албан тушаалтны хүсэлтээр шийтгэл оногдуулсан шийдвэрийг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар албадан гүйцэтгүүлэх эсэхийг шийдвэрлэх ЗШШТХ-ийн 7.5 дугаар зүйлийн 8 дахь хэсэг	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.5, 6.6, 6.8, 6.9, 6.26 дахь заалтад заасан эрх бүхий албан тушаалтны хүсэлтийн дагуу	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.7, 6.10, 6.11, 6.12, 6.13, 6.14, 6.15, 6.16, 6.17, 6.18, 6.19, 6.20, 6.21, 6.22, 6.23, 6.24, 6.25, 6.27 дахь заалтад заасан эрх бүхий албан тушаалтны хүсэлтийн дагуу
4	Эрх бүхий албан тушаалтны хүсэлтээр Зөрчлийн тухай хуульд заасан зарим төрлийн албадлагын арга хэмжээ оногдуулах эсэхийг шийдвэрлэх. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4. 6.5, 6.6, 6.8, 6.9, 6.26 дахь заалтад заасан эрх бүхий албан тушаалтны хүсэлтийн дагуу холбогдогчийг албадан эмчилгээнд хамруулах, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн зөрчил үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналгыг хураах, эсхүл түүний үнийг гаргуулах эсэхийг шийдвэрлэх	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.7, 6.10, 6.11, 6.12, 6.13, 6.14, 6.15, 6.16, 6.17, 6.18, 6.19, 6.20, 6.21, 6.22, 6.23, 6.24, 6.25, 6.27 дахь заалтад заасан эрх бүхий албан тушаалтны хүсэлтийн дагуу зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн зөрчил үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналгыг хураах, эсхүл түүний үнийг гаргуулах эсэхийг шийдвэрлэх
5	Саатуулах эрх хязгаарлах арга хэмжээ авах Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 1.4 дэх заалт	Гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн саналын дагуу гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг саатуулах шийдвэр гаргах	

Прокурор: Прокурор зөрчлийн хэрэг бүртгэлтэд хяналт тавихдаа зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулсан эсэх, холбогдох хуулийг зөв хэрэглэсэн эсэх, уг ажиллагаанд хүний эрх, эрх

чөлөөг баталгаатай хангасан эсэхийг хянах, зөрчил хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцох чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах бөгөөд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлд заасан 17 төрлийн бүрэн эрхийг эдэлнэ.

Эрх бүхий албан тушаалтан: Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан гэдэгт Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан албан тушаалтнууд хамаарна. Эрх бүхий албан тушаалтан нь өөрийн гаргасан шийтгэл оногдуулсан шийдвэр болон тухайн шийтгэлийг албадан гүйцэтгүүлэх үндэслэлийг шүүхэд нотлох үүрэг хүлээнэ. Эрх бүхий албан тушаалтан нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

	Эрх бүхий албан тушаалтны чиг үүрэг	Хуулийн холбогдох зохицуулалт
1	o Хуулиар харьяалуулсан зөрчлийг өөрөө илрүүлсэн, эсхүл зөрчлийн тухай гомдол, мэдээлэл ирүүлснийг хүлээн авч хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх;	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.1, 6.6 дугаар зүйл
2	o Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх;	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.1, 6.2 дугаар зүйл
3	o Хуульд заасан үндэслэл, журмын дагуу зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах, эсхүл зөрчлийн хэрэг нээх;	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.1, 6.5 дугаар зүйл
4	o Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэх саналыг зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтанд гаргах;	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.1, 6.4 дүгээр зүйл
5	o Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулах;	Энэ хуулийн 6.7-6.11 дүгээр зүйл
6	o Шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах, шинжилгээ хийх;	Энэ хуулийн 4.10 дугаар зүйл, 4.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг
7	o Прокурорын шийдвэр, үйл ажиллагааны талаар хуульд заасан журмын дагуу тухайн нэгжийн дээд шатны прокурорт гомдол гаргах;	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйл

8	o Зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчийн гаргасан хүсэлтийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэрлэх;	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.13 дугаар зүйл
9	o Хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх хязгаарлах арга хэмжээг хэрэглэх;	Энэ хуулийн Тавдугаар бүлэг
10	o Хуулиар харьяалуулсан зөрчилд шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ авах;	Энэ хуулийн 7.1, 7.2, 7.3 дугаар зүйл
11	o Зөрчлийн үр дагаврыг арилгах арга хэмжээ авах, зардлыг нөхөн төлүүлэх;	Энэ хуулийн 7.4 дүгээр зүйл
12	o Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд шийтгэл оногдуулсан шийдвэрийг тогтоосон хугацаанд биелүүлээгүй, зөрчлийн үр дагаврыг арилгахтай холбоотой зардлыг нөхөн төлөөгүй бол албадан гүйцэтгүүлэхээр шүүхэд хүсэлт гаргах;	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйл
13	o Шүүхээс зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох;	Энэ хуулийн 8.1, 9.2 дугаар зүйл
14	o Хуульд заасан бусад	

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны оролцогчийг дараах төрөлд хуваж болно. Үүнд:

I. Хууль ёсны эрх ашиг нь хөндөгдөн оролцож байгаа оролцогч:
   1) Холбогдогч
   2) Хохирогч
II. Өмгөөлөх, бусдыг төлөөлөн оролцох оролцогч:
   1) Өмгөөлөгч
   2) Хууль ёсны төлөөлөгч
III. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогч:
   1) Орчуулагч, хэлмэрч
   2) Гэрч
   3) Хөндлөнгийн гэрч

Зөрчил шалгах ажиллагаа ба хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх, шийтгэл оногдуулсан шийдвэрт гомдол гаргах

Зөрчил шалгах ажиллагааг эрх бүхий албан тушаалтан бие даан шийдвэрлэн гүйцэтгэх боломжтой боловч зарим ажиллагааг заавал прокурорын зөвшөөрлөөр хэрэгжүүлэх шаардлага тулгардаг. Иймд, эрх бүхий албан тушаалтан бие даан шийдвэрлэх боломжтой болон прокурорын зөвшөөрлөөр хэрэгжүүлэх ажиллагаануудыг доорх хүснэгтээр харьцуулан харууллаа. Үүнд:

Зөрчил шалгах ажиллагаа		
Эрх бүхий албан тушаалтан бие даан шийдвэрлэх		Прокурорын зөвшөөрлөөр хэрэгжүүлэх
1	Бусдын орон байрнаас бусад газар болон хүний бие, эд зүйлд үзлэг хийх	Бусдын орон байранд үзлэг хийх
2	Байгууллага, хувь хүний нууцтай холбоотойгоос бусад мэдээлэл, баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтан, хүнээс гаргуулан авах	Байгууллага, хувь хүний нууцтай холбоотой мэдээлэл, баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтан, хүнээс гаргуулан авах
3	-	Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах
4	Хүнд холбогдуулан хийхээс бусад шинжилгээ хийх	Хүнд холбогдуулан шинжилгээ хийлгэх зэрэг ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр хэрэгжүүлэхээр заасан.
5	Эд зүйл, баримт бичиг хураан авах	-
6	Эд хөрөнгө битүүмжлэх	-
7	Мэдүүлэг авах	-
8	Шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах	-
9	Зөрчлийн тухай хуульд баривчлах шийтгэлийг сонгож оногдуулахаар заасан зөрчлийг шалгахад дараах ажиллагааг явуулж болно. Үүнд: o Хэргийн газрын үзлэг; o Таньж олуулах; o Туршилт хийх; o Нүүрэлдүүлж мэдүүлэг авах; o Ердийн ажиглалт явуулах; o Мэдүүлгийг газар дээр нь шалгах.	-

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.6 дугаар зүйл. Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх. Дараах үндэслэлийн аль нэг нь тогтоогдвол эрх бүхий албан тушаалтан хялбаршуулсан журмаар зөрчлийг шалган шийдвэрлэнэ. Үүнд:

- Зөрчил үйлдэгдсэн нь ил тодорхой, зөрчил, учирсан хохирлыг нотлох талаар зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах шаардлагагүй бол;
- Зөрчил үйлдэгдсэн, учруулсан хохирол нь нотлох баримтаар тогтоогдож холбогдогч зөрчил үйлдсэнээ сайн дураараа хүлээн зөвшөөрсөн бол;
- Зөрчил үйлдсэн болох нь стандартаар баталгаажсан хэмжилт-хяналтын төхөөрөмжөөр нотлогдсон бол.



Зөрчлийн хэрэг бүртгэлтийн явцад холбогдогч зөрчил үйлдсэнээ сайн дураараа хүлээн зөвшөөрсөн эсхүл зөрчил үйлдсэн нь тогтоогдож байгаа бол эрх бүхий албан тушаалтан хуульд заасан шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ авна.

Харин зөрчлийн холбогдогчийг зөрчил үйлдсэн болохыг хүлээн зөвшөөрүүлэхээр тулган шаардах, албадахыг хориглоно.

Шийтгэл оногдуулсан шийдвэрт гомдол гаргах. Оролцогч эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрийг эс зөвшөөрвөл тухайн шийдвэрт гомдол гаргах эрхтэй.

Яг ямар эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэрийг эс зөвшөөрч байгаагаас хамаарч гомдлыг Эрүүгийн болон Захиргааны хэргийн шүүхэд гаргана.



Үүнийг харьцуулж харвал:

	Эрүүгийн хэргийн шүүхэд гомдол гаргах	Захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргах
Шийдвэр гаргасан субъект	1. Консулын эрх бүхий албан тушаалтан 2. Хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах офицер 3. Төрийн тусгай хамгаалалтын эрх бүхий ажилтан 4. Аймаг, нийслэл, дүүргийн цэргийн штабын дарга 5. Тагнуулын байгууллагын эрх бүхий ажилтан 6. Олон нийтийн цагдаагийн ажилтан 7. Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч 8. Ахлах шийдвэр гүйцэтгэгч 9. Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч 10. Хүүхдийн эрхийн улсын байцаагч	1. Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч 2. Мэргэжлийн хяналтын улсын байцаагч 3. Гаалийн улсын байцаагч 4. Татварын улсын байцаагч 5. Оюуны өмчийн улсын байцаагч 6. Нийгмийн даатгалын байцаагч 7. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч 8. Гал түймрийн улсын хяналтын байцаагч 9. Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагч 10. Монгол банкны хянан шалгагч 11. Улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч 12. Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагч 13. Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч 14. Статистикийн улсын байцаагч 15. Нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт хариуцсан байцаагч 16. Төмөр замын тээврийн улсын байцаагч 17. Улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч
Журам	Шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар гомдол гаргана. o Гомдол гаргахад Улсын тэмдэгтийн хураамж төлөхгүй.	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар гомдол гаргана. o Хуульд тусгайлан заасан бол урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийгдсэн байхыг шаардана. o Гомдол гаргахад Улсын тэмдэгтийн хураамж төлнө.

Захиргааны хэргийн шүүх нь эрх бүхий албан тушаалтны хэрэгжүүлэх **зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд** дараах чиг үүрэгтэй оролцохоор Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан байна. Үүнд:

- Хуульд заасан харьяаллын дагуу эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрийг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар албадан гүйцэтгүүлэх эсэхийг шийдвэрлэх;

- Хуульд заасан харьяаллын дагуу эрх бүхий албан тушаалтны хүсэлтээр Зөрчлийн тухай хуульд заасан зарим төрлийн албадлагын арга хэмжээ оногдуулах эсэхийг шийдвэрлэх.



Мөн Захиргааны хэргийн шүүх нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан харьяаллын дагуу, мөн хуулийн 7.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрт гаргасан гомдол, прокурорын дүгнэлтээр зөрчил хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлнэ.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан **Захиргааны хэргийн шүүхийн чиг үүргийг задалж үзвэл:**

Чиг үүрэг		Захиргааны хэргийн шүүх	Эрх зүйн зохицуулалт
1	Хуульд заасан зөрчлийг харьяаллын дагуу хянан шийдвэрлэх	Хэрэг, маргаан хянан шийдвэрлэх явцад Зөрчлийн тухай хуулийн 15.3, 15.4, 15.5, 15.7 дугаар зүйлд заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд тухайн шүүх шийтгэл оногдуулна.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 8 дахь хэсэг
2	Хуульд заасны дагуу эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрт гаргасан гомдол, прокурорын дүгнэлтээр зөрчил хянан шийдвэрлэх	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн **6.7, 6.10, 6.11, 6.12, 6.13, 6.14, 6.15, 6.16, 6.17, 6.18, 6.19, 6.20, 6.21, 6.22, 6.23, 6.24, 6.25, 6.27** дахь заалтад заасан эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрт гаргасан оролцогчийн гомдол, прокурорын дүгнэлтээр зөрчил хянан шийдвэрлэнэ.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 7.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54, 112 дугаар зүйл

3	Хуульд заасан харьяаллын дагуу эрх бүхий албан тушаалтны хүсэлтээр шийтгэл оногдуулсан шийдвэрийг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар албадан гүйцэтгүүлэх эсэхийг шийдвэрлэх	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.7, 6.10, 6.11, 6.12, 6.13, 6.14, 6.15, 6.16, 6.17, 6.18, 6.19, 6.20, 6.21, 6.22, 6.23, 6.24, 6.25, 6.27 дахь заалтад заасан эрх бүхий албан тушаалтны хүсэлтийн дагуу	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 8 дахь хэсэг
4	Эрх бүхий албан тушаалтны хүсэлтээр Зөрчлийн тухай хуульд заасан зарим төрлийн албадлагын арга хэмжээ оногдуулах эсэхийг шийдвэрлэх	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.7, 6.10, 6.11, 6.12, 6.13, 6.14, 6.15, 6.16, 6.17, 6.18, 6.19, 6.20, 6.21, 6.22, 6.23, 6.24, 6.25, 6.27 дахь заалтад заасан эрх бүхий албан тушаалтны хүсэлтийн дагуу зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн зөрчил үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналгыг хураах, эсхүл түүний үнийг гаргуулах эсэхийг шийдвэрлэх	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг

Агнуурын амьтан агнах, барихыг хориглох хугацаа

Өнөөдрийг хүртэл манай мөрдөн шалгах, шүүхийн практикт гарч байсан байгаль хамгаалах журам зөрчсөн гэмт хэргүүдийн бүтцийг аваад үзвэл, 95% орчмыг нь хууль бусаар ан агнасан гэмт хэрэг, зөрчил эзэлж байгаа нь анхаарал татдаг. Харин сүүлийн жилүүдэд хууль бусаар ан агнах нь хэрэгцээгээ хангах гэхээсээ илүү ашиг хонжоо олох, мөн дур сонирхлоо хангах сэдэлтээр энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийг үйлдэх болсон байна.

Агнуурын амьтныг үйлдвэрлэлийн, ахуйн, тусгай зориулалтаар агнаж, барих ёстой ба зөвшөөрөгдсөн цаг хугацаанд, зөвшөөрөгдсөн газар нутагт агнах ёстойг анхаарах ёстой.

Ан амьтан бол үндэсний баялаг бөгөөд ан гөрөөс, араатан, жигүүртэн бүгдийг хамааруулсан ойлголт юм. Амьтны тухай хууль болон бусад хуулиар ан амьтдыг нөөц болон нөхөн сэргэх чадвар, экологийн ач холбогдлоор нь нэн ховор, ховор, агнах нөөцтэй гэсэн гурван ангилалтыг оруулж тус бүрийн

хамгаалалт, ашиглалт, нөхөн сэргээх эрх зүйн үндсийг тодорхойлон заасан байна.

Энэ нь Монгол улсын түүхэнд ан амьтныг хамгаалах нарийвчилсан журмыг анх удаа хуульчилж, дурдсан ангиллуудад ямар ан амьтдыг хамааруулах, тэднийг барих, агнах явцад үүссэн харилцаанд төр болон бусад субъект хэрхэн оролцох асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэснээрээ биологийн төрөл зүйлийг хамгаалахад онцгой ач холбогдолтой болсон.

Амьтны тухай хуулиар ан агнуурын зохион байгуулалт, амьтныг хамгаалах, тэднийг өсгөн үржүүлэх, тоо толгойг зохицуулах, эдгээр ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн асуудлыг шинээр хуульчилж, амьтныг барих, гадаадад гаргах, худалдаалахтай холбогдсон харилцааг эрх зүйн уламжлалт зохицуулалтыг шинэ агуулгаар баяжуулан баталгаажуулсан нь шинэчлэлийн нэг давуу тал болсон байна.

Агнуурын амьтныг дор дурдсан хугацаанд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнах, барихыг зөвшөөрдөг. Үүнд:

- Бор гөрөөс, цагаан зээр, гахайг 9 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдөр хүртэл;
- Баавгайг 8 дугаар сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 16-ны өдөр хүртэл;
- Ойн булга, хадны суусар, элбэнх, шилүүс, нохой зээх, үнэг, хярс, хэрэм, ойн солонго, чандага, бор туулайг 10 дугаар сарын 21-ний өдрөөс дараа оны 2 дугаар сарын 16-ны өдөр хүртэл;
- Тарвагыг 8 дугаар сарын 10-ны өдрөөс 10 дугаар сарын 16-ны өдөр хүртэл;
- Заарт хархыг 10 дугаар сарын 16-ны өдрөөс дараа оны 1 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл;
- Доргыг 9 дүгээр сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл.

Ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар шувуу агнах, загас барихыг дор дурдсан хугацаанд зөвшөөрнө. Үүнд:

- Хөтүү, ятуу, хахилаг, ногтруу, хур сойрыг 9 дүгээр сарын 01-ний өдрөөс дараа оны 3 дугаар сарын 15-ны өдөр хүртэл;
- Галуу, нугас болон ус, намгийн бусад шувууг 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 5 дугаар сарын 01-ний өдөр хүртэл, 9 дүгээр сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 21-ний өдөр хүртэл;
- Дархадын цагаан загасыг 10 дугаар сарын 20-ны өдрөөс дараа оны 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэл;

- Буйр нуурын загасыг 8 дугаар сарын 01-ний өдрөөс дараа оны 5 дугаар сарын 15-ны өдөр хүртэл;
- Омоль загасыг 9 дүгээр сарын 15-ны өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдөр хүртэл;
- Зарам загасыг 11 дүгээр сарын 15-ны өдрөөс дараа оны 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэл;
- Алтайн сугас загасыг 8 дугаар сарын 01-ний өдрөөс дараа оны 4 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл;
- Бусад загасыг 6 дугаар сарын 15-ны өдрөөс дараа оны 4 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл.

Эмчилгээ, судалгаа шинжилгээ, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор агнуурын амьтныг агнах, барих тохиолдолд хуульд заасан хугацааг харгалзахгүй байж болно.

Агнахыг хориглосон амьтдыг олноор нь хууль бусаар агнасан зөрчлийн тоо илэрсэн гэмт хэргээс хэд дахин олон байна. Судалгаагаар хууль бусаар ан агнасан, барьсан зөрчлийн 35-45% орчмыг илрүүлэн хариуцлага тооцож байгаа боловч илэрсэн нийт зөрчлийн зөвхөн 1% нь эрүүгийн хариуцлага, 70-80% нь Зөрчлийн тухай хуулиар шийтгэл оногдуулж байгаа нь хулгайн анчдыг улам бүр давтаж, энэ төрлийн гэмт хэргийн гаралт буурахгүй байхад нөлөөлж байна хэмээн үздэг.

Амьтан агнах, барихад хориглох арга, зэвсэг хэрэгсэл болон хориглосон үйл ажиллагаа, зохицуулалт

Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон анчны үнэмлэхтэй иргэнийг “анчин” гэнэ. Агнуурын амьтны амьдрал, биологи, агнуурын уламжлалт соёлын талаар мэдлэгтэй, ан агнах, барих арга зүй эзэмшсэн, түүнтэй холбогдсон шалгуурыг хангасан иргэн “анчны үнэмлэх” авах эрхтэй.

Агнуурын амьтан агнах, барихад хориглох арга, зэвсэг хэрэгсэлд дараах зүйлсийг оруулна. Үүнд:

- Химийн болон тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах;
- Агнуурын амьтны жим дээр нүх ухах, буу сойх, занга, сааль тавих;
- Туурайтан амьтныг агнахад цасанд умбуулах, мөсөнд халтиргах, хясаа, эрэг, ганга руу нисгэх, хавх тавих;
- Тарвагыг нүхэнд нь утах, ус цутгах, хавх, урхи тавих, нохойгоор зориудаар бариулах;

- Агнуурын амьтныг агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх;
- Загас барихад буу, бамбар, цахилгаан гүйдэл, хаалт, хашлага, гувчуур хэрэглэх;
- Ахуйн хэрэгцээнд загас барихад тор хэрэглэх;
- Ан агнах зориулалтын бус буу, сумаар;
- Гол, мөрөнд бүх төрлийн завиар загасчлах.

Агнуурын амьтан агнах, барихтай холбогдох хориглосон үйл ажиллагаанд;

- Шуурга, ган, зуд, үер, мөндөр, түймэр зэрэг гамшигт нэрвэгдсэн болон гол, мөрөн, намаг, шаварт орох зэрэг биеэ хамгаалах чадваргүй болсон агнуурын амьтныг агнах, барих;
- Булаг, шанд, хужир мараанд ирж буй амьтныг отож агнах;
- Өөр нутагт шилжин байршиж байгаа агнуурын амьтныг агнах, барих;
- Агнуурын амьтны үүр, ичээ ухах, гэмтээх;
- Агнуурын амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх зорилго бүхий байр, саравч, тэжээл мараа, бусад байгууламжийг эвдэж гэмтээх, устгах;
- Агнуурын амьтныг сайн танилгүй буюу анир чимээгээр таамаглаж буудах;
- Агнуурын амьтны үр төлийг агнах, шувууны өндгийг түүх, гэмтээх, устгах;
- Ангийн буу, агнуурын амьтан агнах, барих гэрээ, тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг бусдад шилжүүлэх;
- Тарвага, зурам, тэдгээрийн, түүхий мах, нойтон болон, халдваргүйжүүлээгүй арьсыг хот, тосгонд оруулах;
- Хот, тосгоны ногоон бүсэд судалгаа шинжилгээ, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх, ан амьтны тоо толгойг зохицуулахаас бусад зорилгоор агнуурын амьтан агнах, барих;
- Үйлдвэрлэлийн зориулалтаар загас барих бүх төрлийн торны нүдний хэмжээ 50х50 мм-ээс доош байх.

Сум, дүүргийн Засаг дарга тухайн жилд ахуйн зориулалтаар агнах агнуурын амьтны тоо хэмжээнд багтаан харьяалах нутаг дэвсгэрт агнуурын амьтан агнах, барих зөвшөөрлийг иргэн, хуулийн этгээдэд олгоно. Ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих тохиолдолд иргэн зохих төлбөр төлж, сумын Засаг даргаас авсан эрхийн бичгийн дагуу агнуурын ховор амьтнаас бусад амьтныг өөрийн ахуйн хэрэгцээнд зориулан агнаж, барьж болно. Ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих эрхийн бичигт иргэний овог, эцгийн нэр, өөрийн нэр, агнах, барих агнуурын амьтны зүйл, тоо, агнах, барих хугацаа, газар, төлбөр, хураамжийн хэмжээг нарийвчлан заана.

Ахуйн зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих нэг удаагийн эрхийн бичгийн хугацаа нь:

- Шувуу, тарвага агнаж, загас барихад гурав хүртэл хоног;
- Бусад агнуурын амьтан агнах, барихад тав хүртэл хоног тус тус байна.

Иргэнд нэг удаагийн эрхийн бичгээр агнах, барихыг зөвшөөрөх агнуурын амьтны тоо хэмжээ нь туурайтан амьтан нэг, тарвага тав, бусад үслэг ан нэг, хөтүү, ятуу, ногтруу шувуу тус бүр арав, ой, хээр, ус, намгийн бусад агнуурын шувуу тав, бусад агнуурын загас арван ширхгээс илүүгүй байна.

Зөрчлийн тухай хууль болон бусад хуулиудыг доорх хүснэгтээр харьцуулан харуулж, тайлбарлав. Үүнд:

7.7	7.7 дугаар зүйл. Амьтны тухай хууль тогтоомж зөрчих	Үйлчилж байсан хуулийн санкц	Тайлбар
7.7.1	1.Хугацаа дууссан гэрээ зөвшөөрлөөр, эсхүл гэрээ, зөвшөөрөлгүйгээр амьтныг ашигласан, эсхүл зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн бол хувь хүнийг далан таван тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг долоон зуун тавин тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл хүлээлгэнэ.	**Амьтны тухай хууль:** 39.1.1.хугацаа дууссан зөвшөөрлөөр амьтныг ашигласан, эсхүл зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн, зохих зөвшөөрөлгүйгээр амьтныг ашиглахыг завдсан иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох; 39.1.3.энэ хуулийн 14, 17, 18, 21 дүгээр зүйлд заасан гэрээ, зөвшөөрөлгүйгээр амьтныг ашигласан, эзэмшсэн иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгож, ашигласан, эзэмшсэн амьтныг төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийн дагуу байгальд нь эргүүлэн тавих буюу зохих байгууллагад хүлээлгэн өгөх;	Агуулгын өөрчлөлтгүй. Нэгтгэн томьёолсон.

7.7.2	2.Ан агнах, загас барих гэрээ, тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг бусдад шилжүүлж, эсхүл гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ан агнасан, барьсан эсхүл зохих гэрээ байгуулахгүйгээр үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнасан, барьсан бол хувь хүнийг нэг зуун тавин тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл хүлээлгэнэ.	**Амьтны тухай хууль:** 39.1.4.хугацаа нь дууссан зөвшөөрлөөр ан агнасан, загас барьсан, эсхүл ангийн буу, ан агнах, загас барих гэрээ, тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг бусдад шилжүүлсэн, зохих зөвшөөрөлгүйгээр агнуурын амьтныг агнах, барихыг завдсан иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох;	Агуулгын өөрчлөлтгүй. Завдах үйлдлийг хуулийн төслийн үзэл баримтлалд нийцүүлэн хассан.
7.7.3	3.Агнуурын амьтан агнах, барихтай холбогдсон хориглосон үйл ажиллагааг явуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулан авч, хувь хүнийг нэг зуун тавин тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл хүлээлгэнэ.	**Амьтны тухай хууль:** 11.1.Агнуурын амьтан агнах, барихтай холбогдсон дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 39.1.6.энэ хуулийн 10.1.2-10.1.4, 10.1.6, 11.1.1-11.1.3, 11.1.5-11.1.8, 11.1.11, 11.1.12-т заасныг зөрчсөн иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох;	Агуулгын өөрчлөлтгүй.

7.7.4	4.Агнуурын амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг тусгай зөвшөөрөл, гарал үүслийн бичиг, дагалдах тодорхойлолтгүйгээр худалдсан, худалдан авсан бол хувь хүнийг нэг зуун тавин тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл хүлээлгэнэ.	**Амьтны тухай хууль:** 39.1.9.зохих эрхийн бичиг, тусгай зөвшөөрөлгүйгээр ахуйн болон тусгай зориулалтаар агнуурын амьтан агнасан, барьсан, энэ хуулийн 26.3-т заасан ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг дагалдах тодорхойлолтгүйгээр худалдсан, худалдан авсан бол хураааж, иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох;	Агуулгын өөрчлөлтгүй.
7.7.5	5.Амьтныг зөвшөөрөлгүйгээр нутагшуулсан бол хувь хүнийг хоёр зуун тавин тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл хүлээлгэнэ.	**Амьтны тухай хууль:** 39.1.2.амьтныг зөвшөөрөлгүйгээр нутагшуулсан, гадаад улсаас оруулсан 39.1.2.амьтныг зөвшөөрөлгүйгээр нутагшуулсан, гадаад улсаас оруулсан иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох;	Агуулгын өөрчлөлтгүй.
7.7.6	6.Харь амьтныг зөвшөөрөлгүйгээр нутагшуулсан бол хувь хүнийг таван зуун тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл хүлээлгэнэ.	**Амьтны тухай хууль:** 36.4.Харь амьтныг төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр нутагшуулах, өсгөж үржүүлэхийг хориглоно.	Агуулгын өөрчлөлтгүй.
7.7.7	7.Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан зөрчлийг байнга үйлдсэн бол тухайн торгуулийн хэмжээг 3 дахин нэмэгдүүлж, эсхүл эрх хасах шийтгэл хүлээлгэнэ.		Шинээр томьёолсон.

ХУУЛЬ БУСААР АН АГНАХ ГЭМТ ХЭРГИЙН ШИНЖ, ЗҮЙЛЧЛЭЛ

Хууль бусаар ан агнах гэмт хэрэг нь амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, түүний нөөцийг зохистой ашиглахтай холбогдсон харилцаанд гэм буруугийн санаатай хэлбэрээр халдсан, Эрүүгийн хуулийн 24.5 дугаар зүйлд хуульчлан тодорхойлж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай үйлдэл юм[1].

1 Б.Энхболд нар. Эрүүгийн эрх зүй. Тусгай анги. сурах бичиг. УБ.,2018. 443 дах тал

2002 оны Эрүүгийн хууль	2015 оны Эрүүгийн хууль
203 дугаар зүйл. Ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчих 203.1. Улсын тусгай хамгаалалттай газар нутагт болон хориотой үед, хориглосон арга, зэвсэг, хэрэгслээр ан амьтан агнасан, барьсны улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан, ховор амьтныг зохих зөвшөөрөлгүйгээр агнасан, барьсан, тэжээж гаршуулсан, тэдгээрийн түүхий эдийн зүйлийг хадгалсан, худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 203.2. Энэ хэргийн улмаас их буюу онц их хэмжээний хохирол учирсан, нэн ховор амьтан агнасан, барьсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	**24.5 дугаар зүйл. Хууль бусаар ан агнах** 1. Улсын тусгай хамгаалалттай газар нутаг, эсхүл агнуурын бүс нутгаас бусад газарт, эсхүл амьтныг агнах хориотой үед, хориглосон хугацаанд, эсхүл хориглосон арга, зэвсэг хэрэгслээр амьтан агнасан, барьсан, эсхүл ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр агнасан, барьсан, зориудаар тэжээж гаршуулсан, үржүүлсэн, тэдгээрийн гаралтай түүхий эд зүйлийг хадгалсан, худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн, гадаад улсад гаргасан, ховор амьтны чихмэл, эд эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол дөрвөн мянга зургаан зуун далан тооцооны нэгжээс хорин дөрвөн мянган тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар гэрийн хоригод байлгах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2. Нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүй агнасан, барьсан, зориудаар гаршуулан тэжээсэн, амьдрах орчныг алдагдуулсан тэдгээрийн түүхий эдийг бэлтгэсэн, тээвэрлэсэн, хадгалсан, худалдсан, худалдан авсан, гадаад улсад гаргасан, ховор амьтны чихмэл, түүхий эд, эд эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол арван мянган тооцооны нэгжээс дөчин мянган тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 3. Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээд үйлдсэн бол тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасаж, хоёр зуун мянган тооцооны нэгжээс дөрвөн зуун мянган тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

Хэрэглээ. 1994 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 3 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал;

1. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийг дараах байдлаар ангилна. Үүнд: (1) дархан цаазат газар; (2) байгалийн цогцолборт газар; (3) байгалийн нөөц газар; (4) дурсгалт газар.

2. Аймаг, нийслэл, сум, дүүрэг өөрийн нутаг дэвсгэрт байгаа тодорхой газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авч болно.

7 дугаар зүйл. Дархан цаазат газар. Байгалийн бүс, бүслүүрийн онцлог, хэв шинжийг төлөөлж чадах унаган төрхөө хадгалсан байдал, шинжлэх ухааны онцгой ач холбогдлыг нь харгалзан байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг дархан цаазат газар гэнэ.

13 дугаар зүйл. Байгалийн цогцолборт газар. Байгалийн унаган төрхөө харьцангуй хадгалсан, түүх, соёл, шинжлэх ухааны болон танин мэдэхүй, экологийн хүмүүжилд ач холбогдол бүхий улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг байгалийн цогцолборт газар гэнэ.

19 дүгээр зүйл. Байгалийн нөөц газар. Байгалийн тодорхой хэв шинж, аль нэгэн нөөц, баялгийг хамгаалах, хадгалах, нөхөн сэргээх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг байгалийн нөөц газар гэнэ.

22 дугаар зүйл. Дурсгалт газар. Байгалийн өвөрмөц тогтоц, түүх, соёлын ул мөрийг уламжлагдан хадгалагдсан байгалийн байдлаар нь өвлөн үлдээх зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг дурсгалт газар гэнэ.

Хэрэглээ. 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн Амьтны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 4.1.3-д “нэн ховор амьтан” гэж тархац нутагтаа бүхэлдээ, эсхүл ихэнх хэсэгт тоо толгой эрс цөөрсөн, ашиглах нөөцгүй, устах аюулд орсон амьтныг хэлнэ гэж томьёолсон байна.

“*Зохих зөвшөөрөлгүйгээр*” гэдэгт мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д зааснаар иргэн ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад эрхийн бичиг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тусгай зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад тусгай зөвшөөрөл тус тус авч, үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад гэрээ байгуулж зөвшөөрөл аваагүйгээс бусад тохиолдлыг ойлгоно.

Амьтны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх хэсэгт “Ховор амьтан” гэж тархац нутагтаа тоо толгой цөөрсөн, нөөц багатай, устаж болзошгүй амьтныг хэлнэ гэж томьёолсон байна.

Амьтны тухай хууль (2012)-ийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтад тусгагдсан "Нэн ховор амьтад"

1) Мазаалай баавгай *(Ursus arctos gobiensis)*
2) Хавтгай тэмээ *(Camelus bactrianus ferus)*
3) Тахь адуу *(Equus ferus przewalskii)*
4) Ойн буган цаа *(Rangifer tarandus)*
5) Цоохор ирвэс *(Uncia uncia)*
6) Баданга хүдэр *(Moshus moshiferus)*
7) Молцог хандгай *(Alces alces)*
8) Татаар бөхөн *(Saiga tatarica)*
9) Голын халиу *(Lutra lutra)*
10) Азийн минж *(Castor fiber)*
11) Ойн унтаахай *(Dryomos nitedula)*
12) Зүүн гарын даахай *(Stylodipus sungorus)*
13) Борцгор хотон *(Pelicanus crispus)*
14) Хургач бор *(Paradoxornis heudei)*
15) Цагаан тогоруу *(Grus leucogeranus)*
16) Хар мөрний хилим /Acipenser schrenckii/
17) Шаргал үхэрдэй *(Tinca tinca)*
18) Цөөвөр чоно (*Cuon alpinus)*
19) Шивэр молцог хандгай *(Alces alces pfizenmayeri)*
20) Дорнын молцог хандгай *(Alces alces cameloides)*
21) Соргог бөхөн *(Saiga tatarica)*
22) Монгол бөхөн *(Saiga borealis)*
23) Алтайн чацуулин *(Talpa altaica)*
24) Гозоорой зурам *(Citellus alaschanicus)*
25) Сухайн чичүүл *(Meriones tamariscinus)*
26) Давжаа алагдаага (*Allactaga elater)*
27) Цагаантолгойт ямаансүүл *(Oxyura leucocephala)*
28) Могойч загалай (*Circaetus gallicus)*
29) Бор бүргэд *(Aguilla clanga)*
30) Усны нөмрөгбүргэд *(Aguila clanga)*
31) Реликт цахлай *(Larus relictus)* зэрэг 31 зүйл амьтад орсон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Ховор амьтад"

Нэг. Хөхтөн

1) Дорны сармаахай *(Vespertilio superans)*
2) Ойн булга *(Martes zibellina)*
3) Говийн шилүүс *(Lynx lynx isabellina)*
4) Суусар булга *(Martes foina)*
5) Эрээн хүрнэ *(Vormela peregusna)*
6) Хүрэн баавгай *(Ursus arctos)*
7) Хулан адуу *(Equus hemionus hemionus)*
8) Зэгсний зэрлэг гахай *(Sus scrofa nigripes)*
9) Халиун буга *(Cervus elaphus)*
10) Хар сүүлтий *(Gazella subgutturosa)*
11) Аргаль хонь *(Ovis ammon)*
12) Янгир ямаа *(Capra sibirica)*
13) Элсний тажигдаахай *(Sabpingotus kozlovi)*
14) Соотон алагдаахай *(Euchoreutes naso)*

Хоёр. Шувуу

1) Одой галуу *(Anser erythropus)*
2) Байгалийн нугас *(Anas formosa)*
3) Ундар шумбуур *(Aythya nyroca)*
4) Хан бүргэд *(Aquila heliaca)*
5) Ооч ёл *(Gypaetus barbatus)*
6) Азийн цууцил *(Limnodromus semipalmotus)*
7) Монгол хулан жороо *(Podoces hemdersoni)*
8) Хонин тоодог *(Otus tarda)*
9) Усны бух *(Botaurus stellaris)*
10) Бичил одой бух *(Ixobrychus minutus)*
11) Зээрд дэглий *(Ardea purpurea)*
12) Манхин галуу *(Anser albifrons)*
13) Гэзэгт нугас *(Anas Falcata)*
14) Хуруут хун *(Cygnus olor)*
15) Хархираа тогоруу *(Grus grus)*
16) Цагаан сүүлт нөмрөг *(Haliaeetus albicilla)*
17) Алтайн хойлог *(Tetraogallus altaicus)*
18) Зэрлэг гургуул *(Phasianus colchicus)*
19) Загийн бор *(Passer ammodendri)*
20) Ойн шийхнүүхэй *(Anthus trivialus)*

21) Шагшуургын шатан сүүлт *(Locustella luscinioides)*
22) Өгөөлэй шулганаа *(Saxicola insignus)*
23) Наран хөмрөг *(Emberiza yessoensis)*
24) Шар элэгт хөмрөг *(Emberiza aureola)*

Гурав. Мөлхөгч

1) Говийн нүцгэн хуруут гүрвэл *(Cyrtapodion elongatus)*
2) Тойрмын хонин гүрвэл *(Phrynosephalus helioscopus)*
3) Толбот могой гүрвэл *(Eremias arguta potanini)*
4) Тэмээн сүүл могой *(Eryx tataricus)*
5) Нарийн могой *(Coluber spinalis)*
6) Эгэл загалмайт могой *(Vipera berus*)

Дөрөв. Хоёр нутагтан

1) Шивэр гүлмэр *(Salamandrella keyserlingii*)
2) Ногоон бах *(Bufo danatensis)*
3) Модны мэлхий *(Hyla japanica)*
4) Дорнодын мэлхий *(Rana chensinensis)*

Тав. Загас

1) Тул *(Hucho taimen)*

Зургаа. Дугуй амтан

1) Номхон далайн могор *(Lampetra japonica*)

Долоо. Шавьж

1) Төст царцаа *(Eclipophleps similis)*
2) Эмэлжановын голио *(Eulithoxenus emeljanovi)*
3) Дамнуурга цэнхэр соно *(Aeshna juncea mongolica)*
4) Шүтээн цох *(Scarabaeus typhoon)*
5) Дорнын заар эвэрт цох *(Aromia moschata orientalis)*
6) Аполлон эрвээхэй *(Parnassius apallo)*
7) Эверсманны дэвүүр *(Parnassius eversmanni)*
8) Штуббендорфын дэвүүр *(Parnassius stubbendorfi)*
9) Фэб дэвүүр *(Parnassius phoebus)*
10) Зүүн сибирийн дэвүүр *(Parnassius tenedius)*
11) Махаон дэвүүр *(Parnassius mashaon)*
12) Одон бүгэг эрвээхэй *(Macroglossum stellatarum)*
13) Инжирийн шумбуур *(Deilephila elpenor)*
14) Голт борын шумбуур *(Sphinx ligustri)*
15) Бэр цэцэгч шумбуур *(Hemaris tityus)*

16) Хөвдний үхэр хэдгэнэ *(Bombus muscorum)*
17) Модестус үхэр хэдгэнэ *(Bombus modestus)*
18) Спорадикус үхэр хэдгэнэ *(Bombus sporadicus)*
19) Байгалийн үхэр хэдгэнэ *(Bombus subbaicalensis)*
20) Ихэр ирлэг ялаа *(Satanas gigas)*

Найм. Хавч хэлбэртэн

1) Хар мөрний хавч *(Leander modestus)*
2) Голын хавч *(Cambaroides dauricus)*

Ес. Зөөлөн биетэн

1) Дагуурын сувдан хясаа *(Dahurinaia dahurica)*
2) Дэлт танан хясаа *(Cristaria plicata)*
3) Сэлэнгийн танан хясаа *(Anodonta sedakovi)*
4) Монгол танан хясаа *(Middendorffinaia mongolica)* зэрэг 9 анги, бүлэгт хамаарх нийт 76 зүйл амьтан орсон байдаг.

Ховор амьтныг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлөөр тодорхой зориулалтаар агнаж, барьж болно.

Агнуурын ховор амьтныг тусгай төлбөртэйгөөр агнах, барих зөвшөөрлийн хугацааг Байгаль орчин, аялал жуулчлалын яам тогтооно.

Хууль бусаар ан агнах гэмт хэргийг нийгмийн аюулын шинж, түүний хэр хэмжээг харгалзан үндсэн болон хүндрүүлэх шинжид хуваан ангилдаг.

Энэ гэмт хэргийн объект нь манай оронд байгалийн жамаараа амьдардаг, унаган, нутагшсан, нүүдлийн харь амьтан зэрэг мал, гэрийн тэжээвэр амьтнаас бусад амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, түүний нөөцийг зохистой ашиглах, амьтныг болон амьтны эд эрхтнийг хууль бусаар худалдаалах, олон улсын гэрээ, конвенцоор худалдаалахыг хориглосон амьтны хууль бус худалдаатай холбогдсон харилцаа байна.

Хэргийн объектын өөр нэг онцгой шинжид тусгай хамгаалалттай газар нутгийн тухай ойлголт мөн хамаарна. Тусгай хамгаалалттай газар нутагт орших элбэг тархацтай, ховор болон нэн ховор амьтныг зохих зөвшөөрөлгүйгээр агнах, барихыг хориглодог болно.

Гэмт хэргийн халдлагын зүйл нь Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан, Амьтны тухай хууль[1]-д заасан мал, гэрийн тэжээвэр амьтнаас бусад амьтан, тэдгээрийн гаралтай эд эрхтэн, чихмэл болон амьтны амьдрах орчин нь халдлагын зүйл байна.

Энэ зүйлд заасан амьтан гэдэгт Байгаль орчныг хамгаалах тухай хууль[2]-ийн 4-д зааснаар Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга буюу түр нутагшсан хөхтөн, шувуу, мөлхөгч, хоёр нутагтан, загас, хавч хэлбэртэн, шавж, зөөлөн биетэн, эгэл биетэн хамаарна.

Түүнчлэн амьтны гаралтай **“түүхий эд”** гэдгийг Амьтны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.20. “ангийн гаралтай түүхий эд” гэж амьтны арьс, шир, үс, өд, эвэр, толгой, цус, өөх, тос зэрэг эд эрхтнийг гэж хуулийн **нэр томьёоны тодорхойлолтод заасан байна. Харин хууль зүйн шинжлэх ухааны үүднээс амьтны түүхий эд гэдэгт дээрх эд эрхтнээр хязгаарлахгүйгээр булчирхай, ноос ноолуур, яс, туурай, мах, дотор эрхтэн, хошуу зэрэг бүхий л эд эрхтэн байна.**

Хууль бусаар ан агнах гэмт хэргийн объектив тал нь дараах үйлдлүүдээр тодорхойлогдсон байна. Үүнд:

- Улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүйгээр
- эсхүл ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр агнасан;
- барьсан;
- зориудаар тэжээж гаршуулсан;
- үржүүлсэн;
- тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг хадгалсан;
- худалдсан;
- худалдан авсан;
- тээвэрлэсэн;
- гадаад улсад гаргасан;
- ховор амьтны чихмэл, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн;
- Нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүй агнасан, барьсан;
- зориудаар гаршуулан тэжээсэн;
- амьдрах орчныг алдагдуулсан;
- тэдгээрийн түүхий эдийг бэлтгэсэн, тээвэрлэсэн, хадгалсан, худалдсан, худалдан авсан, гадаад улсад гаргасан;
- ховор амьтны чихмэл, түүхий эд, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн.

1 Амьтны тухай.2012.5. //Төрийн мэдээлэл. 2012. №22 (739)
2 Байгаль орчныг хамгаалах тухай. 1995.//Төрийн мэдээлэл.1995. №5-6

Эдгээр үйлдлийн шинжийг тусгайлан авч үзвэл:

Улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүйгээр амьтан агнах, барих гэдэг нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд заасан газар нутагт зохих зөвшөөрөлгүйгээр амьтан агнасан барьсан үйлдлийг ойлгоно.

Мөн тархац нутагтаа тоо толгой цөөрсөн, нөөц багатай, устаж болзошгүй ховор болон тархац нутагтаа бүхэлдээ, эсхүл ихэнх хэсэгт тоо толгой эрс цөөрсөн, ашиглах нөөцгүй, устах аюулд орсон нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр агнасан, барьсан, зориудаар тэжээж гаршуулсан, үржүүлсэн аливаа үйлдэл хамаарна.

Ховор болон нэн ховор амьтны түүхий эдийн зүйлийг хадгалсан гэдэгт өөрийн болон бусдын орон байр, агуулах сав, тээврийн хэрэгсэлд байлгасан эдгээрээр хязгаарлагдахгүй хээр гадаа зэрэг хадгалах боломжтой бүхий л нөхцөл хамаарна.

Ховор, нэн ховор амьтны эд эрхтнийг худалдсан, худалдан авсан,тээвэрлэсэн, гадаад улсад гаргасан үйлдэлд хэн нэгний амьтан агнасан барьснаас үл шалтгаалан арилжааны хэрэгсэл болгон худалдаалах, худалдан авах, бараа таваарын солилцоонд ашиглах, харилцан солилцох зэрэг төлбөрийн хэрэгсэл болгох үйлдлийг худалдсан, худалдан авсан үйлдэл гэж ойлгох бол амьтны эд эрхтэн түүхий эдийг төрөл бүрийн тээврийн хэрэгслээр зөөвөрлөн авч яваа үйлдлийг тээвэрлэхэд хамааруулж үзнэ. Улсын хилээр нэвтрүүлж байгаа аливаа үйлдлийг гадаад улсад гаргасан гэж ойлгоно.

Харин ховор амьтны чихмэл, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн гэдэгт Амьтны тухай хуулийн 20.1-д эрдэм шинжилгээ, танин мэдэхүйн зорилгоор барьсан амьтан, тэдгээрийн чихмэл, арьс, үс, яс болон амьтны гаралтай бусад зүйлс амьтны цуглуулгад хамаарна. Амьтны тухай хуулиар иргэн, хуулийн этгээдэд ховор амьд амьтны цуглуулга хийх зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгохоор заасан бөгөөд зөвшөөрөлгүйгээр хийсэн үйлдлийг хамааруулна.

Амьдрах орчныг алдагдуулсан гэдэгт тархац нутагтаа бүхэлдээ, эсхүл ихэнх хэсэгт тоо толгой эрс цөөрсөн, ашиглах нөөцгүй, устах аюулд орсон нэн ховор амьтны бэлчээр ус, хүнс, тэжээл, орчныг алдагдуулах, талхлах, гол горхийг бохирдуулах хордуулахыг ойлгоно.

Нэн ховор амьтны түүхий эдийг бэлтгэсэн гэдэгт аливаа зорилгод ашиглахаар олон эсвэл цөөн тоогоор бэлтгэх үйлдэлд хамаарна.

Энэ хуулийн 2 дахь хэсэгт заасан үйлдэл нь нэн ховор амьтанд хамаарах бөгөөд оногдуулах ялын хэмжээ нэмэгдэж байгаа нь хүндрүүлэх шинжийг агуулж байна.

Хууль бусаар агнах гэмт хэрэг нь байгаль орчинд хохирол учруулсан эсэхээс үл хамаарч хэлбэрийн шинжтэй үйлдэл хийснээр төгсдөг гэмт хэрэг болно.

Гэмт хэргийн субъект нь эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр заасан 16 насанд хүрсэн хэрэг хариуцах чадвартай, Монгол улсын иргэн, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн алин ч байж болно.

Хууль бусаар ан агнах гэмт хэргийн криминологи шинж

Хууль бусаар ан агнах гэмт хэрэг нь экологийн эсрэг гэмт явдлын бүрэлдэхүүнд багтах, Эрүүгийн хуулиар хориглосон гэмт хэрэг юм.

Энэ гэмт хэрэг үйлдэх болсон шалтгаан нөхцөлийг үйлдэгдсэн хэргээс үзэхэд хийморь лундаагаа сэргээхээр ан хийх зорилготой явж, энэ явцдаа хуулиар агнахыг хориглосон ан амьтан таарахад амьтан алах гэсэн хүсэл эрмэлзэлдээ дийлдэж, баригдахгүй байх гэсэн бодол сэтгэлээр ямар ч эргэлзээгүйгээр, зориуд хүсэж ан агнах, адуу малдаа явахдаа заавал галт зэвсэг авч явж ан тааралдахад агнаж байгаа нь амьтан агнаж авлах гэсэн бие хүний онцлог шинжтэй холбон тайлбарлаж болох юм. Монгол эр хүн бүрд байдаг ан агнах сонирхол нь хууль бус үйлдлийг хийлгэхэд маш ойрхон болгодог хэдий ч тэр бодол санаа нь ухамсарт үйлээр хязгаарлагдах ёстой.

Нөгөөтээгүүр эдийн засгийн шинжтэй ашиг хонжоо олох гэсэн шууд санаа шунахай зорилготой, өвчин эмгэгийг эмнэх, эрүүл мэндээ сайжруулах зорилго сэдэлт бүхий нуугдмал шинжтэй гэмт хэрэг юм.

Ан агнуурыг бүлэглэн гүйцэтгэдэг нь энэ хэргийн онцлог бөгөөд гэмт хэргийг давтан үйлдэх, ял шийтгэгдсэн этгээдүүд бага байгаа нь ял шийтгэлийн үр нөлөөтэй шууд холбоотой гэж дүгнэж болно.

Хууль бусаар ан агнах, барих үйлдэл нь хөдөө хээр, хүнгүй газарт зэвсэг хэрэгсэл ашиглан үйлдэгддэг, харин амьтны эд эрхтэн худалдаалах үйлдэл нь зөвхөн худалдагч, худалдан авагч нарын дунд хүний нүднээс далд хийгддэг зэргээрээ нуугдмал шинжтэй, нийгмийн хор аюулаар үлэмж их гэмт хэрэг учраас энэ гэмт хэргийн гаралтыг үнэлэхдээ нуугдмал түвшнийг судалгаа шинжилгээгээр тогтоох нь чухал юм.

Хууль бусаар ан агнах гэмт хэргийн криминалистик шинж

Криминалистик нь “Гэмт хэргийн бүтцийн зүй тогтол, гэмт хэрэг ба түүнд оролцогчдын тухай мэдээлэл бий болох зүй тогтол, түүнчлэн нотлох баримт цуглуулах, шинжлэх, үнэлэх, ашиглах зүй тогтлууд, тэдгээрийн танин мэдэхүй дор суурилсан гэмт хэрэг илрүүлэх, таслан зогсоох тусгай арга хэрэгслийн тухай шинжлэх ухаан мөн”[1] гэж Оросын эрдэмтэн Р.С.Белкин тодорхойлжээ.

Криминалистикийн арга зүйн зөвлөмж нь тодорхой төрлийн гэмт хэрэг илрүүлэх, бүртгэх, мөрдөх, таслан зогсоох ажиллагааг зохион байгуулах, явуулах судалгаа шинжилгээний үндсэн дээр боловсруулсан практикаар шалгагдсан зөвлөмж юм. Зөвлөмж нь одоо байгааг боловсронгуй болгох, шинэ арга зүйг боловсруулах шинжийг заавал агуулсан байх ёстой.

Хууль бусаар ан агнах гэмт хэргийн криминалистик шинж гэдэг гэмт хэрэг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээ баримтын нийлбэр цогцыг хэлнэ. Эдгээр элементэд:

- Халдлагын зүйл;
- Гэмт хэрэг үйлдсэн болон нуун далдалсан арга;
- Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн болон гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал (цаг хугацаа, газар орон г.м);
- Гэмт этгээдийн ул мөр;
- Гэмт хэргийн хор уршиг;
- Гэмт этгээдийн болон хохирогчийн хувийн байдал;
- Гэмт хэргийн шалтгаан нөхцөл зэрэг орно.

Криминалистикийн арга зүйд гэмт хэргийн криминалистик шинж нь чухал ач холбогдолтой бөгөөд хууль бусаар ан агнах гэмт хэрэг мөрдөх арга зүйг боловсруулахад криминалистикийн шинжийг тогтоохгүйгээр тухайн гэмт хэргийн мөрдөн байцаалтын ажиллагааны арга зүйн зөвлөмжийг гаргах боломжгүй юм. Тийм учраас хууль бусаар ан агнах гэмт хэргийн криминалистик шинжийг тодорхойлох нь гэмт хэрэг мөрдөхөд үнэтэй зөвлөмж болно.

Криминалистик тодорхойлолтын бүтцийн жишиг элементийн нэг болох гэмт хэрэгт өртөгдсөн тодорхой биет нь хууль бусаар агнагдсан амьтад юм. Амьтны тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэргийн нөхцөл байдлын судалгаагаар ямар зүйлийн амьтад, ямар зорилго, зориулалтаар ихэвчлэн өртөгдөж байгааг дараах байдлаар төрөлжүүлэн үзнэ. Үүнд:

1 Р.С Белкин. Криминалистика. М.,1999

Гэмт үйлдлийн зорилгоор нь (а) ашиг орлого олох, (б) ахуйн хэрэгцээндээ зориулах, (в) тодорхой чиглэсэн зорилгогүй зөвхөн зугаа, цэнгэл буюу амьтан алах сонирхлоор гэж ангилж болно.

Амьтны эд эрхтнийг хууль бусаар худалдаалж буй гэмт үйлдлийг;

1. үслэг ангийн худалдаа (тарвага, үнэг, хярс, булга, суусар, баавгай, цоохор ирвэс, чоно зэрэг үслэг амьтдын арьсыг худалдаална),
2. эм, эмчилгээний зориулалтай худалдаа (буга, хүдэр, бөхөн, чоно, хойлог зэрэг амьтдын эд, эрхтнийг худалдаална),
3. ангийн махны худалдаа (буга, хандгай, зэрлэг гахай, бор гөрөөс, цагаан зээр, хар сүүлт, хулан, аргаль, янгир, тарвага, хур, сойр, олон зүйл загасны амт чанар сайтай махыг худалдаална),
4. гоёл, чимэглэлийн зориулалтын худалдаа (аргаль, янгир, хандгай, буга, гахай, баавгай, чоно зэрэг хөхтөн, шонхор, тас, бүргэд зэрэг жигүүртэн, тул, хилэм, зэвэг зэрэг загаснуудыг агнаж, тэдгээр амьтдын эвэр, туурай, яс, соёо, шагай болон арьс үсээр нь чихмэл, хатаамал зэрэг бүтээгдэхүүн хийж худалдаална) гэж хуваана.

Дээр дурдсан элементүүдээс хамгийн их түлхүү ач холбогдолтой нь гэмт хэрэг илрүүлэх, мөрдөхөд ул мөр үүсэх механизмыг судлах явдал юм. Хэргийн газарт ул мөрийг мэргэжлийн түвшинд илрүүлж, гэмт хэрэг үйлдсэн аргыг тодорхойлох нь хэргийн илрүүлэлтэд чухал нөлөөтэй. Хууль бусаар ан агнах гэмт хэрэг нь бусад хэргээс өөрийн өвөрмөц онцлогтой. Амьтныг агнахад ямар нэгэн зэвсэг хэрэгсэл, аргыг ашигладаг тул гэмт хэргийн газарт эд мөрийн баримт заавал үлддэг.

Хууль бусаар ан агнах гэмт хэргийн объектив үйлдлийг зэвсэг хэрэгсэл ашигласан, аливаа нэгэн аргаар амьтан агнаж, барьсан гэж ангилан хуваж болно. Амьтныг агнасан байдлаар нь ямар төрлийн галт зэвсэг, сум хэрэглэсэн, мэргэжлийн анчин уу эсвэл туршлага багатай анчин уу гэдгийг тодорхойлж болно. Аливаа амьтныг байлдааны зориулалттай галт зэвсэг, сумаар агнахыг хориглодог.

Амьтны эд, эрхтнийг хууль бусаар худалдаалагчид нь (а) бэлтгэн нийлүүлэгч анчин, (б) цуглуулагч, (в) тээвэрлэгч, (г) ченж нэртэй худалдан авагч, (д) ангийн эд, эрхтнийг хил дамнуулан зарагчид гэсэн сүлжээ бүхий зохион байгуулалттай.

Худалдан авагч, бэлтгэгч анчид нь ихэнх тохиолдолд бие биеэ танихгүй, утсаар хоорондоо харилцаж, шуудан илгээмж, явуулын хүнээр худалдаалах зүйлээ дамжуулж, төлбөрөө банк, АТМ-ээр хийх зэргээр нууц далд аргатай. Амьтны эд эрхтэн худалдан авагч ченж нар нь эд эрхтнийг хадгалах зориулалтын агуулах байр сав, хэрэгслийг урьдчилан бэлтгэсэн байдаг.

Хууль бусаар ан агнагчид нь амьтны эд эрхтний үлдэгдлийг булах, нуух устгах, машин техник, галт зэвсэг зэрэг бохирлогдсон эд зүйлээ цэвэрлэх зэргээр гэмт хэргээ нуун далдлах, ул мөрөө баллах идэвхтэй ажиллагааг явуулдаг. Ан агнах гэмт хэрэг нь эзгүй ой, хээр тал газар, ихэвчлэн шөнийн цагаар үйлдэгддэг тул тэр бүр бусдад мэдэгддэггүй, амьтны эд эрхтний худалдааг хүний нүднээс далд хийдэг тул ихэнхдээ нуугдмал шинжийг агуулж байдаг. Ийнхүү хууль бусаар ан агнах гэмт хэргийн криминалистикийн шинжийг жишиг байдлаар тодорхойлох нь тухайн гэмт хэргийг мөрдөх арга зүйн зөвлөмжийн үндсэн суурь болж байгаад түүний ач холбогдол оршино.

ШИНЖЭЭЧ ТОМИЛОХ, ШИНЖИЛГЭЭ ХИЙЛГЭХ

Хууль бусаар ан агнах гэмт хэрэг сүүлийн жилүүдэд ихсэж, малын махыг амьтны махаар солих, нохой, буга, зээр, хулан зэрэг тураг амьтдын махаар хоол унд хийж худалдах, хууль бусаар баавгайн донид, хүдрийн заарыг худалдан борлуулж байгаад баригдах үед үхрийн цөс, малын засаа гэж мэлзэх асуудлууд цөөнгүй гарч, түүнийг илрүүлэхэд амьтан судлалын мэдлэгийг ашиглах зайлшгүй шаардлага гарсаар байна.

Хууль хяналтын байгууллагын ажилтнуудад махны төрлийг найдвартай ялган таних мэдрэг арга зайлшгүй хэрэгтэй болж байна. Манай орны эрдэмтэд амьтдын махны төрлийг ясны жишил анатомийн онцлогоор тодорхойлох, амьтны морфологи шинжээр ямар зүйлийн амьтан болохыг таних зэрэг шинжлэх ухааны аргуудаас гадна, ийлдэс, дархлаа судлалын олон аргуудыг боловсруулж, үйлдвэрлэлд нэвтрүүлжээ. Тухайлбал, доктор А.Батсүрэн, Г.Уртнасан, Э.Төмөртогтох нар үхэр, хонь, ямаа, буга, цагаан зээр, хар сүүлтийн махыг ялган таних арга[1], доктор Т.Даваа адуу, хулангийн махыг нэвчин тунадасжих урвалын өвөрмөц ийлдсээр махны төрлийг ялгах арга[2] зэрэг үнэ өртөг багатай, мал эмнэлэг, ариун цэврийн аль ч лабораторид ашиглаж болох арга зүйг боловсруулж, стандартыг (MNS 5817:2007) батлуулсан байна.

Мөн хүн ба амьтны үс[3] ашиглаж гэмт хэрэг илрүүлэх боломжийн талаар доктор А.Доржготов судалгаа явуулж, үс бол гэмт хэрэг илрүүлэх нэг чухал

1 С.Лхавгасүрэн. Махны төрөл, малын хүйс тодорхойлох ДНХ оношилгоо.//Эрдэм шинжилгээ бүтээлийн эмхтгэл. УБ.,2014. 243 дахь тал

2 Т.Даваа. Адуу, хулангийн махны шинэлэг байдал, ялган таних арга. Мал эмнэлгийн ухаанаар боловсролын докторын зэрэг горилсон бүтээл УБ.,2008.

3 А.Доржготов. Хүн ба амьтны үс ашиглаж гэмт хэрэг илрүүлэх боломж Хууль зүйн ухааны дэд докторын зэрэг горилсон бүтээл УБ.,1995

эх үүсвэр бөгөөд тухайн гэмт хэргийн талаар өөртөө үнэтэй мэдээлэл агуулж байгааг адилтгал, харьцуулалт, хими, биологийн арга зүйн мэдлэгийг ашиглан тогтоосон байна. Түүнчлэн амьтны мөр нь гэмт хэргийн нотлох баримтын эх сурвалж болох талаар доктор Ц.Гантулга судалгаа явуулж, криминалистикийн мөр судлалд амьтны мөрийг судлах шаардлага байгааг илэрхийлсэн юм. Судлаач С.Лхагвасүрэн, Ц.Амарсайхан нар орчин үеийн судалгааны арга зүй ашиглаж боловсруулалт хийгдсэн махан бүтээгдэхүүн, олон жил хадгалагдсан амьтны үс, ноос, ялгадас, цусны толбо, арьсны гуужсан хэсгээс ч махны төрөл, амьтны хүйсийг илрүүлэх ДНХ-ийн оношилгооны арга зүйг боловсруулсан[1] нь практикт нэвтрээд удаагүй байна.

Хууль бусаар ан агнах гэмт хэргийн эд мөрийн баримт болох амьтны эд, эрхтэнд шинжлэн магадлахуйн амьтан судлалын шинжилгээ явуулахад хууль сахиулах байгууллагын ажилтнуудад анхаарах хэрэгтэй. Үүнд:

1 *Амьтны үхлийн шалтгаан тогтоох (паталоги).* Амьтны үхсэн шалтгааныг тогтооход шинжээч нь амьтны хүүр байсан газрыг үзэх, түүнчлэн эргэн тойрны байдлыг харах нь дүгнэлт гаргахад маш их тус болдог.

Хууль бусаар агнагдсан амьтны хүүр бүрэн бүтэн байх нь тун хомс. Ихэвчлэн эд эрхтнийг нь авсан, эвдэж янзалсан байдалтай олддог бөгөөд хүүрийг үзэхдээ гэмтлийн шинж байдал, цус, хөөс гэх мэт болон гаднын юмс байгаа эсэхэд анхаарлаа хандуулна. Илэрсэн бүх зүйлийг нарийн үзэж, үр дүнг тэмдэглэлд тусгайд нь оруулна. Амьтан үхсэний дараа хүүрэнд хөрөлт, хаталт, хөшилт болон хүүрийн задралт зэрэг олон янзын өөрчлөлтүүд бий болдог ба амьтан үхмэгц ялгах булчирхайн үйл ажиллагаа зогсож чийгээ алдаж хатна.

Хэргийн газрын үзлэгийг ихэнх тохиолдолд нэлээд цаг хугацаа өнгөрч, хүүр хатсан үед хийдэг учир хаталт нь ил харагдах салст бүрхүүл, нүдний эвэрлэг бүрхүүлээс эхэлж, булингартаж, дараа нь үрчийн, сүүлдээ бүр хуурай болно. Хаталтын хугацаа янз бүр хуурай цаг уур, өндөр температуртай үед богиносох ба агаарын чийг их, нам температуртай үед уртасна. Хүүрийн хөшилт нь үхэх үед ямар байсан тэр байдлаа хадгална. Хэрэв хөшсөн байдлыг хүчээр өөрчилбөл буцаж анхны байдалдаа орохгүй[2].

1 PCR-RFLP-ийн шинжилгээний арга зүйгээр тухайн төрөл зүйлийн хүрээнд генетикийн варицыг митохондрийн цитохром В генийг ашиглан шулсан, ангилсан, савласан халууны боловсруулалт хийсэн махны төрөл, гарал үүслийг тодорхойлсон. Мөн амьтдын хүйсийг тодорхойлоход PSR-ийн аргыг хэрэглэх нь найдвартайг туршилтаар тогтоосон байна. Чоно, ирвэс, зээрийн махны төрлийг тогтоохдоо дэлхийн гений банк /GenBank/-ны судалгааны дүнг ашиглажээ. С.Лхавгасүрэн нар. Махны төрөл, малын хүйс тодорхойлох ДНХ оношилгоо.//Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл УБ., 2014. 243 дах тал.

2 В.З.Черняк ба бусад. Шүүх мал эмнэлэгийн магадлан шинжилгээ. УБ.,1969. 22-23 дахь тал

❷ *Амьтны биед үүссэн шархаар нь шалтгааныг тодорхойлох.* Амьтны бие махбодын гадна талын бүрэн бүтэн байдал эвдрэхийг шарх гэнэ. Шархыг өнгөн арьсыг нэвтлээгүй, гүн, дотор эд эрхтнийг гэмтээсэн, нэвтэрсэн, хоёр талаасаа нээлттэй гэж хуваана.

Амьд байх үеийн шарх: Үхсэний дараахаас ялгагдах нэг онцлог нь дотно ба гадна цус гоожилтын ором байх төдийгүй шархны эргэн тойронд улайж хавдсан зэрэг үрэвслийн урвал илэрсэн, эд ба үс ноосонд цус наалдсан байна. Амьтан шарх авснаас хойш үхэх хүртэл хэдий хугацаа өнгөрсөн байна шархны ялгагдах шинж тэмдэг төдий чинээ тод байна. Амьд үеийн шархны амсар нь амьд эдийн агшилтаас болж заавал ангайна. Хэрвээ шархны амсар цайвар ба цусгүй, ангайлт нь сул байх нь үхсэний дараа шархалсныг гэрчилнэ. Шархны тусгай хэлбэрүүдийн талаар хоёрдугаар бүлгээс дэлгэрүүлнэ үзээрэй.

❸ *Эд, эрхтэнд хийх магадлан шинжилгээ.* Эд мөрийн баримтыг шинжлэх нь хууль бусаар ан агнах, амьтны эд, эрхтнийг худалдаалах гэмт хэргийн мөрдөн байцаалт, шинжлэн магадлах ажлын хамгийн хариуцлагатай хэсэг юм. Амьтан судлалын магадлах шинжилгээнд шинжлэгдэх гэж буй эд эрхтэн нь жижиглэн таслагдсан, бүтээгдэхүүн болсон, халуун аргын боловсруулалтад орсон зэрэг гаднах хэлбэр дүрс, хэмжээ нь өөрчлөгдөж, ясны жишил анатоми, морфологийн шинжилгээгээр тодорхойлогдох боломжгүй болсон байдаг. Энэ үед хими, биологи, бактери, генетик судлалын магадлан шинжилгээг тусгай лабораторид хийлгэнэ.

Амьтныг химийн аливаа хороор хордуулсан эсэхийг тодорхойлоход токсихологийн шинжилгээ ач холбогдолтой. *Хор гэдэг нь амьтны бие махбодод бага хэмжээгээр ороход эрүүл байдлыг өөрчилж, үхэлд хүргэдэг бодисыг хэлнэ*. Одоогоор амьтныг хордуулж агнасан хэрэг бүртгэгдээгүй боловч чоно, үнэг зэрэг амьтанд хортой өгөөш тавьж агнах арга бий.

Эд мөрийн баримтаар хураагдсан амьтны эд эрхтэнд шинжилгээ явуулж, дүгнэлт гаргах нь мөрдөн байцаалтын чухал хэсэг бөгөөд шинжилгээгээр юуг тогтоож болох, шинжээчид ямар асуултууд тавьж шийдвэрлүүлэх нь нотолгооны онцгой ач холбогдолтой юм. Мөрдөгчид шинжилгээний байгууллагаар ямар асуудлыг шийдвэрлүүлж болох эсэхийг мэдэхийн тулд мөрдөгч нарт амьтан судлалын мэдлэг чухал шаардлагатай байдаг. Гэтэл хууль сахиулах байгууллагын ажилтнуудаас шинжилгээний байгууллагад хандаж дүгнэлт гаргуулж байгаа явцыг ажиглахад амьтан судлалын шинжилгээгээр шийдвэрлэж болох асуудлыг мэдэхгүй, шинжээчид оновчтой зөв асуултууд тавьж чадахгүй байна.

Бодит жишээ 13. Шинжлэх ухааны академи (ШУА)-ийн Биологийн хүрээлэнд амьтны эд эрхтэнд шинжилгээ хийлгэхээр хүргүүлсэн тогтоол, шинжээчийн дүгнэлтүүдээс үзэхэд, нэр бүхий цагдаагийн хэлтсийн мөрдөгч Эрүүгийн 00000 дугаартай хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан 6 ш чив, 11 ш сүүл, 45 ш чонын шагай, 1 ш хүдрийн заар зэрэг амьтны эд эрхтэнд шинжилгээ хийлгэхээр ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн Хөхтний экологийн лабораторид хандсан байдаг.

Тус шинжилгээ хийх, шинжээч томилох тогтоолд *“(1) ...хураагдсан 6 ш чив, 11 ш сүүл, 1 ш хүдрийн заар зэрэг нь хэдэн төрөл зүйлийн ямар амьтны чив, сүүл, шагай, заар болох, (2) ... тэдгээр нь ховор, нэн ховор амьтны жагсаалтад орсон амьтны эд эрхтэн мөн эсэх”* гэсэн асуултууд тавьжээ.

Бодит жишээ 14. Мөн нэр бүхий хэлтсийн мөрдөгчийн ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн Хөхтний экологийн лабораторид хүргүүлсэн баавгай хууль бусаар агнаж, худалдаалахаар тээвэрлэж явсан хэрэгт шинжилгээ хийх, шинжээч томилсон тогтоолд *“(3) ... хураан авсан баавгайнд үзлэг хийх боломжтой эсэх, баавгайны эд эрхтэн нь бүрэн бүтэн байгаа эсэх, уг баавгайн нь ямар хүчин зүйлийн хэдэн удаагийн үйлчлэлээр алагдсан болох, алагдсан цаг хугацааг тогтоох, хэрэв галт зэвсгийн үйлчлэлээр алагдсан бол сумны хошуу болон бусад ул мөр, эд мөрийн баримт тогтоогдох эсэх”* зэрэг хүсэлт гаргажээ.

Бодит жишээ 15. Түүнчлэн нэр бүхий цагдаагийн хэлтсийн мөрдөгчийн ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн Хөхтний экологийн лабораторид хүргүүлсэн шинжилгээ хийх, шинжээч томилох тогтоолд *“(4) хураагдсан амьтны хэсэг мах, 803 ш арьснуудыг ямар нөхцөл бүхий газарт хадгалдаг болох, одоо хадгалж буй цагдаагийн хэлтсийн эд мөрийн бариmтын өрөө нь дээрх арьснуудыг хадгалах нөхцөлийг бүрдүүлж чадаж байгаа эсэх, хураагдсан мах, арьснууд нь түргэн муудаж чанар байдлаа алдах эсэх, арьсны экологи-эдийн засгийн үнэлгээг тогтоох”* зэрэг хүсэлт гаргасан байна.

Дээрх асуултууд нь утга найруулга, логикийн алдаатай, шийдвэрлэвэл зохих асуултыг оноож тавиагүй, илүүц шаардлагагүй асуултуудыг тавьсан байна. Тухайлбал, 1-р асуултад буй “хүдэр”-ийн заар гэх зүйл нь ямар зүйлийн амьтны заар болох гэсэн асуулт нь логикгүй, 2-р асуултад дурдагдсан нэн ховор, ховор амьтны жагсаалтад орсон амьтан мөн эсэх гэсэн асуулт нь илүүц

болсон байна. Учир нь тухайн зүйл амьтны ховор, нэн ховор амьтны аль нь болохыг мөрдөгч өөрөө тогтоох ёстой бөгөөд шинжээч нь хууль тогтоомж, дүрэм журмыг тайлбарладаггүй. 3-р асуултад нэгэнт эд мөрийн баримтаар бүтэн баавгай хураагдсан байхад үзлэг хийх боломжтой эсэх асуултыг тавих нь оновчгүй бөгөөд харин түүний агнагдсан үхлийн шалтгааны тогтоох асуултыг тавих, 4-р асуултад амьтны эд эрхтнийг хадгалах газрын нөхцөлийг шинжээчээр шийдвэрлүүлэх шаардлага байхгүй, амьтны арьс, үсэнд зах зээлийн үнэлгээ тогтоохоос биш экологи-эдийн засгийн үнэлгээ тогтоодоггүй зэрэг олон алдаатай зүйлүүд байгааг дурдаж болохоор байна.

Дээрх байдлаас үзэхэд, мөрдөгч нарын эзэмшвэл зохих, ялангуяа амьтан судлал, байгаль орчныг хамгаалах хууль, эрх зүйн мэдлэг сул байна. Иймд, хууль бусаар ан агнах гэмт хэргийг мөрдөх арга зүйд шинжээчид тавих асуултыг боловсронгуй болгох нь нэн яаралтай хийх тулгамдсан ажлуудын нэг болж байна.

Амьтны үхлийн шалтгааныг тогтоолгохоор шинжилгээнд хүргүүлж буй амьтан нь бүхлээрээ байгаа тохиолдолд үхлийн шалтгааныг тогтоох боломжтой бөгөөд шинжээч бололцооны хирээр дараах асуултуудад хариулах ёстой. Үүнд:

- Шинжилгээнд хүргүүлж буй амьтан нь ямар зүйлийн амьтан болох, түүний олон улсын нэршил?
- Тухайн зүйл амьтан нь Монгол орны аль бүс бүслүүрт тархсан бэ?
- Тухайн амьтны үхлийн шалтгаан юу болох?
- Уг амьтны биеийн гадна арьсанд ил харагдах ямар гэмтэл үүссэн байна вэ?
- Задлан шинжилгээгээр амьтны дотор эд эрхтэнд ямар гэмтэл (бууны сум, хавх, урхинаас үүдэлтэй гэмтэл г. м) үүссэн байна вэ?
- Тухайн амьтныг үхэлд хүргэсэн гаднын нөхцөл, нөлөөлөл юу байна вэ?
- Энэ амьтан үхсэнээс хойш хэдий хэр хугацаа өнгөрсөн, хугацааг ойролцоогоор тогтоох. Дурдсан хугацаанд (...төдийд) үхсэн байж болох уу?

Мөрдөн байцаах байгууллагаас тавьсан бусад асуултуудад шинжээч нь хариулахаас гадна, шинжилгээний явцад олж мэдсэн бусад асуудлуудыг асуулт тавиагүй ч гэсэн мэргэжлийн шинжээчийн хувьд тодорхой тайлбарлаж бичнэ.

Амьтны биед үүссэн гэмтэл бэртлийг тодорхой тогтоож бичнэ. Хэрвээ эд мөрийн баримтаар хураагдсан амьтан нь амьд байгаа бөгөөд гадна үзлэгээр бэртсэн гэмтсэн цус гарсан, шархтай байгаа бол:

- Тухайн амьтны биеийн аль хэсэгт ямар шарх үүссэн байна вэ?
- Уг шарх нь хатуу мохоо, эсвэл хурц үзүүртэй эд зүйл (хутга, шөвөг г.м)-ээр хатгагдсан, огтлогдсон, зүсэгдсэн, эсвэл буудагдсан аль нь болох?

Амьтны эд эрхтэнд хийх шинжилгээгээр дараах зүйлсийг тодруулах шаардлагатай. Үүнд:

- Шинжилгээнд хүргүүлсэн зүйлс (арьс, булчин, мах, яс, дотор эрхтний хэсэг г.м) нь амьтны эд эрхтэн мөн үү? Хэрвээ мөн бол мал, амьтан, хүний алиных нь болох?
- Шинжилгээнд хүргүүлсэн эд эрхтэн нь амьтных мөн бол ямар зүйлийн амьтны эд эрхтэн (арьс, мах, эвэр, туурай, дотор эрхтэн) болох? Олон улсын нэршил?
- Тухайн амьтан нь манай орны аль бүс бүслүүрт тархсан бэ?
- Уг эд, эрхтнээр тухай амьтны нас, хүйсийг тогтоох боломжтой эсэх?
- Шинжилгээнд хүргэгдсэн амьтны эд эрхтэн болох эвэр, арьс, үсээр нь тухайн амьтны агнагдсан хугацааг тогтоох боломжтой эсэх?
- Шинжилгээнд хүргүүлсэн эд зүйл (нэрийг нь бичих) дээр цус байгаа эсэх?
- Хэрэв цус мөн бол тэр нь хүнийх үү, амьтных уу? Амьтных бол ямар зүйлийн амьтных вэ?
- Тухайн объект үс мөн эсэх[1], хэрэв мөн бол хүн ба амьтны алиныхан үс болох?
- Хэрэв амьтны үс бол ямар зүйлийн амьтны үс вэ? ..... тухайн амьтны үс мөн эсэх?
- Үс нь ямар зүйлээр бохирлогдсон эсэх, ямар шалтгаанаар үс гэмтэлд орсон эсэх?
- Тухайн үсийг зулгаасан, тасалсан, хайчилсан аль нь болох, амьтны аль хэсгийн үс болох?

1 А.Доржготов. Хүн ба амьтны үс ашиглаж гэмт хэрэг илрүүлэх боломж Хууль зүйн ухааны дэд докторын зэрэг горилсон бүтээл УБ.,1995. 112 дахь тал

Хэрэг учрал болсон газарт илэрсэн хөлийн мөр ямар амьтных болох (энэ нь тухай амьтны мөрний талаарх харьцуулах хэв загвартай үед хийх боломжтой)?

- Тухайн мөрний хувийн онцлог шинж тэмдэг юу вэ?
- Тухайн амьтан аль чиглэлд явж байсан байна вэ?
- Амьтны мөрөөр нас, хүйсийг тогтоох боломжтой эсэх?
- Хэрэг учрал болсон газарт хэчнээн тооны амьтан байсныг тогтоох боломжтой эсэх?
- Тухайн амьтны мөрүүд дотор өөр амьтны мөр (ялангуяа морь, тэмээ, үхэр г.м) холилдон орсон эсэх?[1] зэрэг асуудлуудыг шийдвэрлүүлэх боломжтой.

Хууль бусаар ан агнах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд эд мөрийн баримт нь онцгой чухал үүрэгтэй байдаг. Энэ гэмт хэргийн эд мөрийн баримтад гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг хэрэгсэл, гэмт хэргийн ул мөр, амьтны эд, эрхтний үлдэгдэл, бусад зүйлс, түүнчлэн гэмт үйлдлийн замаар олсон мөнгө, үнэ бүхий зүйл, баримт бичиг болон гэмт хэргийг илрүүлэх, хэргийн бодит байдлыг тогтоох, гэмт этгээдийг олох, эсхүл сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм бурууг үгүйсгэх буюу хөнгөрүүлэхэд ач холбогдол бүхий бусад эд зүйлийг тооцдог.

Мөрдөн байцаалтын ажиллагаа нь эд мөрийн баримтыг олж тогтоох, хураан авах, түүнд үзлэг, шинжилгээ хийх болон хуульд заасан бусад байцаан шийтгэх ажиллагаа явуулах замаар нотлох баримтыг цуглуулна.

Хууль бусаар ан агнах гэмт хэргийн гол нотлох баримт болох биологийн гаралтай амьтны эд эрхтэн, амьд амьтныг хураан авах, бэхжүүлэх, хадгалах арга зүйн асуудал хөндөгдөнө. Шинжилгээг үр дүнтэй явуулахын тулд эд мөрийн баримт болох амьтны эд, эрхтнийг хураан авах, нотолгооны шаардлагыг хангаж хадгалах асуудал чухлаар тавигдана.

Амьд амьтан нь тухайн хэргийг нотлох хөдөлшгүй баримт мөн. Хууль бусаар ан агнах, барих гэмт хэрэгт зохих зөвшөөрөлгүйгээр нэн ховор, ховор амьтан, тэдгээрийн үр төлийг амьдаар нь барьж тэжээх, гаршуулах, худалдан борлуулж буй хэргүүд олон бий. Тэдгээр амьтныг эд мөрийн баримтаар хураан авах, хадгалах, буцаан тавих ажиллагаа нь бусад гэмт хэргийн эд мөрийн баримт, түүнийг хураан авах, хадгалах арга зүйгээс ялгагдах онцлогуудтай. Амьд амьтан хураан авсан хэргийн баримтуудаас дурдвал;

1 Ш.Довдон. Криминалистик (мал судлал) УБ.,2010. 178 дахь тал

Бодит жишээ 16. 2007 онд Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 6-р хорооны нутаг дэвсгэрт байрлах "Амирита" нэртэй цэнгээний газарт зохих зөвшөөрөлгүйгээр хүрэн баавгайн бамбарууш тэжээсэн, Нарантуул худалдааны захад мөн хүрэн баавгайн бамбарууш худалдсан, Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутагт айлын хашаанд шонхор шувууг олноор нь барьж, гадаадын иргэдэд худалдахаар агуулж, түүнд өгөөш болгох зорилгоор олон тооны тагтаа барин тэжээж байсан, түүнчлэн тусгай хамгаалалттай газар нутгаас зохих зөвшөөрөлгүйгээр тарвага барьж, өөр газарт нутагшуулах нэрээр тор саванд хадгалсан зэрэг хэргүүд шалгагдан шийдвэрлэгдэж байжээ.

Хууль бусаар барьсан амьтан нь амьд байгаа тохиолдолд амьтныг хэрхэх тухай шийдвэрийг яаралтай гаргана. Тухайн хэргийг илрүүлсэн даруйд амьтныг байгальд нь буцаан тавих боломжтой, орчин нөхцөл нь тохирсон бол шууд тавих шаардлагатай. Энэ үед эд мөрийн баримт болох амьтны гэрэл зураг, дүрс бичлэг, тэмдэглэлээр бэхжүүлнэ.

Амьтныг байгальд нь буцаан тавихдаа тухайн газар нь амьтны амьдрах чадварт нөлөөлөх эсэхийг тооцоолж, хот суурин газраас хол, хүн малын хөлөөс зайдуу газрыг сонгон авна[1]. Зэрлэг амьтныг байгальд нь эргүүлэн тавьж байгаа тохиолдолд алба хаагчид өөрсдийн аюулгүй байдлыг хангахад онцгойлон анхаарч ажиллана. Амьтан бүр өөрийн гэсэн өвөрмөц зан араншинтай бөгөөд дайрах, хазах, мөргөх, түлхэх, өшиглөх зэрэг үйлдлүүд гаргаж болзошгүйг санаж байх шаардлагатай.

Аливаа амьтныг байгальд нь буцаан тавих ажиллагаанд боломжтой бол мэргэжлийн хүмүүсийг оролцуулж, тэдний зөвлөгөөг авч, хаана хэрхэн яаж тавих, оролцох хүн тээврийн хэрэгсэл, бусад багаж хэрэгсэл зэргийг урьдчилан сайтар төлөвлөж, уг ажиллагааг мэргэжлийн хүмүүсээр гүйцэтгүүлж, харин мөрдөгч нь тэдгээрийн үйл ажиллагааг баримтжуулбал зохимжтой.

Хэрвээ тухайн амьтныг буцаан тавих боломжгүй бол амьтныг хадгалах тохиромжтой байр сав, зөөж тээвэрлэх тээврийн хэрэгсэл зэргийг бэлтгэнэ. Энэ үед амьтныг хангалттай хооллох хэрэгтэй. Амьтныг зөөж тээвэрлэхдээ түүний айдсыг намжаахын тулд аль болох юмаар бүтээж, ус өгч, нар, дуу

1 Амьтныг байгальд эргүүлэн тавихдаа: амьтанд тохирох идэш тэжээлгүй, хорогдох хэвтэх бартаа саадгүй газарт болон бие даах чадваргүй нялх төлийг байгальд шууд тавьснаар үхэх аюултай, олон тооны амьтныг нэг дор зэрэг тавихад өөр хоорондоо сөргөлдөөн үүсэх зэрэг байдлыг харгалзах хэрэгтэй. Жишээ дурдвал: "Амирта" бааранд хууль бусаар баавгай тэжээж байсныг хураан авч циркэд түр хугацаагаар хадгалуулсан. Энэ үед Нарантуул захад 2 сар ч хүрээгүй баавгайн бамбарууш худалдаж байсан хууль бус үйлдлийг илрүүлж, мөн хураан авсан. Тэдгээр хураагдсан амьтдыг байгальд нь эргүүлэн тавих комиссын шийдвэрийн дагуу ойд буцаан тавихдаа баавгайг бамбарууашаас нь тусад нь өөр газарт тавьсан. Учир нь том нь багаа барьж идэх аюултайг харгалзан үзсэн болно.

чимээнээс хол байлгана. Дуу чимээ болон хүмүүс нь түүнийг стресст оруулж, шархдах, үхэх нөхцөлийг нэмэгдүүлнэ. Амьтад наршсанаас үхэх аюултай. Амьтанд ус нь хоолноос ч илүү чухал байдаг.

Амьтныг зөөж тээвэрлэх үедээ хаана байрлуулах талаар ямар нэгэн шийдвэр гаргасан байх ёстой. Учир нь хууль хяналтын байгууллагад амьд амьтан хадгалах зориулалтын байр байхгүй тул амьтны хүрээлэн, цирк, хувираа амьтан тэжээдэг хүмүүс зэргийг сонгон авч урьдчилан тохирох, холбогдох зөвшөөрлийг авсан байх шаардлагатай. Амьтдыг зөөж тээвэрлэх үеийн үйл ажиллагааг мөн баримтжуулна.

Биологийн гаралтай эд эрхтнийг хураан авах, хадгалах. Биологийн гаралтай эд мөрийн баримт нь хураан авах, хадгалах тусгай горим, арга ажиллагааг шаарддаг. Баримтыг хураан авч бэхжүүлэх, чанар байдлыг алдагдуулахгүй хадгалах нь нотлох ажиллагааны нэг элемент юм. Хэргийн газраас болон мөрдөн байцаалтын үзлэгээр илрүүлсэн эд мөрийн баримт болох амьтны эд эрхтнийг хураан авахдаа эд эрхтэн тус бүрийг уут саванд хийж, битүүмжлэн дугаарлан хаягжуулна.

Биологийн гаралтай эд эрхтнийг зөвхөн цаасан уутанд хийж, аль болох нар тусахгүй, халаах хэрэгсэл, хорхой шавжаас хол тавьж, сэрүүн газарт хадгална. Эд мөрийн баримтыг гялгар уутанд хийж хэрхэвч болохгүй муудах аюултай. Амархан муудах цус, бусад эд эрхтнийг яаралтай хөргөгч, хөлдөөгчид хадгална. Ийм учраас хууль хяналтын байгууллагууд нь эд мөрийн баримт хадгалдаг газартаа заавал хөргөгч, хөлдөөгч байлгах шаардлагатай.

Амьтны үсийг хэргийн газраас хайж олох нь ихээхэн бэрхшээлтэй бөгөөд цайвар гадаргуун дээр цагаан үс мэдэгдэхгүй үлдэж болно. Сэжигтний бие, хувцас, харьцсан объект, бусад газарт үс байж болно. Үс хайхдаа гэрэлтүүлэгч гар чийдэн, өсгөгч шил, бичил тоос сорогч ашиглаж хэргийн газрын орчин, бүх эд зүйл, түүний гадаргуу, зай завсарт анхаарлаа хандуулах хэрэгтэй. Хувцас даавуун дээр үс хайхдаа цагаан цаасан дээр болгоомжтой сэгсрэх эсвэл гялгар уутанд хийж гөвж болох бөгөөд хэрвээ үс байвал энэ үед цаасан дээр унаж, уутанд үлддэг. Мөн скоч буюу наалтууз, хувцасны хог авдаг наалдамхай тууз зэргийг ашиглаж үсийг олж авч болно.

Олсон үсэндээ механик гэмтэл учруулахгүйн тулд тухайн гадаргуугаас үзүүртээ резин зөөлөвчтэй хямсаа, гараар өнгөгүй наалдамхай туузад наалдуулан авч дугтуйд хийнэ. Дугтуй дээр хэн хэзээ, хаанаас авсныг тодорхой бичиж, хаягжуулах хэрэгтэй. Үзлэгээр өөр өөр газраас авсан үс бүрийг тус тусад нь дугтуйд хийж, хаягийг тодорхой бичнэ.

Аливаа үслэг эдийг хадгалахад агуулах хэрэгтэй. Эд мөрийн баримтаар хураагдаж ирсэн ангийн үс, арьсыг хүлээн авахдаа тэдгээрийг төрөлжүүлэн ялгах, баглах, хүлээн авсан үеийн анхны чанар байдлыг алдагдуулахгүйн тулд норж гэмтэх, хортон шавжаас хамгаалах, ариутгал цэвэрлэгээ хийх, чанарын хамгаалалт, хаягжуулалт хийнэ.

Гэмт хэргийг нотлох ажиллагааны чухал үе шатны нэгэн нь эд мөрийн баримтыг бэхжүүлэх ажиллагаа юм. Нотлох баримтыг бэхжүүлэхэд дараах үндсэн шаардлагуудыг хангасан байх ёстой. Үүнд: болсон үйл явдал, нөхцөл байдал, эд мөрийн баримтын шинж байдлыг зөв, тодорхой, бүрэн тусгах, нотлох баримтыг зохих журмаар хадгалж, түүнийг үрэгдэх, гэмтэх, солигдох, устгагдах байдал гаргуулахгүй байх шаардлагыг тавьдаг.

Үзлэгийн тэмдэглэлд эд мөрийн баримтын шинжийг тэмдэглэх шаардлагатай бөгөөд түүнийг тэмдэглэхэд зохих арга зүй шаардагдана. Тиймээс мөрдөгчид үзлэгийн тэмдэглэлд аливаа баримтыг зөв, тодорхой дүрслэхийн тулд амьтны морфологи шинжийн талаар мэдлэгтэй байх ёстой. Амьтны арьсыг үсэн бүрхүүлийн тархац, хөрсний зузаан, нимгэн зэрэг шинж чанар байдлын онцлогоос хамааруулж хэд хэдэн топографи хэсгүүдэд хуваадаг. Амьтны арьсыг нуруу, хээл хэсэг гэсэн 2 үндсэн хэсэгт хуваана. Түүнчлэн хоншоор, дух, хүзүү, сэрвээ, хоолой, хажуу дал, өгзөг, хонго, цавь зэрэг нэлээд хэдэн хэсэгт ангилна.

Хоншоор гэж хамрын үзүүрээс хоёр нүдний хоорондын зайг, дух гэж толгойн дээд хэсгийн хоёр нүдний хоорондын зайнаас чих хүртэлх арьсыг, хацар гэж толгойн хоёр талын арьсыг, сэрвээ гэж дал хүртэлх хүзүүний үргэлжлэл хэсгийг, зоо гэж нурууны дагуух буюу арьсны төв хэсгийн арьсыг тус тус нэрлэх бөгөөд ихэнх амьтны арьсны зоо нурууны хэсэг нь нэлээд урт үсэн бүрхүүлтэй, бараандуу байна.

ХУУЛЬ БУСААР АН АГНАХ ГЭМТ ХЭРГИЙГ МӨРДӨН ШАЛГАХ АРГАЧЛАЛ, АНХААРАХ АСУУДАЛ

Хууль бусаар ан агнах гэмт хэрэг нь ихэнхдээ нууц далд аргаар үйлдэгддэг. Энэ гэмт хэрэг нь Улсын тусгай хамгаалалттай газар нутагт буюу хориотой үед, хориглосон арга, зэвсэг, хэрэгслээр ан амьтан агнасан, барьсан, тэжээж гаршуулсан, тэдгээрийн түүхий эд зүйлийг хадгалсан, худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн байхыг шаарддаг.

Энэ төрлийн гэмт хэрэг гарсан тохиолдолд хойшлуулшгүй ажиллагаа явуулахад дараах зүйлийг анхаарах шаардлагатай. Тухайлбал, гэмт хэрэг хаана үйлдэгдсэн болохыг тогтоохын тулд тухайн орон нутгийн байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч нарыг хэргийн газрын үзлэгт оролцуулах нь чухал. Тэд тухайн орон нутгийн байгаль орчны бүсчилсэн зураглал болон нүдэн баримжаагаар тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн бүс, заагийн талаар мөрдөгч нарт ерөнхий ойлголт өгнө. Нөгөө талаас, ямар амьтан агнасан, ховор юм уу нэн ховор амьтны аль нь болохыг урьдчилж мэдэх боломжтой.

Хууль бусаар ан агнасан хэргийн газарт ямар амьтан болох нь тодорхойгүй байх тохиолдол олонтоо гардаг. Энэ нь тухайн амьтны толгой, эд эрхтнийг тастаж аваад явсан, амьтны сэгийг нохой шувуу идсэн тохиолдолд тухайн амьтны цуснаас дээж авах, ямар буугаар буудсан болохыг тогтоохын тулд тухайн амьтны биеэс сумны хошууг олж, шинжилгээнд өгөх зэрэг хойшлуулшгүй ажиллагааг хийх хэрэгтэй.

Амьтны эд эрхтэн хураагдсан тохиолдолд тоо ширхгийг нэг бүрчлэн гаргаж, ямар амьтны эд эрхтэн болохыг урьдчилан тогтоож, хэрвээ урин дулааны цагт бол амьтны түргэн муудах эд эрхтэн, бүтээгдэхүүнийг өмхийрч, муудахаас урьдчилан сэргийлж сэрүүн газарт юм уу хөргөгч, хөлдөөгчид хадгалуулах нь зүйтэй. Амьтны эд эрхтэн олноор хураагдсан тохиолдолд хэдэн зүйл амьтны ямар эд эрхтэн байгааг нь ялган зааглаж, нэг бүрчлэн үзлэгийн тэмдэглэлд тусгах шаардлагатай. Практикт хураагдсан эд эрхтнүүд дундаас нь алга болох, хаягдах явдал гардаг учир анхаарах хэрэгтэй.

Амьтны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3-д ... амьтан болон тэдгээрийн гаралтай түүхий эдийг цуглуулсан, худалдсан, худалдан авсан, гадаадад гаргахыг завдсан этгээдийг тухайн ан амьтныг агнасан, барьсантай адилтган үзэж нөхөн төлбөр ноогдуулна хэмээн заасан байдаг учир хэргийн газрын үзлэг дээр их хэмжээний ангийн эд эрхтнийг хурааж авахдаа нэг бүрчлэн тоолж үзлэгийн тэмдэглэлд тусган фото зураг болон дүрс бичлэгээр бэхжүүлж авах нь зүйтэй.

Түргэн муудах эд эрхтнийг өнөөгийн нөхцөлд орон нутгийн мэргэжлийн хяналтын газарт хүлээлгэн өгч, акт тогтоолгох нь нотлох баримтын мөн чанараа алдахгүй байх ач холбогдолтой.

Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолоор Ан амьтны экологи, эдийн засгийн үнэлгээг тогтоож өгсөн байдаг учир түүний дагуу хэдэн толгой, ямар амьтан агнасныг тогтоосноор мөрдөгч урьдчилсан байдлаар хохирлын хэмжээг тооцоолох боломжтой болно. Ингэснээр энэ нь гэмт хэргийн шинжтэй үйлдэл мөн эсэх, хэргийн харьяаллыг хүртэл урьдчилан тооцоолж мэдэх боломжтой юм.

Шинжилгээний байгууллага болох Мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон ШУА-ийн Биологийн хүрээлэнд хандаж дүгнэлт гаргуулна. Тухайн эд эрхтэн нь ямар амьтных болох нь тодорхойгүй тохиолдолд үс, яс, цус, эвэр, туурай зэргийг биологийн шинжилгээнд өгч ямар амьтан болохыг тогтоолгож болно.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.5 дугаар зүйлд заасан “Хууль бусаар ан агнах” гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгаж, хойшлуулшгүй ажиллагаа явуулсан материалд дараах ажиллагааг хийсэн байх шаардлагатайг анхаарна уу. Үүнд:

- Тухайн зөрчлийг илрүүлж байгаа цагдаагийн алба хаагч нь үзлэг хийх мөрдөгч, халдварт өвчин судлалын ажилтан, биологич, мэргэжлийн хяналтын байцаагч нарыг иртэл тээврийн хэрэгслийг түр саатуулж, хамгаалалтад авах,

- Хэргийн газрын үзлэг хийх мөрдөгч, халдварт өвчин судлалын ажилтан, биологич, мэргэжлийн хяналтын байцаагч нарыг иртэл амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг тээврийн хэрэгсэл болон ачаа тээшнээс буулгахгүй, гаргахгүй байх (тухайн амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдэд гоц халдварт өвчний голомт тараах хачиг, бүүрэг бөөс, бусад шимэгч хорхой ихээр байдаг учир мэргэжлийн хүмүүс иртэл хамгаалалтад авах),
- Хэргийн газрын үзлэг хийж байгаа мөрдөгч нь үзлэгийн тэмдэглэлд тухайн амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд нь ямар амьтных болох талаар үзлэгт оролцож байгаа биологич, мэргэжилтэн нараар урьдчилан тогтоолгож, үзлэгийн тэмдэглэлд тоо ширхэг, шинж байдлыг нарийн тусгаж, гэрэл зургийн аргаар бэхжүүлэх,
- Олон зүйлийн амьтан (тарвага, зурам, хэрэм, гахай, чоно г.м), тэдгээрийн гаралтай түүхий эд олон тоогоор хураагдаж байгаа тохиолдолд тухайн амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг тээвэрлэн яваа жолооч болон авч яваа хүнээс хэдэн хүний эд зүйл болох талаар асуун тодруулж, тус тусад нь үзлэг хийх,
- Үзлэг хийж байгаа алба хаагч нь үзлэгт оролцож байгаа биологичоор тухайн амьтны нас, хүйсийг нэг бүрчлэн үзүүлж, үзлэгийн тэмдэглэлд тусгах нь хэргийг шалгаж шийдвэрлэх, тухайн зүйл амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг тогтооход маш чухал ач холбогдолтой,
- Үзлэгийн тэмдэглэлд тухайн амьтны агнагдсан байдал (буудагдсан, хавханд орж үхсэн, нохойд бариулсан, утагдсан, урхиар барьсан г.м)-ыг үзлэгт оролцож байгаа биологичоор тогтоолгож, үзлэгийн тэмдэглэлд нарийн тусгах, гэрэл зургийн аргаар бэхжүүлэх,
- Амьтан агнагдсан хэргийн газарт ул мөрийг бэхжүүлэн авах, мөрөөр нь хөөж хаанаас буудсан болох (байршил)-ыг тогтоож, сумны хонгио байгаа эсэхийг нягтлан шалгах,
- Агнагдсан амьтан байсан газрын солбицлыг GPS багажаар тогтоож, үзлэгт тэмдэглэнэ.
- Тухайн газар оронд оршин сууж байгаа айл өрх болон иргэдээс мэдээлэл авч ярилцлага явуулах.
- Үзлэгийн явцад илрүүлсэн амьтан нь нас бие гүйцсэн болон үр төлний алин болохыг үзлэгт оролцож байгаа биологичоор тогтоолгож, үзлэгийн тэмдэглэлд тусгах. Учир нь үр төл амьтныг нас бие гүйцсэн зүйлийн 70 хувиар тооцож хохирол бодогддог учраас хохирлын хэмжээг тогтооход ач холбогдолтой юм.

Амьтдыг агнасан, барьсны улмаас гарах хохирлын хэмжээг Засгийн газраас баталсан Экологи-эдийн засгийн үнэлгээгээр тогтооно.

Тухайн тээвэрлэн яваа амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд нь ямар амьтных болох нь тогтоогдохгүй байгаа тохиолдолд хураан авч, түргэн муудаж шинж чанараа алдахааргүй газарт хадгална. *ШУА-ийн Биологийн хүрээлэнгээс шинжээч томилох тогтоолын хамт тухайн амьтны эд, эрхтнийг хүргүүлж, шинжээчийн дүгнэлт гаргуулна.* Шинжилгээг шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэж байгаа тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу шинжээч нараас ашиг сонирхлын зөрчил байгаа эсэхийг тодруулах, гэрчийн мэдүүлэг авах нь зүйтэй.

Хууль бусаар агнагдсан амьтан болон түүний эд эрхтнийг шинжилгээний байгууллагад өгч дүгнэлт гаргуулахдаа:

- Тухайн эд эрхтэн нь ямар зүйл амьтных болохыг тогтоох
- Тухайн эд эрхтэн нь амьтны ямар эд эрхтэн болох
- Тухайн эд эрхтнүүд нь хэдэн зүйлийн амьтных болохыг тодруулах
- Тухайн амьтны нас, хүйсийг тогтоох
- Тухайн амьтан нь ховор юм уу нэн ховор амьтны аль нь болох
- Тухайн амьтан (амьтад)-ны агнагдсан байдлыг тогтоох

Тухайн эд эрхтэн болон амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг тогтоох зэрэг ерөнхий асуултууд тавихаас гадна, нэмэлт дараах асуултуудыг тавьж болно. Үүнд:

- Шинжилгээнд хүргүүлсэн бууны гол төмөр, замгийн дугаар, ямар зориулалтын, ямар төрлийн, аль улсад үйлдвэрлэсэн галт зэвсэг эсэх
- Галт зэвсэгт ямар нэгэн эвдрэл, гэмтэл байгаа эсэх. Эвдрэлтэй бол чухам ямар эд анги нь эвдэрсэн болохыг тогтоох. Мөн уг галт зэвсгээр буудлага үйлдэж болох эсэх
- Ямар калибрын хэмжээтэй буу болох, уг галт зэвсгээр буудлага үйлдэгдсэн эсэх
- Уг галт зэвсэг нь хэдэн мм-ийн ямар сумаар буудаж болох эсэх
- Шинжлэгдэж байгаа галт зэвсгээр дурдсан калибрын сумаар буудаж болох эсэх
- Галт зэвсгийн аль нэг хэсэгт байсан дугаар, үйлдвэрийн тэмдгийг арилгаж өөрчилсөн эсэх. Өөрчлөгдсөн бол урьд нь ямар дугаар, тэмдэгтэй байсан ба яаж өөрчилснийг тогтоох
- Галт зэвсгийн аль хэсгийг засварлаж өөрчилсөн буюу сольсныг тогтоох
- Сум нь ямар улсын үйлдвэрийн ямар төрлийн буунд зориулагдсаныг тогтоох

Шинжлэгдэж байгаа галт зэвсгээр шинжилгээнд хүргүүлсэн дурдсан калибрын сумаар буудаж болох эсэх гэх зэргээр хэргийн нөхцөл байдлаас шалтгаалан шинжээчид дээрх асуултуудыг тавьж, дүгнэлт гаргуулж болно.

АШИГЛАСАН МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦ, НОМ, БҮТЭЭЛ

НЭГ. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ

Амьтны тухай хууль (шинэчилсэн найруулга) (2012)//Төрийн мэдээлэл. 2012 он. №22 (739)

Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995)//Төрийн мэдээлэл.1995 он. №5-6

Галт зэвсгийн тухай хууль (шинэчилсэн найруулга) (2015)//Төрийн мэдээлэл. 2015 он. №31

Гүйцэтгэх ажлын тухай хууль (1997)//Төрийн мэдээлэл. 1998 он. №3

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (шинэчилсэн найруулга) (2019)//Төрийн мэдээлэл. 2019 он. №42

Зар сурталчилгааны тухай хууль (2002)//Төрийн мэдээлэл. 2002 он. №23 (260)

Монгол Улсын Үндсэн хууль (1992)//Төрийн мэдээлэл. 1992 он. №1 (1)

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994)//Төрийн мэдээлэл.1995 он. №2

Үндэсний аюулгүй байдлын тухай хууль (2001)//Төрийн мэдээлэл. 2002 он. №3 (240)

Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002)//Төрийн мэдээлэл. 2002 он. №43 (280)

Цагдаагийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга) (2017)//Төрийн мэдээлэл. 2017 он. №8

Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга) (2015)//Төрийн мэдээлэл. 2016 он. №7

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (шинэчилсэн найруулга) (2017)//Төрийн мэдээлэл. 2017 он. №23

ХОЁР. ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦ

Биологийн олон янз байдлын тухай конвенц (1994)//Төрийн мэдээлэл. Тусгай дугаар 2010 он. №9

Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц //Төрийн мэдээлэл. Тусгай дугаар 2010 он. №9

Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (1994)//Төрийн мэдээлэл. Тусгай дугаар 2010 он. №9

Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц //Төрийн мэдээлэл. Тусгай дугаар 2010 он. №9

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРАЛ, ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ, ХӨТӨЛБӨР

Байгаль орчны талаар авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоол. №3. 2005.01.13//Төрийн мэдээлэл. 2005 он. №3 (384)

Монгол Улсын Засгийн газрын тогтоол 2011 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 277 дугаар “Хөтөлбөр батлах тухай (нэн ховор, ховор амьтдыг хамгаалах)” тогтоол. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 277 дугаар тогтоолын хавсралт *“Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр”.* Улаанбаатар

Монгол Улсын Их Хурлын 2012 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 37 дугаар “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” тогтоол. Монгол Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолын хавсралт *“Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”.* Улаанбаатар// Төрийн мэдээлэл. 2012 он. №36 (753)

Монгол Улсын Их Хурлын 2014 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 43 дугаар “Ногоон хөгжлийн бодлого батлах тухай” тогтоол. Монгол Улсын Их Хурлын 2014 оны 43 дугаар тогтоолын хавсралт *“Ногоон хөгжлийн бодлого”.* Улаанбаатар//Төрийн мэдээлэл. 2014 он. №25 (838)

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 8 дугаар сарын 04-ний өдрийн 325 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тогтоол. Засгийн газрын 2015 оны 325 дугаар тогтоолын хавсралт *“Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр*”. Улаанбаатар

Улсын Их Хурлын 1997 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 106 дугаар “Төрөөс экологийн талаар баримтлах бодлого батлах тухай” тогтоол. Улсын Их

Хурлын 1997 оны 106 дугаар тогтоолын хавсралт *“Төрөөс экологийн талаар бариmтлах бодлого”*. Улаанбаатар

ДӨРӨВ. ТАЙЛАН

Байгаль орчин, ногоон хөгжлийн яам. (2009). *Биологийн төрөл зүйлийн үндэсний тайлан.* Улаанбаатар

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, UNEP, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар. (2011). *Биологийн олон янз байдлыг хамгаалах чиглэлээр байгуулагдсан олон улсын конвенциудын танилцуулга.* Улаанбаатар

Байгаль орчин, аялал жуулчлалын яам. (2011). *Монгол Улсын байгаль орчны төлөв байдлын тайлан 2008-2010 он* (State of the Environment Report Mongolia 2008-2010). (Англи хэл дээр) Улаанбаатар

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар. (2012). *Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенцийн тайлан.* Улаанбаатар

Байгаль орчин, ногоон хөгжлийн яам. (2013). *Байгаль орчны төлөв байдлын тайлан 2011-2012 он.* (Монгол, Англи хэл дээр). Улаанбаатар

Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Даян дэлхийн байгаль орчны сан, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр. (2014). *Биологийн олон янз байдлын тухай конвенцийг хэрэгжүүлэх Үндэсний тавдугаар тайлан.* Улаанбаатар

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам. (2015). *Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан 2013-2014 он.* (Монгол хэл дээр). Улаанбаатар

Байгаль орчин, аялал жуулчлалын яам. (2017). *Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан 2015-2016 он.* (Монгол хэл дээр). Улаанбаатар

Байгаль орчин, аялал жуулчлалын яам. (2019). *Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан 2017-2018 он.* (Монгол хэл дээр). Улаанбаатар

Гомбобаатар, С., Мягмарсүрэн, Ш. (2019). *Монгол улс ба Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн Үндэсний хоёрдугаар тайлан.* Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Монголын Шувуу судлалын нийгэмлэг, МУИС, Степ Форвард хөтөлбөр. Улаанбаатар

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF), АНУ-ын Дотоод хэргийн яамны Загас ба зэрлэг ан амьтдыг хамгаалах агентлаг. (2006). *Байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх сургалтын ажлын тайлан.* Улаанбаатар хотноо 2006 онд Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар болон АНУ-ын Дотоод хэргийн яамны Загас ба зэрлэг ан амьтдыг хамгаалах агентлагийн хамтран зохион байгуулсан сургалтын ажлын тайлан. Улаанбаатар

Үндэсний аудитын газар. (2010). *Монгол орны нэн ховор, ховор амьтдын хамгаалалтын байдал.* Үндэсний аудиторын газрын Гүйцэтгэлийн аудитын газар. 2010 оны 12 дугаар сар. Улаанбаатар

Хеффернан, Д.Е. (2005). *Дорнод Монголын тусгай хамгаалалттай газруудад хийсэн үнэлгээний тайлан.* Улаанбаатар

Хил хамгаалах ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Байгаль орчны яамны Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг (USAID), Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг (WCS)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар. (2007). *Нөмрөгийн Дархан цаазат газрын байгаль хамгаалагчид, хил хамгаалагчдад "Зэрлэг амьтдыг хамгаалахтай холбогдсон хуулийг хэрэгжүүлэх" сургалт зохион байгуулсан тухай тайлан* (2007 оны 9 дүгээр сарын 18-аас 25-ны өдөр). Чойбалсан

ТАВ. НЭГ СЭДЭВТ БҮТЭЭЛ, СУРАХ БИЧИГ, НОМ, ГАРЫН АВЛАГА

Амархүү, О. (2009). *Монголын орчин цагийн экологийн эрх зүй.* Улаанбаатар

Амгаланбаяр, Ц. (1994). *Шүүх шинжилгээ хийлгэхэд тавих асуултын лавлах.* Улаанбаатар

Алтанхишиг, Ч., Мөрөн, Д. (2004). *Шүүхийн шинжилгээ.* Улаанбаатар

Андрей, С., Энхтөр, Б. (2005). *Шүүх мал эмнэлгийн задлан шинжилгээний арга.* Улаанбаатар

Андрей, С., Энхтөр, Б. (2006). *Шүүх мал эмнэлэг.* Улаанбаатар

Баатаржав, Н. (1985). *Гэмт явдлын шалтгаан судлал, урьдчилан сэргийлэлтийн криминологийн асуудлууд.* Улаанбаатар

Баатаржав, Н. (2003). *Нотлох бариmтын онолын үндэс.* Улаанбаатар

Баатаржав, Н. (2003). *Мөрдөн байцаалтын тактик.* Улаанбаатар

Батжав, Л. (2003). *Криминологийн зарим асуудал.* Улаанбаатар

Болдбаатар, Ж. (1999). *Илрээгүй гэмт хэргийг илрүүлэх ажиллагаа.* Улаанбаатар

Болдбаатар, Ж., Нямдаваа, О. (2010). *Криминологи I дэвтэр.* Улаанбаатар

Бүдханд, Ц. (2002). *Криминалистик.* Улаанбаатар

Вингард, Ж.Р., Паскаул, М., Рюд, А., Хоул, А., Конабой, Н., Батачаряа, Г., Гомбобаатар, С., Мөнхжаргал, М., Мягмарсүрэн, Ш., Батсугар, Т., Болд, Т. (2019). *Зэлүүд тал-2: Нэгэн арваны дараах зэрлэг амьтны худалдааны хямрал.* 2019 оны 9 дүгээр сар. Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг, Лондон, ИБУИНВУ, Лийгэл Атлас, Хараат бус судалгааны хүрээлэн (Монгол, Англи хэл дээр). Улаанбаатар

Дамба, Д. (2008). *Өвгөн анчны тэмдэглэл. У*лаанбаатар

Дамдин, Ж. (1965). *Буурал анчны тэмдэглэл.* Улаанбаатар

Даш, Я. (1987). *Агнуур зүйн жимээр.* Улаанбаатар

Даш, Я., Гонгор, Ш. (1965). *Ан агнуурын товч мэдэгдэхүүн.* Улаанбаатар

Дондогдорж, Д. (1980). *Услэг түүхий эдийг хэрэглэх.* Улаанбаатар

Довдон, Ш. (2010). *Криминалистик (мал судлал).* Улаанбаатар

Доржпалам, Х., Сайнжаргал, Ж. (1996). *Гэмт хэрэг илрүүлэх хойшлуулшгүй ажиллагаа.* Улаанбаатар

Дэндэв, Т (редактор). (1977). *Тодорхой төрлийн гэмт хэргийг мөрдөх аргачлал.* Улаанбаатар

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дах хөтөлбөрийн газар. (2018). *Уул уурхайн үйл ажиллагаанд холбогдох талуудын оролцоог хангах боломж сэдэвт сургалтын гарын авлага* (Сургагч багш нарт зориулав). “Уул уурхайн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд талуудын оролцоог нэмэгдүүлэх замаар Монгол орны ард иргэд, мал сүргийн амьдрах аюулгүй орчныг бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах нь төсөл”. Улаанбаатар

Жанцан, Н. (2004). *Криминологи (нэмж засварласан).* Улаанбаатар

Жанцан, С. (2009). *Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол I.* Улаанбаатар

Жанцан, Ё. (1977). *Шүүх шинжилгээ хийлгэхэд шинжээчид тавих асуултын лавлах.* Улаанбаатар

Жаргалсайхан, Б. (2008). *Учралын газрын үзлэг.* Улаанбаатар

Жаргалсайхан, Б. (1998). *Криминалистикийн техник.* Улаанбаатар

Лувсан, С. (1986). *Монгол анчны тэмдэглэл.* Улаанбаатар

Луузаншарав, Е. (1960). *Залуу анчдад өгөх зөвлөгөө.* Улаанбаатар

Отгонжаргал, М., Эрдэнэбилэг, П., Очбадрах, П., Билэгдэмбэрэл, Я., Мөнхтуяа, Т., Бүрнээ, М. (2019). *Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах арга члал* (Цагдаагийн байгууллагын албан хаагч нарын албан хэрэгцээнд зориулав). Улаанбаатар

Сайнбаяр, А (эмхэтгэгч). (2011). *Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг мөрдөх арга члал, эрх зүйн орчин.* Улаанбаатар

Содномдаржаа, А. (1970). *Амьтны эмгэг бие бүтэц зүй тэргүүн ба дөтгөөр дэвтэр.* Улаанбаатар

Сүхбат, Х., Шагдаржав, Д. (1990). *Ан агнуур.* Улаанбаатар

Хурцгэрэл, Ж. (1989). *Криминалистикийн онол арга зүйн асуудал.* Улаанбаатар

Хурцгэрэл, Ж. (2002). *Криминалистик I.* Улаанбаатар

Хурцгэрэл, Ж. (2004). *Криминалистик II.* Улаанбаатар

Хишигтогтох, Б., Жаргал, Б. (2002). *Нотлох бариmтын онолын үндэс.* Улаанбаатар

Цэлмэг, Ц., Сайханцэцэг, Б. (2007). *Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн зүйчлэл.* Улаанбаатар

Черняк, В.З. (1969). *Шүүх мал эмнэлгийн магадлан шинжилгээ.* Улаанбаатар

Чимэддорж, Б., Пүрэвсүрэн, С., Тэрбиш, Х., Гантулга, Б., Суран, Д., Пүрэвдорж, С. (2017). *Амьтан, ургамал, тэдгээрийн эд эрхтнийг таних гарын авлага.* Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Байгаль орчин аялал жуулчлалын яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл. Улаанбаатар

Чимэддорж, Б., Пүрэвсүрэн, С., Тэрбиш, Х., Гомбобаатар, С., Одхүү, Б., Төвшин, Ү., Жамъянхүү, Н., Гэрэл, Н., Суран, Д. (2019). *Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн лавлах.* БОАЖЯ, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Байгалийн ухааны салбар, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл. Улаанбаатар

Чувилев, А.Н. (1988). *Мөрдөн байцаалтын ажиллагаа.* Улаанбаатар

Чулуунбат, Д. (2001). *Зарим төрлийн гэмт хэргийг илрүүлэхэд анхаарах асуудал.* Улаанбаатар

Шагдарсүрэн, О. (1966). *Монгол орны агнуурын үндсэн амьтад.* Улаанбаатар

Шадаев, А. (1957). *Залуу анчид.* Улаанбаатар

Эрдэнэбаяр, М. (2009). *Ногоон ном (Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийг илрүүлэх шалгахад анхаарах зарим асуудал).* ХЗДХЯ, БОАЖЯ, ЦЕГ, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар. Улаанбаатар

Эрэгдэндавга, Д. (1969). *Амьтан судлал.* Улаанбаатар

ЗУРГАА. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ, СЭТГҮҮЛ

Бадарч, Д. (1989). *Гэмт хэргийн газрын үзлэг явуулахад анхаарах зүйл.* Социалист хууль ёс сэтгүүл №2 (1989). Улаанбаатар

Бат-Эрдэнэ, Б. (2002). *Криминалистикийн арга судлалын тулгамдаж буй асуудал.* Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүл №1 (2002). Улаанбаатар

Ганболд, С. (2009). *Гэмт хэргийг илрүүлэхэд "Генетик мэдээллийн сан" бий болгож, ашиглах асуудал.* Хууль дээдлэх ёс сэтгүүл №1 (24) (2009). Улаанбаатар

Ганболд, С. (2009). *Хэргийн газраас илрүүлсэн биологийн ул мөрийн ДНХ-ийг "Генетик мэдээллийн сан"–д оруулах асуудалд*. Хууль дээдлэх ёс сэтгүүл №3 (26); 2009. Улаанбаатар

Ганболд, С., Баярмаа, Р. (2009). *Хэргийн газраас илрүүлсэн биологийн ул мөрийн ДНХ-ийг "Генетик мэдээллийн сан"-д оруулах асуудалд*. Хууль дээдлэх ёс сэтгүүл №4 (27); 2009. Улаанбаатар

Дашдэмбэрэл, Д. (1970). *Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх зарим асуудал.* Ардын төр сэтгүүл №4 (1970). Улаанбаатар

Доржпалам, П. (1973). *Мөрдөн байцаалтын ажлыг шинжлэх ухааны үндэстэй төлөвлөх нь.* Социалист хууль ёс сэтгүүл №2 (1973). Улаанбаатар

Жанцан, Ё. (1987). *Хэргийн газрын үзлэг хийхэд анхаарах зарим асуудлууд.* Социалист хууль ёс сэтгүүл №2 (1987). Улаанбаатар

Жанцан, Н. (1982). *Судалгаа бол гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэстэй явуулах үндсэн нөхцөл мөн.* Социалист хууль ёс сэтгүүл №2 (1982). Улаанбаатар

Кежоян, А. (1981). *Группээр хэрэг мөрдөх ажлыг зохион байгуулах нь.* Социалист хууль ёс сэтгүүл №1 (1981). Улаанбаатар

Лхагвасүрэн, Б. (2014). *Шүүх шинжилгээний эрх зүйн зохицуулалтын зарим асуудал.* Хууль сахиулахуй. Онол арга зүйн улирал тутмын сэтгүүл №2 (02); 2014. Улаанбаатар

Очирбат, Т. (2014). *Криминалистикийн хэл, хөгжлийн зарим асуудал.* Хууль сахиулахуй. Онол арга зүйн улирал тутмын сэтгүүл №2 (02); 2014. Улаанбаатар

Төмөржав, М., Никофоров, М.И. (1972). *Янгирын арьсан бүрхүүлийн гистологийн бүтцийг судалсан дүнгээс.* БНМАУ-ын Шинжлэх ухааны академийн мэдээ сэтгүүл №1 (1972). Улаанбаатар

Цэлмэг, Ц. (2004). *Хууль бусаар ан агнах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, тэмцэх арга зам.* Хууль дээдлэх ёс сэтгүүл №4 (07); 2004. Улаанбаатар

ДОЛОО. ДЭД ЭРДЭМТЭН, ДОКТОРЫН ЗЭРЭГ ХАМГААЛСАН БҮТЭЭЛ

Болдбаатар, Ж. (2013). *Гэмт хэрэг илрүүлэхэд полиграф ашиглах онол, арга зүйн асуудал.* Хууль зүйн шинжлэх ухааны докторын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар

Баатаржав, Н. (1989). *Гэмт явдал, түүний шалтгаан судлалын криминологийн асуудал.* Хууль зүйн шинжлэх ухааны докторын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар

Гантулга, Ц. (2009). *Гэмт хэргийг илрүүлэхэд мөр нотолгооны ач холбогдолтой болох нь (амьтны мөрний жишээ дээр).* Хууль зүйн шинжлэх ухааны докторын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар

Даваа, Т. (2008). *Адуу, хулангийн махны шинэлэг байдал, ялган таних арга.* Мал эмнэлгийн шинжлэх ухааны докторын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар

Доржготов, А. (1995). *Хүн ба амьтны үс ашиглаж гэмт хэрэг илрүүлэх боломж.* Хууль зүйн шинжлэх ухааны докторын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар

Дуламцэрэн, С. (1977). *Хэнтий, Хангайн ойн туурайтан амьтны экологи, агнуурын холбогдлын зарим асуудал.* Биологийн шинжлэх ухааны дэд эрдэмтний зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар

Жаргалсайхан, Б. (2015). *Монгол Улсад криминалистикийн үнэр судлалын хөгжлийн онол, арга зүйн асуудал.* Хууль зүйн шинжлэх ухааны докторын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар

Нямдорж, Ц. (2006). *Адуу хулгайлах гэмт хэргийг мөрдөх арга зүй.* Хууль зүйн шинжлэх ухааны докторын зэрэг горилсон бүтээл. Москва

НАЙМ. ГАДААД ХЭЛ ДЭЭР ХЭВЛЭГДСЭН НОМ, БҮТЭЭЛ

Орос хэл дээр

Агафонов, В.В., Филиппов, А.Г. (2000). *Криминалистика.* (Вопросы и ответы) Учебное пособие. Юриспруденция. Москва

Белкин, Р.С. (2000). *Криминалистическая энциклопедия.* Москва

Белкин, Р.С., Лившиц, Е. М. (1997). *Тактика следственных действий.* Новый юрист, Москва

Гармаев, Ю.П. (2006). *Проблемы создания криминалистических методик расследования преступлений (теория и практика).* Москва

Ермолович, В.Ф. (2001). *Криминалистическая характеристика преступлений.* Минск

Егошин, В.В. (2002). *“Методика расследования незаконной охоты”* диссертации. Москва

Селиванов, Н.А. (2000). *Криминалистика.* Учебник для вузов. Москва

Ерофеев, Б.В. (2008). *Экологическое право России.* Москва

Жаров. А.М. (2001). *Судебная ветеринарная медицина*. Москва

Каневский, Л.Л. (2002). *Дискуссионные проблемы сущности типовой криминалистической характеристики преступлений и ее использование в процессе расследования.* Вестник криминалистики. Вып.3. Москва

Криминалистика. Учебник для вузов (Под ред. Р.С, Белкина). М.:Норма. Москва

Мерецкий, Н.Е. (2008). *Криминалистика и оперативно-тактические комбинаций.* Москва

Шляпочников, А.С., Забрянский, Г.И. (1971). *Выявление латентной преступности - советское государства и право.* Москва

Торвальд, Ю. (1980). *Криминалистика сегодня* (Развитие судебной серологии). “Юридическая литература”. Москва

Экология (Юридический энциклопедический словарь). (2001). Москва

Англи хэл дээр

Aaron N. Moen. (1973). *Wildlife ecology*. W.H Freeman and Company San Francisco

James R. Wingard., Peter Zahler. (2006). *Silent Steppe: The illegal Wildlife Trade Crisis*. Mongolia. Ulaanbaatar

Criminology. (2007). Singapore Adler, Freda

Jane E. Huffman., John, R. (2011). *Wildlife forensics*. HJ.

James R. Wingard., Peter Zahier. (2006). *The liiegal Wildlife Trade Crisis.* Washington, DC. USA. SilentSteppe: 2006

Gauvin, F. (2012). *Criminal protection of the environment into frencn law*. Экологийн дуудлага: оршихуйн эрх зүйн баталгаа. Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын материал. Ulaanbaatar

Laurel A. Neme. (2009). *Animal investigator's (Wildlife forensics lab)*. USA

Thomas J. Karabanoff. (2007). *Report on tne Mongolian National Police Agency' s Visit to tne Southwest*. Affer-Action Asseessment. September 16, 2007 through September 21, 2007. Resident Agent in Charge NM /WTX. November 15, 2007

Robert, R. (2012). *Crime Scene Investigation and Reconstruction*. Ogle Jr.

Ross M. Gardner. (2012). *Practical Crime Scene Processing*. N.

Zahler, P., Lkhagvasuren, B., Reading, R.P., Wingard, G.J., Amgalanbaatar, S., Gombobaatar, S., Barton, N and Onon, Yo. (2004). *Illegal and unsustainable wildlife hunting and trade in Mongolia*. Mongolian Journal of Biological Sciences 2(1): 23-31 (In English with a Mongolian summary). Ulaanbaatar

ЕС. ИНТЕРНЭТ СҮЛЖЭЭН ДЭХ ВЭБ САЙТ

https://www.env.go.jp/nature/choju/hunt/hunt2.html

http://definitions.uslegal.com/p/poaching/

http://en.wikipedia.org/wiki/Poaching#In_North_America

http://adventure.owstuffworks.com/outdoor-activities/hunting/traditional-methods/poaching3.htm

http://en.wikipedia.org/wiki/Poaching#Acts_of_poaching

http://www.loc.gov/law/help/wildlife-poaching/mozambique.php

http://www.bancomoc.mz/Files/DAJ/Lei_7_2005_Taxa%20de%20Conversao%20Metical%20Nova%20Familia.pdf.

http://www.bancomoc.mz/ Files/CDI/caderno_online.pdf

ХАВСРАЛТ 1

ХУУЛЬ БУСААР АН АГНАХ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙГ МӨРДӨН ШАЛГАХ, ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АРГАЧИЛСАН ЗӨВЛӨМЖ

ГЭМТ ХЭРГИЙН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ТОВЧ ОЙЛГОЛТ

Хууль бусаар ан агнах гэмт хэргийн товч ойлголт

Хууль бусаар ан агнах гэмт хэргийг мөрдөхөд Эрүүгийн хуульд заасан үндсэн болон хүндрүүлэх шинж, объектив үйлдэл, халдлагын зүйлийн онцлогийг мэдэхгүйгээр тухайн хэргийг бүрэн, бодитой шийдвэрлэх боломжгүй юм.

Эрүүгийн хуулийн 24.5 дугаар зүйл. Хууль бусаар ан агнах

1.Улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүйгээр амьтан агнасан, барьсан, эсхүл ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр агнасан, барьсан, зориудаар тэжээж гаршуулсан, үржүүлсэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг хадгалсан, худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн, гадаад улсад гаргасан, ховор амьтны чихмэл, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүй агнасан, барьсан, зориудаар гаршуулан тэжээсэн, амьдрах орчныг алдагдуулсан, тэдгээрийн түүхий эдийг бэлтгэсэн, тээвэрлэсэн, хадгалсан, худалдсан, худалдан авсан, гадаад улсад гаргасан, ховор амьтны чихмэл, түүхий эд, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Гэмт хэргийг мөрдөхдөө Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.5-д заасан гэмт хэргийн объектив үйлдэл болох:

- Улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүйгээр амьтан агнасан, барьсан;
- Нэн ховор, ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр агнасан, барьсан;

- Зориудаар тэжээж гаршуулсан;
- Үржүүлсэн;
- Түүхий эдийн зүйлийг хадгалсан;
- Худалдсан;
- Худалдан авсан;
- Тээвэрлэсэн;
- Гадаад улсад гаргасан;
- Амьтны чихмэл, түүхий эдийн цуглуулга хийсэн;
- Амьдрах орчныг алдагдуулсан;
- Түүхий эдийг бэлтгэсэн зэрэг үйлдлүүдийг анхаарч шалгалтын ажиллагааг явуулна.

Хууль бусаар ан агнах гэмт хэрэг нь байгаль орчинд учруулсан хохирлын хэмжээнээс үл хамаарч хэлбэрийн шинжтэй үйлдэл хийснээр төгсдөг.

Хэргийн чухал нотлох баримт болох амьтны арьс, шир, үс, өд, эвэр, толгой, цус, өөх, тос булчирхай, ноос ноолуур, яс, туурай, мах, дотор эрхтэн, хошуу зэрэг гэмт хэргийн халдлагын зүйлийн шинж байдлыг сайтар мэддэг байх шаардлагатай.

Амьтны эд эрхтнийг худалдах, худалдан авах, тээвэрлэх, хадгалах, бэлтгэх нь биеэ даасан үйлдэл боловч хууль бусаар эсхүл зохих зөвшөөрлөөр агнасан үйлдэлтэй холбоотой байдаг. Иймд ямар зорилгоор хэзээ агнагдсан, хууль бус уу эсвэл хууль ёсны агнагдсан амьтны эд эрхтэн үү? гэдгийг заавал шалгаж тогтоох ёстой. Практикаас харахад, амьтны эд эрхтний хууль бус худалдааны үйлдэлд тухайн амьтныг хэн, ямар зөвшөөрөл, зорилгоор агнасныг шалгахгүй, төвөгшөөн орхигдуулах тохиолдол нэлээд байна.

ХУУЛЬ БУСААР АН АГНАХ ГЭМТ ХЭРЭГ МӨРДӨН ШАЛГАХ АНХАН ШАТНЫ АЖИЛЛАГАА

Аливаа гэмт хэргийг мөрдөхөд эн тэргүүнд чиглэл, баримжаа авах, үр ашигтай, жишиг зөвлөмж буюу хэрэг мөрдөх аргачлал чухал шаардлагатай. Гэмт хэрэг мөрдөх аргачлал нь практикаас урган гарсан, түүгээр дамжин туршигдсан, шинжлэх ухааны үндэслэлтэй байдгаараа ач холбогдолтой байдаг.

Гэмт хэрэг бүр өөр өөрийн онцлогтой учир хэрэг бүрд яв цав тохирсон мөрдөх аргачлалыг боловсруулах боломжгүй юм. Тодруулбал, хэрэг нэг бүрд таарсан жор гэж байхгүй, харин зөвлөмжөөс хэрэглэж болох хувилбарыг сонгож ашиглах нь зүйтэй.

Гэмт хэрэг мөрдөх аргачлал нь мөрдөн шалгах анхан шатны ажиллагаа, мөрдөн шалгах дараагийн шатны ажиллагаа гэсэн үндсэн хоёр хэсгээс бүрддэг.

Анхан шатны ажиллагаанд гэмт хэргийн шинж тэмдгийг илрүүлэх, тогтоох, гомдол мэдээллийг хүлээн авах, хойшлуулшгүй ажиллагаа, хэрэг бүртгэлтийн хэрэг нээх, нотлох баримт цуглуулах тодорхой ажиллагаа, тодруулбал, үзлэг, нэгжлэг хийх, нотлох баримтыг хураан авах, шинжилгээ хийлгэх, сэжигтэн, гэрч, хохирогчийг байцаах зэрэг ажиллагаа хамаарна. Харин дараагийн шатанд эрүүгийн хэрэг үүсгэх, яллагдагчаар татах, хавтас хэргийн материалыг танилцуулах зэрэг шүүхэд хэргийг шилжүүлэхээс өмнө хийгдэх мөрдөн шалгах ажиллагаа хамаарна.

Хууль бусаар ан агнах гэмт хэрэг мөрдөхөд нэн тэргүүнд гэмт хэрэг илрүүлэх тухай асуудал байдаг. Гэмт хэрэг мөрдөх анхан шатны ажиллагаа нь мэдээлэл цуглуулах ажиллагаанаас эхэлнэ.

Нэгдүгээр алхам

Мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа. Мөрдөгч гэмт хэрэг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох зорилгоор гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч шалгах үүрэгтэй. Хууль бусаар ан агнах гэмт хэрэг ихэвчлэн нууц далд аргаар үйлдэгддэг учраас гэмт хэргийг илрүүлэх зорилгоор мэдээ, мэдээлэл цуглуулах нь хамгийн эхний алхам юм.

Хувь хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас гэмт хэргийн талаар гомдол, мэдээлэл гаргах, эсхүл гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийгөө илчилж ирэх нь харьцангуй цөөхөн байдаг. Иймд цагдаагийн алба хаагч хууль бусаар ан агнах гэмт хэргийн шинжийг өөрийн санаачилгаар илрүүлэх нь зүйтэй.

Хууль бусаар ан агнах гэмт хэргийг илрүүлэхэд мэдээллийг хаанаас авч болох, түүний эх сурвалжийн талаар мэддэг байх нь чухал.

Энэ гэмт хэрэг ихэвчлэн ой тайга, хээр тал зэрэг хүний нүднээс далд, алс зэлүүд газарт үйлдэгддэг тул илрэх боломжоор харьцангуй бага байдаг. Тийм учраас энэ төрлийн гэмт хэргийн талаарх мэдээллийг идэвхтэй хайж, олж авсны үр дүнд ихэвчлэн илрүүлж байна.

Аливаа хэргийн талаарх мэдээллийг урсгалаараа аяндаа ирнэ гэж алгуурлаж, хүлээн сууж хэрхэвч болохгүй. Мэдээллийг янз бүрийн эх сурвалжаас авч

болох бөгөөд дараах эх сурвалжууд нь хууль бусаар ан агнах гэмт хэргийг илрүүлэх боломжуудын нэгээхэн хэсэг юм. Үүнд:

- Тухайн газар нутгийн иргэд;
- Мэдээлэгчид;
- Цэргийн албан хаагчид;
- Хууль хэрэгжүүлэх бусад байгууллага, тэдгээрийн ажилтан (мэргэжлийн хяналт, гаалийн байцаагч, байгаль хамгаалагч нар);
- Зар сурталчилгаа ба мэдээлэл;
- Мэдээлэл олж авахын тулд хууль сахиулах байгууллагын ажилтны явуулж буй идэвхтэй үйл ажиллагаа (ажиглалт, эргүүл, хяналт шалгалт г.м) хамаарна.

Мэдээллийн эх сурвалжид дүн шинжилгээ хийж, ашиглах нь энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхэд чухал ач холбогдолтой.

Хоёрдугаар алхам

Хойшлуулшгүй ажиллагаа. Мөрдөгч хууль бусаар ан агнах гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хянан үзээд гэмт хэргийн шинж байгаа эсэхийг тогтооно. Хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах, сэжигтэн, яллагдагч оргон зайлах, хэргийн ул мөр, эд мөрийн баримт устах, зөөвөрлөх, нуун далдлах, үрэгдэх бодит аюул байгаа тохиолдолд хойшлуулшгүйгээр үзлэг хийх, шинжилгээнд зориулж дээж, хурууны хээ, ул мөрийн хэв авах, гэрчээс мэдүүлэг авах, хэрэгт ач холбогдол бүхий тээврийн хэрэгсэл, мөнгө, эд зүйлийг хурааж авах, эд хөрөнгийг битүүмжлэх зэрэг ажиллагаа явуулна.

Хойшлуулшгүй ажиллагааны хүрээнд анхаарах хэд хэдэн асуудал байдаг. Үүнд:
а) Амьтны эд эрхтэн худалдан борлуулж байгаа эсвэл сэжигтэй тээврийн хэрэгсэл, ачаа тээш, хүний биед хойшлуулшгүй ажиллагааны хүрээнд үзлэгийг хийхдээ хэрэгт ач холбогдолтой баримтыг эрж хайх, эд зүйл үлдсэн эсэхэд анхаарч үзлэгийг нэг бүрчлэн нямбай хийнэ.

б) Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийг шалгахдаа хэрэг, учрал болсон гэх тэрхүү газрын ойр орчим оршин сууж байгаа, тухайн үед зорчиж явсан, яваа хүмүүсээс тухайн нутаг газарт ан агнахаар хүмүүс явж байсан эсэх, буун дуу гарсан, сонссон эсэх талаар асуун сураглаж, тэдгээр иргэдээс гэрчээр мэдүүлэг авах хэрэгтэй. Ялангуяа тухайн газрын байгаль хамгаалагч, тусгай хамгаалалттай газар нутгийн байцаагч зэрэг хүмүүсээс өдөр тутмын хийдэг ажиглалт судалгаагаар сэжигтэй зүйл илэрсэн эсэх талаар нарийн тодруулж асууна.

Байгаль хамгаалагч нар өдөр бүр хариуцсан нутаг дэвсгэртээ байгаа амьтдын тоо толгой, нас, хүйс, үржил хөгжил, байршил, нутагшил, хужир мараанд ирдэг цаг хугацаа, мөр, баас зэрэгт ажиглалт судалгаа явуулах үүрэгтэй бөгөөд энэ талаараа тэмдэглэл бичдэг, энэ тэмдэглэл нь нотлох баримт ч болох боломжтойг анхаарах хэрэгтэй.

в) Хойшлуулшгүй ажиллагааны хүрээнд хууль бусаар амьтан агнагдсан хугацааг богино хугацаанд тодорхойлж чадвал тухайн газраас тээврийн хэрэгсэлтэй хүмүүс хэдий хугацаанд, хэр их зайтай газарт холдож болох зэргийг судлан үзэж, замын пост болон зах худалдааны газар, тодорхой нутаг дэвсгэр, орон байранд нэвтрэн орох гарахад хяналт тогтоох ажиллагааг зохион байгуулж болно.

г) Хэргийн газарт хийсэн үзлэгээр илэрсэн эд зүйл, амьтны сэг зэм, эвэр туурай зэргээс тухайн амьтан ямар зүйлийн амьтан болох, нас, хүйс зэргийг тодорхойлох болон бусад ул мөрнөөс шинжилгээнд зориулж дээж, ул мөрийн хэв авна. Дээжийг авч шинжилгээнд хүргүүлэхдээ зохих технологи журмыг сайтар баримтлах нь зүйтэй.

Мөрдөгч гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч хянаж үзсэн даруй эсхүл мөрдөн шалгах ажиллагаа явуулж хэрэг бүртгэлтийн хэрэг нээх эсхүл харьяаллын дагуу шилжүүлэх, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах санал гаргах шийдвэрийн аль нэгийг гаргана.

Гуравдугаар алхам

Хууль бусаар ан агнах гэмт хэрэгт хэрэг бүртгэлтийн хэрэг нээх. Мөрдөгч гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох зорилгоор гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авснаас хойш эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах хүртэл хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, нотлох баримт цуглуулах тодорхой ажиллагааг тодруулбал, үзлэг, нэгжлэг хийх, нотлох баримтыг хураан авах, шинжилгээ хийлгэх, сэжигтэн, гэрч, хохирогч нарыг байцаах зэрэг мөрдөн шалгах анхан шатны ажиллагааг хуульд заасны дагуу явуулна.

Дөрөвдүгээр алхам

Нотлох баримт цуглуулах. “Нотлох ажиллагаа” нь хуулийн зорилгыг хангах, зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд хуульд тогтоосон үндэслэл, тодорхойлсон журмын дагуу, үүрэгжсэн байгууллагын үүрэг бүхий албан тушаалтнаас хуулийн дагуу хэрэгжүүлж байгаа өөр хоорондоо нарийн холбоотой иж бүрэн, цогц үйл явц байдаг.

Түүний зорилго нь болж өнгөрсөн үйл явдал, тухайн үеийн нөхцөл байдал зэргийн бодит үнэнийг тогтооход чиглэгдэнэ. Хууль бусаар ан агнах гэмт хэрэгт хийх зарим тодорхой ажиллагааны талаар дор онцгойлон оруулаа.

Үзлэг. Үзлэг нь гэмт хэргийн нотлох баримт цуглуулах үндсэн арга юм. Түүний зорилго нь гэмт хэрэг гарсан байдал, хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлыг тогтоох, хэрэг, зөрчлийн ул мөр, эд мөрийн бусад баримтыг илрүүлэх, бэхжүүлэх, хэрэг зөрчилтэй холбоотой бусад байдлыг тогтоох, шалгах, үнэлэх, тодруулахад чиглэгдэнэ.

Мөрдөгч гэмт хэрэг гарсан байдал, хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлыг тогтоох, тодруулах зорилгоор хүний бие, эд зүйл, баримт бичиг, тээврийн хэрэгсэл, ачаа тээш, мал, амьтан, хэрэг гарсан газарт үзлэг хийнэ.

Хэргийн газрын үзлэг. Хэргийн газрын үзлэг хийхэд нотолгооны ач холбогдолтой амьтны сэг зэм,яс, үс, толгой, шийр, арьс, эвэр туурай зэрэг амьтны эд эрхтэн, түүнээс гадна сэжигтэн этгээдийн үлдээсэн ул мөр байж болох сумны хонгио, хутга, тамхины иш зэрэг эд зүйл, хэрэг үйлдэхэд ашигласан зэвсэг хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, морь, тэмээ түүний ул мөр зэргийг илрүүлэн, бэхжүүлж авахад онцгой анхаарна (Хавсралт 2-ыг үзнэ үү).

Тээврийн хэрэгсэлд хийх үзлэг. Хууль бусаар ан агнах гэмт хэрэгт амьтны эд эрхтнийг тээвэрлэсэн үйлдэл нь гэмт хэрэгт тооцогдох учраас тээврийн хэрэгсэлд үзлэг хийж, нотлох баримтыг цуглуулахдаа амьтны үс, хялгас, цусны толбо, арчидас, мах өөх зэрэг амьтны эд эрхтний үлдэгдэл, үнэр зэрэг бичил ул мөрийг нягт нямбай сайтар үзнэ. Мөн ан агнасан байдлыг илтгэх машины гадна талыг нягтлан харж шавар, тоос болсон эсэх, амьтныг машинаар дайрсан байж болзошгүй тул машины явах анги, дугуй, дугуйн дотор тал, машины доод тал зэргийг залхууралгүй үзэж шалган хэрэгт ач холбогдолтой байдлыг үзлэгийн тэмдэглэлд бүрэн тусгах, илэрсэн ул мөрийг шаардлагын дагуу бэхжүүлэн авах хэрэгтэй. Үзлэгээр амьд амьтан тээвэрлэгдэж, зөөвөрлөгдөж байвал тэдгээрт хийх үзлэгт амьтан судлалын мэргэжилтнүүд байлцуулах нь зохимжтой.

Эд зүйл, баримт бичиг, ачаа тээш, мал, амьтан, тээврийн хэрэгсэлд үзлэг хийхэд эзэмшигчийг заавал байлцуулна. Хэрэв эзэмшигчийг байлцуулах боломжгүй тохиолдолд хөндлөнгийн гэрчийг байлцуулах эсхүл дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлнэ.

Хүний бие, галт зэвсэг, бичиг баримтад хийх үзлэг. Сэжиглэгдэж буй этгээдийн биед цус, дарийн тортог зэрэг хэрэгт ач холбогдолтой байдлыг үзэх зорилгоор үзлэгийг хийж болно.

Сэжигтэн этгээд галт зэвсэг авч явж байвал түүнд үзлэг хийж, улмаар шинжилгээ хийх зорилгоор хураан авна. Галт зэвсэгт үзлэг хийхдээ, санамсар болгоомжгүй байдлаас буудлага үйлдэгдэж болзошгүйг анхаарч, унагах, доргиох, бууны гох дарагдах зэргээс урьдчилан сэргийлж, аюулгүй байдлыг чанд сахина.

Хэрвээ зохих зөвшөөрлөөр амьтан агнасан, барьсан, худалдан борлуулахаар амьтны эд эрхтэн авч яваа бол түүний зөвшөөрлийн бичиг баримтыг үзэж шалгана. Бичиг баримтыг үзэхдээ энгийн нүдээр харахад, баримт бичигт засварласан, дарсан үг үсэг байгаа эсэх тамга тэмдэг бүрэн дарагдсан, баримт бичиг дэх бичиглэл бүрэн зөв байгаа эсэхэд анхаарал хандуулна. Сэжигтэй байвал хуурамч эсэхийг тодруулах зорилгоор хураан авч шинжилгээнд хүргүүлж болно. Тухайн зөвшөөрөл нь хууль ёсны байна гэж үзвэл түүн дээр бичигдсэн зүйлс нь шалгуулж буй хүний авч яваа зүйлсийн тоо хэмжээтэй яг таг тохирч байгаа эсэхийг нягтална.

Тавдугаар алхам

Эд мөрийн баримтыг хураан авах, хадгалах ажиллагааны онцлог. Мөрдөгч нотлох баримтыг хэрэгт хавсаргах, хадгалах, үрэгдэх, гэмтэх, солигдох, устгагдах нөхцөл үүсгэхгүй байх шаардлагаар эд мөрийн баримтыг хураан авна. Эд мөрийн баримтыг хураан авах ажиллагаа нь бусад хэргийн адил нийтлэг байдлаар явагдах боловч хууль бусаар ан агнах гэмт хэргийн хувьд хураан авах, бэхжүүлэх, баримтыг хадгалахад анхаарах хэд хэдэн онцлог зүйл байдаг.

Эд мөрийн баримтыг хураан авах ажиллагааны өмнө тухайн эд зүйлд үзлэг заавал хийсэн байх ёстой. Хэргийн нөхцөл байдлаас шалтгаалан эд зүйлд хийх үзлэг, түүнийг хураан авах ажиллагааг хамтад нь хийж болно.

Хураан авах ажиллагааг хийхдээ эд зүйл, баримтын шинж байдлыг маш сайн тодорхойлж тэмдэглэлд тусгах, мөн гэрэл зураг зэргээр бэхжүүлнэ (Хавсралт 3-ыг үзнэ үү).
Мөрдөгч үзлэг, хураан авах ажиллагааны тэмдэглэлд аливаа баримтыг зөв, тодорхой дүрслэхийн тулд амьтны өвөрмөц шинжийн талаар зохих мэдлэгтэй байх ёстой. Амьтны биеийн хэмжээ, өнгө зүс өөр өөр байх тул тэдгээрийг нарийн тодорхойлон бичнэ. Жишээлбэл, шар үнэгийг тодорхойлон бичих

бол цайвар шаргал зүстэй, сор үстэй, хажуу тал бүдэг шаргал, толгой цайвар улаан шаргалдуу. Биеийн урт 60-90 см, сүүл 40-60 см гэх мэт. Мөн арьс үсэнд буудлагын улмаас үүссэн цоорхой, өвчихөд зүсэгдсэн байдал, үс хуйхлагдсан, холгогдсон зэрэг ором мөр үүссэн байх боломжтой тул тэдгээрийн шинж байдлыг үзлэг хийх, хураан авах ажиллагааны тэмдэглэлд сайтар тусгана (Хавсралт 3-ыг үзнэ үү).

Хураан авах ажиллагааны дараа нотлох баримтыг зохих журмаар хадгалах асуудал маш чухлаар тавигддаг. Энэ гэмт хэрэгт амьд амьтан хэргийн баримт болох тохиолдол цөөнгүй байдаг. Амьд амьтан тухайн хэргийг нотлох хөдөлшгүй баримт мөн. Иймд хураагдаж буй амьтныг түр байлгах тор сав бэлтгэх, дараа нь хаана байршуулах, маллах, хоол тэжээл өгөх зэрэг асуудлыг шийдвэрлэх ёстой. Өнөөгийн байдлаар амьд амьтныг хураан авч түр хадгалахдаа цирк, амьтны зоопарк зэрэг газарт хандаж, улмаар амьтан судлаач, мэргэжлийн байгууллагын хүмүүсийг оролцуулан байгальд нь эргүүлэн тавих ажлыг зохион байгуулж байна. Энэ үйл ажиллагааг дүрс бичлэгээр баримтжуулна.

Хууль бусаар ан агнах гэмт хэрэгт биологийн гаралтай эд мөрийн баримт нь хураан авах, хадгалах тусгай горим, арга ажиллагааг шаарддаг. Биологийн гаралтай эд эрхтнийг зөвхөн цаасан уутанд хийж, аль болох нар тусахгүй, халаах хэрэгсэл, хорхой шавжаас хол тавьж, сэрүүн газарт хадгална. Муудах эд мөрийн баримтыг гялгар уутанд хийж хэрхэвч болохгүй. Амархан муудах цус, бусад эд эрхтнийг хөргөгч, хөлдөөгчид яаралтай хадгална. Ийм учраас хууль хяналтын байгууллагын эд мөрийн баримт хадгалдаг өрөө тасалгаандаа хөргөгч, хөлдөөгч заавал байх шаардлагатай.

Аливаа үслэг эдийг хадгалахад зориулалтын агуулах хэрэгтэй. Эд мөрийн баримтаар хурааж ирсэн ангийн үс, арьсыг хүлээн авахдаа тэдгээрийг төрөлжүүлэн ялгах, баглах, хүлээн авсан үеийн анхны чанар байдлыг алдагдуулахгүйн тулд норж гэмтэх, хортон шавжаас хамгаалах, ариутгал цэвэрлэгээ хийх, чанарын хамгаалалт, хаягжуулалт хийнэ.

Амьтны гаралтай эд мөрийн баримтыг хадгалах агуулах байрны температур, агаарын харьцангуй чийг ялгаатай байх шаардлагатай. Хадгалах горим баримтлаагүйгээс арьс, үс муудаж ялзрах, хорхой шавж үржих, улмаар халдварт өвчин ч гарч болзошгүй юм.

Аливаа амьтны эд эрхтэнтэй харьцахдаа халдвар аюулгүй байдлыг хангаж, зориулалтын бээлий, хувцас хэрэглэлийг ашиглах нь зүйтэй.

Зургаадугаар алхам

Сэжигтэн, гэрч, хохирогчийг байцаах. Мөрдөгч мэдүүлэг авах шаардлага хангасан өрөөнд сэжигтэн, гэрч, хохирогчоос мэдүүлэг авна. Шаардлагатай бол мэдүүлгийг тухайн хүний байгаа газарт очиж авч болно. Мөрдөгчид аливаа хэргийг шалгахад хэн нэгэнтэй заавал харилцан ярилцаж, тэдгээр ярилцлагаас шинэ мэдээлэл олж авах, өөр бусад мэдээллийг бататгах, нотлох баримтыг цуглуулах зэрэг олон зүйлийг мэдэж авдаг.

Та хэн нэгэнтэй (энгийн иргэн, хэргийн гэрч, хохирогч, сэжигтэн хэн ч байж болно) ярилцахдаа ямар асуулт асуух, яаж асуухаа мэддэг байх, өөртөө итгэлтэй байх, ур чадваруудыг хөгжүүлж, тодорхой арга техникүүдийг байнга судалж, түүнд суралцаж байх шаардлагатай.

Хүн бүр янз бүрийн ааш авир, зан байдал, дадал хэвшилтэй гэдгийг та байнга санаж байх хэрэгтэй.

Долоодугаар алхам

Шинжилгээ хийх, шинжээчид асуулт тавих. Хууль бусаар ан агнах, мал хулгайлах гэмт хэрэг сүүлийн үед ихсэж, малын махыг амьтны махаар солих, нохой, буга, зээр, хулан зэрэг тураг амьтдын махаар хоол унд хийж худалдах, хууль бусаар баавгайн донид, хүдрийн заарыг худалдан борлуулж байгаад баригдах үед үхрийн цөс, малын засаа гэж мэлзэх асуудал цөөнгүй гардаг.

Хууль бусаар ан агнах гэмт хэргийн эд мөрийн баримт болох амьтны эд, эрхтэнд шинжлэн магадлахуйн-амьтан судлалын шинжилгээ явуулахдаа дараах зүйлсийг мэдэж байх хэрэгтэй.

Энэ төрлийн хэргийн эд мөрийн баримтад хийх шинжилгээг амьтан, түүний гаралтай эд эрхтэнд хийх шинжилгээ болон бусад шинжилгээ гэж хоёр хувааж үзэж болно.

а) Амьтан болон түүний гаралтай эд эрхтэнд биологи, амьтан судлал, генетик (ДНХ)-ийн шинжилгээ хийнэ. Үүнд:

- Амьтанд хийх шинжилгээгээр амьтны төрөл зүйл, нас, хүйсийг тухайн амьтны морфологи шинжээр нь тодорхойлох – Биологи, Амьтан судлал;
- Амьтны үхлийн шалтгааныг тодорхойлох – Паталоги;
- Амьтны эд, эрхтнийг тодорхойлох шинжилгээ нь тухайн эд эрхтэн нь ямар зүйлийн амьтных болохыг генотип шинж болон генетик (ДНХ)-ийн шинжилгээгээр тодорхойлж болно.

б) Энэ төрлийн гэмт хэрэгт хийх бусад шинжилгээнд:

- Мөр судлал (тээврийн хэрэгсэл, гутал, мал, амьтны мөр г.м);
- Галт зэвсэг;
- Хүйтэн зэвсэг;
- Биологи (ургамал, шавж г.м);
- Үнэр судлал;
- Амьтан агнах барих бусад зэвсэг хэрэгсэл (амьтан агнах, барихад хуулиар хориглосон зэвсэг болох сааль, занга, урхи, хаж, загас барих тор, цахилгаан гүйдэл, хаалт, хашлага, гувчуур г.м)
- Хөрс зэрэгт хийх шинжилгээ хамаарна.

Шинжээчид тавих асуулт

Амьтны үхлийн шалтгааныг тогтоолгохоор шинжилгээнд хүргүүлж буй амьтан бүхлээрээ байгаа тохиолдолд, үхлийн шалтгааныг тогтоох боломжтой бөгөөд шинжээчид дараах асуулт тавина.

Эд мөрийн баримтаар амьтан (амьд) хураагдаж ирсэн бол:

- Шинжилгээнд хүргүүлж буй амьтан (амьд бол) ямар төрөл, зүйлийн амьтан болох, түүний шинжлэх ухааны нэршил?
- Хэрвээ эд мөрийн баримтаар хураасан амьтны (амьд) биед хийсэн гадна үзлэгээр бэртсэн, гэмтсэн, цус гарсан, шархтай байгаа бол:
  1) Тухайн амьтны биеийн аль хэсэгт ямар шарх үүссэн байна бэ?
  2) Уг шарх хатуу мохоо эсвэл хурц үзүүртэй зүйл (хутга, шөвөг г.м)-ээр хатгагдсан, огтлогдсон, зүсэгдсэн эсвэл буудагдсан эсэх?
- Агнагдсан амьтны үхлийн шалтгааныг тогтоож болохоор тухайн амьтан бүхлээрээ эсхүл шинжилгээ хийхэд хангалттай эд хэсгүүд байгаа тохиолдолд:
  1) Тухайн амьтны үхлийн шалтгаан юу вэ? .
  2) Уг амьтны арьсанд ил харагдах ямар ямар гэмтэл үүссэн байна вэ?
  3) Задлан шинжилгээгээр амьтны дотор эд эрхтэнд ямар ямар гэмтэл үүссэн (буудсан, хавх, урхины г.м) байна вэ?
  4) Үхэлд хүргэх гаднын ямар нөхцөл нөлөөлсөн байна вэ?
  5) Амьтан үхсэнээс хойш хэдий хугацаа өнгөрсөн, хугацааг ойролцоогоор тогтоох, дурдсан хугацаанд (...төдийд) үхсэн байж болох уу?

Амьтны эд эрхтэнд хийх шинжилгээгээр:

- Шинжилгээнд хүргүүлсэн зүйл (хэсэг арьс, мах, булчин мах, яс, дотор эрхтэн, түүний эд хэсэг г. м) амьтны эд эрхтэн мөн үү? Хэрвээ мөн бол мал, зэрлэг амьтны аль нь болох?
- Шинжилгээнд хүргүүлсэн эд эрхтэн амьтных мөн бол ямар зүйлийн

амьтных (арьс, мах, эвэр, туурай, дотор эрхтэн) вэ? Шинжлэх ухааны нэршил?

- Тухайн амьтан манай орны аль хэсэгт тархсан бэ?
- Тухайн амьтны нас, хүйсийг тогтоох боломжтой эсэх?
- Амьтны эд эрхтэн нь холилдсон олон тоотой байвал:
  1) Ямар ямар амьтны аль хэсгийн, хэдэн бодгаль амьтны эд эрхтэн байна вэ?
  2) Эдгээр эд эрхтэн нь нэг зүйл амьтных уу эсвэл өөр өөр зүйл амьтных байна уу?
  3) Хэрэв нэг зүйл амьтных бол хэдэн бодгалийн эд эрхтэн болох (боломжтой бол тоог гаргах) эсхүл нэг бодгалийнх байна уу?
- Шинжилгээнд хүргүүлсэн амьтны эд эрхтэн болох эвэр, арьс, үсээр тухайн амьтан хэдийд агнагдсан хугацааг тогтоох боломжтой эсэх?
- Шинжилгээнд хүргүүлсэн эд зүйл (нэрийг нь бичих) дээр цус байгаа эсэх?
- Хэрэв цус мөн бол хүнийх үү эсвэл амьтных байна уу? амьтных бол ямар зүйлийн амьтных байна вэ?
- Шинжилгээнд хүргүүлсэн объект үс мөн эсэх?
- Хэрэв мөн бол хүн ба амьтны үсний аль нь болох?
- Хэрэв амьтны үс бол ямар зүйл амьтны үс байна вэ?
- ..... зүйлийн амьтны үс мөн үү?
- Үс нь ямар зүйлээр бохирлогдсон байна вэ?
- Ямар шалтгаанаар үс гэмтэлд орсон байна вэ?
- Үс зулгаагдсан, тасалсан, хайчилсан аль нь болох?
- Тухайн амьтны аль хэсгийн үс вэ?

Мөр судлалын шинжилгээгээр:

- Хэрэг учрал болсон газарт илэрсэн хөлийн мөр ямар амьтных байна вэ? (тухай амьтны мөрийн талаарх харьцуулах хэв загвартай үед хийх боломжтой)
- Тухайн мөрийн хувийн онцлог шинж тэмдэг юу вэ?
- Тухайн амьтан аль чиглэлд явж байсан байна вэ?
- Амьтны мөрөөр нас, хүйсийг тогтоох боломжтой эсэх?
- Хэрэг учрал болсон газарт хэчнээн тооны амьтан байсныг тогтоох боломжтой эсэх?
- Тухайн амьтны явдлын мөрөнд өөр амьтны (ялангуяа морь, тэмээ, үхэр г.м) мөр холилдон орсон эсэх зэрэг асуултаар хариулт авах боломжтой.

Үүнээс гадна шинжилгээний явцад олж мэдсэн бусад асуудлын талаар мөрдөгч асуулт тавиагүй боловч шинжээч мэргэжилтний хувьд тодорхойлж бичиж болно (Хавсралт 4-ийг үзнэ үү).

ХУУЛЬ БУСААР АН АГНАХ ГЭМТ ХЭРЭГ МӨРДӨН ШАЛГАХ ДАРААГИЙН ШАТНЫ АЖИЛЛАГАА

Мөрдөн шалгах дараагийн шатны ажиллагаа буюу эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах тогтоол үйлдсэнээс хойш хэргийг шүүхэд шилжүүлэх хүртэлх мөрдөн байцаалтын ажиллагаа нь нотлогдвол зохих бүхий л байдлыг тогтоох зорилгоор явагдана.

Наймдугаар алхам

Эрүүгийн хэрэг үүсгэх. Мөрдөгч хэрэг бүртгэлтийн шатанд хэргийн нотлох баримт хангалттай гэж үзвэл эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдэж, мөрдөн байцаалтыг эхлүүлнэ.

Гэмт хэрэг гарсан байдлыг тогтоосны дараа тухайн хэргийг хэн үйлдсэн, хэргийн сэдэл, зорилго, гэм буруугийн хэлбэр, яллагдагчид оногдуулах ялыг хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдал, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршиг, түүний шинж чанар, хэр хэмжээ, хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг нарийвчлан тогтооно.

Сүүлийн үед хэрэгт холбогдогсод зэрлэг араатан амьтан дайрсан учраас түүнийг өрсөж буудсан гэж сэдэл, зорилгоо тайлбарлаж ял шийтгэлээс мултрах, худал мэдүүлэх явдал цөөнгүй байна. Иймд тухайн нөхцөлд амьтан дайрсан, довтолсон эсэхийг нөхцөл, шинж байдал, нотлох баримтад тулгуурлан логик уялдаа холбоон дээр дүн шинжилгээ хийж, сайтар тодруулах шаардлагатай.

Амьтны аймагт учирсан хохирлын хэмжээг Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Үнэлгээ, төлбөр,хураамжийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 23 дугаар тогтоолоор баталсан “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-ээр амьтан тус бүрд тогтооно. Энэхүү Засгийн газрын тогтоолд дурдсанаар амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг хоёр дахин нугалж хохирлыг тооцно. Экологи-эдийн засгийн үнэлгээг амьтны зүйл, нас, хүйсээр ялгаатай тогтоосон байдаг. Тухайлбал, Монгол бөхөн (*Saiga borealis*)-ийн эр нь 2000.00 мян.төг, эм нь 2200.0 мян.төг, Хулан адуу (*Equus hemionus*)-ны эр нь 9700.0 мян.төг, эм нь 11000.0 мян.төг тус тус байдаг.

Тиймээс мөрдөн байцаалтын үед тухайн амьтны зүйл, нас, хүйсийг шинжилгээ явуулж тодорхой тогтоох нь хохирлын хэмжээг гаргахад чухал ач холбогдолтой.

Мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавьж буй прокурор, шүүгчээс амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг тогтоолгох, Амьтны тухай хуульд заасан

нэн ховор, ховор амьтныг шинжээч нараар тодорхойлуулахаар мөрдөгчид шаардлага тавьж болохгүй юм.

Мөрдөн шалгах ажиллагааны үед ихэвчлэн гаргаж буй алдаа, дутагдал. Хууль бусаар ан агнах гэмт хэрэг хөдөө хээр, эзгүй газарт үйлдэгдэг, хэргийн талаарх мэдээлэл цаг хугацааны хувьд нэлээд хожуу ирдэг зэргээс шалтгаалан тэр бүр хэргийн газрын үзлэг хийхгүй байгаа нийтлэг дутагдал байдаг. Хэрэг үйлдэгдсэн газарт амьтны яс, үс, толгой, шийр, арьс, эвэр туурай, чив сүүл зэрэг эд эрхтний үлдэгдэл, түүнчлэн галт зэвсэг, сумны хонгио, хутга зэрэг тухайн хэргийг нотлох чухал баримт, эд зүйл, мөр үлддэг бөгөөд түүнд мөрдөгчид анхаарал хандуулахгүй байна. Тухайлбал;

- Мөрдөгч хэрэг мөрдөх тодорхой төлөвлөгөө гаргаж, удирдлага болгохгүй цээжээр буюу хийсвэр маягаар явуулах
- Төлөвлөгөө гаргасан ч эмх цэгцгүй, хэргийн мөрдлөгийг хугацаа алдаж эхлэх
- Зайлшгүй хийвэл зохих хойшлуулшгүй ажиллагааг орхигдуулах
- Хэргийн газрын үзлэгийг чанаргүй хийх
- Гэрчийг хугацаа алдаж, хагас дутуу байцаах
- Шуурхай эрэн сурвалжлах ажиллагааг иж бүрэн явуулаагүйгээс хэргийн холбогдогчийг тогтоож чадахгүй юм уу нотолж чадахгүй байх
- Тухайн хэргийг мөрдөхөд зайлшгүй шаардлагатай мэргэжилтнүүдийн туслалцааг аваагүй байх
- Анхан шатны ажиллагааны үед хэргийн газраас урган гарч байгаа таамаглалыг таньж чадаагүй, ганц таамаглал дэвшүүлж, түүнд хөтлөгдөн бусад таамгийг шалгаагүй орхигдуулах
- Мөрдөгч нарын хамтын ажиллагаа, зөв зохион байгуулалт, дэс дараатай ажиллагаа явуулаагүй зэрэг олон дутагдал байна.

Түүнчлэн, хууль бусаар ан агнах гэмт хэрэгт хураагдсан амьтны гаралтай эд мөрийн баримтад шинжилгээ хийлгэхдээ шинжээчдээс утга, найрлага, логикийн алдаатай асуултууд асуух, шийдвэрлэвэл зохих асуултыг оновчтой тавиагүй, илүүц шаардлагагүй, шинжээчийн тусгай мэдлэгт хамаарахгүй юм уу хэт ерөнхий асуултууд тавьж алдаа дутагдал гаргаж байгаа тухай өмнөх сэдвүүдэд тодорхой жишээн дээр тайлбарласан билээ (тэдгээр жишээг эргэн хараарай). Иймд;

- Эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хууль бусаар ан агнах гэмт хэрэг илрүүлэх тактикт юуны өмнө хэргийн материалд цугларсан нотлох баримтыг нарийн сайн судалж, дүн шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт хийх
- Мөрдөн шалгах нууц болон эрэн сурвалжлах ажиллагааны явцад цуглуулсан материалыг судлах, дэвшүүлсэн таамаг бүрийг бүрэн

гүйцэд шалгах, хойшлуулшгүй ажиллагааг явуулсан байдал, гэмт хэрэг үйлдсэн аргыг хэрхэн зөв тодорхойлсон, төстэй гэмт хэрэгтэй харьцуулан судалж үзэх
- Хэргийг илрүүлэхэд гарсан мөрдөлтийн алдаа дутагдлыг боломжтой бол нөхөн арилгах, цаашид хийх ажлын чиглэл гаргах, олон нийтийн хүчийг зөв зохион байгуулах
- Мэргэжлийн шинжээч нартай тогтмол уулзаж зөвлөгөө авах, эрүүгийн мөрдөгч нарын хамтын ажиллагааг идэвхжүүлэх
- Тагнуул, хил хамгаалах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон байгаль орчин, мэргэжлийн хяналт, гадаадын харьяатын асуудал эрхэлсэн байгууллагууд зэрэгтэй мэдээлэл солилцож, нягт хамтран ажиллах шаардлагатай.

Иймээс, мөрдөгч нар байгаль орчны талаарх суурь мэдлэг, ялангуяа амьтан судлал, байгаль хамгаалал, энэ чиглэлийн хууль, эрх зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэхэд онцгойлон анхаарч, тогтмол хөгжүүлж байх шаардлагатай юм.

Есдүгээр алхам

Мөрдөн байцаалтыг дуусгах буюу хавтаст хэргийн материалыг танилцуулж, хэргийг прокурорт шилжүүлэх. Хууль бусаар ан агнах гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, баривчлагдсан эсхүл яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар дуудагдсан сэжигтэн нарт яллагдагчаар татах тогтоолыг үйлдэж, танилцуулна.

Тухайн хэрийг нотолж, зохих байдлыг бүрэн тогтоож, хэргийн бүрдэл хангагдсан гэж үзвэл хавтаст хэргийг яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч нарт танилцахыг мэдэгдэж, танилцуулна.

Хавтаст хэргийн материалыг яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний өмгөөлөгч нарт танилцуулахдаа тэмдэглэл үйлдэж, тэдгээр оролцогчдоос гаргасан хүсэлтийг хавтаст хэрэгт хавсаргаж, хэргийн материалыг товьёгийн дагуу үдэн цэгцэлж, тухайн хэргийг прокурорт шилжүүлнэ.

ХАВСРАЛТ 2

ХЭРГИЙН ГАЗРЫН ҮЗЛЭГ ХИЙСЭН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 03 дугаар сарын 03-ны өдөр Говь-Алтай аймаг, Жаргалан сум

Говь-Алтай аймаг дахь Цагдаагийн газрын Мөрдөн байцаах тасгийн мөрдөгч албан тушаалтай цагдаагийн ахмад цолтой Т.Баярсайхан би, Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Байгаль орчны улсын байцаагч Б.Болдоогоос 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 09 цаг 00 минутад гаргасан хууль бусаар ан агнагдсан байж болзошгүй байна гэх мэдээллийг хүлээн авахад гэмт хэрэг үйлдэгдсэн үндэслэл байх тул хэргийн нотлох бариmтыг олж тогтоох, хэрэгт ач холбогдол бүхий байдлыг тодруулах зорилгоор криминалистикийн мэргэжилтэн, цагдаагийн ахмад Ц.Гантулга, тус сумын Байгаль орчны улсын байцаагч Б.Болдоо, мэргэжилтнээр Шинжлэх ухааны академийн Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгийн амьтан судлаач, биологич Б.Батзаяа нарыг оролцуулан Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 23.3 дугаар зүйлийг удирдлага болгон үзлэг хийв.

Үзлэгийг 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 15 цаг 00 минутад эхлүүлж, цэлмэг цаг агаартай, агаарын дулаан -10 хэм байх үед байгалийн гэрэлд явуулав.

Үзлэг явуулж буй газар нь хөдөө хээр, төв суурин газраас алслагдсан хөндлөнгийн гэрч оролцуулах боломжгүй байсан тул Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу фото зургийн аппарат, Garmin 64s маркийн GPS байршил тогтоогч багаж, Phantom-4 маркийн нисдэг камер (дрон) ашиглан фото зураг авч, бичлэг хийн мөрдөн шалгах ажиллагааны явцыг бэхжүүлэв.

Үзлэгээр илэрсэн нөхцөл байдал

Хэрэг болсон гэх газар нь Говь-Алтай аймгийн төв Есөнбулаг сумаас ертөнцийн зүгээр зүүн хойд зүгт 100 км, Жаргалан сумын төвөөс ертөнцийн зүгээр баруун зүгт 60 км зайд байршилтай зүүн урдаасаа хойшоо сунаж өндөрссөн, баруун зүүн, хойд талаараа ой модтой, уулаар хүрээлэгдсэн, уулын ам бүхий “Дунд нүүр” гэх нэртэй газар байлаа.

Хууль бусаар ан агнах гэмт хэрэг үйлдэгдсэн байж болзошгүй байна гэх мэдээллийг анх өгч, хэргийн газрын үзлэгт оролцож буй сумын Байгаль орчны улсын байцаагч Б.Болдоор агнагдсан амьтан байгаа газрыг заалгахад уулын амны зүүн энгэр далайн төвшнөөс дээш 2270 м-ийн өндөрт 40^0 налуутай, том хадны дэргэд нэг толгой амьтан үхсэн газар, түүний ойр орчимд үзлэгийг явуулахаар тогтов.

Үзлэг явуулж буй газрын орчин нь эргэн тойрон торлог бут, хад чулуутай хэвгий газар байх бөгөөд нэлэнхийдээ ов тов цоохортсон цастай, цас нь дагтаршсан. Үзлэг явуулах газарт 3 м өндөртэй 2.5 м өргөн, 1.8 м зузаантай шовгор хад байх бөгөөд хадны дэргэдээс 10 м-ийн зайд газрын хэвгийд ертөнцийн зүгээр зүүн урд зүгт 170^0-д толгой нь харсан, урд 2 хөл хагас нугарсан, хойд 2 хөл нь тэнийсэн, зүүн талаараа хэвтээ байрлалтай, гадна морфологи шинжийг энгийн нүдээр харахад Амьтны тухай хуульд заасан ховор амьтан болох Халиун буга үхсэн байна. Уг үхсэн амьтан байгаа газрын үл хөдлөх цэгийг орон зайн байршил тогтоогч Garmin 64s маркийн GPS багажаар тогтооход E46 57 36.51; N101 41 39.45 солбицолд байв.

Үхсэн халиун буга нь бор саарал зүстэй 5 см урт ширүүн, өтгөн, ноолууран үстэй, хэвлий хэсгээр танан цайвар зогдортой, биеийг гараар дарж үзэхэд хөлдүү, биеийн уртыг хэмжиж үзэхэд 240 см, өргөн 82 см, сэрвээний өндөр 160 см, хүрэн улаан өнгийн гонзгой 15 см урт чивтэй, сүүлийн урт 10 см байв. Бугын толгойн эврийг угаар нь тэгш хэмтэй хөрөөдөж таслан авсан бололтой эврийн хатуу эдийн үйрмэг эврийн уг орчимд үлдсэн. Баруун эврийн угийн диаметр нь 3,4 см, зүүн эврийн угийн диаметр нь 3,5 см хэмжээтэй байв. Эврийн уг хэсгээс цус урсаж бохирлогдож, хатаж, хөлдсөн байв.

Агнагдсан бугын биеийг үзэхэд, цээжний баруун талын суга орчим буюу амьтны өвчүү хэсгээс 25 см, цээжний урд хэсгээс 45 см, сэрвээ буюу нурууны хэсгээс 45 см, сүүл хэсгээс 195 см зайд галт зэвсгээр буудагдсан байж болох 0,6х0,7 см хэмжээтэй нүх гарч, түүнээс бага хэмжээтэй цус урсан гарч хатаж, хөлдсөн байв.

Бугын биеийг эргүүлж үзэхэд, зүүн сүвээний хавирганы арын хэсгээр задарч сум гарсан байж болохоор хэвлийн доод хэсгээс 55 см, цээжний урд хэсгээс 185 см, хондлойн буюу нурууны хэсгээс 25 см, сүүл хэсгээс 55 см зайд 1,2х1,3 см хэмжээтэй том нүх гарч цус ихээр урсан гарч, газарт нөжирч хөлдөж наалдсан байв.

Үхсэн халиун бугын эргэн тойрон газарт хөндлөн усан хээтэй гутлын болон хээгүй шовгордуу гутлын мөрүүд байна.

Хөндлөн усан хээтэй гутлын тод гарсан мөрийг хэмжиж үзэхэд өлмий хэсгийн урт нь 15 см, өргөн нь 10 см, өсгий хэсгийн урт нь 7 см, өргөн нь 10 см байв.

Хээгүй шовгордуу гутлын мөрийн урт нь 12 см, өргөн нь 7 см байна. Хэргийн газарт үүссэн гутлын мөрөөр явсан чигийг тодорхойлж үзэхэд, зүүн урдаас ирж, буцсан мөрүүд байна. Мөрний алхмыг хэмжихэд:

- *Хөндлөн, усан хээтэй гутлын баруун хөлийн мөрийн алхмын урт 60 см, алхмын өргөн 3 см, баруун хөлийн солбицлын цэг 10°, зүүн хөлийн солбицлын цэг 10° байна.*
- *Хээгүй шовгор гутлын баруун хөлийн мөрийн алхмын урт 60 см, алхмын өргөн 3 см, баруун хөлийн солбицлын цэг 10°, зүүн хөлийн солбицлын цэг 10° байна.*

Агнагдсан бугын дэргэдэх хаднаас зүүн урагш 4 м-ийн зайд орших жижиг хадан дээр 3х3, 3х2, 1х1 хэмжээтэй цус мэт улаан өнгийн дусал дуссаныг хэмжихүйн гэрэл зургаар бэхжүүлэн шинжилгээнд зориулж мэс заслын хутгаар хусан дээж авч цагаан цаасанд тэгш өнцөгт хэлбэрт оруулан эвхэж, 4х6 см хэмжээтэй цаасан дугтуйд хийж, дугаарлаж нүүрэн талд нь "хадан дээр байсан цус мэт зүйлийн дээж-1, 2, 3" гэж тус бүр дугаарлан амны хаалтад дээр ромбо хэлбэрийн тэмдгийг дарж битүүмжлэв.

Уг хаднаас зүүн тийш 3 м-ийн зайд 1.8 см урттай тамхины иш 1 ш, түүний баруун талд 0.5 гр-ын цэнхэр өнгөтэй "Вояж" гэсэн шошготой усны хуванцар хоосон сав 1 ш, 1.5 м-ийн урттай цагаан өнгийн мяндсан утасны тасархай зэргийг илрүүлж, эд мөрийн бариимтаар хураан авлаа.

Бугыг агнасан буудагчийн байрлал, сэжигтнүүдийн ирсэн буцсан чиглэлийг тогтоох зорилгоор хэргийн газрын эргэн тойрон 450 м радиустай газрыг самнаж үзэхэд, агнагдсан бугаас ертөнцийн зүгээр зүүн урд 250 м-т газраас 30 см өндөртэй торлог бутны ёроолд 120 см урттай, 20 см өргөнтэй хүн хэвтэж байсан байж болзошгүй дагтаршсан цасыг ухаж хонхойлсон мөр, уг мөрнөөс баруун тийш 2 м-ийн зайд 4х5 см өндөртэй, 1.2 см диаметртэй сумны хонгио 2 ш илрүүлэв.

Уг хонхойлсон мөрний баруун талд нь 5 м-ийн зайд бас хүн хэвтэж байсан байж болзошгүй урт нь 110 см, өргөн нь 20 см хонхойлсон ул мөр илрэв. Түүний дэргэд 2х1.5 см-ийн хэмжээтэй улаан өнгийн даавууны өөдөс байлаа.

Агнагдсан бугын явж байсан чиглэлийг тогтоох зорилгоор хөлийн мөрийг үзэхэд хойноосоо урагшаа чиглэлтэй хоёр бугын мөр байх бөгөөд нэг бугын мөр нь урагшаа чиглэлтэй мөрний явдал нь үргэж үсэрч давхисан шинжтэй, алхмын зай хол байна.

Агнагдсан бугын эргэн тойронд үүссэн гутлын мөрийн чиглэлийн дагуу хөөж үзэхэд, тус газраас 600 м-ийн зайд нам доор газарт тээврийн хэрэгслийн мөр илрүүлэв. Уг тээврийн хэрэгслийн мөр нь баруун урд зүгт 1 км орчим явж шороон замд орж ул мөр баларсан байна.

Тээврийн хэрэгслийн мөрийг шинжлэн үзэхэд, баруун урд зүгээс ирж, маневр хийж эргэж явсан чиглэлтэй. Дугуйны мөрний тэнхлэгийн хоорондын зай 4 м-ийн өргөнтэй. Дугуйн мөр усан хээтэй байв.

Үзлэгийн явцад криминалистикийн мэргэжилтэн Ц.Гантулга агнагдсан бугын дэргэдээс хөндлөн усан хээтэй гутлын мөр, хээгүй шовгор хэлбэртэй гутлын мөрийг хэмжих хэрэгсэл тавьж гэрэл зургийн аргаар бэхжүүлэв.

Үзлэгийн явцад илрүүлсэн сумны 2 ш хонгиог тус бүр жижиг уутанд хийж "сумны хонгио" гэж бичиж лацдав.

Цэнхэр өнгийн "Вояж" гэсэн шошготой усны сав, улаан өнгийн даавууны өөдөс, тамхины 1 ш иш, шинжилгээнд зориулж цус мэт зүйлээс авсан дээж зэрэг эд мөрийн бариmтыг тус тусад нь уутанд хийж, гадна талд нь нэрийг бичиж тэмдэглэн лацдав. Тээврийн хэрэгслийн мөрийг гэрэл зургаар бэхжүүлэв.

Үзлэгийн явцад "Canon EOS600D" маркийн дижитал тоон технологид суурилагдсан, өнгөт фото зургийн аппаратаар баримжаалсан 3, тоймчилсон 5, зангилаа болон нарийвчилсан 17, нийт 25 кадр гэрэл зураг авч, хэргийн газрын схем план ба гутлын мөрийн алхалтын элементийг харуулсан зураг үйлдэж, нисдэг камер (дрон) ашиглаж 5 минутын бичлэг хийж, бэхжүүлсэн болно.

Үзлэгт оролцсон амьтан судлаач, мэргэжилтэн Б.Батзаяа нь амьтны арьс болон бусад эд эрхтэн бүтэн, өмхийрч муудаагүй нас бие гүйцсэн эр (дайр) халиун буга байна, алагдаад 2-3 хоносон байж болзошгүй гэснийг тэмдэглэлд тусгав.

Үзлэг хийж буй газарт хамгаалалтын бүс тогтоох шаардлагатай бусад нөхцөл байдал үүсээгүй, төв суурин газраас алслагдсан газарт явуулсан болно.

Үзлэгийн тэмдэглэлийг "Toshiba" маркийн зөөврийн компьютер, "Samsung ML1670" маркийн принтер, автомашинаас цахилгаан өсгөгч багаж (инвертер) зэргийг ашиглан хэвлэв.

Үзлэгийн тэмдэглэлийг оролцогчдод уншуулж танилцуулахад үзлэгийн явцтай холбогдуулж ямар нэгэн санал хүсэлт гаргаагүй тул үзлэгийг 18 цаг 30 минутад дуусгаж, оролцогчдоор гарын үсэг зуруулав.

Тэмдэглэл үйлдсэн:

Мөрдөгч, цагдаагийн ахмад — *Т.Баярсайхан*

Үзлэгт оролцсон:

Криминалистикийн мэргэжилтэн, цагдаагийн ахмад — *Ц.Гантулга*

Амьтан судлаач, мэргэжилтэн — *Б.Батзаяа*

Байгаль орчны улсын байцаагч — *Б.Болдоо*

Хэргийн газрын схем гар зураг



ХАВСРАЛТ 3

АМЬТНЫ ГАРАЛТАЙ ЭД ЗҮЙЛД ҮЗЛЭГ ХИЙСЭН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 02 дугаар сарын 04-ний өдөр Сэлэнгэ аймаг, Мандал сум

Мөрдөн байцаах албаны Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийн ахлах мөрдөгч албан тушаалтай, цагдаагийн хошууч цолтой Т.Буянтогтох би 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдөр Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.5 дугаар зүйлийн 2 дэх хэсгээр хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн (эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан) эрүүгийн 200200145 дугаартай хэрэгт Монгол Улсын Амьтны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нэн ховор амьтанд хамаарах цоохор ирвэс (Uncia uncial)-ийн арьс байж болзошгүй ан амьтны гаралтай арьс түүхий эдийн онцлог шинж, төрөх байдлыг тодруулах, тэмдэглэлийг хэргийн материалд хавсаргах, эд мөрийн бариmтаар тооцох (гэмт хэрэг гарсан байдал, хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлыг тогтоох, тодруулах, хэргийн ул мөр, онцлог шинж тэмдэг байгаа гэх үндэслэл бүхий сэжиг байгаа аль нь болохыг тодорхой бичих) зорилгоор Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 23.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг удирдлага болгон дараах зүйлд үзлэг хийв.

Үзлэгийг Сэлэнгэ аймгийн Мандал сумын 5 дугаар багийн нутаг Нүхтийн ам гэх газарт тус багийн төвийн байранд 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 11 цаг 05 минутад эхлүүлж, цэлмэг нартай цаг агаартай гэрэлтүүлэг хэвийн, үүлгүй, агаарын дулаан хасах -15-18 хэм байх үед байгалийн гэрэлд хөндлөнгийн гэрчээр:

1. *Сэлэнгэ аймгийн Мандал сумын 5 дугаар баг Нүхтийн амны адаг гэх газар нутаглах малчин _____ регистрийн дугаартай Дүгэржавын Цолмон*
2. *Сэлэнгэ аймгийн Мандал сумын 5 дугаар баг Шийртийн ам гэх газарт нутаглах малчин _____ регистрийн дугаартай Батаагийн Сосор нарыг оролцуулан явуулав.*

Үзлэгээр илэрсэн нөхцөл байдал

Хар өнгийн үүргэвчний цахилгааныг онгойлгож үзэхэд шар өнгийн гялгар уутанд хуйлан хийсэн амьтны арьс байна.

Уг арьсыг дэлгэн ерөнхий байдал, уртыг хэмжин үзэхэд толгой, дөрвөн хөл тавхай, хумстайгаа бүрэн, хоншоороос сүүлний үзүүр хүртэл 226 см урттай, толгойн хоншоороос сүүлний уг хүртэл биеийн урт 127 см, сүүлний угаас үзүүр хүртэл 127 см хэмжээтэй, нуруу хэсгийн өргөнөөрөө 85 см, сарвууны алга тавхайн өргөн 5х8 см байна.

Байгалийн гэрэлд энгийн нүдээр арьсыг харахад эрээн цоохор зүстэй. Арьсны их биеийн зоо нуруу дагаж саарал дэвсгэр өнгөн дээр 4-6 см голч бүхий хэмжээтэй гархин дугуй, матигар хагас дугуй бараавтар өнгийн толбонуудтай. Амьтны нүүр толгойн хэсэг мөн өнгийн жижиг, цул бараан толбонуудтай. Арьсны хэвлий хэсэг, суга, цавь толбогүй, цагаан цайвар өнгөтэй байна.

Арьсны өнгө, толгой, сүүл зэрэг амьтны ерөнхий шинжээр "Амьтны тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нэн ховор амьтанд хамаарах цоохор ирвэс (Uncia uncia)-ийн арьс болох нь илэрхий байна.

Уг арьсны гадна хэсгийг нарийвчлан үзэхэд нуруу хэсгийн үсэн бүрхүүл өтгөн, зөөлөн, ноолууртай, эсгийрээгүй. Арьсны баруун урд хөлд тавхайн үзүүрээс 15 см зайд 6х2 см хэмжээтэй хэсэг газарт үс унаж, холгогдсон ором үүссэн. Тус хэсгийн арьсны дотор талд мөн зайд арьсны хөрсөнд цус хурсан мэт тууш бүдэг улаавтар өнгийн толбо үүссэн байв.

Арьсыг битүү туламлан өвчиж, гар аргаар элдсэн байх бөгөөд өвчсөн арьсны хөрсийг эргүүлж гадагш харуулан нягтлан үзэхэд хоншоороос эгц доошоо 25 см зайд 2х2 хэмжээтэй цоорхой, зүүн суганы орчимд 3х4 см хэмжээтэй цоорхой, арьсны сүүлний угаас дээш 3 см зайд 3.2 см урттай цуурч урагдсан гэмтлүүд тус тус үүссэн байна.

Үзлэгт "Nikon D5100" маркийн 13.5 мегапиксел нягтралтай, 18-55 мм-ийн 1/3.5-5.6G дурангийн үзүүлэлттэй дижитал тоон технологид суурилагдсан, өнгөт фото зургийн аппаратаар байгалийн нартай ердийн гэрэлд:

- *Арьсыг дөрвөн хөлийн хамт дэлгэж зоо нуруу талыг дээш харуулсан зураг 1 кадр;*
- *Арьсны өвөр тал болох хэвлий хэсгийг дөрвөн хөлийн хамт дээш нь харуулж дэлгэж 1 кадр;*
- *Дамартай төмөр метрээр арьсны хоншоороос сүүлийн уг хүртэл, сүүлийн угаас сүүлийн үзүүр хүртэл хэмжиж байгаа 2 кадр;*

- *Арьсны хөрсийг гадагш эргүүлэн ар, өвөргүй 1 кадр нийт 2 кадр;*
- *Арьсны хөрсөнд үүссэн цоорхой, цууралт, баруун урд хөлд холголт үүсэж үс унасан зэрэг гэмтэлтэй хэсгийг машстабтайгаар нарийвчилсан 4 кадр гэрэл зураг авч бэхжүүлэв.*

Үзлэгийн ажиллагааг 2019 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 11 цаг 30 минутад дуусгаж, оролцогч нарт тэмдэглэлийг танилцуулахад ямар нэгэн санал хүсэлт гаргаагүй болно.

Тэмдэглэл үйлдсэн:

Ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч .....….....((Т.Буянтогтох)
(гарын үсэг) (нэр)

ХӨНДЛӨНГИЙН ГЭРЧ:
1. .....….....(Дүгэржавын Цолмон)
(гарын үсэг) (нэр)

2. .....….....(Батаагийн Сосор)
(гарын үсэг) (нэр

ХАВСРАЛТ 4

МӨРДӨГЧИЙН ТОГТООЛ БА ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ

МӨРДӨГЧИЙН ТОГТООЛ

Шинжилгээг шүүхийн шинжилгээний
байгууллагаас гадуур хийлгэх, шинжээч
томилох тухай

2020 оны 02 дугаар сарын 02-ны өдөр Дугаар.... Улаанбаатар хот

Мөрдөн байцаах албаны Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийн ахлах мөрдөн байцаагч, цагдаагийн ахмад Б.Бат би Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 184200001 дугаартай хэрэгт ***ОЛСОН НЬ:***

Булган аймгийн Хутаг Өндөр сумын харьяат Д.Доржханд, Б.Сүрэнжав нар нь 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Налайхын замд хувийн 31-52 УАА дугаартай Ланд круйзер маркийн тээврийн хэрэгслээр амьтны эд эрхтэн болох өвөрсдийн хэлж мэдүүлснээр сүүл гэх 12 ш эд эрхтэн, харавтар өнгөтэй, конус хүүдий хэлбэрийн, хатаж хорчийсон өвөрсдийн мэдүүлснээр үхрийн цөс гэж хэлсэн амьтны эд эрхтэн, ямар амьтны үл мэдэгдэх соёо 2 ш, хоншоор шүд бүхий эд эрхтэн 7 ш, амьтны гаралтай мах мэт улаан хүрэн өнгөтэй зүйл 4 ш амьтны эд, эрхтнийг тээвэрлэсэн хэрэгт амьтны эд эрхтэн, төрөл зүйлийг тодорхойлох шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулах шаардлагатай байх тул Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 27.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 19 дүгээр зүйлийг тус тус удирдлага болгон ***ТОГТООХ НЬ:***

1. *Эрүүгийн 184200001 дугаартай хэрэгт шинжилгээ хийхийг шинжээч Шинжлэх ухааны академийн Ерөнхий болон Сорилын биологийн хүрээлэнгийн Хөхтний экологийн лабораторийн эрхлэгч, эрдэм шинжилгээний ажилтан доктор (Ph.D), дэд профессор Ч.Пунцагт даалгасугай.*
2. *Шинжээчид дүгнэлт гаргуулахаар дараах асуултыг тавьсугай.*

1) *Шинжилгээнд хүргүүлж байгаа амьтны эд эрхтний гэх сүүл 12 ш, хараатар өнгөтэй, конус хүүдий хэлбэрийн, хатаж хорчийсон эд эрхтэн 1 ш, амьтны гэх соёо 2 ш, хоншоор шүд бүхий эд эрхтэн 7 ш, амьтны гэх мах мэт улаан хүрэн өнгөтэй 4 ш хэсэг зүйл нь мал, амьтны эд, эрхтэн мөн эсэх?*
2) *Дээрх эд эрхтэн нь амьтных мөн бол ямар зүйл болон хэдэн зүйлийн амьтны эд эрхтэн болох, тэдгээрийн шинжлэх ухааны нэршил?*
3) *Хэрвээ эд эрхтэн нь нэг зүйлийн амьтны эд эрхтэн мөн бол хэдэн бодгаль амьтны ямар ямар эд эрхтэн болох?*
4) *Шинжилгээнд хүргүүлсэн зүйлс нь зэрлэг амьтны эд эрхтэн мөн бол тухайн амьтад нь манай орны аль хэсэгт тархсан болох?*
5) *Уг эд эрхтний хэсгээр тухайн амьтны нас, хүйс, хэдийд агнагдсан хугацааг тогтоох боломжтой эсэх?*

3. *Тогтоолыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор дүгнэлт гаргахыг шинжээч Ч.Пунцагт даалгасугай.*
4. *Шинжээч Ч.Пунцагийн мэдэлд шинжилгээ хийлгэх тогтоолын хамт дараах эд зүйлсийг түр хүргүүлсүгэй. Үүнд:*
   - *амьтны гэх сүүл 12 ш;*
   - *хараатар өнгөтэй, конус хүүдий хэлбэрийн, хатаж хорчийсон эд эрхтэн 1 ш;*
   - *амьтны гэх соёо 2 ш;*
   - *хоншоор шүд бүхий эд эрхтэн 7 ш;*
   - *амьтны гэх мах мэт улаан хүрэн өнгөтэй 4 ш хэсэг зүйлсийг хүргүүлсүгэй.*
5. *Шинжээч Ч.Пунцагт хуульд заасан дараах эрх, үүргийг тайлбарласугай.*

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.2 дугаар зүйл
1.Шинжээч дараах эрхтэй:
1.1.хавтаст хэргийн материалаас шинжилгээ хийх зүйлд холбогдох хэсэгтэй нь танилцах;

1.2.прокурор, мөрдөгчийн зөвшөөрснөөр мөрдөн шалгах ажиллагаанд оролцох, түүнчлэн шинжилгээ хийхтэй холбоотой асуудлаар оролцогчид асуулт тавих, мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэлд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргах;

1.3.дүгнэлт гаргахад хэрэгцээтэй нэмэлт баримт ирүүлэх талаар шүүх, прокурор, мөрдөгчид хандаж хүсэлт гаргах;

1.4.шинжээчид тавьсан асуулт нь түүний тусгай мэдлэгийн хүрээнээс хэтэрсэн, эсхүл тусгай мэдлэгт хамаарахгүй, эсхүл шинжилгээ хийх баримт сэлтэд холбогдох хүн, байгууллагатай ашиг сонирхлын зөрчил үүсэхээр бол шинжилгээ хийж, дүгнэлт гаргахаас татгалзах;

1.5.шинжилгээний байгууллагаас гадуур шинжээчээр томилогдсон тохиолдолд шинжилгээний зардал, ажлын хөлсийг гаргуулан авах;

1.6.аюулгүй байдлаа хамгаалуулах хүсэлтийг шүүх, прокурор, мөрдөгчид гаргах.

2.Шинжээч нь шүүх, прокурор, мөрдөгчийн тавьсан асуултын дагуу тусгай мэдлэг, мэргэжлийн хүрээнд шинжилгээг тал бүрээс нь бүрэн бодитой хийж, тогтоосон хугацаанд шинжлэх ухааны үндэслэл бүхий дүгнэлтийг бичгээр гаргана.

3.Дүгнэлт гаргасан шинжээч нь мэдүүлэг авахаар шүүх, прокуророос дуудсан цагт хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол түүнийг энэ хуульд заасны дагуу шүүхийн шийдвэрээр албадан ирүүлнэ.

7. Шинжээч зориуд худал дүгнэлт гаргавал хуульд заасан дараах хариуцлага хүлээлгэхийг сануулсугай.

Эрүүгийн хуулийн 21.4 дүгээр зүйл.
1.Шинжээч шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон мөрдөн шалгах ажиллагааны үед, шүүхэд үнэн зөв дүгнэлт гаргахаа илэрхийлж, баталгаа гаргасны дараа зориуд худал дүгнэлт гаргасан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар эрх хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

ТАНИЛЦСАН: ШИНЖЭЭЧ.....(.....)
гарын үсэг нэр

ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ

2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр *Улаанбаатар хот*

Шинжлэх ухааны академийн Ерөнхий болон Сорилын биологийн хүрээлэнгийн Хөхтний экологийн лабораторийн эрхлэгч, эрдэм шинжилгээний ажилтан доктор (Ph.D), дэд профессор Ч.Пунцаг би Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 184200001 дугаартай хэрэгт ЦЕГ-ын Мөрдөн байцаах албаны Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийн ахлах мөрдөн байцаагч, цагдаагийн ахмад Б.Батын 2020 оны 02 дугаар сарын 02-ны өдөр шинжээч томилж, шинжилгээ хийлгэхээр ирүүлсэн мөрдөгчийн тогтоолд дурдсан асуултын хариу, шинжилгээний дүгнэлтийг гаргав.

ШИНЖИЛГЭЭНД ИРҮҮЛСЭН ЗҮЙЛ

Шинжилгээнд:

- *амьтны гэх сүүл 12 ш;*
- *харавтар өнгөтэй, конус хүүдий хэлбэрийн, хатаж хорчийсон эд эрхтэн 1 ш;*
- *амьтны гэх соёо 2 ш;*
- *хоншоор шүд бүхий эд эрхтэн 7 ш;*
- *амьтны гэх мах мэт улаан хүрэн өнгөтэй 4 ш ирүүлсэн байна.*

ШИНЖЭЭЧИД ТАВЬСАН АСУУЛТ

1) *Шинжилгээнд хүргүүлж байгаа амьтны эд эрхтний гэх сүүл 12 ш, харавтар өнгөтэй, конус хүүдий хэлбэрийн, хатаж хорчийсон эд эрхтэн 1ш, амьтны гэх соёо 2 ш, хоншоор шүд бүхий эд эрхтэн 7 ш, амьтны гэх мах мэт улаан хүрэн өнгөтэй 4 ш хэсэг зүйл нь мал, амьтны эд, эрхтэн мөн эсэх.*
2) *Дээрх эд эрхтэн нь амьтных мөн бол ямар зүйл болон хэдэн зүйлийн амьтны эд эрхтэн болох, тэдгээрийн шинжлэх ухааны нэршил.*
3) *Хэрвээ эд эрхтэн нь нэг зүйлийн амьтны эд эрхтэн мөн бол хэдэн бодгаль амьтны ямар ямар эд эрхтэн болох.*
4) *Шинжилгээнд хүргүүлсэн зүйлс нь зэрлэг амьтны эд эрхтэн мөн бол тухайн амьтад нь манай орны аль хэсэгт тархсан болох.*
5) *Уг эд эрхтний хэсгээр тухайн амьтны нас, хүйс, хэдийд агнагдсан хугацааг тогтоох боломжтой эсэх.*

ҮЗЛЭГ ШИНЖИЛГЭЭ

*Цагаан өнгийн 20*30 см хэмжээтэй цаасан хайрцаг дотор амьтны сүүл гэх хар бараан өнгийн үстэй ....см урттай 12 ш сүүл мэт зүйл, харавтар өнгөтэй, конус хүүдий хэлбэрийн, хатаж хорчийсон эд 1 ш, амьтны соёо гэх цайвар өнгийн яс мэт зүйл 2 ш, амьтны хоншоор шүд бүхий эрхтэн 7 ш, амьтны гэх мах мэт улаан хүрэн өнгөтэй 4 ш эдийг ирүүлсэн ба мөрдөгчийн тогтоолд дурдсантай тохирч байв.*

ДҮГНЭЛТ

***Асуулт 1.** Шинжилгээнд хүргүүлж байгаа амьтны эд эрхтний гэх сүүл 12 ш, харавтар өнгөтэй, конус хүүдий хэлбэрийн, хатаж хорчийсон эд эрхтэн 1 ш, амьтны гэх соёо 2 ш, хоншоор шүд бүхий эд эрхтэн 7 ш, амьтны гэх мах мэт улаан хүрэн өнгөтэй 4 ш хэсэг зүйл нь мал, амьтны эд, эрхтэн мөн эсэх.*

***Хариулт:** Шинжилгээнд ирүүлсэн зүйлийн гадна шинж тэмдгийг ажиглалт харьцуулалтын аргаар шинжилж, тодорхой шинж тэмдгүүдээр зэрлэг амьтны эд эрхтэн мөн байна гэж үзэв.*

***Асуулт 2**. Дээрх эд эрхтэн нь амьтных мөн бол ямар зүйл болон хэдэн зүйлийн амьтны эд эрхтэн болох, тэдгээрийн шинжлэх ухааны нэршил.*

***Хариулт:** Шинжилгээнд ирүүлсэн амьтны гэх 12 ш сүүл нь ..... морфологийн эдгээр шинжүүдээр Халиун бугын согооны сүүл байна. Халиун бугын шинжлэх ухааны нэршил нь Cervus elaphus.*

- *Харавтар өнгөтэй, конус хүүдий хэлбэрийн, хатаж хорчийсон 1 ш эд эрхтэн, хоншоор шүд бүхий 7 ш эд эрхтэнд ДНХ-ийн аргаар шинжилгээ хийхэд Хүрэн баавгайн донид болон соёо байна. Хүрэн баавгайн шинжлэх ухааны нэршил нь Ursus arctos.*
- *Амьтны гэх соёо 2 ш, мах мэт улаан хүрэн өнгөтэй 4 ш зүйл нь Саарал чононы соёо, шүд бүхий хоншоорын хэсгүүд, дотор эрхтэн болох ходоод байна. Саарал чононы шинжлэх ухааны нэршил нь Canus lupus.*

***Асуулт 3.** Хэрвээ эд эрхтэн нь нэг зүйлийн амьтны эд эрхтэн мөн бол хэдэн бодгаль амьтны ямар ямар эд эрхтэн болох.*

Хариулт: *Халиун буга (Cervus elaphus)-ын согооны сүүл нь 12 бодгальд хамаарна. Хүрэн баавгайн (Ursus arctos) донид болон соёо нь нэг бодгальд хамаарна. Саарал чоно (Canus lupus)-ын соёо, шүд бүхий хоншоорын хэсгүүд, дотор эрхтэн болох ходоод нь 2 бодгалийн эд эрхтэн байна.*

Асуулт 4. *Шинжилгээнд хүргүүлсэн зүйлс нь зэрлэг амьтны эд эрхтэн мөн бол тухайн амьтад нь манай орны аль хэсэгт тархсан болох.*

Хариулт: *Халиун буга (Cervus elaphus) нь .... оны .....эрдэмтний судалгаагаар Монгол орны нутаг дэвсгэрээр элбэг тархдаг бөгөөд нутгийн хойд хэсгээр бүгын том сүргүүд элбэг, бас тал хээр нутгаар тасархай сүргээр, ихэвчлэн ойтой, уулархаг нутгаар байршдаг байна.*

Хүрэн баавгай (Ursus arctos) нь .... оны .....эрдэмтний судалгаагаар манай орны Сэлэнгэ, Хэнтий, Хөвсгөл, Булган, Баян-Өлгий аймгийн нутгууд дахь ой тайгын бүслүүрээр тархсан байдаг.

Саарал чоно (Canus lupus) нь .... оны .....эрдэмтний судалгаагаар манай орны нутаг дэвсгэрт нэлээд өргөн тархсан.

Асуулт 5*. Уг эд эрхтний хэсгээр тухайн амьтны нас, хүйс, хэдийд агнагдсан хугацааг тогтоох боломжтой эсэх.*

Хариулт: *Соёо, шүдээр амьтны хүйсийг шууд тодорхойлох боломжгүй байна. Иймд, ДНХ-ийн шинжилгээ хийлгэх шаардлагатай.*

Бусад соёо, шүд бүхий хоншоорын хэсэг болон согооны сүүл зэрэг эд эрхтнээс дээж авч хүйс тодорхойлох шинжилгээг хийв (Хавсралт 1).

Шинжилгээнд ирсэн дээрх амьтны хэсэг эд эрхтнээр тухайн амьтны хэдийд агнасан хугацааг тодорхойлох боломжгүй байна.

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

.....….....Ч.ПУНЦАГ

ХАВСРАЛТ 5

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ЗҮЙЛЧЛЭЛ ХИЙХ АРГАЧЛАЛ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тухайн шалгагдаж буй үйл баримтад хууль зүйн дүгнэлт өгөхийг зүйлчлэл гэх бөгөөд шүүх шийдвэр гаргахдаа өөрийн эрхийн дагуу дүгнэлт хийдэг. Тэгвэл зүйлчлэл нь тодорхой алхмуудаар хийгддэг процесс юм. Үүнд:

1. Өгөгдсөн тохиолдолд гэмт хэргийн шинж байгаа эсэхийг шалгаж гэмт хэрэг, зөрчлийн шинжийг тодорхойлох
2. Бодлогын өгөгдөлд тохирох гэмт хэргийн объектив, субъектив шинжүүдийг тодорхойлох
3. Сонгож авсан зүйлчлэлийн дагуу гэмт хэрэг тус бүр дээр дүгнэлт хийх буюу тухайн гэмт хэргийн шинжийг холбогдсон субъектийн үйлдлийн шинжтэй нийцүүлж зүйлчлэх
4. Хамтран оролцогч байгаа бол хүн тус бүр дээр оролцоог тодорхойлж, ерөнхий ангийн хэм хэмжээг сонгон хэрэглэх
5. Төсөөтэй гэмт хэргийг сонгож уг гэмт хэргийн ялгагдах онцлог шинжийг тодорхойлох
6. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл, журмыг тодорхойлох гэсэн үе шатуудыг дамжин явагдана.

Зүйлчлэлийн алхмыг тохиолдлоор тайлбарлавал:

Тохиолдол 1

Говь-Алтай аймгийн Жаргалан сумын нутаг дэвсгэрт Ж, А, Э нар нь бүлэглэн Монгол бөхөн агнасан. Дээрх тохиолдолд хууль зүйн дүгнэлт өгнө үү?

Бодолт 1

Нэгдүгээр алхам

Өгөгдсөн тохиолдолд гэмт хэргийн шинж байгаа эсэхийг шалгаж гэмт хэрэг, зөрчлийн шинжийг тодорхойлох

1. Ж, А, Э нарын үйлдэлд гэмт хэргийн шинж байгаа эсэхийг шалгая.
   - Гэмт хэргийн шинж буюу зөрчлөөс ялгагдах шинжийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангид тодорхойлсноор бичиж дүгнэлт өгнө (нийгэмд аюултай, гэм буруутай шинжийг тодорхойлох).

Эрүүгийн хуулийн 2.1 дүгээр зүйлд “Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцно” хэмээн заажээ. Дээрх тодорхойлолтоос үзэхэд гэмт хэрэг нь эрх зүйн зөрчлөөс,

- Эрүүгийн хуулийн тусгай ангид хуульчлагдсан,
- Нийгэмд аюултай байх,
- Гэм буруутай байх шинжүүдээр ялгагдана.

Ж, А, Э нарын үйлдэлд дээр дурдсан гэмт хэргийн шинж байгаа эсэхийг шалгавал:
Говь-Алтай аймгийн Жаргалан сумын нутаг дэвсгэрт Ж, А, Э нар нь бүлэглэн Монгол бөхөн хууль бусаар агнасан үйлдлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.5 дугаар зүйлд тодорхой төрлийн гэмт хэрэгт тооцож хуульчилсан байна.

Нийгэмд аюултай байх шинжид юуны өмнө эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх ашигт хор хохирол бодитойгоор учруулсан, учрах байсан, тухайн хохирлыг ямар нөхцөлд ямар аргаар хэрхэн учруулсан зэргийг хамтатган авч үзнэ.

Ж, А, Э нар нь нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүй агнаж, их хэмжээний хор уршиг учирсан байх бөгөөд хохирол учруулж буй үйлдэл, учирсан хор уршиг нь нийгмийн хор аюулын шинжийг илэрхийлж байгаа юм.

Гэм буруу гэдэг нь үйлдэлдээ хандаж буй сэтгэхүйн харьцаа бөгөөд гэм буруу нь санаатай, эсхүл болгоомжгүй хэлбэртэй байна[1]. Өөрийн үйлдэл, эс үйлдэхүйг хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж түүнийг хүсэж үйлдсэн, хохирол, хор уршигт зориуд хүргэсэн бол санаатай гэмт хэрэгт тооцно.

Өөрийн үйлдэл, эс үйлдэхүйг хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж түүний улмаас хохирол, хор уршиг учрах боломжтойг урьдчилан мэдэж түүнийг гаргахгүй байж чадна гэж тооцсон боловч хохирол, хор уршиг учирсан, эсхүл хохирол, хор уршиг учрах боломжтойг урьдчилан мэдэх ёстой, мэдэх боломжтой байсан боловч мэдэлгүй үйлдсэний улмаас хохирол, хор уршиг учирсан бол болгоомжгүй гэмт хэрэгт тооцно.

Санаатай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас болгоомжгүйгээр хохирол, хор уршигт хүргэснийг гэм буруугийн холимог хэлбэр гэнэ.

Ж, А, Э нар нэн ховор амьтан болох Монгол бөхөнг тусгай зөвшөөрөлгүй агнасан үйлдэлдээ шууд санаатай хандсан гэж үзнэ.

1 Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.3, 2.4 дүгээр зүйл

Ж, А, Э нар нь Монгол бөхөн нь нэн ховор амьтан болохыг мэдсээр байж, тусгай зөвшөөрөлгүй агнасан, эд эрхтнийг нь зарж борлуулах зорилгоор уг гэмт хэргийг үйлдсэн шууд санаатай гэж үзнэ.

Бодлогын нөхцөлд гэм буруугийн холимог хэлбэр байхгүй гэж үзнэ.

Хоёрдугаар алхам

Бодлогын өгөгдөлд тохирох гэмт хэргийн объектив, субъектив шинжүүдийг тодорхойлох.

Сонгож авсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн тодорхой төрлийн гэмт хэргүүдийн бүрэлдэхүүний шинжийг онолын хувьд тайлбарлах шаардлагатай бөгөөд ингэснээр бодлого бодох аргачлалын эхний шатанд тодорхойлсон бүрэлдэхүүний шинжтэй нийцүүлж бодит зүйлчлэлийг хийх урьдач нөхцөлийг бүрдүүлэх юм.

Объектив шинжид Эрүүгийн хуулиар хамгаалагдсан харилцаа, гэмт үйлдэлд өртсөн халдлагын шинжийг тодорхойлох бөгөөд үйлдэл, түүний улмаас учирсан хохирол, хор уршгийн шалтгаант холбоог бичнэ.

1. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.5 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн обьектив шинж нийтийн нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүй агнасан хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хүрээлэн байгаа орчинд хохирол учирснаар илэрнэ. Өөрөөр хэлбэл, тухайн гэмт хэргийн обьектив шинж нь: нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүй агнасан байдал бий болгосон байхыг шаардана.

Объект нь “Амьтны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь хэсэгт “Нэн ховор амьтан” гэж тархац нутагтаа бүхэлдээ, эсхүл ихэнх хэсэгт тоо толгой эрс цөөрсөн, ашиглах нөөцгүй, устах аюулд орсон амьтныг, 4.1.4 дэх хэсэгт “Ховор амьтан” гэж тархац нутагтаа тоо толгой цөөрсөн, нөөц багатай, устаж болзошгүй амьтныг хэлнэ” заасан жагсаалтад багтсан амьтан байна.

Нэн ховор амьтныг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгай зөвшөөрлөөр зөвхөн судалгаа, шинжилгээний зориулалтаар агнаж, барьж болно.

“Субъектив шинж нь үйлдэл, үйлдлийн улмаас учирч болох хор уршгийг хууль бус гэдгийг мэдсээр байж түүнийг хүсэж үйлдсэн, хор уршигт зориуд хүргэсэн байхыг ойлгох бөгөөд үүнд гэмт хэрэг үйлдэх болсон сэдэлт, зорилго багтана.

Ж, А, Э нар нэн ховор амьтан болох Монгол бөхөнг тусгай зөвшөөрөлгүй агнасан үйлдэл хууль бус гэдгийг мэдэж түүнийг хүсэж үйлдсэн, хохирол, хор уршигт зориуд хүргэсэн санаатай гэм буруугийн хэлбэртэй байна.

Шунахай сэдэлтэд үндэслэгдсэн, ашиг олох зорилгоор үйлдлээ хэрэгжүүлжээ. Субъект нь Ж, А, Э нар нь нэн ховор амьтан болох Монгол бөхөнг тусгай зөвшөөрөлгүй агнасан 24 дүгээр зүйлд зааснаар гэмт хэрэг үйлдэх үедээ арван зургаан насанд хүрсэн байх тул Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24. 5 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн субъект мөн болно.

Дүгнэлт: *Ж, А, Э нар нэн ховор амьтан болох Монгол бөхөнг тусгай зөвшөөрөлгүй агнасан үйлдэл нь санаатай гэмт хэргийн шинжийг бүрэн агуулсан байх тул хэргийн зүйлчлэлийг хийж, эрүүгийн хариуцлага оногдуулах асуудлыг зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай.*

Гуравдугаар алхам

Сонгож авсан зүйлчлэлийн дагуу гэмт хэрэг тус бүр дээр дүгнэлт хийх буюу тухайн гэмт хэргийн шинжийг холбогдсон субъектийн үйлдлийн шинжтэй нийцүүлж зүйлчилнэ. Ж, А, Э нар нэн ховор амьтан болох Монгол бөхөнг тусгай зөвшөөрөлгүй агнасан өгсөн үйлдлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.5 дүгээр зүйлд зааснаар зүйлчилнэ.

Хүндрүүлэх нөхцөл байгаа эсэхийг шалгах: Эрүүгийн хуулийн тусгай ангид эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэхээр заасан нөхцөлүүдийг заасан байдаг. Бодлогын нэгдүгээр нөхцөлд хүндрүүлэх өгөгдөл өгөөгүй байна.

Ж, А, Э нар нэн ховор амьтан болох Монгол бөхөнг тусгай зөвшөөрөлгүй агнасан үйлдлийг шалгахдаа мөн хүндрүүлэх шинж байгаа эсэхийг оролцогч болон үйлдэл тус бүрээр шалгана.

Дөрөвдүгээр алхам

Хамтран оролцогчийг тодорхойлох буюу ерөнхий ангийн хэм хэмжээг сонгон хэрэглэх. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн Гуравдугаар бүлэгт гэмт хэргийн хамтран оролцогчийг тодорхойлсон байдаг тул гэмт хэргийг үйлдэхэд 2-оос дээш хүн оролцсон тохиолдолд уг хэм хэмжээг хэрэглэх эсэхийг шалгана.

Жишээ нь: Ж, А, Э нар нэн ховор амьтан болох Монгол бөхөнг тусгай зөвшөөрөлгүй агнасан хэрэгт хамтран оролцогч эсэхийг шалгана. Үгүйсгэх нөхцөл байвал хуулийн заалтаар тодорхой тайлбарлана.

Дүгнэлт: *Дээрх нөхцөлүүдэд хийсэн үйл бариmтыг нэгтгэн дүгнэж зүйлчилнэ.*

Тавдугаар алхам

Төсөөтэй гэмт хэргийг сонгож уг гэмт хэргийн ялгагдах онцлог шинжийг тодорхойлох. Эрүүгийн хуульд заасан ойролцоо төрлийн гэмт хэргээс ялгагдах гол шинжийг дурдаж дүгнэлт хийнэ.

Зургаадугаар алхам

Эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл, журмыг тодорхойлох. Эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг харгалзан үзнэ. Бодлогод өгөгдсөн нөхцөлөөс хуульд заасан шаардлагууд тодорхой өгөгдсөн бол тухайн нөхцөлд дүгнэлт хийнэ.

Жишээ нь: Бодлогод өгөгдсөнөөр эрүүгийн хариуцлага хүлээлгэх нас, хэрэг хариуцах чадвар, согтуурсан, мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн, хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөлийг хуульд нийцүүлж тайлбарлана.

- *Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт гэмт хэрэг үйлдэх үедээ 16 насанд хүрсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гэжээ.*
- *Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт гэмт хэрэг үйлдсэн, хэрэг хариуцах чадвартай хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гэжээ.*
- *Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт согтуурсан, мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй гэжээ.*
- *Эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдлыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.5 дугаар зүйлд зохицуулжээ. Бодлогын нөхцөлд дүгнэлт хийхэд хөнгөрүүлэх нөхцөлүүд байхгүй гэж үзнэ.*
- *Эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөлийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.6 дугаар зүйлд зохицуулжээ. Хүндрүүлэх нөхцөлөөс бодлогын нөхцөлд өгөгдсөн байдлаар дүгнэлт хийнэ.*
- *Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.6 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэгт ...гэмт хэргийг бүлэглэж үйлдсэн...бол эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэхээр зохицуулжээ.*
- *Бодлогын нөхцөлд хэргийг шүүхэд шилжүүлсэн талаар өгөгдөл байхгүй тул ял оногдуулах асуудалд дүгнэлт хийхгүй.*